

# ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

ОРОЛЦОГЧИЙН СУДЛАХ ГАРЫН АВЛАГА



# ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦАА

---

Оролцогчийн Судлах Гарын Авлага

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн  
Юта дахь Солт Лейк Хотод хэвлэв

## Тайлбар ба Санал

Энэ суралцах гарын авлагын талаарх таны тайлбар болон санал бодлыг талархан хүлээн авах болно. Тэдгээрийг дараах хаягаар илгээнэ үү:

Curriculum Planning  
50 East North Temple Street, Floor 24  
Salt Lake City, UT 84150-3200  
USA

Электрон шуудан: [cur-development@ldschurch.org](mailto:cur-development@ldschurch.org)

Нэр, хаяг, хэсэг болон гадасны нэрийг жагсаан бичнэ үү. Суралцах гарын авлагын гарчгийг бичих ба дараа нь суралцах гарын авлагын давуу тал болон сайжруулах боломжтой хэсгүүдийн талаарх тайлбар хийгээд зөвлөгөөгөө санал болгоно уу.

© 2005 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 8/97

Орчуулгын зөвшөөрөл: 8/97

*Marriage and Family Relations: Participant's Study Guide*-ийн орчуулга  
Mongolian

# ГАРЧИГ

---

“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” . . . . .	iv
Удиртгал . . . . .	v
Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны Цуврал Хичээлийг Үзэх . . . . .	vii

## **А хэсэг: Гэрлэлтийг Бэхжүүлэх нь**

1. “Гэр Бүл нь Бүтээгчийн Төлөвлөгөөний Төвд байдаг” . . . . .	3
2. Гэрлэлтэд Эв Нэгдлийг Хөгжүүлэх нь . . . . .	8
3. Гэрлэлтэд Хайр ба Нөхөрлөлийг Хөгжүүлэх нь . . . . .	12
4. Гэрлэлт дэх Бэрхшээлүүдэд Хандах Хандлага . . . . .	16
5. Эерэг Харилцаагаар дамжуулан Бэрхшээлүүдэд Хандах Хандлага . . . . .	19
6. Итгэл, Залбирлаар дамжуулан Гэрлэлтийг Бэхжүүлэх нь . . . . .	23
7. Уучлалын Анагаах Хүч . . . . .	28
8. Гэр Бүлийн Санхүүг Зохицуулах нь . . . . .	31

## **В хэсэг: Гэр Бүлийг Бэхжүүлэх Эцэг Эхийн Үүрэг Хариуцлагууд**

9. “Үр Хүүхэд бол Их Эзэний Өв юм” . . . . .	39
10. Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 1: Эцгийн Үүргүүд). . . . .	44
11. Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 2: Эхчүүдийн Үүргүүд). . . . .	48
12. Үлгэр Жишээ, Зааварчилгаагаар дамжуулан Хүүхдүүдэд Заах нь . . . . .	54
13. Хүүхдүүдэд Сайн Мэдээний Зарчмуудыг Заах нь (Хэсэг 1) . . . . .	61
14. Хүүхдүүдэд Сайн Мэдээний Зарчмуудыг Заах нь (Хэсэг 2) . . . . .	66
15. Хүүхдүүдийг Шийдвэр Гаргахад нь Хөтлөх . . . . .	73
16. Гэр Бүлийн Залбирал, Гэр Бүлээрээ Судраас Суралцах ба Гэр Бүлийн Үдэш. . . . .	77

# ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

## Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөл

**Е**сүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба Арван Хоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан заяасан бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг чин сэтгэлээсээ тунхаглаж байна.

Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралдаа сүнслэг хөвгүүд, охид Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнхийн амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа гэр бүлийн холбоог мөнхжих боломж олгодог. Ариун Сүмүүдэд гүйцэтгэдэг нандин ёслол ба гэрээнүүд нь хувь хүмүүс Бурханы хүрээлэлд эргэн очих, гэр бүлүүд мөнхөд нэгдэх боломжтой болгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн анхны зарлиг нь тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өөрийн хүүхдүүддээ, өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж газар дэлхийг дүүргэ хэмээсэн Бурханы зарлиг нь хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсон гэдгийг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогдлын талаар бид батлан хэлж байна.

Нөхөр, эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. “Үр хүүхэд бол Их Эзэний өв юм” (Дуулал 127:3).

Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуулиа хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр—эцэг, эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

Гэр бүл Бурханаас заяагддаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаалд үндэслэсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлүүд нь итгэл, залбирал, наманчлал, өршөөл, хүндэтгэл, хайр энэрэл, өрөвч сэтгэл, ажил хөдөлмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй ажиллах зарчмуудын дор оршин амьдарна. Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөл байдалд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэгтэй үед туслан дэмжвэл зохино.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхэдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө очиж мэдүүлэх болохыг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг ямагт хэрэгжүүлэгтүн хэмээн уриалан дуудаж байна.

*Энэхүү тунхгийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Юта дахь Солт Лэйк Ситид 1995 оны 9-р сарын 23-нд болсон Нийгмийн Халамжийн Бүлгийн Ерөнхий Уулзалтан дээр захиасынхаа нэгэн хэсэг болгон уншсан юм.*

# УДИРТГАЛ

## Энэ Цуврал Хичээлийн Зорилго

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны Цуврал Хичээл нь Сүмийн гишүүдэд гэрлэлт хийгээд гэр бүлүүдийг бэхжүүлэх мөн гэр бүлийн харилцаандаа баяр баясгаланг олоход нь зориулагдсан болно. Энэ нь хоёр хэсэгт хуваагддаг. “Гэрлэлтийг Бэхжүүлэх нь” гэсэн А хэсэг нь ялангуяа гэрлэсэн хосууд болон гэрлэхээр зэхэж буй гишүүдэд тус болох юм. “Гэр Бүлийг Бэхжүүлэх Эцэг Эхийн Үүрэг Хариуцлагууд” гэсэн Б хэсэг нь эцэг эх болон өвөө эмээ нарт “[хүүхдүүдийг] Их Эзэний дэг журам болон сургамж дотор хүмүүжүүлэх” (Ефес 6:4) хичээл зүтгэлд нь тусална.

Уг цуврал хичээл нь судруудад болон хожмын үеийн бошиглогч, төлөөлөгчдийн заасан сургаал болон зарчмууд дээр үндэслэгдсэн юм. Энэ нь уг суралцах гарын авлагын iv хуудсанд онцлон тэмдэглэгдсэн байдаг.

Уг цуврал хичээлийг хянахын тулд vii-viii хуудсуудыг үзнэ үү. Сурсан сургаал болон зарчмуудаа давтах болон өөрийгөө дараагийн хичээлүүдэд бэлдэхийн тулд үүнийг ойр ойрхон үзнэ үү.

## Хэрэгцээнийхээ Дагуу Уг Цуврал Хичээлд Оролцох нь

Танд хувийнхаа хэрэгцээний дагуу оролцох сонголт бий. Жишээ нь: хэрэв та гэрлэсэн боловч хүүхэдгүй бол сүүлийн найман хичээлд биш, харин эхний найман хичээлд оролцохыг сонгож болох юм. Хэрэв та ганц бие эцэг, эсвэл эх бол зөвхөн Б хэсгийн хичээлүүдэд оролцохоор тогтож болох юм.

## Уг Цуврал Хичээлд Оролцох нь

Энэ цуврал хичээлд оролцохыг сонгосноор та гэр бүлээ бэхжүүлэх хүсэлтэйгээ харуулж байна. Та уг цуврал хичээлийн ашиг тусыг бүрэн хүртэхийн тулд ангийн ярилцлагуудад хувь нэмрээ оруулж, энэ суралцах гарын авлагыг ашиглаж, мөн сурч буй сургаал болон зарчмуудаа хэрэгжүүлэхийг хичээх хэрэгтэй.

## Ангийн Ярилцлагуудад Хувь Нэмрээ Оруулах нь

Та болон бусад оролцогчид нь ангийн ярилцлагуудад хувь нэмрээ оруулснаар та Ариун

Сүнсний нөлөөг урьж, нэг нэгэндээ зааж мөн нэг нэгнийгээ гэгээрүүлж чадна. Их Эзэн “Өөрсдийнхөө дунд багшийг томил, мөн бүгдээрээ нэг зэрэг яригчид бүү байг; бүгдээрээ ярихад бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд, мөн хүн болгон тэгш боломжтой байж болохын тулд харин нэг нь хэсэг хугацаанд ярьж, мөн бүгдээрээ түүний хэлэхийг сонсог” хэмээн хэлсэн байдаг (С ба Г 88:122).

Цуврал хичээлд оролцож буй бүх хүмүүс гэрлэлтэд буюу хүүхдүүд өсгөн хүмүүжүүлэх туршлагатай эсэхээс үл хамааран бие биеэсээ суралцаж чаддаг. Хичээлүүдтэй холбоотой туршлагаа хуваалцаж, мөн бусдыг ч мөн адил зүйлийг хийхэд нь хүндэтгэлтэйгээр сонссоноор хичээл дэх туршлага тань хамгийн үр өгөөжтэй болох болно. Та ярилцаж буй үнэнүүдийн талаар гэрчилснээр өөрийн болон бусдын гэрчлэлийг бэхжүүлж чадна. Гэсэн хэдий ч та ангийн ярилцлагад тохиромжгүй хувийн буюу нандин туршлагаудын талаар ярилцахгүй байхыг анхаарах хэрэгтэй. Түүнчлэн та хичээлийн цаг хязгаартайг анхаарч, багш мөн бусад оролцогчдийг бодох хэрэгтэй.

## Энэ Суралцах Гарын Авлагыг Ашиглах нь

Хичээл бүрийн дараах долоо хоногт сурсан зүйлээ давтахаар энэ суралцах гарын авлагыг ашиглана уу. Суралцах гарын авлага нь хичээл бүрт сурсан сургаал болон зарчмуудын дагуу амьдрахад тань туслах зөвлөгөөнүүд болох “Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд” хэсгийг багтаасан болно. Нэмж хэлэхэд, хичээл бүрт Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн нэг, эсвэл хоёр тунхгийг хавсаргасан болно. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр буюу нөхөртэйгөө хамт тунхгийг уншиж, ярилцсанаар их ашиг тусыг хүлээн авах болно.

Тунхаглалуудын зарим нь анхнаасаа ерөнхий чуулган болон бусад цуглаануудад яриа болгон өгөгдөж байсан бөгөөд бусад нь Сүмийн сэтгүүлүүдэд бичигдсэн юм. Тэдгээрийг өөр өөр хэвлэлээс авсан учраас энэ суралцах гарын авлагын бичлэгийн хэмжээг нэг хэвийн болгохын тулд бага зэргийн засвар хийх шаардлагатай байв. Жишээ нь: зарим удиртгал үгс нь ерөнхий чуулган дээр хандан ярьсан яриануудаас хасагдаж, мөн зарим гарчгууд болон ишлэлүүд нь өөрчлөгдсөн байна. Заасан зүйлийг хэвээр нь үлдээсэн болно.

## Сурсан Сургаал болон Зарчмуудаа Хэрэгжүүлэх нь

Сайн мэдээг зөвхөн сурах нь хангалттай биш юм. Сайн мэдээг амьдралдаа ашигтай байлгахын тулд та сурч буй зүйлийнхээ дагуу амьдрах ёстой. Сүмийн 11 дэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Харолд Б.Ли зөвлөхдөө :

“Сайн мэдээний бүх зарчмууд болон ёслолууд сайн мэдээний заасан зүйлсийг хэрэгжүүлэн суралцах урилга мэт байдаг. Ямар ч хүн аравны нэгийг төлөх хүртлээ аравны нэгийн зарчмыг мэддэггүй. Ямар ч хүн Мэргэн Ухааны Үгийг сахих хүртлээ Мэргэн Ухааны Үгийн зарчмыг мэддэггүй. Хүүхдүүд буюу энэ асуудалд хамаатай өсвөр насныхан эдгээр зарчмуудын талаар хэн нэгний ярьж байхыг сонсоод аравны нэг, Мэргэн Ухааны Үг, Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь хадгалахад буюу залбиралд өөрчлөгдөөгүй байдаг. Бид сайн мэдээний дагуу амьдарснаар үүнийг сурдаг билээ. . . .

“. . . Бид зарчим бүрийн дагуу амьдрахаас ирдэг адислалуудыг мэдрэх хүртлээ сайн мэдээний заасан зүйлсийн талаар ямар ч зүйлийг үнэхээр мэдэж авч чадахгүй” гэжээ (*Stand Ye in Holy Places* [1974], 215).

## Нэмэлт Эх Сурвалжууд

Сүмээс хэвлэн гаргасан дараах эх сурвалжууд нь энэ цуврал хичээлд ярилцах сэдвүүдэд нэмэлт мэдээллээр хангах болно. Тэдгээрийг Сүмийн материал хангамжийн төвүүдээр дамжуулан авах боломжтой. Та эдгээр хэвлэл нийтлэлүүдийг хүлээн авч, гэртээ ашиглахыг хүсч болно.

- *Гэр Бүлийн Удирдамж* (31180). Энэхүү удирдамж нь гэр бүлийн зохион байгуулалтыг тайлбарлаж, сайн мэдээг гэртээ заах тухай мэдээллээр хангадаг бөгөөд санваарын адислалууд болон ёслолуудын үйл явцыг тоймлож өгдөг.
- Сүмийн сэтгүүл дэх гэрлэлт болон гэр бүлийн тухай өгүүлүүд.
- *Заах Удирдамж* (34595). Энэхүү удирдамж нь сайн мэдээг сайжруулан зааж, суралцах тухай санал, зөвлөгөөгөөр хангах болно.
- *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285). Энэ товхимол нь болзоо, хувцаслалт ба гадаад төрх, нөхөрлөл, шударга зан, хэл яриа, мэдээллийн хэрэгсэл, оюун санаа болон биеийн эрүүл мэнд, хөгжим, бүжиг, бэлгийн харьцааны цэвэр байдал, Хүндэтгэлийн өдөр баримтлах зүйл, нанманчлал, зохистой байдал ба үйлчлэлийн талаарх Сүмийн жишгүүдийг тоймлож өгдөг.

# ГЭРЛЭЛТ БА ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ҮЙЛ ЯВЦЫГ ХЯНАХ

А хэсэг: Гэрлэлтийг Бэхжүүлэх нь

---

## Хичээл 1: “Гэр Бүл нь Бүтээгчийн Төлөвлөгөөний Төвд Байдаг”

Хожмын үеийн бошиглогчид гэрлэлт болон гэр бүлийн мөнхийн ач холбогдлыг тунхагладаг.

Мөнхийн гэрлэлт нь энэ амьдралд мөн үүрд мөнхөд баяр баясгалан хийгээд агуу адислалуудыг авчирч чаддаг билээ.

Гэрлэлт ба Гэр Бүлийн Харилцааны цуврал хичээл нь гэр бүлийн харилцаанд баяр баясгаланг олоход зориулагдсан болно.

Орон гэрээ “Гэтэлгэгчийн маань хадан дээр” баривал “тэнгэрийн жаахан хэсэг” нь байх болно.

## Хичээл 2: Гэрлэлтэд Эв Нэгдлийг Хөгжүүлэх нь

Их Эзэн эхнэр нөхрүүд нэгдмэл байхыг зарлигласан юм.

Эхнэр нөхрүүд бие биенээ эрх тэгш хамтрагчийн хувьд үнэлэх ёстой.

Эхнэр нөхрүүд нь хувийн шинж чанар хийгээд чадвараараа нэг нэгнийгээ нөхөн дэмжиж байх хэрэгтэй.

Эхнэр нөхрүүд бие биендээ үнэнч, шударга байх ёстой.

## Хичээл 3: Гэрлэлтэд Хайр ба Нөхөрлөлийг Хөгжүүлэх нь

Эхнэр нөхрүүд бие биенээ хайрлах хайраа хөгжүүлж байх ёстой.

Хайрын нөлөө мөн нинжин сэтгэлийн илрэл нь гэрлэлтэд хайр болон нөхөрсөг байдлыг мөхөөхгүйгээр хадгалдаг билээ.

Гэрлэлт дэх зохистой дотно үерхэл нь хайрын илрэл мөн.

Гэрлэсэн хосууд энэрэл Христийн цэвэр ариун хайрыг байлгахын төлөө хичээн тэмүүлж байх хэрэгтэй.

## Хичээл 4: Гэрлэлт дэх Бэрхшээлүүдэд Хандах Хандлага

Бүх гэрлэсэн хосууд бэрхшээлүүдийг туулах болно.

Хэрэв эхнэр нөхрүүд гэрлэлтийг гэрээн дэх харилцаа хэмээн үздэг бол тэд ямар ч бэрхшээлийг давж чадна.

Бэрхшээл бий болох үед бид сэтгэл гонсгор байдлаар, эсвэл уур хилэнгээс илүү тэвчээр хийгээд хайраар угтахыг сонгож болно.

## Хичээл 5: Эерэг Харилцаагаар Дамжуулан Бэрхшээлүүдэд Хандах Хандлага

Гэрлэсэн хос бүрт үзэл бодлын зарим нэгэн ялгаа байх болно.

Эхнэр нөхрүүд гайхан биширмээр шинж чанаруудыг нэг нэгэндээ олж харах хэрэгтэй.

Эерэг харилцаа нь бэрхшээлүүдийг урьдчилан сэргийлж мөн шийдвэрлэхэд тус болно.

## Хичээл 6: Итгэл, Залбирлаар Дамжуулан Гэрлэлтийг Бэхжүүлэх нь

Эхнэр нөхрүүд Есүс Христэд итгэх итгэлээ өсөн нэмэгдүүлэхэд хамтдаа чармайх хэрэгтэй.

Эхнэр нөхрүүд хамтдаа залбирах үед адислагддаг билээ.

## Хичээл 7: Уучлалын Анагаах Хүч

Эхнэр нөхрүүдийн хоорондох уучлалын сүнс нь амар амгалан, итгэл хийгээд аюулгүй байдлын мэдрэмжийг авчирдаг билээ.

Эхнэр нөхрүүд өөрсдийн сул тал, дутагдалтай байдлыг уучилдаг байхыг эрэлхийлж мөн сайжруулах чин сэтгэлийн оролдлого хийж байх хэрэгтэй.

Эхнэр нөхрүүд бие биенээ уучлан өршөөхийг эрэлхийлж байх хэрэгтэй.



## **Хичээл 8: Гэр Бүлийн Санхүүг Зохицуулах нь**

Аз жаргалтай гэрлэлтийн чухал хэсэг нь зөв зохистой санхүүгийн зохицуулалт мөн.

Эхнэр нөхрүүд мөнгөний зохицуулалтын үндсэн зарчмуудыг мөрдөхийн тулд хамтдаа чармайх хэрэгтэй.

## **В хэсэг: Гэр Бүлийг Бэхжүүлэх Эцэг Эхийн Үүрэг Хариуцлагууд**

---

### **Хичээл 9: “Үр Хүүхэд бол Их Эзэний Өв юм”**

Тэнгэрлэг Эцэг Өөрийн сүнсний хүүхдүүдийг дэлхийн эцэг эхчүүдэд хариуцуулдаг.

Эцэг эхчүүд хүүхэд бүрийн хувийн хэрэгцээг хангаж байхыг эрмэлзэж байх ёстой.

Хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ хайрын харьцаатай байх эрхтэй.

Хүүхэдтэй зүй бусаар харьцах нь Бурханыг доромжилсон явдал мөн.

Хүүхдүүд эцэг эхчүүдийнхээ амьдралд агуу их баяр хөөрийг авчирдаг билээ.

### **Хичээл 10: Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 1: Эцгийн Үүргүүд)**

Эцэг эхчүүд хүүхэд бүрээ итгэлийн бамбайгаар хангаж байхын тул хамтдаа чармайх ёстой.

Эцгүүд хайр хийгээд зөв шударга ёсоор тэргүүлж байх ёстой.

Эцгүүд гэр бүлээ амьдралын хэрэгцээгээр нь ханган тэтгэж, хамгаалж байх ёстой.

### **Хичээл 11: Эцэг Эхчүүдийн Ариун Үүргүүд (Хэсэг 2: Эхчүүдийн Үүргүүд)**

Эхчүүд Бурханы ажилд оролцдог.

Эхчүүдийн үндсэн үүрэг нь хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлэх юм.

Эцэг эхчүүд харилцан бие биендээ адил тэгш туслах ёстой.

### **Хичээл 12: Үлгэр Жишээ, Зааварчилгаагаар Дамжуулан Хүүхдүүдэд Заах нь**

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үүрэгтэй.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заахдаа сүнслэг урмыг хүлээн авч чадна.

Эцэг эхчүүд үлгэр жишээ, зааварчилгаагаар дамжуулан заадаг.

### **Хичээл 13: Хүүхдүүдэд Сайн Мэдээний Зарчмуудыг Заах нь (Хэсэг 1)**

Эцэг эхчүүдийн заасан зүйл нь хүүхдүүдийг итгэлд нь бат бөх байлгахад тусалж чадна.

Эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээний анхны зарчмууд ба ёслолуудыг заах ёстой.

Эцэг эхчүүд “хүүхдүүддээ залбирахыг, мөн Их Эзэний өмнө цэх шулуун алхахыг заах” ёстой.

### **Хичээл 14: Хүүхдүүдэд Сайн Мэдээний Зарчмуудыг Заах нь (Хэсэг 2)**

Эцэг эхчүүд хүүхдүүддээ заах үед хайраа үзүүлдэг.

Эцэг эхчүүд өрөвдөх сэтгэл ба үйлчлэлийг хүүхдүүдэд заах ёстой.

Эцэг эхчүүд шударга байх мөн бусдын өмч хөрөнгөнд хүндэтгэлтэй хандахыг хүүхдүүдэд заах ёстой.

Эцэг эхчүүд үнэнч шударга хөдөлмөрийн шагналын талаар хүүхдүүдэд заах ёстой.

Эцэг эхчүүд ёс суртахууны ариун байдлыг хүүхдүүдэд заах ёстой.

### **Хичээл 15: Хүүхдүүдийг Шийдвэр Гаргахад нь Хөтлөх**

Хүүхдүүдэд шийдвэр гаргахад нь удирдамж хэрэгтэй байдаг.

Эцэг эхчүүд сонголтоо зөв шударга ёсоор хэрэгжүүлэхэд нь хүүхдүүдэд тусалж чадна.

Эцэг эхчүүд ухаалаг бус шийдвэрийн үр дагавраас суралцахыг хүүхдүүдэд зөвшөөрөх ёстой.

Эцэг эхчүүд буруу замд орж буй хүүхдүүдэд тогтмол хайраа үзүүлэх ёстой.

### **Хичээл 16: Гэр Бүлийн Залбирал, Гэр Бүлээрээ Судраас Суралцах ба Гэр Бүлийн Үдэш**

Гэр бүлийн залбирал, судраас суралцах ба гэр бүлийн үдэш нь Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүл бүрийн нэн тэргүүнд тавих зүйл нь байх ёстой.

Гэр бүлүүд хамтдаа залбирах үед тэд агуу их адислалуудыг хүлээн авдаг.

Гэр бүлээрээ судраас суралцах нь гэр бүлийг Бурхантай илүү ойр болоход нь тусалдаг.

Гэр бүлийн үдэш нь дэлхийн нөлөөллийн эсрэг гэр бүлүүдийг хүчирхэг болоход тусалдаг.

# А ХЭСЭГ ГЭРЛЭЛТИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ





# “ГЭР БҮЛ НЬ БҮТЭЭГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨВД БАЙДАГ”

# 1

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг давт хуудас iv. Та энэ бошиглолын зөвлөгөөг дагах илүү сайн арга замыг тодорхойл.
- “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” (35602 буюу 35538)-ийг Сүмийн материал хангамжийн төвөөс олж ав. Гэртээ үүнийг байнга харагдахаар газарт байрлуул.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### ЭНЭ АМЬДРАЛД БА ҮҮРД МӨНХӨД

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Бонд К.Пакер

### Аз Жаргалын Агуу Их Төлөвлөгөө

Хайрт ах эгч нар аа, төлөөлөгчид, бошиглогчдын судрууд болон заасан зүйлүүд нь мөнх бус байдлын өмнөх амьдралд бид Бурханы сүнсний хүүхдүүд—охид, хөвгүүд нь байсан хэмээн өгүүлдэг.<sup>1</sup> Хүйсийн асуудал өмнө оршиж байсан ба энэ нь мөнх бус амьдралаас эхлээгүй юм.<sup>2</sup>

Тэнгэр дэх агуу их зөвлөлд<sup>3</sup> Бурханы төлөвлөгөөг:<sup>4</sup> авралын төлөвлөгөө,<sup>5</sup> гэтэлгэлийн төлөвлөгөө,<sup>6</sup> аз жаргалын агуу их төлөвлөгөө хэмээн танилцуулжээ.<sup>7</sup> Энэ төлөвлөгөө нь нотлогдохын тул өгөгддөг; бүгдээрээ сайн, муугийн хооронд сонгох ёстой.<sup>8</sup> Түүний төлөвлөгөө нь Гэтэлгэл, цагаатгал, Амилуулалтыг өгнө, мөн хэрэв бид дагах юм бол Бурханы оршихуйд буцаж авчрагдана.

Дайсан эсэргүүцэн өөрийн хувийн төлөвлөгөөг хэрэгжүүлэв.<sup>9</sup> Түүнийг дагасан тэд мөнх бус махбодыг эзэмших эрхээсээ хасагдсан ажээ.<sup>10</sup> Энд оршиж буй бидний хувьд Эцэгийн маань төлөвлөгөөг хүлээн зөвшөөрснийг баталж байгаа юм.<sup>11</sup>

Люсиферийн ганц зорилго нь хамгийн ариун нандин, гоёмсог сайхныг мөн амьдралын гоо үзэсгэлэнтэй явдлууд болох: романтик туршлага, хайр, гэрлэлт хийгээд санваарыг сүйтгэхийн тулд аз жаргалын агуу их төлөвлөгөөг эсэргүүцэх явдал байсан юм.<sup>12</sup> Сэтгэлийн зовиур мөн гэмийн<sup>13</sup> хий үзэгдлүүд түүнийг дагадаг билээ. Түүний хор хөнөөлийг зөвхөн наманчлал эдгээж чадна.

### Бурханы Төлөвлөгөө Гэрлэлт болон Гэр Бүлийг Шаарддаг

Аз жаргалын төлөвлөгөө нь зөв шудрага ёсны эр, эм болон эрэгтэй, эмэгтэй, мөн эхнэр нөхрүүдийн холбоог шаарддаг.<sup>14</sup> Бидний биеэ авч явах байдалд хэт их нөлөөлөх төрөлхийн эрч хүчинд хэрхэн хандахыг сургаал бидэнд зааж өгдөг.

Бие махбод Адамд зориулагдаж Бурханы биеийн дүр төрхөөр бүтээгдсэн,<sup>15</sup> мөн тэрбээр Цэцэрлэгт аваачигдсан билээ.<sup>16</sup> Эхэндээ Адам ганцаараа байв. Тэр санваарыг атгаж байсан<sup>17</sup> боловч, ганцаар, тэр бүтээгдсэний төлөөх зорилгуудыг гүйцэлдүүлж чадахгүй байжээ.<sup>18</sup>

Түүнээс өөр хэн ч үүнийг хийж чадахгүй байлаа. Ганцаараа ч бүү хэл, өөр бусад эрэгтэй хүмүүсийн хамтаар ч Адам хөгжихгүй байв. Ева ч мөн өөр эмэгтэйн хамтаар хөгжихгүй л байсан. Энэ нь чухам ийм байсан ажгуу. Мөн эдүгээ ч энэ нь ийм билээ.

Туслагч болох Ева бүтээгдсэн билээ. Гэрлэлт үүсэв.<sup>19</sup> Учир нь өөрийн *эхнэртэй* (зүгээр нэгэн *эмэгтэйтэй* биш) нэгдэн нийлэхийг мөн “өөр хэнтэй ч биш” хэмээн Адамд зарлигласан ажээ.<sup>20</sup>

Сонголт нь Евад оногдсон гэж хэлж болно.<sup>21</sup> Тэр шийдвэрийнхээ төлөө магтаалыг хүртэх ёстой. Дараа нь “Адам хүмүүн байж болохын тулд унасан билээ.”<sup>22</sup>

Ахлагч Оорсон Ф.Витни Уналтыг “доошлох хэдийд ч урагшилдаг— хоёр чиг хандлагатай” хэмээн тайлбарлажээ. Энэ нь хүмүүнийг дэлхийд авчран түүний хөлийг хөгжил дэвшлийн зам дээр байрлуулсан юм.<sup>23</sup>

Бурхан Адам Еваг хоёрт “Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн бол хэмээн тэдэнд хэлж”<sup>24</sup> адисалжээ. Ийнхүү гэр бүл бий болсон билээ.

### **Бурхан Эрэгтэй, Эмэгтэй Хүнийг Адил Тэгш Үнэлдэг.**

Эмэгтэй хүн байхаасаа илүү эрэгтэй хүн байх нь Бурханы таалалд нийцдэг эсвэл Тэрбээр хөвгүүдийг охидоос илүү өндөр үнэлдэг гэсэн илчлэлтүүд хаана ч байдаггүй.

Судруудад жагсаан бичсэн мэт—хайр, баяр хөөр, амар амгалан, итгэх итгэл, бурханлиг шинж, энэрэл гэх мэт—бүх ариун журмыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс хоёулаа хуваалцдаг<sup>25</sup> ба зуурдын байдлын дээд санваарын ёслол нь зөвхөн эмэгтэй хүний хамт байхад эрэгтэй хүнд өгөгддөг билээ.<sup>26</sup>

Уналтын дараа байгалийн хууль нь мөнх бус амьдралын төрөлтийг бидний ойртож үл болох эрх мэдлийн дээгүүр захирах болгожээ. Үүнийг Ерөнхийлөгч Бага Ж.Рюбэн Кларк янз бүрийн хэвийн бус байдал, эрэмдэг, гажиг согогтой болоход хүргэдэг байгалийн “доог тохуу”<sup>27</sup> гэж нэрлэсэн байдаг. Хэдийгээр хүмүүний ухаан бодолд тэдгээр нь шударга бус мэт санагддаг ч, тэд хүн төрөлхтөнд нотлон үзүүлэхээр Их Эзэний зорилгуудад ямар нэгэн байдлаараа тохирч байдаг байна.

Дараах зохистой зөн совин, зөв шударга ёсны өдөөлтөнд хийж буй хариу үйлдэл болон өргөмжлөгдөх хүн төрөлхтний харилцааг бүрэн төгс, төгөлдөр болгохын төлөө нэг бүрчлэн өгөгдөж, Есүс Христийн сайн мэдээний сургаалд батлагддаг бөгөөд Түүний Сүмд илчлэгдсэн зарлигуудаар хамгаалагддаг юм.

### **Эрэгтэй, Эмэгтэй Хүмүүсийн Үүргүүд**

Төрөлхийн шинж чанараараа Адам, Ева хоёр бие биенээсээ ялгаатай байсан учраас тэд өсөн нэмэгдэж мөн газар дэлхийг дүүргэж чадахгүй байв.<sup>28</sup> Ялгаатай зүйлсийг нөхөн дэмжих нь аз жаргалын төлөвлөгөөний гол түлхүүр юм.

Зарим үүргүүд эр хүйстэнд хамгаас илүү тохирч байхад бусад нь эм хүйстэнд тохирч байдаг. Судрууд болон байгалийн жам нь эрэгтэй хүнийг хамгаалагч, тэжээгч хэмээн тодорхойлжээ.<sup>29</sup>

Тэдгээр санваарын үүрэг хариуцлагууд нь гэрээс гадуур гүйцэтгэвэл зохих ажил үүрэгт Сүмийн захиргаатай холбоотой байдаг. Тэнгэрлэг хуулийн дагуу тэднийг эрэгтэй хүмүүст хариуцуулдаг. Энэ нь эхлэлээс авахуулан ийм байсан, учир нь “энэхүү санваарын дэг жаяг нь эцгээс хүүд харьяалагдан доош гардуулагдсан байхаар

батлагдаж ирсэн. . . . Энэ дэг жаяг нь Адамын өдрүүдэд үндэслэгдэн бий болжээ”<sup>30</sup> хэмээн Их Эзэн илчилсэн ажээ.

Санваарыг атгаж буй эрэгтэй хүн өргөмжлөлд бэлтгэгдсэнээрээ эмэгтэй хүнээс давуу эрхтэй биш. Төрөлхийн шинж чанараараа эмэгтэй хүн ч Бурханы хамтран бүтээгч нь бөгөөд анхнаасаа хүүхэд өсгөн хүмүүжүүлэгч мөн билээ. Төгөлдөржилт болон өргөмжлөлд хамаатай ёс суртахууны байдал хийгээд эерэг шинж тэмдэгүүд нь эмэгтэй хүнд төрөхөд өгөгддөг ба эдгээр шинж нь гэрлэж мөн эх болоход нь сайжирдаг юм.

Эцэгийн маань аз жаргалын төлөвлөгөөнд нийцүүлэхээр санваарыг зөвхөн зохистой эрэгтэй хүнд томилдог. Байгалийн хуулиуд болон Бурханаар илчлэгдсэн үгс хамтдаа харилцан зохицдог, энгийнээр хэлэхэд хамгийн сайн тохирдог.

Санваар нь гайхалтай сайхан үүргүүдийг дотроо агуулдаг. “Хүч буюу нөлөөг санваарын ариун журмаар тэтгэгдэн байж *чадах* нь үгүй, гагцхүү сэнхрүүлээр, тэсвэр тэвчээрээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар, . . . цэвэр мэдлэгээр, нинжин сэтгэлээр байх ёстой ажгуу.”<sup>31</sup>

Хүмүүн нь “ямар ч зөвт шударга ёсон бусаар хянаж эзэгнэх эсвээс албадан хүчлэх юм бол”<sup>32</sup> тэрбээр “санваарт хамаарагддаг тангараг хийгээд гэрээг”<sup>33</sup> зөрчиж байгаа юм. Тиймээс “тэнгэр өөрийгөө холдуулдаг; Их Эзэний Сүнс гомддог болой.”<sup>34</sup> Тэр наманчлахгүй аваас, тэрбээр адислапуудыг алдах болно.

Өргөмжлөгдсөн сэлэстиэл тунхаглалуудад эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн өөр хоорондын ялгаатай үүргүүдийг тогтоосон байхад, тэдгээр нь гэр бүлийн амьдралын үйл явдалд хамгийн их тохиолддог энгийн, нийтлэгээр харуулсан юм.

Саяхан ариун ёслолын цуглаан дээр нэгэн яригч яагаад ач, зээ нар нь хэзээ ч Өвөөгийнх руу гэхгүй, дандаа *Эмээгийн* гэр рүү явах талаар ярьж байхыг ойлгодоггүйгээ гомдоллон ярьж байхыг би сонссон билээ. Би тэрхүү нууцыг түүнд зориулж тайлсан: Өвөө нар бялуу хийдэггүй.

### **Байгалийн болон Сүнсний Хууль Мөнхөд Оршдог**

Амьдралыг захирах байгалийн болон сүнсний хуулиуд нь дэлхийн үүслээс өмнө бий болсон.<sup>35</sup> Тэдгээрийг дагах, эс дагах хоёрын үр дагаврууд мөнхийн учир тэд бас мөнхийнх билээ. Тэд нийгмийн болон улс төрийн шийдвэр дээр үндэслэгддэггүй. Тэднийг өөрчлөх боломжгүй. Тэднийг

ямар ч дарамт, эсэргүүцэл, хууль зэрэг нь өөрчлөх боломжгүй.

Олон жилийн өмнө би Индианчуудын семинарыг хянан хариуцаж байлаа. Албюкёрки сургуульд айлчлан очиход захирал нь надад нэгдүгээр ангийнхны дунд болсон нэгэн явдлыг хуваалцсан юм.

Хичээлийн үеэр нэгэн муурын зулзага ангид орж ирж хүүхдүүдийн анхаарлыг сарниулжээ. Тэр ангийн өмнө байсан болохоор бүгд харж чаджээ.

Нэгэн жаал, “Энэ эр муурын зулзага уу, эсвэл эм муурын зулзага уу?” гэж асуужээ.

Тиймэрхүү ярианд бэлтгэлгүй байсан багш нь, “Энэ хамаагүй. Зүгээр л муурын зулзага байна” гэж хэлж.

Гэтэл хүүхдүүд зөрүүдлэн асуухад, нэгэн жаал хүү “Муурын зулзагын эр эмийг би мэдэж чадна” хэмээн хэлжээ.

Ацан шалаанд орсон багш нь, “За яахав, чи бидэнд энэ муурын зулзага эр эсвэл эмийг хэрхэн мэдэж болохыг хэл” гэжээ.

“Бид үүний төлөө санал хураая” хэмээн хөвгүүн хэлжээ.

Зарим зүйлс өөрчлөгдөх боломжгүй. Сургаалыг өөрчилж болохгүй.

“Хүмүүний хүүхдүүдийн аврал хийгээд өргөмжлөлийн төлөө илчлэгдсэн зарчмууд нь . . . та нарыг бүр мөсөн устгах зарчим биш. *Эрэгтэй [эсвэл эмэгтэй] хүмүүсийн нэгдмэл байдлыг ч устгахаар зарчмууд биш билээ.* Тэдгээр нь хэзээ ч мөхөж болох зарчмууд биш юм. . . . Тэдгээр нь хүмүүний гарт хүрэх эсвээс устгагдахаас ангид байдаг. . . . Эдгээр зарчмуудын нэг зураас эсвээс нэг үсэг ч устгагдах нь үгүй.”<sup>36</sup>

Дэлхийн Хоёрдугаар Дайны үеэр эрэгтэй хүмүүсийг байлдуулахаар дууддаг байлаа. Хүнд бэрх үед урьд өмнө нь тохиолдож байгаагүйгээр дэлхий даяар эхнэр болоод эх хүмүүс ажил хийхэд хүрсэн билээ. Дайны хамгийн их сүйрүүлэх нөлөө нь гэр бүлд учирсан юм. Энэ нь үе удамд ул мөрөө үлдээсэн билээ.

### Өсөн Нэмэгдэж Газар Дэлхийг Дүүрэг

1942 оны Аравдугаар сарын ерөнхий чуулганд “бүх газар нутаг, дэвсгэр дэх Гэгээнтнүүдэд” Тэргүүн Зөвлөл захиас бичгийг хүргэсэн билээ. Үүнд тэд “Сүмийн Тэргүүн Зөвлөл бидэнд байгаа ариун журмын эрх мэдлийн дагуу бид өөрийн хүмүүст анхааруулж байна” хэмээн өгүүлсэн байдаг.

Дараа нь тэд: “Адам Ева хоёрт өгөгдсөн хамгийн эхний зарлигуудын дунд: ‘Өсөн нэмэгдэж газар дэлхийг дүүргэ’ хэмээн Их Эзэн хэлсэн байдаг. Тэрбээр тэрхүү зарлигийг манай өнөө үед дахин давтсан билээ. Тэрбээр энэ хожмын эрин үед гэрлэлтийн гэрээний мөнхөд орших зарчмуудыг дахин илчилсэн юм. . . .

“Адамд өгсөн өсөн нэмэгдэж газар дэлхийг дүүргэх тушаалыг эхнэр, нөхөр бүрийн дагах үүрэг даалгавар мөн гэдгийг Их Эзэн бидэнд хэлсэн, тэгснээр бие махбодынхоо асрыг хүлээж буй сонгогдсон олон сүнснүүд энд ирж мөн Бурханы агуу их төлөвлөгөөний дагуу төгс бодгалиудтай болохын тулд урагш тэмүүлэх болно, учир нь эдгээр бие махбодын асаргүйгээр Бурханы төлөвлөсөн зорилгод хөгжин хүрч чадахгүй билээ. Тиймээс эхнэр, нөхөр бүр ариун, мөнхийн гэрээнд төрөх хүүхдүүдийн Израил дахь эцэг, эхчүүд болох ёстой.

“Эдгээр сонгогдсон сүнснүүдийг газар дэлхийд авчирснаар эцэг, эх бүр бие махбодтой болсон сүнсийг мөн Их Эзэн Түүний өгсөн хамгийн эрхэм нандин хариуцлага болох боломжоо хэрэгжүүлэхээ мэдэрдэг, учир нь тэрхүү сүнсний мөнх оршихуй дахь ирэх хувь тавилан, үүний дараах ертөнцөд хүлээж буй адислалууд эсвэл шийтгэлүүд нь голчлон тэдний анхаарал халамж, заасан зүйлүүд, хүмүүжлээс шалтгаалах болно.

“Ямар ч эцэг, эх тэрхүү хууль болон хүлээлгэсэн үүрэг, хариуцлагаас зайлсхийж чадахгүй, учир нь Их Эзэн бидэнтэй хатуу тооцоо хийхээр зохих хурлыг хийх болно. Эгэл хүнд хүлээлгэх үүнээс ч илүү өндөр хариуцлага хаа ч үгүй билээ.”

### Эх болох нь Ариун Нандин Дуудлага юм

Эхчүүдийн тухайд: “Эх болох нь өөрсдийн анхны байдлыг хадгалсан мөн ‘тэдний Бурхан Их Эзэний тэдэнд зарлиглах бүх зүйлийг хийх нь үү гэдгийг харахын тулд’ (Абрахам 3:25) өөрсдийн хоёр дахь байдлын төлөө энэ газар дэлхийд ирдэг хийгээд нэг дэх байдлаа хадгалсан тэдний бие махбод, оюун ухаан, сүнсийг өсгөн хүмүүжүүлж, халамжлан хайрлах, гэжээн тордон үнэнчээр зориулах болохоор ариун нандин дуудлага мөн билээ. Эх хүний ажил үүрэг нь тэднийг хоёр дахь байдлаа хадгалахад нь удирдах явдал юм. ‘Өөрсдийн хоёр дахь байдлыг хадгалдаг тэдний тэргүүн дээр алдар суу үүрд мөн мөнхөд нэмэгдэх болно’ (иш татав.) [Абрахам 3:26] гэж Тэргүүн Зөвлөл хэлсэн байдаг.

“Эх болох энэхүү тэнгэрлэг үйлчлэл нь зөвхөн эхчүүдэд өгөгддөг юм. Үүнийг бусдад хүлээлгэн

өгч болохгүй. Асрагчид үүнийг хийж чадахгүй; улсын асрамжийн байгууллагууд хийх ёсгүй; туслуулахаар хөлсөлсөн хүн үүнийг хийж чадахгүй— магадгүй тусалж, дэм болохуйц хайрт эцэг, ах, эгч, дүү нарын тусламжийн хамтаар эх хүн бүрэн дүүрэн халамжийг шаардагдсан хэмжээгээр өгч чадна.

“Алт мөнгө, алдар хүнд, эсвэл нийгмийн ажил үйлчлэлийн төлөө эх хүн ямарваа ажлыг хийхгүй байж болох ч, хүүхдээ бусдын хайр халамжинд хариуцуулдаг эх хүн ‘дур зоргоороо аашлагч хүүхэд эхийгээ ичгүүрт оруулдаг’ (Сургаалт үгс 29:15) гэдгийг санах ёстой хэмээн Тэргүүн Зөвлөл зөвлөсөн юм. Эдүгээ манай үед эцэг эхчүүд Сүмийн сургаалуудаас хүүхдүүдэд заахгүй аваас ‘уг нүгэл нь тэдгээр эцэг эхчүүдийн толгой дээр байх болой’ (С ба Г 68:25) хэмээн Их Эзэн хэлжээ.

“Эх болох гэдэг нь бараг тэнгэрлэг шинж юм. Энэ нь хүн төрөлхтний бодож таамаглах учиртай хамгийн дээд ариун үйлчлэл мөн. Энэ нь ариун нандин дуудлага хийгээд үйлчлэлийг хүндэтгэдэг тэр эмэгтэйг тэнгэр элч нарын хажууд байрлуулдаг билээ.”<sup>37</sup>

Тэргүүн Зөвлөлөөс ирсэн тэрхүү захиас бичиг хийгээд анхааруулга нь өгөгдсөн цагаасаа ч илүүтэйгээр өнөөдөр хэрэгтэй байна. Тэргүүн Зөвлөлийн дуу хоолойтой тэнцэхүйц Сүмийн ямар ч байгууллага захиргааны байр суурь хаа ч үгүй билээ.<sup>38</sup>

Төрөлхийн шинж чанар хийгээд нөхцөл байдлаас болж, гэрлэлт болон эцэг эх болох адислалуудыг олж аваагүй эсвэл гэм буруугүй хүүхдүүдээ ганцаараа хуулийн дагуу өсгөн хүмүүжүүлж, тэтгэн тэжээхээр ажиллах ёстой болсон бодгалууд мөнх оршихуй дахь—зарлигуудыг сахьдаг хүмүүст өгөгддөг—ямар ч адислалуудаас хасагдах нь үгүй.<sup>39</sup> Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн амласнаар, “Энэ нь баттай ба үүнд итгэлтэй байна.”<sup>40</sup>

### **Эрдэнэс ба Түлхүүрүүдийн тухай Сургаалт Зүйрлэл**

Би нэгэн сургаалт зүйрлэлээр дуусгая.

Эрт цагт нэгэн хүн өөрийн өв болох хоёр түлхүүрийг хүлээн авчээ. Түүнд хэлснээр нэг дэх түлхүүр нь түүнийг чадах чинээгээрээ хамгаалах ёстой нэгэн агуулахыг нээнэ. Хоёр дахь түлхүүр нь нөгөө агуулах дотор байгаа үнэлж баршгүй эрдэнэс агуулсан нэгэн мөнгөний авдарын түлхүүр байв. Тэр энэхүү авдрыг онгойлгож, тэнд хадгалсан үнэт зүйлсийг чөлөөтэй хэрэглэх ёстой байв. Түүний өв хөрөнгийг олон хүмүүс хулгайлахыг хүсч буйг түүнд анхаарууллаа. Тэр эрдэнэсийг зохистой хэрэглэвэл энэ нь мөнх бус амьдралд өсөн

нэмэгдэж мөн хэзээ ч багасахгүй хэмээн түүнд амлагджээ. Түүнийг турших ёстой байлаа. Хэрэв тэр үүнийг бусдын тусын төлөө хэрэглэсэн бол өөрийнх нь адислалууд хийгээд баяр хөөр нэмэгдэх ёстой байлаа.

Тэр хүн ганцаараа агуулах руу явж очлоо. Эхний түлхүүр үүдийг нээв. Нөгөө түлхүүрээр эрдэнэсийн авдрыг нээх гэж оролдсон боловч, тэр онгойлгож чадсангүй, учир нь авдар хоёр цоожтой байв. Түүний ганц түлхүүр үүнийг онгойлгож чадсангүй. Тэр хичнээн их оролдсон боловч, онгойлгож чадсангүй. Тэр балмагджээ. Түүнд түлхүүрүүд нь байлаа. Эрдэнэс нь эрхийн дагуу түүнийх гэдгийг тэр мэдэж байв. Тэр заавруудыг дагасан боловч, авдрыг онгойлгож чадсангүй.

Энэ үеэр нэгэн эмэгтэй агуулахад орж иржээ. Тэрээр бас түлхүүр атгасан байв. Өнөөх эрэгтэйд байгаа түлхүүрээс өөр түлхүүр байсан нь илт байлаа. Түүний түлхүүр нь нөгөө цоожинд тохирчээ. Энэ нь тэр эрэгтэй зүй ёсныхоо хөрөнгийг тэр эмэгтэйгүйгээр авах боломжгүй байсан гэдгийг сурч авахын тулд түүнийг даруусгажээ.

Тэд хамтдаа эрдэнэсийг нээж, зааварчилгааны дагуу эрэгтэй агуулахыг харж хамгаалах; мөн эмэгтэй эрдэнэсийг харж хамгаалахаар гэрээ хийжээ. Агуулахын хамгаалагч болох эрэгтэй хоёр түлхүүрийг атгаж байсанд нь эмэгтэй санаа зовоогүй байжээ, учир нь эрэгтэйн гол зорилго нь тэдний хамгийн үнэтэй зүйлсийг харж хамгаалж, эмэгтэйг аюулгүй байлгах явдал юм. Хамтдаа тэд авдрыг нээж өв хөрөнгөнөөсөө хүртэж, маш их баярлажээ, учир нь амлагдсан ёсоор энэ нь өөрөө өсөн нэмэгдсэн аж.

Агуу их баяр хөөртэйгөөр тэд эрдэнэсийг хүүхдүүдээ дамжуулан өгч болохыг мэджээ; сүүлийн үе хүртэл үл багасан, хүссэнээрээ хүн бүр хүлээн авах боломжтой байлаа.

Дараа үеийнхний хэсэг хүмүүс бие биенээ нөхсөн түлхүүр эзэмшсэн эсвээс эрдэнэстэй холбоотой гэрээнүүдээ сахих хүсэлтэй зохистой нэгэн болох хамтрагчаа олохгүй байж магад. Яалаа ч гэсэн, хэрэв тэд зарлигуудыг мөрдөн сахих юм бол тэднийг тэр ч бүү хэл, өчүүхэн адислалуудаас хасах нь үгүй билээ.

Зарим нь тэдний эрдэнэсийг үрэн таран хийхээр уруу татдаг байсан учир, тэд хүүхдүүдээ түлхүүр хийгээд гэрээнүүдийн талаар заахыг анхаарсан ажээ.

Тодорхой цаг хугацаанд дараа үеийнхний дунд хуурамч, атаархуу эсвэл хувиа хичээсэн зарим хүмүүс гарч ирж, учир нь нэгэнд нь хоёр түлхүүр өгөгдсөн байхад, нөгөөд нь зөвхөн ганц л байжээ. Хувиа хичээсэн нэгэн, “Хүсч байгаагаараа хэрэг-

лэхээр эрдэнэс яагаад зөвхөн минийх байж болдоггүй юм?” хэмээн бодлоо.

Хос түлхүүрт нь тохируулахаар тэдэнд өгсөн түлхүүрийг зарим нь дахин хэлбэрт оруулахыг оролдож байв. Ингэснээр энэ нь хоёр цоожинд таарах байх хэмээн тэд бодсон байж болох юм. Тиймээс ч авдар тэдэнд хаалттай байв. Тэдний дахин хэлбэрт оруулсан түлхүүр ямар ч хэрэгцээгүй байсан ба тэдний өв залгамжлах хөрөнгө нь алдагдсан байв.

Эрдэнэсийг талархалтайгаар хүлээн авч мөн үүнтэй хамаатай хуулиудыг дуулгавартай дагасан хүмүүс энэ амьдралд, мөн үүрд мөнхөд үргэлжлэх хязгааргүй их баяр хөөрийг мэдэж байлаа.

Би Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөг гэрчилж мөн Цагаатгалыг бий болгохоор гүйцэлдүүлсэн Түүний нэр дээр гэрчлэлээ хуваалцаж байна.

1993 оны Аравдугаар сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Пакерын хэлсэн үгнээс (Conference Report–г үз, 1993 оны Аравдугаар сар, 27–31; эсвэл *Ensign*, 1993 оны Аравдугаар сар, х. 21–24).

## ТЭМДЭГЛЭЛ

1. Сургаал ба Гэрээ 76:24–г үз; мөн Тооллого 16:22; Ром 12:9–ийг үз.
2. Сургаал ба Гэрээ 132:63–г үз; Тэргүүн Зөвлөл, “The Origin of Man” (1909 оны Арваннэгдүгээр сар), James R. Clark–ийн, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints* эмхэтгэл, 6 боть. (1965–75), 4:203; Түүнчлэн Spencer W. Kimball, “The Blessings and Responsibilities of Womanhood”–г үз, *Ensign*, 1976 оны Гуравдугаар сар, 71; Gordon B. Hinckley, Conference Report–нд, 1983 оны Аравдугаар сар, 115; буюу *Ensign*, 1983 оны Арваннэгдүгээр сар, 83.
3. *Teachings of the Prophet Joseph Smith*–г үз, сонг. Joseph Fielding Smith (1976), 348–49, 357, 365.
4. Абрахам 3:24–27–г үз.
5. Жэром 1:2; Алма 24:14; 42:5; Мосе 6:62–г үз.
6. Иаков 6:8; Алма 12:25–36; 17:16; 18:39; 22:13–14; 39:18; 42:11, 13–г үз.
7. Алма 42:8.
8. Алма 42:2–5–ыг үз.
9. 2 Нифай 9:28; Алма 12:4–5; Хиламан 2:8; 3 Нифай 1:16; Сургаал ба Гэрээ 10:12, 23; Moses 4:3–г үз.
10. *Teachings of the Prophet Joseph Smith*–г үз, 181, 297.
11. *Teachings of the Prophet Joseph Smith*–г үз, 181.
12. 2 Нифай 2:18; 28:20–ийг үз.
13. Алма 39:5; Моронай 9:9–ийг үз.
14. Сургаал ба Гэрээ 130:2; 131:2; 1 Коринт 11:11; Ефес 5:31–ийг үз.
15. Мосе 6:8–9–ийг үз.
16. Мосе 3:8–ыг үз.
17. Мосе 6:67–г үз.
18. Мосе 3:18–ыг үз.
19. Мосе 3:23–24–ийг үз.
20. Сургаал ба Гэрээ 42:22–ыг үз.
21. Мосе 4:7–12–ыг үз.
22. 2 Нифай 2:25.
23. *Cowley and Whitney on Doctrine*, эмхэтгэл Forace Green (1963), 287.
24. Мосе 2:28; мөн Эхлэл 1:28; 9:1–ийг үз.
25. Галат 5:22–23; Сургаал ба Гэрээ 4:5–6; Алма 7:23–24–ийг үз.
26. Сургаал ба Гэрээ 131:2–ыг үз.
27. “Our Wives and Our Mothers in the Eternal Plan” (Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий чуулганд өгсөн яриа, 1946 оны Аравдугаар сарын 3)–г үз, *J. Reuben Clark: Selected Papers on Religion, Education and Youth* дотор, хэвэл. David H. Yarn Jr. (1984), 62.
28. Эхлэл 1:28, тэмдэглэл 28с–ыг үз.
29. Сургаал ба Гэрээ 75:28; 1 Тимот 5:8–ыг үз.
30. Сургаал ба Гэрээ 107:40–41; мөн Сургаал ба Гэрээ 84:14–16–г үз.
31. Сургаал ба Гэрээ 121:41–42; налуу бичлэгийг нэмэв.
32. Сургаал ба Гэрээ 121:37.
33. Сургаал ба Гэрээ 84:39.
34. Сургаал ба Гэрээ 121:37.
35. *Teachings of the Prophet Joseph Smith*–г үз, 308, 367.
36. *The Discourses of Wilford Woodruff*, сонг. G. Homer Durham (1946), 25–26; налуу бичлэгийг нэмэв.
37. Conference Report–нд, 1942 оны Аравдугаар сар, 7, 11–12.
38. Сургаал ба Гэрээ 107:8–9, 22, 91–ийг үз.
39. Сургаал ба Гэрээ 137:7–9–ийг үз.
40. “Discourse by President Lorenzo Snow,” *Millennial Star*, 1899 оны Наймдугаар сарын 31, 547.



# ГЭРЛЭЛТЭД ЭВ НЭГДЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

# 2

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Эв нэгдлийн талаарх дараах судрын хэсгүүдийг унш: 1 Коринт 1:9–10; Филиппой 1:27; Моза 18:21; Сургаал ба Гэрээ 38:27. Эдгээр хэсгүүд эхнэр, нөхрийн хоорондох харьцаанд хэрхэн хамаатай байж болохыг тунгаан бод.
- Эхнэр буюу нөхөртэйгээ, та өөрсдийн цагийн хуваарьт, үүнд олон нийтийн, мэргэжлийн,

нийгмийн, бүлгийн болон Сүмийн үүргүүдийг багтаасан хэрэгцээ шаардлагуудыг ярилц. Нэг нэгнийхээ хэрэгцээг ойлгохын тулд цаг гарга, мөн бие биедээ үнэнч байх байдалд таны амласан бусад үүргүүд тань саад болохгүй байхыг баталгаажуул.

## УНШИХ ЦААЛГАВАР

Дараах өгүүлийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүлийг уншиж ярилц.

### Бид Нэг Байж Болохын Тулд

Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Хенри Б.Айринг

#### “Хэрэв Та нар Нэг Байхгүй Аваас, Та нар Минийх Биш Болой”

Энэ дэлхийн Аврагч Есүс Христ Түүний Сүмийн хэсэг болох тэдний тухайд: “Нэг байгтун; мөн хэрэв та нар нэг байхгүй аваас, та нар минийх биш болой” (С ба Г 38:27) хэмээн хэлжээ. Мөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг бүтээхдээ гэрлэлт дэх эв нэгдэлд найдах горьдлого мэтээр өгөөгүй юм; энэ нь зарлиг байв! “Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлэн, тэр хоёр нэгэн бие болох ажгуу” (Эхлэл 2:24). Тэнгэрлэг Эцэг маань зүрх сэтгэлээ нэгтгэсэн байлгахыг хүсдэг. Тэрхүү хайран дахь нэгдмэл байдал нь зүгээр нэг төгс юм биш. Энэ бол хэрэгцээ юм.

Бидний нэг байх шаардлага бол зөвхөн энэ амьдралын турш биш. Энэ нь эцэс төгсгөлгүй юм. Адам болон Ева үхэшгүй байхдаа анхны гэрлэлтээ Бурханаар цэцэрлэгт гүйцэлдүүлсэн байна. Тэр анхнаасаа эрэгтэй, эмэгтэй хүмүүст төгс төгөлдөр, зөв шударга эв нэгдэл болох гэр бүлүүдэд мөнхөд эхнэр, нөхөр болон хамтдаа нэгдэх хүслийг суулгасан юм. Тэр эргэн тойронд хүрээлж буй бүх хүмүүстэйгээ амар амгаланд амьдрах хүслийг Өөрийн хүүхдүүдэд суулгасан билээ.

Гэвч Уналтын дараа эвтэй амьдрах нь тийм ч хялбар байхгүй гэдэг нь тодорхой болж ирсэн. Эмгэнэлт явдал эрт дайрсан. Каин өөрийн дүү

Абелыг хөнөөсөн. Адам, Ева хоёрын хүүхдүүд Сатаны уруу таталтуудын гол шалтгаан болсон юм. Чадварлаг, өс хонзонт мөн овжин заль мэхтэй Сатан зорилгоо үргэлжлүүлсэн. Энэ нь бидний Тэнгэрлэг Эцэг ба Аврагчийн зорилгын эсрэг юм. Тэд төгс эв нэгдэлт байдал болон мөнхийн аз жаргалыг бидэнд өгөхийг хүсдэг. Тэдний, бас бидний дайсан Сатан Бүтээлээс өмнө авралын төлөвлөгөөг мэддэг байсан. Тэдгээр баяр хөөртэй нандин гэр бүлийн холбоонууд нь мөнхийн амьдралд л мөхөхгүйг тэр мэддэг. Сатан биднийг хайрт хүмүүсээс маань холдуулж мөн биднийг золгүй өрөвдөлтэй байлгахыг хүсдэг. Мөн тэр хүмүүний зүрх сэтгэлд хорон муу зөрчилдөөний үрийг суулгаж биднийг салан тусгаарлагдах байх хэмээн горьддог тэр мөн билээ.

Бид бүгд эв нэгдэл буюу тусгаарлалтаас ямар нэгэн зүйлийг мэдэрдэг. Хүн бусдын сонирхлыг өөрийнхөөс дээгүүрт, хайр хийгээд золиослолын хамтаар тавихыг заримдаа гэр бүлүүдэд, магадгүй өөр орчинд бид амьдралыг зэрвэсхэн харж байсан. Мөн бид бүгд тусдаа ганцаардмал байдлын уйтгар гуниг хийгээд ганцаардахын зарим нэг зүйлийг мэддэг. Бид юу сонгох ёстой вэ гэдгийг хэлүүлэх хэрэггүй. Бид мэднэ. Гэхдээ бид энэ амьдралд эв нэгдлийг мэдэрч болох ба ирэх амьдралд үүнийг мөнхөд хамт байлгахын тулд бэлтгэж болно гэдэгт бид итгэж найдах хэрэгтэй. Мөн бид тэр агуу адислал хэрхэн ирдгийг мэдэх хэрэгтэй, тэгснээр бид өөрсдийнхөө хийх ёстой зүйлийг мэдэж авч чадна.

## Аврагч Эв Нэгдлийг Боломжтой Болгодог

Тэрхүү эв нэгдэл мөн үүнийг боломжтой болгоход бидний төрөлхийн мөн чанар хэрхэн өөрчлөгдөж болох талаар дэлхийн Аврагч ярьжээ. Түүнийг нас барахаас өмнө Өөрийн Төлөөлөгчдийн хамт сүүлчийн уулзалтан дээр өгсөн залбиралд Тэр үүнийг тодорхой заасан. Тэрхүү бурханлиг сайхан залбирлыг Иоханы номонд бичсэн байгаа. Мөнхийн амьдралыг боломжтой болгох тэр аймшигтай золиослолыг Тэр бид бүхний төлөө туулах учиртай байсан. Түүний томилж, Түүний хайрлаж байсан мөн Өөрийн Сүмийг удирдуулахаар түлхүүрүүдийг хамт үлдээх тэр Төлөөлөгчдийг орхих ёстой байв. Түүнчлэн Төгс Төгөлдөр Хүү Төгс Төгөлдөр Эцэгт хандан Тэрээр Эцэгтээ залбирчээ. Аврагч болон Түүнд үйлчлэгчдийг дагадаг Тэнгэрлэг Эцэгийн маань бүх хүүхдүүдийн хүслийн адилаар бид Түүний үгсд гэр бүлүүдийг нэг болгох замыг хардаг билээ.

“Та намайг дэлхий уруу илгээсний адил Би тэднийг мөн дэлхий уруу илгээв.

“Тэд бас өөрсдөө үнэн дотор ариусгагдахын тулд Би өөрийгөө тэдний төлөө ариусгана.

“Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө бас гуйж байна.

“Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд бөгөөд мөн тэд бидний дотор байж, Таны Намайг илгээсэн гэдэгт дэлхийг итгүүлэхийн тулд билээ” (Иохан 17:18–21).

Есүс Христийн сайн мэдээ нь зүрх сэтгэлийг нэг болгож чаддагийг тэдгээр цөөн үгсээр Тэр тодорхойлжээ. Түүний заасан үнэнд итгэгч хүмүүс Түүний эрх мэдэл бүхий үйлчлэгчдийн гүйцэтгэдэг ёслолууд хийгээд гэрээнүүдийг хүлээн авч болно. Дараа нь тэдгээр ёслолууд болон гэрээнүүд дэх дуулгавартай байдлаар дамжуулж мөн төрөлхийн чанарууд нь өөрчлөгдөх болно. Тиймэрхүү арга замаар Аврагчийн Цагаатгал нь биднийг ариусгагдах боломжтой болгодог. Энэ амьдралд бид амар амгаланг байлгах ёстой ба мөнх оршихуйд Эцэг болон Түүний Хүүтэй хамт амьдрах ёстой учраас бид дараа нь эвтэй амьдарч чадна.

Тэр үеийн төлөөлөгчид болон бошиглогчдын тохинуулал нь, өнөөдрийнхтэй адил Адам, Ева хоёрын хүүхдүүдийг Есүс Христэд итгэх итгэлийн нэгдэлд авчрах ёстой байсан. Тэдний заасан мөн бидний заадаг зүйлийн үндсэн зорилго бол гэр бүлүүдийг нэгтгэх явдал мөн. Нөхрүүд, эхнэрүүд, хүүхдүүд, ач зээ нар, өвөг дээдэс хийгээд эцэст нь үүнийг сонгох нь Адам, Ева нарын гэр бүлийнхэн бүгд байх болно.

## Сүнс Бусадтай Нэгдэхэд Хөтөлдөг

Аврагчийн залбирсныг та нар санаж байгаа, “Тэд бас өөрсдөө үнэн дотор ариусгагдахын тулд—Төлөөлөгчдийг хэлж байгаа нь—Би өөрийгөө тэдний тусын төлөө ариусгана” (Иохан 17:19). Ариун Сүнс бол ариусгагч. Бид түүнийг хамтрагчаа болгож болно учир нь Их Эзэн Мелкизедек Санваарыг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан сэргээсэн юм. Тэрхүү санваарын түлхүүрүүд эдүгээ дэлхий дээр байгаа. Үүний хүчээр Ариун Сүнсийг өөрсөдтэйгөө байнга хамт байлгах гэрээнүүдийг бид хийж чадна.

Сүнсийг өөрсөдтэйгөө хамт байлгадаг хүмүүсийн орчинд бид эв нэгдэлт байдлыг хүсэн хүлээдэг. Гэрчлэлээ хуваалцдаг тэдэнтэй нэгтгэдэг тэр Сүнс бидний зүрх сэтгэлд үнэний гэрчлэлийг бий болгодог. Бурханы Сүнс хэзээ ч зөрчилдөөнийг үүсгэдэггүй (3 Нифай 11:29–г үз). Энэ нь амьдралд тэмцэж буй хүмүүсийн хооронд ялган үзэх мэдрэмжийг хэзээ ч үүсгэдэггүй (Joseph F. Smith, *Gospel Doctrine*–г үз, 5 дахь хэвл. [1939], 131). Энэ нь өөрийн хувийн амар амгалан руу мөн бусадтай нэгдэх сэтгэлийг төрүүлдэг билээ. Энэ нь бодгалиудыг нэгтгэдэг. Эв нэгдмэл гэр бүл, нэгдсэн Сүм ба энх амгалан дахь дэлхий нь нэгдсэн бодгалиудаас хамаардаг юм.

## Ариун Ёслолын Залбирал дахь Амлалтуудыг Сахих нь

Хүүхэд ч гэсэн Ариун Сүнсийг хамтрагчаа болгохдоо юу хийхээ ойлгодог. Ариун ёслолын залбирал үүнийг бидэнд хэлж өгдөг. Долоо хоног бүр ариун ёслолын цуглаануудад оролцохдоо үүнийг бид сонсдог. Энэ нандин мөчид бид баптисм дээр хийсэн гэрээнүүдээ шинэчилдэг билээ. Мөн бид Сүмийн гишүүнээр батлагдах үед бидний хүлээн авсан амлалтыг—Ариун Сүнсийг хүлээн авч болохыг Их Эзэн бидэнд сануулдаг. Эдгээр нь ариун ёслолын залбирлын үгс юм: “Тэд өөрсөддөө таны Хүүгийн нэрийг авч, мөн үргэлж түүнийг санаж, мөн түүний тэдэнд өгсөн зарлигуудыг нь дагахад бэлэн байж; тэд түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд болой” (С ба Г 20:77).

Тэрхүү гэрээг сахиснаар бид Түүний Сүнстэй байж чадна. Нэгдүгээрт, бид өөрсөддөө Түүний нэрийг хүлээн авна гэж амладаг. Энэ нь бид өөрсдийгөө Түүнийх хэмээн үзэх ёстой гэсэн утгатай. Бид өөрсдийн амьдралд Түүнийг эхэнд тавих болно. Энэ дэлхий бидэнд юуг хүсэхийг заадгийг эсвэл бидний юу хүсэж буй зүйлээс илүү Түүний юуг хүсч буйг бид хүсэх болно. Дэлхийн зүйлст анхнаасаа бид хайртай байх юм бол, бидэнд амар амгалан байхгүй байх болно. Материаллаг эд зүйлээр үндэстний тохь тух эсвээс гэр бүлд төгс

сайхан байдлыг тогтоон бий болговол эцсийн эцэст бутрах болно. (Harold B. Lee, *Stand Ye in Holy Places* [1974], 97–г үз). Их Эзэн биднээр бие биеийнхээ төлөө хийх төгс сайхан зүйл нь Түүний нэрийг өөрсөд дээрээ авахаас эхлэн Түүнийг зөнгөөрөө даган, биднийг дэлхий дээрх тэнгэрийн нэгэн хэсэг болох сүнслэг түвшинд хүргэж чадна гэжээ.

Хоёрдугаарт, бид Түүнийг үргэлж санана гэж амладаг. Түүний нэрээр залбирах болгондоо бид үүнийг хийдэг. Ялангуяа Түүнээс өршөөлийг гуйх үед Түүнийг санадаг, энэ нь бидний байнга хийх ёстой зүйл юм. Наманчлал болон өршөөлийг боломжтой болгодог Түүний золиослолыг бид яг тэр мөчид санадаг билээ. Бид гуйж байх үедээ Түүнийг Эцэгийн өмнө Өмгөөлөгчөө хэмээн дурсан санадаг. Өршөөл хийгээд энх амгалангийн мэдрэмж төрөх үед, бид Түүний тэвчээр болон Түүний төгсгөлгүй хайрыг санадаг. Тэрхүү дурсамж зүрх сэтгэлийг маань хайраар дүүргэдэг.

Бид гэр бүлийнхэнтэйгээ хамтдаа залбирахдаа, судраас суралцахдаа ч мөн адил Түүнийг дурсан санах амлалтаа сахьдаг. Өглөөний цайны үеэр хэлдэг гэр бүлийн залбиралдаа хүүхдүүд нэгнийхээ шалгалт эсвэл зарим гүйцэтгэлүүд нь тэр өдөр сайн өнгөрөн адислагдасай хэмээн залбирч болох юм. Адислалууд ирэх үед, адислагдсан хүүхэд тэрхүү өглөөний хайр хийгээд түүний нэрээр залбиралаа хэлсэн Өмгөөлөгчийн сайхан сэтгэлийг санах болно. Зүрх сэтгэлүүд хайраар хүрээлэгдэх болно.

Судраас суралцахаар гэр бүлээрээ цуглах болгонд, бид Түүнийг дурсан санах гэрээгээ бас сахьдаг. Тэд Их Эзэн Есүс Христийг гэрчилдэг, учир нь энэ нь захиас бичиг бөгөөд үргэлж бошиглогчдын захиас бичиг байлаа. Хэдийгээр хүүхдүүд үгсийг нь санадаггүй ч гэсэн тэд Есүс Христ болох жинхэнэ Зохиогчийг санах болно.

### **Бүх Зарлигуудыг Дуулгавартай Дага**

Гуравдугаарт, ариун ёслолоос хүртэх үедээ бид Түүний зарлигуудыг бүгдийг дагана гэж амладаг. Ерөнхийлөгч Бага Ж.Рюбэн Кларкийн ерөнхий чуулганы ярианд эв нэгдлийн талаар—олон удаа залбирч гуйсан шигээ—бидний дуулгавартай дагахаар өөрсдөө сонгодог зүйлүүдийн талаар сэрэмжлүүлж байв. Тэр үүнийг ийнхүү хэлжээ: “Их Эзэн бидэнд ашиггүй эсвээс шаардлагагүй ямар ч зүйлийг өгөөгүй. Авралыг олж авч болохын тулд бидний хийх хэрэгтэй зүйлээр Тэр Судруудыг дүүргэсэн билээ.”

“Бид Ариун Ёслолоос хүртэх үед Түүний зарлигуудыг сахьж, дуулгавартай дагах гэрээ хийдэг. Үүнд ямар нэгэн хасах зүйл байхгүй. Энд ямар нэгэн ялгаа зааг байхгүй” хэмээн Ерөнхийлөгч

Кларк цааш нь хэлжээ (Conference Report–нд, 1955 оны Дөрөвдүгээр сарын 10–11). Бид зөвхөн ганц нүглээ бус, бүх нүглээ наманчилсан үедээ бид бүх зарлигуудыг сахих албан ёсны чухал амлалтыг өгдөг гэж Ерөнхийлөгч Кларк заасан билээ. Хэцүү юм шиг сонсогддог ч энэ нь хэцүү биш. Бид зүгээр л Аврагчийн эрх мэдэлд захирагддаг бөгөөд Түүний зарлигласан ямар ч зүйлд дуулгавартай байна гэж амладаг (Мозая 3:19–г үз). Энэ нь гэр бүлүүд, Сүм хийгээд Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхдүүдийн хувьд холбодог Есүс Христийн эрх мэдэлд өөрсдийгөө хүлээлгэн өгөх явдал юм.

Их Эзэн тэрхүү эрх мэдлийг Өөрийн бошиглогчоор дамжуулан даруу үйлчлэгчид илгээдэг. Тэрхүү итгэл нь гэрийн багш эсвэл айлчлагч багш гэгдэх дуудлагыг Их Эзэний даалгавраар бий болгодог. Бид Түүний тушаалаар Түүнийг төлөөлөн явдаг. Нэгэн эгэл эр, өсвөр насны залуу хамтрагчтайгаа айл уруу очихдоо гэр бүлүүд нь нэгдмэл мөн тэнд хахир хатуу хандах, худал хэлэх, хов жив хөөцөлдөх, тэр ч бүү хэл, муугаар ярих нь үгүй байна гэдгийг тэнгэрийн хүч баталж өгөхөд туслана гэдэгт найдан явцгаадаг. Их Эзэний үйлчлэгчдийг дууддаг—тэрхүү итгэл нь үйлчлэгчид биднийг зэмлэхдээ ч, зэмлэж болох үед ч тэдний дутагдал, хязгаарлалтыг нь үл тоомсорлоход туслах болно. Хүн төрөлхтний дутагдал хязгаарлалтаас илүү тэдний сайн сайхан зорилгыг бид илүү тодорхой харах болно. Бид гомдлыг бага мэдрэх бөгөөд харин тэднийг дуудсан Их Эзэнд таларханыг илүү ихээр мэдрэх болно.

### **Энэрэл Эв Нэгдэлд Зайлшгүй Хэрэгтэй**

Зарим нэг зарлигуудыг зөрчих нь эв нэгдлийг устгах үндэс болдог. Зарим нь бидний юу хэлж байгаагаас болдог байхад, зарим нь бусдын хэлж буйд бидний хэрхэн хандсанаас шалтгаалдаг билээ. Бид хэний ч тухай муу зүйл ярих ёсгүй. Бид бие биеийнхээ сайныг харж мөн бие биеийнхээ тухай ярих бүрдээ сайн зүйлийг ярь (David O. McKay, Conference Report–нд, 1967 оны Аравдугаар сар, 4–11-ийг үз).

Үүний зэрэгцээ, бид нандин зүйлсийн талаар жигшмээр зүйлийг ярьдаг хүмүүсийн эсрэг байх ёстой, яагаад гэвэл тэрхүү доромжлолын нөлөө нь Сүнснийг гомдооход хүргэдэг ба түүнчлэн сөргөлдөөн хийгээд үймээнийг дэгдээдэг. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл маргахгүйгээр үүний эсрэг зогсох арга замыг үзүүлэхдээ “эмнэлгийн дамнуурга дээр хэвтэж байхад нэгэн үйлчлэгч бүтэлгүйтэхдээ Их Эзэний нэрийг дэмий дурдахад: “ ‘Болгоогтун! Энэ чинь миний Их Эзэний нэрээр та зүхэн харааж байна уу!’ Тэгэхэд тэр чив чимээгүй болж, дараа нь: ‘Намайг өршөөгөөч’ хэмээн нам дарагдсан дуу хоолойгоор

шивнэн дуугарч байсан юм” (*The Teachings of Spencer W. Kimball*, хэвл. Edward L. Kimball [1982], 198). Сүнслэг урам оруулсан, хайрын зэмлэл нь эв нэгдэлт байдлын урилга болж чадна. Ариун Сүнсээр хөтлөгдсөн үед буулт хийхгүй бол зөрчилдөөн рүү хөтлөгдөнө.

Хэрэв бид эв нэгдэлтэй байх ёстой бол бидний бодож байгаагаас үл хамааран сахих ёстой зарлигуудыг дагах ёстой. Биднийг гомдоодог хүмүүст өс хонзон саналгүйгээр уучлах ёстой. Аврагч загалмай дээр: “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаага мэдэхгүй байна” хэмээн үлгэр жишээ үзүүлсэн байдаг (Лук 23:34). Биднийг гомдоодог хүмүүсийн зүрх сэтгэлийг сайн ойлгогддоггүйн адилаар өөрсдийн уур хийгээд сэтгэлийн шархны бүх үүслүүдийг ч бид мэддэггүй билээ. Бидний амьдарч буй дэлхийд төгс төгөлдөр бус хүмүүсийг хэрхэн хайрлах талаар Төлөөлөгч Паул: “Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй, зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй” (1 Коринт 13:4–5) хэмээн хэлжээ. Дараа нь бусдын алдаанд хариу үйлдэл хийхийн эсрэг мөн өөрсдийнхөө алдааг мартдаг хүмүүсийн талаар үнэн сэтгэлээсээ тэр анхааруулахдаа: “Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно” хэмээн бичжээ (1 Коринт 13:12).

### Цэвэр Байж Бардамналаас Зайлсхий

Ариун ёслолын залбирал нь Есүс Христийн сайн мэдээний ёслолууд хийгээд хуулиудад дуулгавартай байдлаар дамжуулж эв нэгдэлт байдлын бэлэг хэрхэн ирдгийг долоо хоног бүр бидэнд сануулж чаддаг. Түүний нэрийг өөрсөддөө авч, Түүнийг үргэлж санаж, мөн Түүний бүх зарлигуудыг сахих гэрээнүүдийг дагах үед бид Түүний Сүнсийг хамтрагчаа болгон хүлээн авах болно. Тэр бидний зүрх сэтгэлийг маань зөөлрүүлж, биднийг нэгдмэл болгоно. Гэхдээ тэрхүү амлалтын хамт ирэх ёстой хоёр анхааруулга бий.

Нэгдүгээрт, хэрэв бид цэвэр байж, дэлхийн эд зүйлсд хайртай байхаас холдох л юм бол Ариун Сүнс нь бидэнтэй хамт үлддэг. Цэвэр бус байх сонголт Ариун Сүнсийг холдуулна. Сүнс нь дэлхийгээс илүү Их Эзэнийг л сонгодог хүмүүстэй орших болно. “Та нар цэвэр байгтун” (3 Нифай 20:41; С ба Г 38:42) мөн Бурханыг бүх “зүрх сэтгэлээрээ, . . . өөрийн бүх хүчин чадал, оюун ухаан хийгээд чадлаараа” хайрла гэдэг нь зөвлөгөө биш харин зарлиг юм. Мөн Сүнсний тусламжгүйгээр бид нэг байж чадахгүйн адил Сүнсийг хамтрагчаа болгох шаардлагатай байдаг.

Өөр нэг анхааруулга бол бардамналаас зайлсхийх явдал юм. Сүнсээр номхорсон тухайн гэр бүл эсвэл хүмүүст хамаатай эв нэгдэл нь агуу их хүчийг авчрах болно. Тэрхүү хүчээр дэлхийг таньж, сайшаах болно. Тэр таньж, сайшаах нь магтаал эсвэл атаархлыг төрүүлдэг тул энэ нь биднийг бардамнал руу хөтөлж болох юм. Ийм зүйл Сүнсийг гомдоож мэднэ. Үнэхээр эв нэгдэлгүй байдлын уг сурвалж болох бардамналын эсрэг хамгаалалт бий. Зөвхөн Өөрийн ээлтэй байдлын тэмдэг мэтээр Бурхан бидний дээр цутгаж буй өгөөмөр сэтгэлийг харах нь биш харин бидний эргэн тойронд буй хүмүүстэй илүү агуу үйлчлэлд нэгдэх боломж билээ. Бие биенээ ойлгохын тулд адил төстэй тал дээрээ суурилан нэг нэгэндээ мөн өөрсдийн эргэн тойрон дахь хүмүүсийн үйлчлэлд харилцан бие биенээ нөхөхийн тулд ялгаатай талуудаа ашиглан эхнэр нөхөр хоёр эв нэгдэлтэй байхыг сурдаг билээ. Иймэрхүү маягаар сургаалыг хүлээн зөвшөөрдөггүй ч Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхдүүдийг адислах хүслээ хуваалцдаг хүмүүстэй бид нэгдэж болно.

Бид дуудагдаж, адислагдахад, мөн Бурханы хүүхдүүд болоход зохистой амар тайвныг тогтоогч нь болж чадна (Матай 5:9-ийг үз).

Бурхан Эцэг амьд. Түүний хайрт Хүү, Есүс Христ бол энэ Сүмийн тэргүүн бөгөөд Тэр үүнийг хүлээн авах бүхэнд энэхүү энх тайваны тугийг санал болгож байна.

1998 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Айрингийн хэлсэн үгнээс (Conference Report, 1998 оны Дөрөвдүгээр сар, 85–89; эсвэл *Ensign*, 1998 оны Тавдугаар сар, х. 66–68-г үз).

# ГЭРЛЭЛТЭД ХАЙР БА НӨХӨРЛӨЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ

# 3

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Моронай 7:45–48–ыг судал. Энэхүү хэсэгт дурьдсан энэрлийн онцлох шинжүүдийн жагсаалтыг гарга. Амьдралдаа эдгээр онцлох шинжүүдийг сайжруулах амлалтыг өг. Эдгээр онцлох шинжүүд гэрлэлтэд хайр хийгээд нөхөрлөлийг хөгжүүлэхэд тусалж болох арга замуудыг бод.
- Долоо хоног бүр эхнэр буюу нөхөртэйгээ цагийг хамтдаа өнгөрүүлэх төлөвлөгөө зохио. Хуанли буюу дэвтэр дээр сануулга бичиж эдгээр цагуудаа төлөвлөх шаардлагатай байж магад.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### ГЭРЛЭЛТ ДЭХ НЭГДМЭЛ БАЙДАЛ

Сүмийн 12 дахь Ерөнхийлөгч,  
Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл

Ариун шударга, аз жаргалтай хийгээд амжилттай гэрлэлт нь жирийн хүн бүрийн үндсэн зорилго юм. Гэрлэлт нь магадгүй бүх шийдвэрүүдээс хамгийн амин чухал, илүү урт удаан алсад үргэлжлэх үр нөлөөтэй, учир нь энэ нь ойрын аз жаргалтай хамаатай биш, харин бас мөнхийн баяр баясгалантай хамаатай юм. Энэ нь зөвхөн хамаатай хоёр хүмүүсийг хөндөх биш мөн түүнчлэн гэр бүлүүдийг, ялангуяа хүүхдүүдийг, мөн хүүхдүүдийнх нь хүүхдүүд гээд олон үе удамд дамжин нөлөөлдөг.

Амьдрал болон мөнх оршихуйн хамтрагчийг сонгоход бүх шийдвэрүүдээс энэ нь буруу байх ёсгүй хэмээн баттай болгоход илүү их анхааралтай төлөвлөж, бодох, бас залбирч, мацаг барьсан байх ёстой. Үнэнч гэрлэлтэнд оюун ухаанаараа нэгдмэл байдгийн адилаар зүрх сэтгэлээрээ нэгдмэл байдал байх ёстой. Сэтгэлийн хөдөлгөөн нь шийдвэрүүдийг бүхэлд нь тодорхойлох ёсгүй харин мацаг барилт, залбирал хийгээд чухалчлан бодсоноор бат бөх болсон оюун ухаан болон зүрх сэтгэл нь гэрлэгсдийн аз жаргалын нэгэн туйлын их аз завшааныг өгөх болно. Энэ нь золиослол, хуваалцаж хамтрах буюу агуу их аминч бус байдлыг шаарддаг билээ.

Телевиз дэлгэцийн олон үзүүлбэр нэвтрүүлгүүд болон зохиомол түүхүүд нь: “Үүнээс хойш тэд үүрд аз жаргалтай амьдарчээ” хэмээн гэрлэлтээр төгсдөг. Нэгэн мөчийн ёслолын үйл ажиллагаа нь

аз жаргал болон амжилттай гэрлэлтийг авчирдаггүй гэдгийг бид ойлгож ухамсарласан билээ. Цахилгаан гэрлийг асаадгийн адилаар аз жаргал нэгэн товчлууур дарахад ирдэг биш; аз жаргал нь сэтгэл санааны байдал, бидний дотроос гарч ирдэг. Үүнийг олж авах ёстой. Үүнийг мөнгөөр худалдаж авах боломжгүй; юу ч өгөлгүйгээр авах боломжгүй.

Аз жаргалын тухайд зарим нь хөнгөхөн, баян тансаг, мөн байнгын сэтгэлийн гүн хөөрөлтэй сэтгэл татам амьдрал мэтээр төсөөлөн боддог. Гэтэл үнэнч гэрлэлт нь үүнээс ч илүү, өгөх, үйлчлэх, хуваалцах, золиослох, амь биеэ хайрлахгүйгээр зориулах гэх зэрэг зүйлээс үүсэлтэй аз жаргал дээр үндэслэгддэг.

Боловсрол, гэр бүлийн хүмүүжил өөр гаралтай хоёр хүн ёслолын үйл ажиллагааг удалгүй гүйцэтгэсний дараахан хүнд хэцүү бодит үнэнтэй нүүр тулах ёстой гэдгээ ойлгон сурдаг. Дахин хэлэхэд хийсвэрлэн, дүр эсгэсэн амьдрал байх нь үгүй; бид үүлэн дундаас гарч бодит амьдралд хөл тавин орох хэрэгтэй. Шинэ үүрэг даалгаварт хариуцлагатай хандах ёстой. Зарим хувийн эрх чөлөөнөөс татгалзаж, олон зохицуулалт, аминч бус нийцүүлэлтийг хийсэн байх ёстой.

Удалгүй гэрлэлтийн дараахан хэн нэг нь эхнэр буюу нөхөрт өмнө нь илрээгүй эсвэл мэдэгдээгүй сул дорой байдлыг олж мэддэг. Үерхэх явцад сайн чанаруудыг дөвийлгөн тодруулдаг байсан бол одоо харьцангуй багасаж мөн үерхэх явцад өчүүхэн, ялихгүй санагддаг байсан сул талууд нь одоо хэмжиж болохуйц хэмжээнд өсдөг байна. Зүрх сэтгэлийг ойлгох, өөрийгөө үнэлэх, ухаалгаар бодох,

ялган тунгаах, төлөвлөх цаг ирчихсэн байдаг. Олон жилийн зуршлууд одоо харагдана; эхнэр буюу нөхөр нь нарийн, харамч эсвэл үрэлгэн, өгөөмөр, залхуу эсвэл хөдөлмөрч, шүтлэгтэй эсвэл сүсэг бишрэлгүй байж магад; эрэгтэй нь нийтгэч, өгөөмөр сайхан сэтгэлтэй эсвэл шазруун, ширүүн ууртай, шахан шаарддаг эсвэл өглөгч, хувиа хичээсэн эсвэл зожиг байж магад. Хамаатан садны асуудлууд анхаарлын төвд орж ирдэг, мөн тэдэнтэй хамаатай эхнэр, нөхрийн харьцаа нь дахиад тодорч ирдэг.

Ихэнхдээ тэр даруй гарч ирдэг хүнд үүрэг даалгавруудыг тухлан сууж мөн бодож үзэхээс дургүйцэн зөрүүдлэх явдал бий. Элбэг дэлбэг амьдралыг өөр юмаар орлуулахад дурамжхан байдаг залуу хүмүүс ихэвчлэн “Жөүнсийнхнаас дутахааргүй байхыг” маш ихээр хүсэж мөрөөдөж буй мэт санагддаг. Санхүүгийн зохицуулалтыг шаардлагатай болгохоос ихэвчлэн дургүйцэн зөрүүдлэх явдал бий. Амжилт дүүрэн, азтай аавын баян чинээлэг гэр оронд төрж өссөн залуу эхнэрүүд бүх тансаг эд зүйлсийг өөрсдийн гэр оронд үргэлжлүүлэн байлгахыг байнга шаарддаг. Тэд нарын зарим нэг нь тэрхүү элбэг дэлбэг амьдралыг олж авахад туслахын тулд гэрлэлтийнхээ дараа ажил, албаа үргэлжлүүлэхийг их хүсдэг. Мэргэжил эзэмших, эсвэл бизнес хөөх үүрэг хариуцлага бууж ирэхэд тэд тогтмол гэр орноо орхидог, ингэж тогтвортой болдог эдийн засгийг байгуулснаар жирийн гэр бүлийн амьдралд буулт хийх нь маш хэцүү болдог юм. Ажил хийж буй эхнэр, нөхрийн гэр бүлд хамтын ажиллагаанаас илүү өрсөлдөөн бий болдог. Хоёр ядарсан ажилчин мэдрэлийн ядаргаа, хувийн бардамнал, биеэ даасан байдал ихэссэн байдалтай гэртээ буцаж ирдэг бөгөөд тэгээд үл ойлголцох байдал үүснэ. Бага зэргийн санал зөрөлдөөн нь асар том болж хувирдаг.

Хэцүү, зөрчилдсөн мөн бүтэлгүйтсэн гэрлэлтүүд энгийн үзэгдэл боловч бодит үнэн, үргэлжилсэн аз жаргал нь боломжтой бөгөөд гэрлэлт нь хүн төрөлхтний оюун ухаанаар төсөөлж чадахаас илүү баяр хөөр, баясгалантай байдал байж болох юм. Энэ нь гэр бүлийн хос бүрт, хүн бүрт хүртээлтэй билээ. “Санаа нэгтнүүд” гэдэг нь санаанаасаа зохиосон хий хоосон зүйл юм; залуу эрэгтэй, залуу эмэгтэй бүр хамгийн сайн таарч тохирох, сайхан амьдралтай байхад хань ижлээ хичээл зүтгэл болон залбиралтайгаар хайх юм бол, мөн ямар ч сайн эрэгтэй бас ямар ч сайн эмэгтэй хүн хоёулаа үүний төлөө зүтгэх юм бол, аз жаргал хийгээд амжилттай гэрлэлттэй байх болно гэдэг нь аль хэдийнээ тодорхой болсон юм.

Гэр бүлийн хосд аз жаргалтай хийгээд мөнхийн гэрлэлтийн баталгаа нь болох найдвартай томьёо бий; гэхдээ бүх томьёоны адилаар үндсэн бүрэл-

дэхүүн хэсгийг нь орхиж, багасган хасах эсвэл хязгаарлаж болохгүй. Үерхэхээс өмнө сонголт хийх мөн гэрлэлтийн явцад үргэлжлэх үерхэл болон гэрлэлт чухал ч, үүний амжилт нь—ганц хүнээс биш харин хоёулангаас—хоёр хувь хүнээс шалтгаалдаг билээ.

Үргэлжилж буй гэрлэлт нь өмнө дурьдсан боломжийн жишгүүд дээр үндэслэгдсэн байхад эхнэр, нөхрүүдийн аль нэгийнх нь эсвэл хоёулангийнх нь дотор байдаг хүчээс өөр үүнийг сүйтгэх хосолсон хүч байхгүй билээ. Мөн тэд хариуцлагыг ерөнхийд нь тааварлах ёстой. Бусад хүмүүс болон бизнесийн байгууллагууд сайнаар эсвэл муугаар нөлөөлж болно. Санхүү, нийгэм, улс төрийн болон бусад нөхцөл байдал нь холбоо хамааралтай санагдаж магад; гэхдээ хэрэв эхнэр, нөхөр хувиа хичээдэггүй мөн үнэнч шударга шийдэмгий байх аваас гэрлэлтээ амжилттай, аз жаргалтай болгохыг үргэлж зорьдог эхнэр, нөхөр хоёроос анхнаасаа мөн үргэлж шалтгаалдаг.

Томьёо нь маш хялбар; бүрэлдэхүүн хэсэг нь хэдхэн байдаг ч гэсэн, нэг бүр нь дэлгэрэнгүй олон тайлбартай байдаг.

Нэгдүгээрт, ханиа сонгох гэж байгаа хувь хүмүүст хамаатай бүх үйл хэргийн төгс байдлын оргилд аль болох ойртож байгаа хүмүүст тохирсон арга барилууд байх ёстой байх. Мөн дараа нь тэдгээр хоёр тал энэхүү амжилттай хамтын амьдрал өөд маш их хөдөлмөрлөх ёстойг ойлгон ухамсарласнаар, ариун сүмийн тахилын ширээнд ирэх ёстой.

Хоёрдугаарт, бүх гэр бүлийн амьдралыг удирдан залах мөн өөрийн аминч хүслийг даван туулж, түүнчлэн гэр бүлийн сайн сайханд хамаатай бүх зүйлд хувиа үл бодон өөрийгөө мартаж ёстой.

Гуравдугаарт, хайрыг бодитойгоор өсгөн хадгалахын тулд анхаарал, сайхан сэтгэл хийгээд хайрын илрэлүүд мөн амьд үерхэл байх хэрэгтэй.

Дөрөвдүгээрт, Есүс Христийн сайн мэдээнд тодорхойлсон Их Эзэний зарлигуудыг бүрэн дүүрэн дагаж амьдарч байх ёстой.

Эдгээр ажиллагаа хангасан, зохистойгоор хосолсон бүрэлдэхүүн хэсгүүдийн хамтаар уйтгар гуниг ирэхгүй, үл ойлголцох байдал нь үргэлжлэхгүй эсвэл салж сарних нь бараг боломжгүй юм. Гэрлэлтийг цуцлах хуульчид өөр салбарт шилжих хэрэгтэй болж, гэр бүлээ цуцлах шүүх хурлууд оршин тогтнохоо болино.

Ариун сүмийн гэрлэлтийн тахилын ширээнд дөхөж буй хоёр хүн хүсэн найдаж байгаа тэр аз жаргалтай гэрлэлтийг хүртэхийн тулд, хууль ёсны гэрлэлт бол хууль зүйн хүрэн дэх зүйл биш, харин энэ нь золиослол, хамтран хуваалцах ба хувийн эрх чөлөө, дур зоргоороо байдлаа багасгах

гэсэн утгатай гэдгийг тэд ухааран ойлгож байх ёстой. Энэ нь урт удаан хугацаагаар маш их арвич хямгач байхыг хэлнэ. Энэ нь хүүхдүүд, санхүүгийн хүндрэл, үйлчлэлийн ачаалал, хайр халамж, мөн санаа зовж түгшээх бэршээл зэргийг авчирна гэсэн үг боловч, басхүү юм бүхний цаадах хамгийн гүн гүнзгий, сайхан сэтгэл хөдлөлдүүд гэсэн үг юм.

Гэрлэлтээс өмнө бүх шийдвэрүүдийг гаргах, хамгийн сайн гэж санагдахаар амьдралаа зохион байгуулж, төлөвлөх, мөн хүссэнээрээ явж ирэх нь хувь хүн бүрт нэлээд чөлөөтэй байдаг. Дурлалт хосууд тангараг өргөхөөсөө өмнө, бяцхан шинэ гэр бүлийн сайн сайхан нь эхнэр, нөхөр хоёр бие биедээ хамгийн сайнаар хандах явдал гэдгийг хоёулаа хүлээн зөвшөөрч ухаарсан байх ёстой. Хоёр тал хоёулаа “Би” буюу “миний” гэдгээ багасгаж, үүний оронд “бид” буюу “манай” гэдгээр орлуулдаг байх ёстой. Энэ нь хоёр эсвэл түүнээс дээш хүмүүст нөлөөлдөг учир, шийдвэр бүрийг анхааран авч үздэг байх ёстой. Эхнэр хүн тэр үндсэн шийдвэрүүдийн талаар тунгаан бодож эхэлбэл эцэг, эх, үр хүүхдүүд гэр орон болоод тэдний сүнсний амьдрал дээр гарч ирсэн үр дүнгийн нөлөөний талаар санаа нь зовних болдог. Нөхрийн ажил алба, түүний нийгэм дэх амьдрал, найзууд нь болоод түүний сонирхол бүрийн сонголтыг онцгойлон авч хэлэлцсэн байх ёстой. Учир нь гэр бүлийн ихэнх хэсэг түүнд найдаж байдаг болохоор тэрээр гэр бүлийн нэгээхэн хэсэг нь юм.

Гэрлэлт нь үргэлж тэгш, өө сэвгүй мөн хүндрэл бэрхшээлгүй байдаггүй ч гэсэн энэ нь асар их тайвшрал байж чадна. Гэр бүлийн хос нь ядуурал, өвчин зовлон, гансрал гунихрал, алдаа тэр ч бүү хэл гэр бүл нь үхэл хагацалтай тулгарч мэднэ, гэвч эдгээр нь амар амгаланг хясахгүй. Аминч үзэл үүнд халдахгүй л юм бол гэрлэлт амжилттай байж чадна. Хэрэв ямар ч хувиа бодсон бодол байхгүй аваас гай зовлон мөн хүндрэл бэрхшээлүүд нь эцэг эхчүүдийг хамтад нь тарж бутрахааргүй эв нэгдэлтэй болгодог. 1930–аад оны эдийн засгийн бууралтын үеэр гэр бүл салалт мэдэгдэхүйц багассан байна. Ядуурал, уналт, сэтгэлээр унах нь—эцэг эхчүүдийг хамтад нь холбож байжээ. Гай зовлон гэр бүлийн харьцааг бэхэлж байхад чинээлэг хангалуун байдал устгах магадлалтай.

Аминч үзэл бодол дээр үндэслэгдсэн гэрлэлт бутрах нь бараг тодорхой байдаг. Хөрөнгөнөөс нь болж гэрлэдэг, эсвэл нэр хүнд буюу нийгмийн байр сууринаас болж гэрлэдэг хүний урам хугарах нь лавтай. Бардамнал буюу бахаа хангахаар гэрлэдэг, эсвэл өс хонзон буюу өөр хүнийг зовоохоор гэрлэдэг хүн, зөвхөн өөрийгөө хуурч байгаа хэрэг юм. Харин аз жаргалыг өгч бас хүлээн авахаар мөн үйлчлэл хийж, бас хүлээн авахын тулд, мөн хоёр биенийхээ хүсэл сонирхлыг

авч үзэхээр гэрлэдэг нэг нь гэр бүлтэй болсныхоо дараа гэрлэлт нь нэгэн аз жаргалтай мөч болох тул, сайхан боломжийг олох болно.

Хайр бол цэцэг шиг мөн бие махбод мэт байнга тордогдох ёстой. Мөнх бус бие махбод нь хэрэв байнга тэжээгдэхгүй байсан бол удахгүй турж эцэн, үхэх байсан. Уяхан эмзэг цэцэг тэжээл усгүй байсан бол хатаад үхчих байсан. Тиймээс хайрыг ч гэсэн хайрын бага хэсгээр, бишрэл хүндэтгэлийн тунхаглал, талархлын илэрхийлэл хийгээд аминч бус байдлын анхаарал халамжаар байнга тэтгэн тэжээхгүй юм бол, мөнхөд үргэлжилнэ гэж бодох боломжгүй гэсэн үг.

Амь биеэ хайрлахгүйгээр зориулдаг, аминч бус байдал нь амжилттай гэрлэлтийн бас нэгэн өөр хөдөлгөх хүчийг олж авах нь лавтай. Хэрэв нэг нь нөгөөгийнхөө сонирхол, амар тайван хийгээд аз жаргалыг мөнхөд эрэлхийлдэг бол, үерхэлд олдсон болоод гэрлэлт дотор бэхжүүлэгдсэн хайр нь хүчирхэгжин их хэмжээтэйгээр өсөж том болно. Олон хосууд гэрлэлтийнхээ шинэлэг чанарыг алдагдуулан, хайраа хөрч гүйцсэн болгож, эсвээс тоглоом шоглоомд идэгдсэн, хүйтэн царцанги байдалтай болгодог. Хайрын нэн чухал тэжээл бол анхаарал, сайхан сэтгэл, халамж, санаа тавилт, хайрын илрэлүүд, талархлыг өөртөө агуулах, бишрэл, бахархал, хамтач үзэл, өөртөө итгэх итгэл, харилцан итгэлцэл, нөхөрлөл, нэгдмэл шинж мөн харилцан хамаарал юм.

Гэрлэлтдээ үнэхээр аз жаргалтай байхын тулд тухайн хүн Их Эзэний зарлигуудыг үргэлжлүүлэн үнэнчээр дагах ёстой билээ. Ганц бие эсвээс гэрлэсэн хэн ч зөв шударга биш байсан бол хэзээ ч байгаагүй тийм их дээдийн аз жаргалтай байхгүй. Түр зуурын сэтгэлийн таашаал болон хуурамч нөхцлүүд тэрхэн мөчид байдаг ч, байнгын тогтонги бүрэн дүүрэн аз жаргал нь зөвхөн цэвэр хийгээд зохистой байдлаас үүдэн гарч ирэх чадвартай юм. Шашны хатуу шүтлэгтэй, сүсэг бишрэлийн хэв, маягаар амьдарч байгаа хүн идэвхгүй амьдралд хэзээ ч аз жаргалтай байж чадахгүй. Үүнийг бүрмөсөн орхихгүй юм бол ухамсар нь үргэлжлүүлэн зовоож, шаналгах ба иймэрхүү нөхцөлд гэрлэлт аль хэдийнээ аюулд учирдаг билээ. Дотроос хатгаж буй ухамсар нь амьдралыг хамгийн тэвчишгүй, тэсвэрлэшгүй болгож мэднэ. Идэвхгүй байдал гэрлэлтэнд хор хөнөөлтэй, ялангуяа хоёр тал янз бүрийн байдлаар идэвхгүй байхад нөлөөлнө.

Шашны хувьд ялгаатай байна гэдэг бол хамгийн төвөгтэй байдаг, тэр тусмаа бүх санал зөрөлдөөний дунд хамгийн шийдвэрлэгдэшгүй нь юм.

Гэрлэлт Бурханаар томилогддог. Энэ нь зөвхөн нийгмийн ёс жаяг биш. Зөв зохистой хийгээд амжилттай гэрлэлтгүйгээр хүн хэзээ ч өргөмжлөг-

дөхгүй. Гэрлэх нь зөв мөн зүй ёсны зүйл хэмээдэг Их Эзэнийхээ үгсийг унш.

Энэ нь үнэн ба хайр халамжтай бас ухаалаг Хожмын Үеийн Гэгээнтэн хүн зам дахь ямар ч саад тотгоргүй эсэхийг баттай болгон анхаарал-тайгаар амьдралаа төлөвлөх болно. Нэг л ноцтой алдаа гаргаснаар, хүн хэзээ ч зайлуулагдаж үл болох, түүнчлэн мөнхийн амьдрал хийгээд шүтэн биширдэг зүйл—бидний хувь заяанд хүрэх замыг халхалж болох саад бэрхшээлүүдийг бий болгоно. Хэрэв хоёр хүн Их Эзэнийг амьдралаасаа илүү хайрладаг бол, үндсэн бүтэц болох сайн мэдээний хөтөлбөрийн хамтаар бүрэн дүүрэн хөг аяс нийлж ажиллан бие биенээ амьдралаасаа илүүтэйгээр хайрлан, энэхүү агуу их аз жаргалыг олохдоо итгэлтэй байдаг. Эхнэр, нөхөр хоёр байнга хамтдаа ариун сүм рүү явдаг, гэртээ гэр бүлээрээ өвдөг сөгдөн хамтдаа залбирдаг, шүтлэг бишрэлийн цуглаануудад гар гараасаа хөтлөлцөн очдог, амьдралаа бүхэлд нь—оюун ухаан, бие махбодын хувьд—цэвэр ариун байлгаж, ингэснээр бүх бодол санаа, хүсэл болон хайр нь хамтрагч болох нэг хүн дээр бүгд төвлөрсөн байх ба хоёулаа Бурханы хаант улсыг хөгжүүлэхэд хичээн чармайх ёстой, дараа нь аз жаргал нь үүний оргил цэгт хүрнэ.

“Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш, харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой” (С ба Г 42:22) хэмээн Их Эзэний хэлсэн үнэн зүйлээс гадна гэрлэлтэд заримдаа нэгдэн нийлэх өөр зүйл бий.

Энэ нь бараг бүхэлдээ “Чи нөхрөө бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой” гэсэн утгатай. Хүмүүс өөрийн эцэг эх, найз нөхөдтэйгээ нэгдэн нийлэхээ үргэлжлүүлэх нь олонтаа тохиолддог юм. Заримдаа эхчүүд хүүхдүүдийнхээ дээр тавьсан эрх мэдлээ сулруулдаггүй ба эхнэр нөхрүүд эцэг эх рүүгээ зөвлөгөө зөвлөмж авахаар очиж, нууцаа дэлгэхээр очдог ч гэлээ, ихэнх зүйл дээр эхнэртэйгээ нэгдэн нийлж байх ёстой бөгөөд бүх

дотночлол нь өндөр нууцлал хувийн шинжтэйгээр хадгалагдсан байх ёстой.

Гэр бүлийн хосууд хоёр талын хадмаасаа тусдаа гарч, орон гэрээ тэр даруй олж авдаг. Тэдний гэр орон маш энгийн, даруухан байж магад, гэхдээ л энэ нь бие даасан байнга оршин суух хаяг нь юм. Гэрлэснээс хойш та нар бие биенийхээ төрөл төрөгсдөөс бие даан, тусдаа гарсан байх хэрэгтэй. Та тэднийг урьд өмнө байснаасаа илүү хайрлана; тэдний зөвлөгөөг өндрөөр үнэлнэ; харилцаа холбоотой байхад нь та талархана; гэхдээ өөрийн гаргасан шийдвэрүүдийн дагуу, зөвлөгөө өгөх ёстой хүмүүсээс зөвлөгөө авсны дараа хувийн залбирлаараа анхааран үзэж өөрийн амьдралаар амьдрах л болно. Нэгдэн нийлэх гэдэг нь зөвхөн нэг гэрт сууж эзэмшихийн нэр биш; энэ нь ойртож нийлэх, хамт байх гэсэн утгатай:

“Иймийн тул, . . . мөн хоёул нэг махбод байх нь хууль ёсны байх болно, мөн энэ бүгд нь өөрийн бүтээлтийн зорилгыг дэлхий хэрэгжүүлж болохын тулд буюу;

“Мөн ийнхүү дэлхий бий болгогдохоос өмнөх түүний бүтээлтийн дагуу энэ нь хүмүүний тоо хэмжээгээр дүүргэгдэх болно” (С ба Г 49:16–17).

Ах эгч нар аа, энэ нь Их Эзэний үг гэдгийг би хэлмээр байна. Энэ нь үнэхээрийн үнэн, Их Эзэнтэй маргах хэн ч байхгүй билээ. Тэр газар дэлхийг бүтээсэн; Тэрбээр хүмүүнийг бүтээсэн. Тэр нөхцөл байдлыг мэддэг. Тэрбээр хөтөлбөрийг зохион байгуулсан бөгөөд эдгээр чухал зүйлсийн талаар түүнтэй маргаж чадахаар хангалттай мэдлэг буюу оюун ухаан бидэнд байхгүй. Тэр аль нь зөв, аль нь үнэнийг мэддэг билээ.

Эдгээрийн талаар та бүхэн бодоорой гэж бид хүсэж байна. Гэрлэлт тань зөв байгаа эсэхийг анхаар. Амьдрал тань зөв байгаа эсэхийг анхаар. Гэрлэлт дэх танаас шалтгаалах үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа эсэхээ та анхаар.

1977 оны Гуравдугаар сарын *Ensign*-аас, хуудас 3–5



# ГЭРЛЭЛТ ДЭХ БЭРХШЭЭЛҮҮДЭД ХАНДАХ ХАНДЛАГА

# 4

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Доорх унших даалгаварт Ахлагч Линн Ж.Роббинс нэгэн "гай гамшигт зориулсан жорыг" тайлбарлана. Энэхүү хуудас дээрх түүний тайлбарыг унш. Дараа нь гэр оронд нийцэл зохицлыг бий болгох зааврыг хөгжүүлэн зохио. Иймэрхүү зааварт өөрийн багтаах "бүрэлдэхүүн хэсгүүдийг" тодорхойл.
- Бэрхшээлүүдэд уур хилэнгээс илүү тэвчээр хийгээд хайраар хандах амлалтыг өг. Энэхүү

амлалтыг танд байнга сануулахаар хийж болох ямар нэгэн зүйлийг та шийдэж бод. Жишээ нь: та гутал дотроо нэгэн зоосыг эсвэл өөр жижиг зүйлийг хийж болно мөн өөртөө зориулан зурвасыг халаасандаа хийж хадгал.

- *Family Home Evening Resource Book* (31106) has not been translated in our language.

## УНШИХ ЦААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### СОНГОЛТ БА УУР ХИЛЭН

Далын  
Ахлагч Линн Ж.Роббинс

#### Сатан Гэр Бүлүүдийг Уур Хилэнд Өдөөн Хатгадаг

"Энэ газар дэлхийд надад өөрийн гэр бүл байдаг. *Намайг тэд хайрлан дэмждэг.*" Энэхүү хүүхэд бүрийн итгэл найдварыг манай дууллын нэгний үгсээр илэрхийлсэн байдаг. ("*Families Can Be Together Forever,*" *Hymns*, дугаар 300; налуу бичлэгийг нэмэв).

Бид гэр бүлийн тунхгаас "гэр бүл нь Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдаг" бөгөөд "нөхөр, эхнэр хоёр бие биенээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээдэг," "хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлэх нандин үүрэгтэй" гэдгийг сурч мэддэг ("Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг," *Ensign*, 1995 оны Арваннэгдүгээр сар, 102).

Гэр бүл нь мөн Сатаны гол бай юм. Тэрбээр гэр бүлд хэрүүл маргааныг дэгдээдэг. Түүний нууц төлөвлөгөөний нэг нь нарийн бөгөөд залт аргаар дайсны шугамын араас гэтэж бидний гэр орон болон амьдралд орох явдал юм.

Тэрээр ихэнхдээ гэр бүлүүдийг гэр орон дотор нь сүйтгэдэг. Түүний хэтийн бодлого нь гэр бүлийн гишүүдийн дунд уур хилэнг бий болгох явдал юм. Сатан бол "зөрчилдөөний эцэг мөн тэрбээр

хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг билээ" (3 Нифай 11:29; налуу бичлэгийг нэмэв). Өдөөх буюу хутгах гэдэг үйл үг нь гай гамшигт зориулсан жор мэт сонсогдоно: Уур уцаараа дунд зэргийн халуун дээр тавиад, сонгосон хэдхэн үгээ хийж хутгаад, буцалгаж, өтгөн болтол нь үргэлжлүүлэн хутгана; дараа нь хөргөж, санаа сэтгэлээ хэдэн өдөр хүйтрүүлж, хүйтнээр хэрэглэ; маш их хоолны үлдэгдэл байх болно.

#### Бид Уурлахгүй Байхаа Шийдэж Болно

Түүний хэтийн бодлогын залт мэхт, чадварлаг нэг хэсэг бол сонголтоос уур хилэнг салгаж, бидний хянаж чадахгүй байгаа тэр сэтгэлийн хөдөлгөөний золиос нь гэж бидэнд итгүүлдэг. "Би уурлаад хаясан," гэж бид сонсдог. Хэн нэгэнд уурлаад хаясан гэдэг нийтлэг хэрэглэдэг өвөрмөц хэллэг нь сонирхолтой үгсийн сонголттой билээ. "Ямар нэгэн юм хаях" гэдэг нь "утга илэрхийлдэггүй," "гэнэтийн," "сайн дурын биш," "хариуцлагагүй"—магадгүй болгоомжгүй гэхдээ "хариуцлагагүйг" илэрхийлж байгаа юм.

"Тэр намайг уурлуулсан." Энэ бол бидний сондог бас нэг өөр үг хэллэг, мөн адил сонголт буюу хяналт дутмаг гэсэн битүү утгыг илэрхийлж байгаа юм. Энэ нь юмыг чухал бус болгодог домог юм. Хэн ч биднийг ууртай болгодоггүй. Бусад хүмүүс биднийг уурлуулдаггүй. Үүнд оролцсон ямар ч хүч байдаггүй. Ууртай болох гэдэг нь ухамсар-

тай сонголт мөн шийдвэр юм, тиймээс бид уургүй байх сонголт хийж чадна. *Бид* л сонгоно!

“Гэхдээ би өөрийгөө хянаж чадахгүй,” гэж хэлдэг тэдгээр хүмүүст зохиолч Виллиам Вилбанкс, “Ямар ч утгагүй юм” гэж хариулжээ.

“Түрэмгий зан авир, . . . уур уцаараа нуух, үүний тухай ярих, орилох мөн хашгичих нь,” бүгд ууртай харьцах харьцааны сурсан арга барилууд мөн. “Өнгөрсөн үед бидэнд үр дүнтэй байснаа нотлон харуулсан нэг арга барилыг бид *сонгодог*. Захирлаасаа болж цухалдахдаа хэрхэн хааяа хяналтаа алдаж байснаа, харин найз нөхөд буюу гэр бүлээсээ залхахдаа хэрхэн үргэлж хяналтаа алдаж байснаа бид анзаарч байсан уу?” (“The New Obscenity,” *Reader’s Digest*, 1988 оны Арванхоёрдугаар сар, 24; налуу бичлэгийг нэмэв).

Вилбанкс хоёрдугаар курсын оюутан байхдаа дунд сургуулийн сагсан бөмбөгийн багт орохоор хичээхэд, түүнийг багтаа авчээ. Дасгалжуулалтын эхний өдөр багийн дасгалжуулагч түүнийг нэг тоглогчийн эсрэг тоглууллаа. Тэр үеэр баг нь ажиглаж байлаа. Тэгэхэд нэгэн амархан гоолыг тэрээр алдахдаа уурлаж, хөлөө дэвсэн, яншихад дасгалжуулагч түүнд дөхөн ирж, “Дахиад ингэж аашлах юм бол, чи хэзээ ч манай багт тоглохгүй” хэмээн хэлсэн аж. Дараагийн гурван жилийн турш тэр дахин хяналтаа сулруулсангүй. Олон жилийн дараа, тэрээр өөрийнхөө болсон явдлыг эргэцүүлэхдээ дасгалжуулагч нь амьдралыг өөрчлөх зарчимыг тэр өдөр түүнд заасан гэдгийг ухааран ойлгожээ: уурыг хянаж болно (“The New Obscenity,” 24).

### Их Эзэний Заасан Сургаалууд

Ефес 4:26-гийн Иосеф Смитийн Орчуулганд “Та ууртай байж нүгэл үйлдэхгүй байж чадах уу?” хэмээх асуултыг Паул асуусан байдаг. Их Эзэн ийнхүү асуудалд маш тодорхойгоор:

“Зөрчилдөөний сүнстэй тэр нь надаас бус, харин зөрчилдөөний эцэг болох тэр чөтгөрөөс болой, мөн тэрбээр хүмүүний зүрх сэтгэлийг нэг нэгэндээ уурлан зөрчилдөхөд өдөөн хатгадаг билээ.

“Болгоогтун, хүмүүний зүрх сэтгэлийг нэг нь нөгөөгийнхөө эсрэг уураар өдөөн хатгах нь миний сургаал бус, харин иймэрхүү зүйлүүд зайлуулагдана гэдэг нь миний сургаал бөлгөө” гэв (3 Нифай 11:29–30).

Их Эзэнээс ирж буй энэхүү сургаал буюу зарлиг нь сонголтыг урьдчилан төсөөлж, шийдвэр гаргахдаа ухаалгаар хандахыг уриалж байдаг. Их Эзэн биднийг уурлах сонголтыг *хийхгүй* гэдэгт найддаг.

Түүнчлэн ууртай байхыг зөвтгөдөггүй. Матай 5-ын 22-р шүлэгт, Их Эзэн хэлэхдээ: “Харин би

та нарт хэлье, ах дүүдээ *учир шалтгаангүйгээр* хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай” (налуу бичлэгийг нэмэв). “Учир шалтгаангүйгээр” гэдэг хэллэг бурханлиг нөлөөгөөр дамжуулан ирсэн Иосеф Смитийн Орчуулганд ч (Матай 5:24-г үз) мөн 3 Нифай 12:22-р шүлэгт ч байхгүй байгаа нь ямар сонирхолтой хэрэг вэ. Их Эзэн “учир шалтгаангүйгээр” гэдэг хэллэгийг хасаад, Тэрээр өөрсдийгөө уучлан зөвтгөх ямар ч боломжгүй байдалд биднийг оруулж, “харин иймэрхүү зүйлүүд зайлуулагдана гэдэг нь миний сургаал бөлгөө” (3 Нифай 11:30) гэжээ. Бид уур хилэнг Түүний бидэнд ийнхүү сургаж, зарлигласан ёсоор “зайлуулж” болно.

### Уур Хилэн нь Сатаны Нөлөөд Автамтгай

Бие барих чадвараа алдсанаар уур хилэн нь Сатаны нөлөөнд автдаг. Энэ нь дайсагнах үзэл буюу үйлдэл рүү хүргэдэг нүгэлт бодол юм. Энэ нь хурдны зам дээр ууртай давхих, спортын дэвжээн дээр дүрэлзтэл уурлах мөн гэр оронд гэрийн нөхцөлд хүчирхийллийг үүсгэхэд хүргэдэг юм.

Жолоогүй уур уцаар нь зөөлөн зүрх сэтгэлд сорви үлдээж мэдэхээр харгис хэрцгий үгс болон бусад хэлбэрээр сэтгэл санааг элдвээр хараахад хүргэдэг, дэлбэртлээ уурлахыг тэр даруй өдөөн хатгадаг билээ. Энэ нь Аврагчийн хэлсэнчлэн: “амнаас гарч буй нь хүнийг бузарладаг юм” (Матай 15:11).

“Гэр орон тань галд автаагүй л юм бол, эхнэр нөхрүүд нэг нэгэнтэй хэзээ ч дуугаа өндөрсгөн ярьцгаахгүй бай” хэмээн Давид О.МакКей хэлсэн байдаг (*Stepping Stones to an Abundant Life*, зохиол. Llewelyn R. McKay [1971], 294).

Бие махбодын хүчирхийлэл нь ууртай догшин хүнд байдаг, үүнийг хэзээ ч зөвтгөдөггүй мөн үргэлж шударга бус байдаг.

Уур хилэн нь өөр хүнийг буруутай болгон мэдрүүлэх эелдэг бус оролдлого аль эсвэл тэднийг зөв болгон засах гэж буй хэрцгий арга барил юм. Үүнийг ихэвчлэн хүмүүжил хэмээн буруу нэрлэдэг боловч бараг үргэлж эсрэг үр дүнд хүргэдэг. Тиймээс “Нөхрүүд ээ, эхнэрээ хайрлагтун. Тэдэнд бүү хатуу ханд,” “эцгүүд ээ, хүүхдийнхээ сэтгэлийг мохоохгүйн тулд тэднийг бүү уурлуул” гэсэн сүнслэг сануулга болно (Колоссай 3:19, 21).

### “Би Дахид Хэзээ ч Уурлахгүй”

Сонголт болон хариуцлага гэдэг салшгүй зарчмууд юм. Уур хилэн нь сонголт учраас тунхагт зааснаар “хань ижил, үр хүүхэдтэй зүй бусаар харьцсан . . . хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэх болно” хэмээх хатуу анхааруулга бий.

Сонголт болон уур хилэнгийн хоорондох холбоог ойлгох нь амьдралаасаа уур хилэнг арилгах анхны алхам юм. Бид уурлахгүй байхыг шийдэж болно. Тиймд бид өнөөдөр, яг одоо: “Би дахин хэзээ ч уурлахгүй” хэмээх сонголтыг хийж болно. Энэхүү шийдвэрийг тунгаан бод.

Сургаал ба Гэрээний 121-р бүлэг нь зөв удирдах зарчмыг суралцах бидний эх сурвалжуудаас хамгийн сонгодог нь юм. Магадгүй 121-р бүлгийн хамгийн чухал анхааруулга нь эхнэр нөхрүүдэд мөн эцэг эхчүүдэд хандсан билээ. Бид гэр

бүлүүдээ сэнхрүүлээр, тэсвэр тэвчээр, эелдэг зөөлөн хийгээд номхон дөлгөөнөөр, чин сэтгэлийн хайраар удирдан чиглүүлэх ёстой ажгуу (С ба Г 121:41–42-ыг үз).

Энэ газар дэлхий дээр ач тустай гэр бүлтэй болох талаар хүүхэд бүрийн мөрөөдөл биелэх болтугай.

1998 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Роббинсийн хэлсэн үгнээс (Conference Report, 1998 оны Дөрөвдүгээр сар, 105–6; буюу *Ensign*, 1998 оны Тавдугаар сар, 80–81-г үз).

# ЭЭРЭГ ХАРИЛЦААГААР ДАМЖУУЛАН БЭРХШЭЭЛҮҮДЭД ХАНДАХ ХАНДЛАГА

5

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Доорх унших даалгаварт Ахлагч Жөү Ж.Крисченсен: “Тогтмол шүүмжлэл буюу яншин үглэхийн үр дүнд урьд өмнө нь хэдхэн хүн өөрчлөгдөж байсан. Хэрэв бид болгоомжтой байхгүй л юм бол зарим бидний *засан залруулах* мэтээр хүссэн шүүмжлэл нь ихэнхдээ *эвдэн сүйтгэдэг*. Зарим тохиолдолд, зарим зүйлийн тухайд юу ч ярилгүйгээр орхих нь илүү дээр байдаг” гэдгийг ажиглажээ (хуудас 20-ыг үз). Ирэх долоо хоногт та бусдын талаар бодож мөн ярьж буй зүйлүүдэд

сайтар анхаарлаа хандуул. Та өөрийнхөө хэлдэг бүх зүйлд баярлаж бахдан, сайхан сэтгэлээр хандах чармайлт хий.

- Эхнэр нөхрийнхээ биширмээр, гайхалтай шинж чанаруудыг олж хай. Эдгээр шинж чанаруудын жагсаалтыг гаргаж, эхнэр буюу нөхөртэйгөө хуваалц.

## УНШИХ ЦААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### ГЭРЛЭЛТ БА АЗ ЖАРГАЛЫН АГУУ ИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Далын  
Ахлагч Жөү Ж.Крисченсен

Барбара бид хоёр зургаан хүүхэдтэй болж адислагдсан. Хэдэн жилийн өмнө, бид тэднийг бүгдийг нь эмээ өвөө нараар нь айлчлуулахаар аваад ирэхэд, манай аав, “Жөү, Барбара та хоёрын зогсоож чадахгүй байдаг ямар нэгэн зүйлийг эхлүүлсэн гэж би бодож байна” гэв.

Улаан Өндөгний Баярын улирлаар бид дэлхий даяар Есүс бол Христ мөн, Түүний ариун санваараар мөн үүний лацдах хүчээр дамжуулан, гэрлэлтүүд хийгээд гэр бүлүүд нь хэзээ ч зогсох ёсгүй—хэзээ ч төгсөшгүй гэдгийг тунхагладаг.

Эдүгээ би та бүгдэд гэрлэлтийн талаар ярихыг хүсэж байна. Одоо мөн ирээдүйд гэрлэлтийг маань хүчирхэгжүүлж болох үнэ цэнэ бүхий мөн итгэл найдварыг агуулсан амьдралын найман зөвлөгөө өгье.

### Гэрлэлтийн Ач Холбогдлыг Сана

1. Гэрлэлтийнхээ гол ач холбогдлыг сана. Тэнгэрлэг Эцэгийн маань “аз жаргалын агуу их төлөвлөгөөн” (Алма 42:8) дэх гэрлэлтийн ач холбогдолын талаар Ахлагч Брюс Р.МакКонкийн хэлсэн эдгээр үгсийг сонс. Үүнд:

“Зуурдын амьдралд, төрөх цагаас бид ариун сүмд гэрлэх тэр цаг хүртэл, тэр бүхэл бүтэн сайн мэдээний системд байгаа бүхэн маань энэ амьдралд хийгээд ирэх амьдралд эхнэр нөхөр болгох тэрхүү гэрлэлтийн ариун нандин зарлигийг сахиулахаар биднийг сайжруулан бэлтгэдэг. . . ”

“Гэр бүлийн нэгдлийг бүтээн үүсгэж мөн төгөлдөржүүлэхээс илүү чухал зүйл гэж энэ дэлхийд байхгүй” (“Salvation Is a Family Affair,” *Improvement Era*, 1970 оны Зургадугаар сар, 43–44).

### Гэрлэлтийнхээ Амжилтын Төлөө Залбир

2. Гэрлэлтийнхээ амжилтын төлөө залбир. Хэдэн жилийн өмнө Ерөнхий Эрх Мэдэлтний хувьд номлолоор айлчлан бүх номлогч нартай ярилцлага хийх нь жирийн үзэгдэл байхад, хожим нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд асан Ахлагч Спенсер В.Кимбалл номлолоо бараг дуусгах гэж буй нэгэн ахлагчтай уулзсан юм.

“Та номлолоосоо буухад төлөвлөсөн зүйл тань юу вэ, Ахлагч аа?” гэхэд,

“Өө, би коллежид буцаж орох төлөвлөгөөтэй байгаа.” Дараа нь тэр инээмсэглэн, “Тэгээд магадгүй дурлаад гэрлэх байх” гэж нэмэн хэлжээ.

“За тиймээс, зөвхөн хайрладаг нэгэнтэйгээ гэрлэхийн төлөө бүү залбир. Үүний оронд, гэрлэх нэгнийгээ хайрлахын төлөө залбир” хэмээх энэхүү ухаалаг зөвлөгөөг Ахлагч Кимбалл хуваалцжээ.

Бид илүү эелдэг сайхан сэтгэлтэй, халуун дотно, даруу, тэвчээртэй, уучлан өршөөдөг мөн *ялангуяа*, аминч үзлээр бага болохын төлөө залбирах ёстой.

Гэрлэлтийн илүү сайн хамтрагч байхад саад болж буй хувийн асуудал, бэрхшээлүүд буюу сул талуудаа таньж мэдэхийн тулд, бид Их Эзэнд хандан залбирч мөн энэ хүчирхэг Мормоны Номны: “Хэрэв хүмүүс надад ирэх аваас би тэдэнд сул доройг нь үзүүлэх болно. . . . Учир нь хэрэв тэд миний өмнө өөрсдийгөө даруусгах, мөн надад итгэлтэй байх аваас, тэгвэл би тэдэнд сул дорой зүйлүүдийг нь хүчирхэг болгож өгнө” (Ифэр 12:27) гэдэг амлалтын ашиг тусын үр шимийг үзэх хэрэгтэй.

Тиймээс бас залбирах хэрэгтэй. Сүмийн олон удирдагчид болон гэрлэлтийн зөвлөгч нар, гэр бүлийн хос өдөр болгон залбирвал ноцтой зовлонд орсон нэг ч гэр бүлийг хараагүй гэдгийг гэрчилдэг. Асуудал үүсэж мөн гэрлэлт нь аюулд учрах үед гэр бүлийн хосууд хамтдаа залбирах нь хамгийн шилдэг арга болж мэднэ.

### Ханиа Сонс

3. Сонс. Цаг гарган хань ижлээ сонс, тэр ч байтугай үүнд тогтмол цаг гарган төлөвлө. Бие бие тэйгээ уулз мөн гэр бүлийн хамтрагчийн хувьд түүний ямар байгааг тодруул.

Брент Барлөү ах хэсэг санваартан ах нарт хандан: “Та нарын хэд нь илчлэлтийг хүлээн авахыг хүсч байна?” гэж асуухад, бүгд гараа өргөв. Дараа нь тэрээр тэдэнд бүгдээрээ гэртээ очоод, яаж илүү сайн нөхөр болохыг эхнэрээсээ асуухыг зөвлөжээ. “Би өөрийнхөө зөвлөгөөг дагаж, [эхнэр] Сюзантайгаа тэр өдөр сургамж бүхий маш хэрэгтэй юмны талаар цаг илүүтэй ярилцсан” гэж тэрээр нэмж хэлжээ (“To Build a Better Marriage,” *Ensign*, 1992 оны Есдүгээр сар, 7). Иймэрхүү ярилцлага нь бидний хэнд ч илчлэлт байж болно.

Ах нарын хэн нэг нь миний саяхан сонссон шиг зүйлийг эхнэр тань танд хэлсэн үү: “Жөү, чи сонсож байна уу?” Намайг сонсож байсан уу гэдэгт гайхан бодож байсан нь ганцхан тэр биш. Нэг өдөр намайг зүүрмэглэж байх үед манай ач охин Аллисон ирээд зовхийг маань сөхсөнөө “Өвөө, та энд байна уу?” гэж асууж билээ. Бид “энд байж” хань ижилдээ уриалагхан байх хэрэгтэй.

### Байнга Хатгах Зэвүүцэлд Хүргэхээс Зайлсхий

4. “Байнга хатгах зэвүүцэлд хүргэхээс” зайлсхий. Нэг нэгнийхээ алдаанд хэтэрхий шүүмжлэлтэй бүү ханд. Бидний хэн нь ч төгс хүн биш гэдгийг ухааран ойлго. Бидний удирдагчдын биднээс хүсдэгээр Христтэй адил болохын тулд бид бүгдэд урт удаан зам бий.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын хэлдгээр “байнга хатгах зэвүүцэлд хүргэх” нь бараг ямар ч гэрлэлтийг хагаралд хүргэж болно (“Marriage and Divorce,” *1976 Devotional Speeches of the Year* [1977], 148). Ер нь хүн бүр сул талаа ухааран мэдэрдэг бөгөөд бидэнд байнгын сануулга хэрэггүй. Тогтмол шүүжлэл буюу яншин үглэхийн үр дүнд хэдхэн хүн өөрчлөгдөж байсан. Хэрэв бид болгоомжтой байхгүй л юм бол зарим бидний *засан залруулах* мэтээр хүссэн шүүмжлэл нь ихэнхдээ *эвдэн сүйтгэдэг*.

Зарим тохиолдолд, зарим зүйлийн тухайд юу ч ярилгүйгээр орхих нь илүү дээр байдаг. Шинэхэн гэрлэгсдийн хувьд, Лола Волтерс Эгч нэгэн сэтгүүлд, гэрлэлтийг бэхжүүлэхийн тулд гэр бүлийн хосууд мэдэж олсон өөрсдийг нь залхаан уурлуулдаг ямар нэгэн ааш байдлыг жагсаан бичээд, чин сэтгэлээсээ хуваалцан өдөр тутам ярилцдаг байх ёстой гэдгийг уншжээ. Тэрбээр бичихдээ:

“Биднийг залхаан уурлуулдаг таван зүйлсийг бид нэрлэх ёстойг би эхлээд хэлсэн. . . . Би түүний амтат жүржийг иддэг байдал нь надад таалагддаггүй болохыг түүнд хэлсэн. Тэр амтат жүржний хальсыг арилгаад яг жүрж идэж байгаа мэтээр иддэг! Миний мэддэгээс өөр хэн ч яг иймэрхүү маягаар идэж байгаагүй. Ямар ч бүсгүй нөхрөө амтат жүржийг ердийн жүрж мэт иддэг хүнийг хараад л амьдралын цаг хугацаа, тэр ч байтугай мөнх оршихуйг өнгөрүүлж болно гэж үү? . . .”

“[Өөрийнхөө тавыг] би хэлж дууссаны дараа миний тухайд түүнд таалагддаггүй зүйлүүдийг ярих түүний ээлж ирлээ. ‘За, хайрт минь, үнэндээ чиний тухайд гэвэл надад таалагддаггүй зүйлийг би бодоод олохгүй юм’ гэж [тэрээр] хэлсэн.

“Амьсгаа нь давхцаад.

“Би түүнээс хурдан нүүр буруулж зогссон, учир нь нүдийг минь дүүргэж буй нулимс хацар даган урсаж, би яагаад уйлж байгаагаа тайлбарлаж чадахгүй байлаа.”

“Би гэрлэсэн хосуудыг хагаралтай, таарахгүй байгааг сонсох бүрдээ, үргэлж миний эдүгээ нэрлэдэг Амтат Жүржний Синдромоор тэд өвчлөн зовж байгаа болов уу хэмээн боддог” гэж Волтерс эгч дуусган хэлж билээ (“The Grapefruit Syndrome,” *Ensign*, 1993 оны Дөрөвдүгээр сар, 13).

Тийм ээ, зарим тохиолдолд, зарим зүйлийн тухайд юу ч ярилгүйгээр орхих нь илүү дээр байдаг.

### Үерхлээ Бодитой Байлга

5. Үерхлээ бодитой байлга. Хамтдаа юм хийхээр цаг гарга—зөвхөн та хоёр хоёулхнаа. Гэр бүлийн хувьд хүүхдүүдийнхээ хамт байх нь нэн чухал ч,

зөвхөн та хоёр хамтдаа байх тогтмол цаг долоо хоног бүр гаргах хэрэгтэй. Үүнийг төлөвлөснөөр гэрлэлтээ бэхжүүлэн хөгжүүлж байх ёстой гэдэг нь нэн чухал байдаг гэж та нар боддогийг хүүхдүүд тань мэдэх болно. Үүнд амласнаа биелүүлж, төлөвлөж мөн цаг товлож байх ёстой.

Үүнд мөнгө зарах шаардлагагүй. Хамтдаа байх цаг хугацаа бол хамгийн чухал хэсэг мөн.

Нэг удаа хадам аав маань өдрийн ундны дараа тариалангийн талбай руу ажиллахаар гэрээс гарч явахад, хадам ээж маань түүнд: “Альберт, чи яг энд буцаж ирээд надад хайртай гэдгээ хэл” гэхэд тэрээр инээмсэглэж, “Элси, бид гэрлэхэд би чамд хайртай гэдгээ хэлсэн, хэрэв энэ нь хэзээ нэгэн цагт өөрчлөгдөх юм бол би чамд үүнийг мэдүүлнэ” гэж тоглон хариулж билээ. “Би чамд хайртай” хэмээх илэрхийлэл болох хэллэгийг хэт их хэрэглэх нь боломжгүй зүйл биш юм. Үүнийг өдөр тутам хэрэглэж.

### “Намайг Уучлаач,” гэж Хэлэхдээ Хурдан Бай

6. “Намайг уучлаач,” гэж хэлэхдээ хурдан бай. Хэдийгээр үгээ нийлүүлэн хэлэх нь хэцүү боловч, мөн та бүрэн буруутай нэгэн биш ч гэсэн, “Би уучлалт гуйж байна, намайг өршөөгөөч” хэмээн түргэн хэлж бай. Үнэнч хайрыг хувийн алдаа болон гомдлоо сайн дураараа амархан хүлээн зөвшөөрдөг хүмүүс хөгжүүлдэг билээ.

Хэрэв санал зөрөлдөөн үнэхээр үүсэх үед үүнийг ярилцаж мөн шийдвэрлэх боломжтой байх нь нэн чухал байдаг боловч, зарим үед амсхийх нь хамгийн сайн байдаг байна. Амаа татаад арав хүртэл тоолох, тэр ч бүү хэл, зуу хүртэл тоолох нь чухал байдаг. Мөн хааяа бүр уураа барин нар жаргахыг хүлээж, тэрхүү асуудлыг илүү сайн шийдвэрлэх боломжтой учир та өглөөдөө илүү сайн амарсан мөн тайвширсан үед асуудлыг хөндөхөд тань тусална.

“Бид тавин жилийн турш гэрлэсэн хэвээр байхад яагаад хэзээ ч санал бодлоор зөрөлдөж байгаагүй юм бол” гэж байхыг хааяа сонсдог билээ. Хэрэв энэ нь үнэн бол, хамтрагчийн нэг нь нөгөө нэгнийгээ хэтэрхий захирдаг эсвээс хэн нэгний хэлдэгээр үнэн гэхэд, итгэхэд хэцүү л юм байна. Ямар ч ухаантай гэр бүлийн хосууд санал бодлоор зөрөлдөнө. Бидний бэрхшээл бол үүнийг хэрхэн шийдвэрлэхээ бид баттай мэддэг байх явдал юм. Энэ нь сайн гэрлэлтийг сайжруулах үйл явцын хэсэг мөн.

### Хэрэгцээнийхээ Дагуу Амьдар

7. Хэрэгцээнийхээ дагуу амьдарч сур. Гэрлэлт дэх хамгийн хэцүү бэрхшээлүүдийн нэг нь санхүүгийн хэсэгт үүсдэг. “Америк Баар Нийгэмлэг нь . . .

бүх гэрлэлт цуцлалтын 89 хувь нь мөнгөнөөс болж хэрүүл маргаан үүсгэн, буруушааж зэмлэхээс болдог гэдгийг заасан байдаг” (Marvin J. Ashton, “One for the Money,” *Ensign*, 1975 оны Долдугаар сар, 72). Төсвөөсөө хэтрэхгүйгээр байж болохын тулд зарим худалдаагаа сайн дураараа хойшлуулах буюу татгалздаг бай. Хамгийн түрүүнд аравныхаа нэгийг төлөх ба болж өгвөл хэтэрхий их өр тавихаас зайлсхий. Та авдаг мөнгөнөөсөө сар бүр тавин доллар бага зарцуулж байх юм бол энэ нь аз жаргалтай тэнцэн харин үүнээс тавийг илүү зарцуулж байх юм бол ядуурал, гай зовлонтой тэнцдэгийг санагтун. Хайч болон кредит картуудаа гарган Ахлагч Жефффри Р.Холландын хэлдэгээр зарим “уян хатан хагалгаа” хийлгэх цаг ирчихээд байгаа юм болов уу (“Things We Have Learned—Together,” *Ensign*, 1986 оны Зургадугаар сар, 30).

### Гэрийн болон Гэр Бүлийн Үүрэг Хариуцлагуудыг Хуваалцаж Бай

8. Гэрийн болон гэр бүлийн үүрэг хариуцлагуудад үнэнч хамтрагч бай. Эхнэр нь ганцаараа орон гэр мөн хүүхдүүдийг халамжлах үүрэгтэй харин өөрөө амьдралаа тэтгэх мөнгө олох үүрэгтэй гэж бодон, гэр орондоо ирээд үйлчлүүлэхээр сууж л байдаг тиймэрхүү нөхөр шиг бүү бай. Орон гэр болон гэр бүлийг авч явах үүрэг нь нэг хүнээс илүү өндөр хариуцлага юм.

Та хоёулаа хамтран зүтгэгч гэдгээ сана. Барбара бид хоёр өглөө болгон минутаас бага хугацаанд ороо хураачихдаг болсноо олж мэдсэн бөгөөд энэ нь тэр өдөртөө л боллоо гэсэн үг. Үүнийг надаар хийлгүүлэн туслуулснаар намайг тэр бүтэн өдрийн турш өөрийн тухайд сайхан сэтгэлтэй байлгуулдаг гэж тэрээр хэлдэг ба үүнд ямар нэгэн утга учир байдаг л байх гэж би боддог.

Хамтдаа судраас суралцах цаг гарга, мөн Ерөнхийлөгч Кимбаллын: “Эхнэр, нөхөр хоёр байнга хамтдаа ариун сүм рүү явдаг, гэртээ гэр бүлээрээ өвдөг сөгдөн хамтдаа залбирдаг, шүтлэг бишрэлийнхээ цуглаануудад гар гараасаа хөглөцөн очдог, амьдралаа бүхэлд нь оюун ухаан, бие махбодын хувьд цэвэр ариун байлгаж, . . . хоёулаа Бурханы хаант улсыг хөгжүүлэхэд хичээн чармайх ёстой, дараа нь аз жаргал нь үүний оргил цэгт хүрнэ” гэж хэлж буй энэхүү зөвлөгөөг дага (*Marriage and Divorce* [1976], 24).

Дүгнэлтэнд:

- Гэрлэлтийнхээ гол ач холбогдлыг сана.
- Гэрлэлтийнхээ амжилтын төлөө залбир.
- Сонс.
- “Байнга хатгах зэвүүцэлд хүргэхээс” зайлсхий.
- Үерхлээ бодитой байлга.

- “Намайг уучлаач,” гэж хэлэхдээ хурдан бай.
- Хэрэгцээнийхээ дагуу амьдарч сур.
- Гэрийн болон гэр бүлийн үүрэг хариуцлагуудад үнэнч хамтрагч бай.

Есүс бол Христ мөн, тэр гурав дахь өдөр булш хоосон байсан бөгөөд “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22) хэмээн би гэрчилж байна. Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээ дэх лацдалтын

хүчинд бид талархалтайгаар тэр яруу найрагчийн хамтаар: “Үхлийн дараа Таныгаа би илүү ихээр хайрланам” гэж итгэлтэйгээр хэлж чадна (Elizabeth Barrett Browning, *Sonnets from the Portuguese*, дугаар 43, 14–р шугам).

1995 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Крисченсений хэлсэн үгнээс (Conference Report, 1995 оны Дөрөвдүгээр сар, 84–87; эсвэл *Ensign*, 1995 оны Тавдугаар сар, х. 64–66–г үз).

# ИТГЭЛ, ЗАЛБИРЛААР ДАМЖУУЛАН ГЭРЛЭЛТИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ

# 6

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христэд итгэх итгэл-ээ батжуулахын тулд хийж чадах нэгэн зүйлийг бодож шийд.
- Эхнэр нөхөртэйгөө өдөр бүр залбирахаар цаг тогтоо.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### АМЬДРАЛ ДАХЬ БАЯР БАЯСГАЛАНГ ОЛОХ НЬ

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Ричард Ж. Скотт

### Тогтвортой Байдал дахь Харилцан Адилгүй Байдал

Саяхан би Номхон Далайн арлын хойд эрэг дээр үдийн завсарлагаар далайн зүг ширтэн зогсож байв. Эргийн шугамыг нэвтлэн урагш эмх цэгцтэйгээр дараалан нүүж байгаа аварга том давалгааг би гайхан биширч байлаа. Тогтоосон мөнхийн хуулийн хамт дуулгавартай байдлаар олж авсан мөнхөд үргэлжлэх шударга ёсны баталгаа мөн энэрлийн уян чанар нь надад Бурханы төлөвлөгөөн дэх тогтвортой байдлыг сануулсан юм. Давлагаа бүр эрэгт хүрэх онцгой замыг олохын тулд тэнгэрийн хаяанд харагдахаар янз бүрийн өндөрлөгт хүрдгийг би анзаарсан. Зарим нь хадан дээгүүр хүрхрээлж усыг хөөсрүүлэн цагаан болгон үлдээдэг байв. Харин бусад нь өөр өөрийн хэв маягаар эрэг рүү хүчтэй түрж, тэд чийгтэй элс рүү наадан, хөөсрөн гулсаж эрэг дээр бөмбөлөг үүсгэж буусаар, хуйлран эргэлдэж буцдаг байв.

Би Их Эзэний бидэнд бэлтгэж өгсөн төгсөшгүй олон боломжуудыг бодсон. Бидэнд маш их эрх чөлөө, өөрсдийнхөө онцгой хувийн мөн чанар, авьяас чадварыг мөн өөрсдийн дурсамжууд болон биеллээ олох хувь нэмрээ хөгжүүлэх маш их боломжууд бий. Аугаа хүчтэй, гайхамшигт тэнгисийг ажиглах боломж цаашид гарахгүйгээс, би хожим нь нүд гялбам туяарсан нарны бий болгох гайхамшигт газар нутгийн өнгө үзэмжийг төсөөлөхийг хичээсэн. Намайг энэхүү сүр жавхлан,

гайхамшигт үзэгдлийг бишрэл хүндэтгэлтэйгээр ажиглаж байхад үүлээр хучсан нэгэн цонх бий болж, мандаж буй нарны гялтганан цацарсан туяа нь үүл бүрхсэн тэнгэрийг нэвтлэн, бүх юмсыг өөрийн өнгө, амьдралаар гэрэлтүүлж, өөрчлөн хувиргасан билээ. Энэ нь хүрч буй хүн бүхэнд гэрэл гэгээ хийгээд итгэл найдварыг өгдөг. Түүний сургаалын гэрэл гэгээний билэг тэмдэг болох нэгэн нэмэлт адислалыг Их Эзэн хуваалцахыг хүссэн мэт байлаа. Бидний амьдарч буй энэ гайхамшигт дэлхийн төлөө мөн ер бусын гайхамшигт гоо үзэсгэлэнг харахыг хүсэж буй хэн бүхэнд өгөөмрөөр хуваалцсан Тэнгэрлэг Эцэгийнхээ төлөө бид талархлын нулимсыг унагадаг. Үнэндээ, амьдрал бол гайхамшигтай сайхан юм.

### Амьдралын Гоо Үзэсгэлэнд Талархах нь

Та өдөр болгон амьдрал тань хичнээн сайхан байж чадахыг олж үзэхээр цаг гаргадаг уу? Жаргах нарны—хэвийж буй нарны цацрагууд нь үүл, модод, толгод хийгээд нам дор газруудаас холдон, сайхан амрахын салах ёслолыг гүйцэтгэн, заримдаа тайван дөлгөөнөөр, заримдаа ганган хээнцэр өнгө мөн хэлбэрээр гэнэт гарч ирдгийг үзсэнээс хойш хэр удсан бэ?

Их Эзэн тэнгэр огторгуйн гайхамшгуудаа ил гаргах үед—гялтганах одод, сарны туяа—Түүний сүр жавхлан ба алдар хүндийн хамт төсөөллийг маань оргилуулдаг үүлгүй шөнө ямар гайхамшигтай билээ?

Үржил шимтэй хөрсөнд суулгасан үр нь соёолон ургаж, хүчээ хуримтлуулан бараг үл мэдэгдэхүйцээр нахиалж байхыг ажиглах нь хичнээн



сэтгэл татам билээ. Энэ нь тэсвэртэй ургаж эхэлдэг ба өөрийн хувийн зан чанарыг хөгжүүлж, хөгжил дэвшил рүүгээ чиглүүлэх Их Эзэний бэлтгэсэн генетикийн хуулиар удирдагддаг юм. Халамж анхаарлын хамтаар энэ нь үнэхээр хувь тавилангийн эрхээр: алдар суу хийгээд гоо үзэсгэлэнгээр титэмлэгдсэн сараана цэцэг; анхилуун үнэрт гааны ургамал; тоор жимс; авокадо ногоо эсвэл онцгой мэдрэмтгий чанар, өнгө төрх ба анхилуун үнэртэй гоо үзэсгэлэнт цэцэг болон хувирах болно.

Та хамгийн сүүлд хэзээ сарнай цэцгийн жижигхэн цоморлогийг ажиглан харсан бэ? Сүрлэг, гоёмсог сайхан сарнай цэцэг болтол тэрээр өдөр бүр илүү их гоо үзэсгэлэнг амлаж, шинэхэн, мөн сэтгэл хөдлөм сайхан шинж чанарыг хөгжүүлэн нэмэгдүүлдэг билээ.

Та бол Бурханы бүтээлүүдийн хамгийн гайхамшигт, сүр жавхлангийн нэг нь мөн. Түүний хүсэл тэмүүлэл таны амьдрал дахь нөхцлүүдээс үл хамааран амьдралыг тань бахдам сайхан болгох явдал юм. Талархалтай хийгээд дуулгавартай байх аваас Бурхан таныг хэн болгох хүсэл зорилгын дагуу та юм бүхэнд хүрч чадна.

### **Амьдрал дахь Баяр Баясгалан нь Бурханд Итгэхээс Хамаарна**

Гунигтай байдал, сэтгэлээр унах явдал болон хүнд хэцүү бэрхшээлүүд нь дан ганцаараа амьдрал биш, харин амьдрал дахь *үйл явдлууд* билээ. Эдгээр үйл явдлуудын зарим нь хэрхэн хүнд хэцүү байдгийг би багасган ярьж байгаа юм биш. Тэдгээр нь урт удаан хугацаагаар үргэлжилж чадах боловч таны хийж буй бүх зүйлийг хязгаарлан төвлөрүүлдэг байх ёсгүй. Их Эзэн Лихайгаар үндсэн гол үнэнийг тунхаглуулахаар: “Тэд баясгалантай байж болохын тул хүмүүн байх бөлгөө”<sup>1</sup> хэмээн бурханлигаар урамшуулсан. “Тэд баясгалантай байж *болохын* тул бөлгөө” хэмээх нь нөхцөлт үйлийг заасан үг юм. Энэ нь Их Эзэний хувьд нөхцөлт үйлийг заасан үг биш. Түүний хүсэл тэмүүлэл нь хүн бүхэн баяр баясгаланг олох явдал юм. Та зарлигуудыг дуулгавартай даган, Их Эзэнд итгэх итгэлтэй байж, мөн энэ газар дэлхийд баяр баясгаланг байлгах шаардлагатай зүйлийг хийснээр энэ нь таны хувьд нөхцөлт үйл заасан үг биш болно.

Таны амьдралд дахь баяр баясгалан Тэнгэрлэг Эцэг болон Түүний Ариун Хүүд итгэх мөн тэдний аз жаргалын төлөвлөгөө нь танд үнэхээр баяр хөөрийг авчирдаг гэдэг таны хатуу итгэх баталгаанаас шалтгаалдаг. Тэдний сургаалыг тунгаан бодох нь энэхүү газар дэлхийн гоо үзэсгэлэнг таашаах мөн бусадтай харьцах таны харилцан холбоо өсөн нэмэгдэхэд хүргэнэ. Энэ нь Тэнгэрлэг

Эцэгт хандсан залбирал хийгээд Тэрээр бидэнд өгдөг хариултуудаас урган гарч ирдэг тэрхүү тайтгаруулан хүчирхэгжүүлдэг туршлагаууд руу таныг хөтлөх болно.

### **Алсын Хараа ба Тэвчээр**

Нүдэнд орсон хайрганы үйрмэг хүртэл том саад болон хувирдаг. Газарт хаяхад энэ нь үл мэдэгдэм харагддаг. Үүний адил, бидний амьдрал дахь асуудлууд буюу сорилтуудыг судрын сургаал дотор хэтийн төлөвтэйгөөр авч үзсэн байх ёстой. Тэгэхгүй л юм бол тэд үзэл бодолд маань нөлөө үзүүлж, эрч хүчийг маань сорж, мөн Их Эзэн биднийг энэхүү газар дэлхийд хүлээн аваасай хэмээн хүсдэг тэр баяр баясгалан хийгээд гоо сайхнаас биднийг салгадаг. Зарим хүмүүс зовлон бэрхшээлийн далайд хаягдсан чулуу мэт байдаг. Тэд тэдэнд дарагдан живдэг. Хөвж буй бөглөө бай. Асуудалд дарагдах үед үүнээс чөлөөлөгдөж, аз жаргалтайгаар дахин үйлчлэхээр хөвөн гарч ирэхийн төлөө тэмц.

Бурханлиг зорилгын дагуу та энэ газар дэлхий дээр байгаа юм. Энэ нь эцэс хязгааргүй зугаацуулах эсвэл тогтмол жаргал цэнгэл хөөхийн тулд байдаггүй юм. Бурханы танд зориулан бэлтгэсэн нэмэлт адислалуудыг хүлээн авч болохын тулд мөн өөрийгөө нотлон, соригдохоор та энд байгаа юм.<sup>2</sup> Тэвчээрийн нөлөөллийг зохицуулах шаардлагатай байдаг.<sup>3</sup> Зарим адислалуудыг энэ амьдралд, энд илгээх болно; бусад нь хөшөгний цаана ирэх болно.

Их Эзэний хүсэл тэмүүлэл нь таны хувийн өсөлт ба хөгжилд голчилдог. Эхнээсээ таны хувийн сонирхол байсан уу эсвэл үгүй юу гэдгээс танд учирч буй өсөн хөгжих туршлага бүрт Түүгээр өөрийгөө удирдуулахыг зөвшөөрөн хүсэх юм бол тэрхүү хөгжил дэвшил нь хурдасдаг. Та Их Эзэнд итгэн зүрх сэтгэл болон оюун ухаанаа Түүний хүсэл зоригт нийцүүлэн төвлөрүүлэхийг хүсэх үед, мөн Түүний хүсэл зоригийг биелүүлэхээр Сүнсээр хөтлөгдөхийг та өөрөө хүсэх үед замд тань хамгийн агуу адислалууд хийгээд энэхүү зуурдын амьдралд хамгийн сайн биелэгдэх амжилтууд танд амлагдах болно. Хэрэв таныг хий гэсэн бүх зүйлийн талаар тайлбар тавих эсвэл таагүй бэрхшээл бүрт уурлаж эсэргүүцэх юм бол таныг Их Эзэн адислахад нь та түүнд хүндрэл учруулж байна.<sup>4</sup>

Таны сонголт болох сонголтууд хийх тэрхүү эрх нь таны юу хүсэж буй бүхнийг авахад өгөгдөөгүй юм. Энэхүү бурханлиг бэлэг нь Тэнгэрлэг Эцэг маань танд юуг хүсэж буйг та сонгохын тулд бэлтгэгдсэн байдаг. Ийнхүү байдлаар Тэрээр таныг хэн байхыг хүсэж байдаг юм бүхэнд хүрэхэд тань Тэрээр хөтлөн удирдаж чадна.<sup>5</sup> Тэрхүү зам нь

таныг гайхамшигтай баяр баясгалан хийгээд аз жаргал руу хөтөлдөг билээ.

### **Гай Зовлон ба Муу Нөлөөтэй Орчинд Баяр Хөөртэй Амьдар**

Өөрсдийн бэрхшээлүүдийг амар амгалан болгож, гай зовлон, бэрхшээл дунд баяр баясгалантай амьдарч буй сүнслэгээр урамшуулагдсан хувь хүмүүсээс суралц. Хурдтай тархлааждаг үхэлд хүргэх өвчнөөр өвчилсөн нэгэн сайхан эмэгтэй амьдралдаа аз жаргалыг тогтмол олдог байв. Тэрээр аз жаргалын төлөвлөгөөг ойлгож, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч, мөн амлагдсан адислалуудад бэлтгэхэд чадах бүхнээ хийсэн. Түүний хувийн өдрийн тэмдэглэлд:

“Намрын сайхан өдөр байна. Би захиагаа аваад савлуур дээр суулаа. Би үнэхээр аз жаргалтай байсан ба дулаахан нар, миний эргэн тойронд дахь байгаль орчин хийгээд моддын сайхан анхилуун үнэрт сэтгэл хангалуун байлаа. Би зүгээр л суугаад өнөөг хүртэл энэхүү үзэсгэлэнтэй сайхан дэлхий дээр амьд явж буй үнэнд баярлаж байв. . . Их Эзэн үнэхээр надад сайн юм. Би өнөөг хүртэл энд байж, сэтгэл үнэхээр сайхан байгаад түүнд хичнээн их талархдаг билээ. Би үнэхээр аз жаргалтай байгаа тул тэр том цонхоор нар гэрэлтэж байх зуур энэхүү гайхалтай сайхан байшинд зүгээр нэг хашгирч, бүжиглэмээр байна. Би амьд яваадаа сэтгэл хангалуун байна” гэжээ.

Хүнд хэцүү өвчинтэй зоригтойгоор тэмцэж буй нэгэн хүчирхэг эр зоригтой эх хүн том гэгч, мөн авъяас шаардсан нэгэн урлагийн бүтээл болох гар нэхээсийг хичээнгүйлэн дуусгахаар хэлж баршгүй их цаг хугацааг зарцуулсан байна. Энэ нь соригдож буй гэр бүлийн хосуудын хувьд адислал байлаа. Гэр бүлийн хосуудын хувьд энэ нь үнэлж баршгүй эрдэнэс, гай зовлонтой нүүр тулахад шийдэмгий хичээл зүтгэл гаргасны үнэтэй үр шимийг байнга сануулан, цэвэр хайр хийгээд сайн дурын золиослолын уялдаа холбоонд эцсээ хүртэл орших итгэл найдварын захиас болдог юм.

### **Өөрт Байдаг Зүйлээсээ Баяр Баясгаланг Ол**

Хамгийн хэцүү бэрхшээлтэй нөхцөл байдлуудад ч хэрхэн баяр баясгаланг олохыг хүүхдүүд бидэнд заадаг. Өөрсдөд нь байхгүй зүйлүүдэд бодол санаагаа төвлөрүүлэн сэтгэлээр унаж дарамтад орохыг хүүхдүүд хараахан сураагүй байгаа. Тэд өөрсдөд нь юу боломжтой байна, түүнээс баяр баясгаланг олдог. Би нэгэн жаал хүүг голын эргийн дагуу тоглож байсныг санаж байна. Тэрээр загасны дэгээний утасны хоёр үзүүрт ундааны хаягдал лаазыг нэг нэгээр нь уян тогтоосон байв. Нэг лаазыг мөдны мөчир дээгүүр давуулан шидэж,

тэгээд усаар дүүргэв. Дараа нь нөгөө нэг лаазыг тэр татаж байгаад тавихад, нэгдүгээр лааз жингээрээ хоёрдугаар лаазыг дээш болгон унагахад тэрбээр зугаатай нь аргагүй баярлан хөхөрч мөн бүжиглэж байв.

Бидний эргэн тойронд энгийн, залуужуулан хүч чадлыг сэргээдэг тохиолдлууд байдаг. Тэд түгшүүрт байдлыг намжаан мөн сүнс буюу сэтгэл санааг өөдрөг байлгах найдвартай хаалт байж чадна. Өөрт тань байхгүй эсвэл алдсан зүйлүүдэд санаагаа та бүү зовоо. Их Эзэн дуулгавартай нэгэнтэй хамтдаа эзэмших бүхнийг хуваалцахыг амласан байдаг. Та энд зарим юмаар түр зуур дутмаг байж болох юм, гэвч дараагийн амьдралд хэрэв та өөрийнхөө зохистой эсэхээ зоригтойгоор нотлон амьдарч чадах юм бол элбэг дэлбэг байдал таны адислал байх болно.

Их Эзэн мэргэн ухааныхаа дагуу таны маш их хүсэж буй ямар нэгэн зүйлээс тань салгах үед амьдралдаа үүнийг тэнцвэртэй болгох адислалыг олж ав. Тэрээр хараагүй буюу сонсгол муутай хүмүүсийн бусад мэдрэхүйг тод хүчтэй болгодог. Өвчтэй нэгэнд Тэрээр тэсвэр тэвчээр өгч, ойлгон ухаарах хийгээд бусдын сайхан сэтгэлд ихээр талархалтай болгодог. Хайртай нэгнийг алдахад Тэрээр хайрын холбоог гүн гүнзгий болгож, дурсамжуудыг өсгөн нэмэгдүүлдэг ба ирээдүйд дахин уулзах итгэл найдварыг сэргээдэг юм. Их Эзэний хүсэл зоригийг дуртайяа хүлээн зөвшөөрч, мөн Түүнд итгэх итгэлээ хөгжүүлэх юм бол та тэнцвэртэй болгох адислалуудыг нээж олох болно.<sup>6</sup>

Их Эзэн Алмагийн зовлон зүдгүүртэй хүмүүст хандан:

“ . . . Тэр ачаануудыг би түүнчлэн хөнгөлнө, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол. . . ; мөн та нар цаашид миний гэрчлэгчид болон зогсож болно, мөн та нар, Их Эзэн Бурхан би өөрийн хүмүүст тэдний зүдгүүрт үед зочилдог гэдгийг та нар гарцаагүй мэдэж болохын тул би үүнийг хийх болно.

“Мөнхүү . . . тэр ачаанууд хөнгөлөгдсөн байлаа; тийм ээ, тэд ачаагаа амархан дааж чадахын тул Их Эзэн тэднийг хүчирхэгжүүлсэн, мөн тэд баяртайгаар мөн тэвчээртэйгээр Их Эзэний бүх тааллуудад захирагдсан болой”<sup>7</sup> гэжээ.

### **Шинийг Санаачилж Бүтээлч Байх нь Амьдралыг Зугаатай Өнгөрүүлэхэд Танд Тус Болно**

Шинийг санаачилж бүтээлч байхыг хичээн оролд, учир нь энэ нь баяр хөөрийг авчирдаг. Эрхэмсэг сайхан нөхрүүдийг нь Бурханы оронд дуудахад Камилла Кимбалл, Амелиа МакКонки,

Елен Ричардс Эгч нар зураг зурж сурсан байв. Тэд зөвхөн уран бүтээлүүдийн өвийг үлдээсэн биш, харин нар жаргах, хүний нүүр царай эсвэл моддыг дахин тэд хэзээ ч энэ байгаагаар нь үзэхгүй. Эдүгээ тэд өнгө, хэлбэрийн нарийн сайхан өнгө аясыг мэдэрч байгаа бөгөөд тэдний эргэн тойрон дахь элбэг дэлбэг гоо үзэсгэлэнд тэд баярлаж байгаа.

Хөгжим, бүжиг, уран баримал эсвэл яруу найраг гэх зэргийг сонго. Шинийг санаачилж бүтээлч байх нь амьдралыг зугаатай өнгөрүүлэхэд танд тус болно. Энэ нь талархалтай байх сэтгэл санааг төрүүлдэг. Энэ нь нуугдмал авьяасыг хөгжүүлж, тунгаан бодох, үйлдэх хийгээд амьдралын зорилгыг олох чадварыг тань нэмэгдүүлдэг. Энэ нь ганцаардмал байдал хийгээд сэтгэлийн зовиурыг сарниулдаг. Энэ нь шинэ зүйлийг оруулж, урам зоригийн дөлийг бадрааж, амьдралд сонирхолтой болгодог.

### Үйлчлэл: Аз Жаргалд Хүрэх Түлхүүр

Бусдад сайн дураар үйлчлэх үйлчлэл нь эцсийг хүртэл орших аз жаргалд хүргэх түлхүүр юм. “Бурхан биднийг үнэхээр анзаарч байдаг ба тэрээр биднийг хараа хяналтандаа байлгадаг. Гэхдээ үүнийг ихэнхдээ бидний хэрэгцээг хангадаг өөр нэгэн эгэл хүнээр дамжуулдаг. Тиймээс бид бие биендээ үйлчлэх нь амин чухал юм”<sup>8</sup> хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлсэн байдаг.

Баяр хөөрөөр дүүрэн аз жаргалтай байсан нэгэн эмэгтэйг би мэднэ. Өглөө бүр тэрээр Тэнгэрлэг Эцэгээсээ өөрөө тусалж болох хэн нэгэн рүү түүнийг хөтлөхийг асуудаг байв. Тэрхүү чин сэтгэлийн залбирал нь цаг ямагт хариулагддаг байв. Тиймээс олон хүмүүсийн ачаа нь хөнгөрч, амьдрал нь гэрэл гэгээтэй болжээ. Тэрээр Их Эзэний зэмсэг болж удирдуулснаар байнга адислагддаг ажээ.

### Хүнд Хэцүү Байдал нь Өсөлт, Хөгжил Болон Хувирч Болно

Амьдрал дахь хүнд хэцүү бүхнийг бид туулсан хэдийд ч өөрсдийн хайнга хандлагаас болж тэр ч бүү хэл, гэм нүглээс үүдэн гардаг тэдгээр хүнд хэцүү байдал нь Их Эзэнээр дамжуулж дээш чиглэх нэмэлт нэг шат болох өсөлт, хөгжлийн туршлага болон хувирч болохыг би мэднэ.<sup>9</sup> Би мэдээж гэм нүглийг өсөлт, хөгжлийн зам болгохыг зөвлөөгүй. Ингэх нь зовиуртай, хүнд хэцүү байдаг бөгөөд тиймээс ч ингэх ч шаардлагагүй. Үүний оронд зөв шударга ёсоор урагш дэвших нь илүү ухаалаг ба үнэхээр хамаагүй хялбар байдаг. Гэхдээ зүй ёсны наманчлал, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл хийгээд Түүний зарлигуудад дуулгавартай байхад гэм нүглээс болж сэтгэлээр унах хүртэл дараа нь буцаад аз жаргал болон хувирч мэднэ.

Аз жаргалтай байхын тулд өөрийн хийж чадах зүйлсийн жагсаалт гарга, тухайлбал:

- Аз жаргалын төлөвлөгөөг ойлгохын тулд судруудыг тунгаан бод.
- Есүс Христэд итгэх итгэлтэйгээр залбир.
- Бусдыг хайрлаж, тэдэнд үйлчил.
- Ариун Сүмийн ёслолуудыг хүрт. Бусдыг адислахаар буцаж ир.
- Бошиглогчийг сонсож мөн түүний зөвлөгөөг дуулгавартай дага.
- Өөрт байгаа зүйлд талархалтай бай.
- Илүү их инээмсэглэ.

Жагсаалт тань сэтгэл хангалуун байдал болон баяр баясгаланд хүрэх түлхүүрээр таныг хангах болно.

### Бэрхшээл Бол Түр Зуурийнх харин Аз Жаргал Бол Мөнхийнх юм

Бразилийн нэгэн алдартай дуунд: Уйтгар гуниг хэзээ ч төгсдөггүй боловч аз жаргал төгсдөг хэмээн олонх хүмүүсийн итгэдэг худал хуурмаг зүйл давтагддаг юм. Аврагчид итгэх итгэл хийгээд Түүний заадаг зүйлүүдэд дуулгавартай байснаар аз жаргал хэзээ ч төгсдөггүй харин уйтгар гуниг төгсдөг гэдгийг би гэрчилж байна.

Та болон таны хайртай хүмүүс хичнээн хүнд хэцүүг туулсан нь хамаагүй, энэ нь таны амьдралыг бусниулах ёсгүй ба таны сонирхлын төвд байх шаардлагагүй. Бэрхшээлүүд нь нэгэн сайхан амьдралын арын хэсэгт өрнөж буй түр зуурын үйл явдал болох өсөлт, хөгжлийн туршлагууд мөн. Өөрийгөө эсвэл амиа танд даатгасан тэдгээр хүмүүст анхаарал халамж тавьж чадахгүй, эсвэл өөр юу ч бодож чадахгүй тийм ганц үйл явдалд бүү ууссан мэт бай. Бие махбодыг арчлан тордогтой адилаар зарим сүнс болон оюун ухааны бэрхшээлүүд эдгэхдээ цаг хугацаа шаарддаг гэдгийг санагтун.

“Зовлон зүдгүүрүүдэд тэвчээртэй байгтун, учир нь чамд эдгээр нь олон байх болно; гэвч тэдгээрийг тэсвэрлэ, учир нь, харагтун, би чамтай, бүр чиний өдрүүдийн төгсгөл хүртэл хамт байх болно”<sup>10</sup> хэмээн Их Эзэн хэлсэн байдаг. Та тэвчээртэй байх аваас “Би чамтай хамт байх болно” гэж хэлсэн үг ямар утгатайг та ухааран ойлгох болно. Бурханы хайр амар амгалан хийгээд баяр хөөрийг авчирдаг.

Есүс Христэд итгэх таны итгэл амьдралыг эцсээ хүртэл тэвчин туулах гэсэн утгыг агуулж байгаа юм. Та өргөмжлөлд хүрэх аян замынхаа дунд байгаа гэдгийг санагтун. Заримдаа танд бусдаас илүү их аз жаргалтай байгаа туршлагууд байдаг, гэхдээ энэ бүхэн Их Эзэний зорилгод хамаатай юм.<sup>11</sup>

Аврагчийн гэрчлэгчийн хувьд, таныг гомдоосон байж болох ямар ч хүнийг уучлахыг би та нарт уриалж байна. Хэрэв гэм нүгэл үйлдсэн бол нүглээ наманчил, тэгснээр Их Эзэн таныг илааршуулан эдгээх болтугай.

Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хайрт Хүүд аз жаргалын төлөвлөгөө мөн үүн дээр үндэслэсэн сайн мэдээний зарчмуудын төлөө таларх. Бидэнд зориулан бэлтгэж өгсөн ёслолууд хийгээд гэрээнүүдэд талархан баярлаж бай. Амьдралыг тань зорилго, утга учиртай болгож, амар амгалан болон

баяр баясгалангаар титэмлэх хүч тэдэнд байдаг гэдгийг би албан ёсоор гэрчилж байна. Та уйтгар гуниг мөн сэтгэл санааны хямрал түр зуурынх гэдгийг ойлгох болно. Аз жаргал нь Есүс Христээр дамжуулж мөнхөд үргэлжлэх мөнхийн юм. Тэрээр амьд, Тэр та нарт хайртай мөн Тэрээр та нарт туслах болно гэдгийг би албан ёсоор гэрчилж байна.

1996 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Скоттын хэлсэн үгнээс (Conference Report, 1996 оны Дөрөвдүгээр сар, 31–35; эсвэл *Ensign*, 1996 оны Тавдугаар сар, х. 24–26–г үз).

---

#### ТЭМДЭГЛЭЛ

1. 2 Нифай 2:25.
2. Абрахам 3:25–ыг үз.
3. Мозая 3:19–ийг үз.
4. 1 Нифай 3:7–г үз.
5. Сургаал ба Гэрээ 58:26–32–ыг үз.
6. Олсон Ф.Витней, Spencer W. Kimball, *Faith Precedes the Miracle*–с иш татав (1972), 98–г үз.
7. Мозая 24:14–15.
8. *The Teachings of Spencer W. Kimball*, хэвл. Edward L. Kimball (1982), 252.
9. Исаиа 40:31–ийг үз.
10. Сургаал ба Гэрээ 24:8.
11. Joseph F. Smith, *Gospel Doctrine*, 5 дугаар хэвл. (1939), 177–г үз.

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Дараах судрын шүлгүүдэд уучлалын жишээнүүдийг судал: Лук 23:33–34; Үйлс 7:58–60; 1 Нифай 7:8–21.
- Илүү уучилдаг, бусдын уучлалыг хүртэхдээ илүү зохистой байх үүргээ амлан биелүүл.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгөө энэ өгүүллийг уншиж ярилц.

### “УУЧЛАХ НЬ ТА НАРААС ШААРДАГДАНА”

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх  
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли

Биднийг буруутгасан байж болох хүмүүст уучлалын сүнс, хайр хийгээд үнэн сэтгэлээсээ өрөвдөн хайрлах харьцаагаар хандах нь Есүс Христийн сайн мэдээний жинхэнэ мөн чанар юм. Хүн бүрт энэхүү сүнс хэрэгтэй байдаг. Дэлхий бүхэлдээ үүний хэрэгцээ байдаг. Их Эзэн үүнийг зааж өгсөн. Өөр хэний ч үзүүлээгүй энэ үлгэр жишээг Тэр үзүүлсэн билээ.

Калварын загалмайн дээр Тэрээр зовон шаналах үед, Түүнийг энэхүү аймшигтай цовдлолтод авчирсан, үзэн ядалтаар дүүрэн өчүүхэн ялагчдын өмнө, “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” гэж Тэрээр уйлсан байдаг (Лук 23:34).

Бидний хэн нь ч ийм өгөөмөр сэтгэлээр өршөөл гуйж байсангүй, гэхдээ бидний хүн нэг бүр бурханлигаар хүлээлгэсэн үүрэг гэрээний дагуу өршөөл хийгээд энэрэлд хүрдэг билээ. Их Эзэн илчлэлтийн үгсэд тунхаглахдаа: “Эрт дээр үед, миний шавь нар бие биеийнхээ эсрэг далим эрж мөн зүрх сэтгэлдээ бие биенээ уучилдаггүй байлаа; мөн энэ хилэнцийн учир тэд зовлонд унаж мөн гашуунаар цээрлүүлэгддэг байв.

“Иймийн тул, та нар бие биенээ уучлах ёстой гэдгийг би та нарт хэлнэ; учир нь ах дүүгийнхээ зөрчлийг үл уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой.

“Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана.

“Чи бид хоёрын хооронд Бурхан шүүг, мөн чиний үйлдлүүдийн дагуу чамайг шагнаг—хэмээн та нар зүрх сэтгэлдээ хэлэх ёстой” (С ба Г 64:8–11).

Бурханаар өгөгдсөн энэхүү зарчим ба түүнтэй хослох зарчим болж буй наманчлалд бид хэрхэн анхаарлаа хандуулах нь хичнээн их хэрэгтэй байна вэ! Бид үүний хэрэгцээг сохор номингийн үүр шиг жижигхэн байсан үл ойлголцол нь хэрүүлийн уул болон өсөж байгаа хүмүүсийн гэр оронд хардаг. Гай зовлон өшөө хорсол руу хөтөлдөг өчүүхэн ач холбогдолгүй ялгаануудыг бид хөршүүдийнхээ дунд хардаг. Ихэнх тохиолдолд, хэрэв тэд сайн дураар, албадуулалгүйгээр хамтдаа суугаад өөр хоорондоо намуухан ярилцвал тэрхүү асуудал нь бүх зүйлийн адислал болон шийдвэрлэгдэж болох байтал хэрэлдэн маргалддаг мөн харилцан буулт хийхийг эсэргүүцдэгийг бид бизнесийн хамтран ажиллагсдын дунд хардаг. Үүний оронд шүд зуун мөн шийтгэл, залхаан цээрлүүлэлтийг төлөвлөн өдөр хоногийг өнгөрүүлдэг байна.

Энэ Сүмийг зохион байгуулж байсан анхны жилүүдэд бошиглогч Иосеф Смит удаа дараалан баривчлагдаж, хор хөнөөл учруулахыг хүссэн хүмүүсээр хуурамчаар яллагдаж мөрдөгдөхөд, Их Эзэн түүнд илчлэлтээр дамжуулж, “Мөн та нартай хуулиар заргалдах хэн боловч тэрхүү хуулиар зүхэгдэх болно” хэмээн хэлжээ (С ба Г 24:17). Өнөө үед атаа жөтөөтэйгөөр мөшгин мөрдөж байгаа хүмүүсийн дунд би үүнийг харсан. Хэдийгээр тэдний дундах тэмцэлд ялсан ч тэд өчүүхэн, богино ухаантай гэдэг нь илт байдаг ба тэд доллар мөнгө арвижуулсан ч, тэд ямар нэгэн илүү үнэт зүйлээ алдсан байдаг.

## Гай Зовлон, Өшөө Хорслоос Зайлсхий

Францын зохиолч Ги де Мапассант, Хаучеком гэдэг нэгэн тариачин зах гарах өдөр тосгонд ирсэн тухай өгүүлэг бичжээ. Олон нийтийн талбайгаар алхаж явахад, бөөрөнхий чулуун зам дээр хэвтэж байсан олсны тасархай түүний нүдэнд өртлөө. Тэр түүнийг аваад халаасандаа хийжээ. Тэр үйлдлийг өмнө нь түүнтэй маргалдаж байсан тосгоны тоноглогч ажиглан олж харжээ.

Тэр өдөр оройхон тийшээ түрийвч алдагдсан тухай мэдээллэхэд, тоноглогч Хаучекомыг гүтгэн баривчлав. Тэр хотын даргын өмнө авчрагдахад тэрээр өөрийн гэнэн буруугүй байдлыг хамгаалан, олж авсан олсны тасархайг хотын захирагчид үзүүлэв. Гэвч түүнд итгэсэнгүй харин ч үүний төлөө түүнийг шоолон тохуурхав.

Маргааш нь түрийвч олдоход, Хаучеком буруутгаж байсан бүх зүйлээс цагаадлаа. Гэвч, хуурамч гүтгэлэгээс болж хайхрамжгүйгээр гутаан доромжлогдсондоо өсөрхөн, зовж шаналсан учраас тэрээр уур удаартай болсон бөгөөд хэргийг зүгээр л нэг өнгөрүүлэхийг хүссэнгүй. Уучлан мартахыг хүсэхгүйгээр тэрээр нөгөө л нэг жижигхэн юмны талаар бодож ярилцан фермээ үл хайхран түүнийгээ орхижээ. Тэр хаа сайгүй явж, уулзсан хүн бүртээ тэр шудрага бус байдлын талаар ярьж байв. Шөнө ч, бас өдөр ч тэр үүнийг дурсан санасаар байжээ. Гомдол зовиур нь салахгүй даган шаналгасаар тэр маш хүнд өвчтөй болж нас барав. Үхэлтэй тэмцэн оюун санаа нь балартах үед тэр “олсны тасархай, олсны тасархай” гэж дахин дахин гомдоллон бувтнасаар байв (*The works of Guy de Maupassant* [n.d], 34–38).

Зан араншин, шинж чанар болон нөхцөл байдлын ялгаагаар, энэ түүх бидний өнөөгийн амьдралд олон удаа давтагдах магадлалтай. Биднийг гомдоон эмзэглүүлсэн тэдгээр хүмүүсийг уучлах нь бид бүхэнд ямар их хэцүү байдаг билээ. Бидэнд хийсэн муу зүйлүүдийг бодохдоо бид бүгд эмзэглэдэг. Эргэн санаж бодох нь байнгын янгинах өвчин болдог ба сүйтгэх зовиуртай. Өнөө үед уучлан мартаж үйлдлээс илүү ариун ёс журам байна уу? Үүнийг сул дорой байдлын тэмдэг болгон хардаг хүмүүс ч байна. Тийм үү? Амьдралын турш өс хонзонгийн сүнстэйгээр явах, залхаан цээрлүүлэлтийг төлөвлөн ур чадвараа үрэн таран хийж, буруутгагдан шаналснаа ууртайгаар эргэн санан дурсахад хүч чадал болон оюун ухаан шаардагдахгүй гэдгийг би та нарт баталж байна. Атаа жөтөөг хөгжүүлэхэд ямар ч амар тайван байхгүй. Өс хонзон авсан тэр өдрөөс эхлээд аз жаргалгүй амьдрах болно.

Паул бидний амьдрал дахь “дорой буурай болоод зохисгүй үндсэн юмсын” талаар ярьсан байдаг (Галат 4:9). Биднийг гомдоон доромжилсон

хүмүүсийн эсрэг заналхийлсэн санааг нууцаар төлөвлөн сэдэх болон төгсөшгүй гомдол, хорслыг өвөрлөсөн бодол санаанд хэн нэгний амьдралыг сүйтгэх хандлагаас ч илүү дорой буурай болоод зохисгүй үндсэн юмс байдаг гэж үү?

Манай хүмүүсийн эсрэг маш их хорсол зэвүүцэлтэй байсан тэр цаг хугацаанд Жозеф Ф.Смит Сүмийг тэргүүлж байв. Тэрээр ямар ч үнэ цэнэгүй гүтгэлгийн бай байсан, тэр ч бүү хэл өөрийн нийгмийн өгүүллэг бичигчдийн жинхэнэ шуугиан дуулиантай шүүмжлэлийн бай нь байсан. Түүнийг шог зохиолд бичих, шог зургаар элэг доог хийж, шоглон тохуурхаж байсан. Түүнийг гутаан доромжилж байсан хүмүүст хандан хариулсан хариултыг нь сонс: “Тэднийг байгаагаар нь орхи. Тэд үргэлжлүүлэг. Тэд хүсээд байгаа бол эрх чөлөөтэй бодол санаагаа илэрхийлэг. Тэднээр өөрсдийнх нь түүхийг хэлүүл, бас өөрсдийнх нь хувь тавиланг бичүүл” (*Gospel Doctrine*, 5 дахь хэвл. [1939], 339). Тэгээд, мартаж, уучлах илүү их сэтгэлээр, тэрээр тэр агуу их мөн эргэлзээгүй ажлын өмнө Сүмийг шинэ хөгжил дэвшил, гайхамшигтай амжилт руу удирдаж байсан юм. Түүнийг нас барах үед, элэг доог хийж байсан тэдгээр хүмүүс түүний тухай магтаал өргөмжлөлийг өргөж билээ.

Миний өмнөх ширээнд сууж байсан гэр бүлийн хоёрын яриаг сонсож байснаа би санаж байна. Тэр хоёрын хооронд хорсол, гомдол байв. Нэг үедээ тэдний хайр гүн гүнзгий бөгөөд үнэн байсныг би мэдсэн. Гэвч аль аль нь бие биенийхээ алдааг ярих зуршлыг хөгжүүлсэн байв. Бид бүгдэд байдаг л тэр алдааг уучлахгүй, эсвэл тэднийг болон тэдний өвөг дээдсийн алдааг өгөөмрөөр уучилдаггүй болон өршөөдөггүй нь, тэдний нэгэнт мэддэг байсан тэр хайр нь алга болтол бие биенээ шүүмжилжээ. Энэ нь “буруугүй” салалт гэж нэрлэгддэг шүүхийн шийдвэртэй хамт үнс нурам болон хутгалддаг. Энэ нь зөвхөн харилцан бие биеэ зэмлэн буруушаах мөн ганцаардал юм. Хэрэв нүглээ наманчлах болон уучлал өчүүхэн хэмжээний ч гэсэн байсан бол, тэд хамтдаа, анхны жилүүддээ элбэгээр адислагдсан халуун дотно харьцаандаа баясан байсаар байх байсан.

## Уучлалаар Дамжин Ирдэг Амар Амаглан

Хэрэв зүрх сэтгэлдээ хэн нэгэнд дайсагнасан үзэн ядалтын харьцааг бий болгогч ямар ч хүнийг Их Эзэнээс өршөөх хүч чадлыг гуйхыг би та нараас хүсч байна. Энэхүү хүслийн илэрхийлэл нь нүглээ наманчлахын тань үнэн мөн чанар нь болно. Энэ нь амархан биш байж магад, энэ нь хурдан ирэхгүй байж болно. Гэхдээ хэрэв та нар үүнийг чин сэтгэлээсээ эрэлхийлэн өөрсөддөө бий болгох юм бол энэ нь танд *байх болно*. Мөн хэдийгээр таны уучилсан тэр хүн таныг үргэлжлүүлэн мөрдөн мөшгиж мөн заналхийсэн ч,

эвлэрэхийн тулд юу нөлөөлж болохыг үзүүлж чадсан гэдгээ мэдэх болно. Зүрх сэтгэлд тань амар амгалан өөрөөр хэлбэл ханаж баршгүй их байх болно. Тэр амар амгалан нь:

“Учир нь, хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал Тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна.

“Харин хэрэв та нар хүмүүсийг уучлахгүй бол Эцэг тань мөн та нарын алдааг уучлахгүй” гэж хэлсэн Түүнийх билээ (Матай 6:14–15).

### Үрэлгэн Хүү

Би бүх уран зохиолоос илүүгүй гайхамшигтай түүх Лукийн арвантавдугаар бүлгээс олддог гэдгийг мэднэ. Энэ нь нүглээ наманчилсан хүү ба өршөөнгүй аавын тухай түүх юм. Энэ нь түүнд хайртай бүх хүмүүсийг үл тоомсорлон, аавынхаа зөвлөгөөг эсэргүүцэн, өөрийнхөө өв хөрөнгийг үймсэн амьдралаар үрэн таран хийсэн хүүгийн тухай түүх юм. Бүхнээ үрчихсэн, тэрээр өлссөн мөн найз нөхөдгүй болсон байхдаа “тийнхүү тэр ухааран,” (Лук 15:17) түүнийг холоос харж буй, эцэг уруугаа буцаж очиход, эцэг нь “ихэд өрөвдөн гүйн ирж, тэврээд үнсэв” (Лук 15:20).

Энэ түүхийг уншихыг би та нараас хүсч байна. Эцэг эх бүр үүнийг дахин дахин унших ёстой. Энэ нь гэр бүл бүрийг оролцуулсан өргөн далайцтай бөгөөд бүх хүн төрөлхтнийг хамарснаас ч илүү өргөн хүрээтэй, учир нь бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийнхээ өршөөл ивээлээс хүртэн нүглээ наманчилж, дараа нь Түүний үлгэр дууриаллыг дагах ёстой үрэлгэн охид, хөвгүүд нь биш гэж үү?

Бидний Цагаатгагч болох Түүний Хайртай Хүү өршөөл ивээлийн гарыг сунгадаг боловч ийнхүү үйлдэхдээ Тэрээр наманчлалыг шаарддаг. Үнэн бодит мөн уужим санаатай өршөөлийн сүнс нь тэрхүү шаардагдаж буй наманчлалын илрэл байх болно. Их Эзэний хэлсэнчлэн—мөн Бошиглогч Иосефт өгөгдсөн илчлэлтээс би иш татъя:

“Тиймийн тул би чамд наманчлахыг зарлиглаж байна—наманчил, эс тэгвээс би чамайг амныхаа үгэн саваагаар, мөн хилэгнэлээрээ, мөн уураараа арчин хаях болно, мөн чиний зовлон гашуун байх болно—хэр зэрэг гашууныг чи мэдэх нь үгүй, хэр зэрэг хүчтэйг чи мэдэх нь үгүй, тийм ээ, тэвчихэд хэр зэрэг хэцүүг чи мэдэх нь үгүй.

“Учрыг болгоогтун, хэрэв тэд наманчлах аваас, тэд зовохгүй байж болохын тулд Бурхан, бибээр бүхний төлөө эдгээр зүйлүүдийг амссан билээ;

“Гэвч хэрэв тэд үл наманчлах аваас, бүр миний адилаар тэд зовох ёстой;

“Бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн. . . .

“Надаас сурагтун, мөн миний үгсийг анхаарагтун; миний Сүнсний номхон дөлгөөн байдалд алхагтун, мөн надаар дамжин амар амгалан чамд байх болно (С ба Г 19:15–18, 23).

Ийнхүү энэ нь зарлиг билээ, мөн Өөрийн агуу их үлгэр дууриаллын залбиралд, “Эцэг минь, . . . . Бид өртөнгүүдээ уучилсны адил, бидний өрийг мөн уучлаач” (Матай 6:9, 12) хэмээн гуйж Түүний амлалт ийнхүү билээ.

### “. . . Шархыг Боох нь”

“Хэнд ч өс хонзон саналгүй, бүгдэд энэрэнгүйгээр, . . . шархыг. . . боогтун” хэмээх иргэний дайны аймшигт эмгэнэлт явдлын талаар Абрахам Линколны хэлсэн үгс гайхалтай биш гэж үү (John Bartlett, *Familiar Quotations*–д [1968], 640).

Хайрт ах, эгч нар минь, шархнуудыг—тийм ээ, хорон муу үгс, зөрүүдлэн бий болгосон зовиурууд, биднийг буруутгасан байж болох тэдгээр хүмүүсээс “өс хонзон авахаар” төлөвлөгөө боловсруулснаас бий болсон олон шархнуудаа бооцгоё. Бид бүгдэд өс санах сүнс бага зэрэг байдаг. Аз болоход, хэрэв бид “төгс чанар хийгээд амар амгалангийн холбоо болох нөмрөг лугаа [өөрсдийгөө] энэрлийн холбоогоор хувцаслах” (С ба Г 88:125) юм бол, үүнийг давж, дийлэн гарах хүч бид бүгдэд байдаг.

“Алдах нь хүн төрөлхтнийнх, өршөөх нь бурханых юм” (Alexander Pope, *An Essay on Criticism*, 2:1711). Хуучан шархнуудын өвдөлтийг дурсахад, ямар ч амар амгалан байдаггүй. “Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно” хэмээн хэлсэн Христийн сайхан амар амгалан билээ (Матай 5:9).

1991 оны Зургадугаар сарын *Ensign*–аас, хуудас 2–5

# ГЭР БҮЛИЙН САНХҮҮГ ЗОХИЦУУЛАХ НЬ

8

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Саяхан худалдаж авсан юмсын жагсаалт гарга. Танд шаардлагатай юмс бүрийн хажууд *Ш* үсэг бич. Таны хүсэж буй гэхдээ зайлшгүй биш юмс бүрийн хажууд *Х* үсэг бич. Үрж цацах зуршлыг тооцоолон дүгнэхийн тулд энэхүү жагсаалтыг ашигла. Хэрэв та шаардлагагүй зүйлд хэт их мөнгө зарцуулж байвал, мөнгөө илүү ухаалгаар ашиглах арга замыг ол.
- Эхнэр, нөхөртэйгээ хамт ойрын хугацааны төсөв боловсруул—магадгүй нэг буюу хоёр долоо хоногийнх байж болно. Хуудас 34 нь дээрх жишээг удирдамж болгон хэрэглэхийг бод. Өөрсдийн тогтоосон төсвийн дагуу амьдрахаар хоёул хамтдаа хичээ.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүлийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүлийг уншиж ярилц.

### ӨӨРЧЛӨЛТ ДЭХ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх  
Ерөнхийлөгч Н.Элдон Таннер

Өнөөдөр би та нартай юуны талаар ярьж хуваалцах вэ гэвэл эдийн засгийн *ямар ч* нөхцөл байдалд тогтвортой байх тэр үндсэн гол зарчмуудыг бид дагах юм бол энэ нь санхүүгийн баталгаа хийгээд сэтгэл санааны тайван байдлыг авчирдгийг би ажигласан юм.

#### “Та нар Эхлээд Бурханы Хаант Улсыг Эрэлхийл”

Хамгийн түрүүнд, эдгээр эдийн засгийн зарчмуудын хүрээнд хэрэглэж болохуйц хэтийн төлөвлөгөө зохиож, үндсэн суурийг тавьж өгөхийг би хүсэж байна.

Нэгэн өдөр миний ач хүү надаас: “Би таныг болон бусад амжилт гаргаж буй хүмүүсийг ажиглан хараад би амьдралдаа амжилт олохыг хүсэж байна хэмээн бат шийдсэн. Тэднийг юу нь амжилтанд хүргэснийг тодорхойлохын тулд аль болох олон азтай, амжилт гаргасан хүмүүстэй ярилцлага хийхийг хүсэж байна. Тэгээд Өвөө, та өөрийн туршлага түүхийг гүйлгэн хараад таны амжилт дахь хамгийн гол хэсэг нь юунд байдаг гэдэгт итгэдэг вэ?” хэмээн асууж билээ.

Их Эзэний өгсөн миний мэдэх хамгийн их амжилттай болгох тэр томъёо бол “Эхлээд Бурханы хаант улсыг болон Түүний зөвт байдлыг хайгтун.

Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” (Матай 6:33) гэдгийг би түүнд хэлсэн.

Эхлээд Бурханы хаанчлалыг хайн *эрдэггүй* зарим хүмүүс санхүүгийн хувьд хөгжин дэвшдэг гэж хүмүүс маргадаг юм. Энэ бол үнэн. Гэхдээ хэрэв бид эхлээд Бурханы хаанчлалыг эрэлхийлэхэд Их Эзэн бидэнд зөвхөн материаллаг эд баялгийг амлаад байгаа юм биш. Өөрийн хувийн туршлагаас аваад үзэхэд ийм байдаггүйг би мэднэ. Хенрик Айбсений хэлснээр: “Мөнгө бол олон зүйлсийн гаднах хальс нь байж болох боловч үр (цөм) нь биш юм. Тэрээр хоол хүнсийг авчирдаг боловч хоол идэх хүслийг төрүүлдэггүй; эм тариаг авчирдаг ч, эрүүл мэндийг өгөхгүй; танилуудтай болгодог боловч найз нөхдийг үгүй; үйлчлэгчдийг гэхдээ үнэнч байдлыг биш; мөн баяр баясгалантай өдрүүдийг авчирдаг, гэвч аз жаргалыг үгүй” (*The Forbes Scrapbook of Thoughts on the Business of Life—m* [1968], 88) ажээ.

Хэрэв зүй ёсоор олж, зөв зорилгонд зориулах юм бол материаллаг адислалууд нь сайн мэдээний нэгэн хэсэг мөн. Ерөнхийлөгч Хью Б.Брауны нэгэн туршлагыг би санаж байна. Дэлхийн Нэгдүгээр Дайнд тэрээр залуу цэрэг байхдаа эмнэлэгт хэвтэж буй нэгэн нас өндөр болсон найзаа эргэв. Энэ найз нь үхлийн хаалганд ойртсон наян настай бөгөөд бусад хүмүүсээс хэд дахин илүү хөрөнгөтэй баян, саятан байжээ. Түүний салсан эхнэр, мөн таван хүүхдийнх нь алин ч түүнийг үл тоон, уулзаж эргэхээр эмнэлэгт ирдэггүй байв. Ерөнхийлөгч Браун найзынхаа “мөнгөөр худал-



дан авах боломжгүй алдсан зүйлс мөн эмгэнэлт байдлыг нь анзааран” бодсоноо, хэрэв амьдралаа дахин туулах байсан бол амьдралын мөрөө хэрхэн өөрчлөхийг тэрбээр найзаасаа асуув.

Хожим нь нас барахаасаа хэдхэн өдрийн өмнө нь тэр настай ноёнтоно: “ ‘Би амьдралаа эргэн бодоход магадгүй өөрт маань байсан сая сая мөнгийг хурааж байх явцад алдсан хамгийн чухал хийгээд үнэ цэнэтэй сайн чанар бол *ээжийн маань Бурханд итгэх жирийн тэр итгэл мөн хүмүүний үхэшгүй байдал байсан юм байна.*’

“ ‘. . . Та надаас амьдрал дахь хамгийн үнэ цэнэтэй зүйл юу вэ гэдгийг асуусан. Үүнийг тэр яруу найрагчийн өгүүлсэн тэдгээр үгсээс илүү сайхан үгсээр би хариулж чадахгүй нь’ ” хэмээн тэр хэлжээ. Тэрээр “Би Харийн Хүн” гэсэн нэртэй яруу найргийг уншихаар нэгэн жижиг номыг цүнхнээс нь гаргаж өгөхийг Ерөнхийлөгч Браунаас хүсэв.

Ээжийн минь заасан итгэл бишрэлд би харийн хүн,

Ээжийг минь уйлахад сонссон Бурханд би гаднын хүн,

Аавыг минь нас барахад тэврэн авсан үүрдийн гар хийгээд

“Унтлагын цаг” руу хөтлөх тайтгаруулалтанд би харийн хүн,

Агуу их дэлхий намайг дуудах үед түүнийг дагахаар бүхнийг орхисон би,

Хэзээ ч, яагаад ч сохорчихсон үед гараа Түүнээс татан авсныг мэдэлгүй,

Гайхшрал төрөх үедээ алдар нэр хоосон байдгийг хэзээ ч бодож байгаагүй,

Хойч үед тэр алт, эд баялаг нь гялгар саа мэт байдгийг ухаарсан билээ би,

Амьдралын турш хайн эрж байснаа олох үед жигшин зэвүүцсэн юм,

Би тэмцэж дийлэн давсны төлөө олонтаа шагнуулсан юм,

Гэвч гагцхүү ээжийг минь *итгэлтэй* хүн болгосон шиг тэр л итгэл байсансан бол,

Алдар нэр, хувь заяа, тааламжит зүйлс бүрийг тойрсон *бүхнийг* өгөх сөн.

“Энэ бол Сүмд төрж өссөн боловч үүнээс аллагдсан хүний мөхөж буй гэрчлэл байлаа. Энэ нь мөнгөөр авч болох бүх зүйлс түүнд байсан боловч дэлхийн баялагийг цуглуулахаар амьдралын хамгийн чухал зүйлсээ алдчихсан ганцаардмал хүний зүрх шимшрүүлсэн гаслан юм” (*Continuing the Quest* [1961], 32–35; налуу бичлэгийг нэмэв).

Мормоны Номонд бошиглогч Иаков энэхүү асуудлын тухайд зарим нэн чухал зөвлөгөөг бидэнд өгсөн байдаг.

“Харин та нар баялгийг эрэлхийлэхийн өмнө Бурханы хаант улсыг эрэлхийлэгтун.

“Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо дараа баялгийг олох болно, *хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас буюу*; мөн та нар сайныг үйлдэх зорилгын тулд тэдгээрийг эрэлхийлэх болно—нүцгэнийг хувцаслах, мөн өлссөнийг хооллох, бас боолчлогдсоныг чөлөөлөх, мөн өвдсөн бас зовсныг халамжлахад буюу” (Иаков 2:18–19; налуу бичлэгийг нэмэв).

Үндсэн зарчим болон хэтийн төлөвлөлтийн үүслүүдийн дараагаар эдгээр нь: Нэгдүгээрт, бид хаант улсыг эрэлхийлэх, ажиллаж, төлөвлөж мөн юмсыг ухаалгаар зарцуулах ёстой; ирээдүйг төлөвлөх хийгээд хаант улсыг байгуулахаар туслахын хамт бид адислагдсан баялгийг ашиглах ёстой гэх зэрэг байх болно. Үүрдийн энэхүү хэтийн төлөвлөгөөгөөр удирдуулан энэ бат бөх суурин дээр зарчмуудаа байгуулснаар бидний ухаалгаар төлөвлөж, хичээнгүйгээр даган мөрдөх ёстой амьдралынхаа ажил хөдөлмөр болон өдөр тутмын даалгавруудыг бид бат итгэлтэйгээр мөрдөж чадна.

Энэхүү нийгмийн тогтолцооны хүрээнд эдийн засгийн тогтвортой байдлын таван зарчмыг би тайлбарлах гэсэн юм.

## Аравны Нэгийг Шударгаар Төлөх нь

*Тогтолцоо #1: Аравны нэгийг шударгаар төлөх нь.* Аравны нэгээ төлөх гэдэг нь Их Эзэн болон Сүмд өгч буй бэлгийг төлөөлдөггүй гэдгийг бид ойлгодог болов уу хэмээн би үргэлж боддог. Аравны нэгийг төлж байгаа нь Их Эзэнд өрөө төлж байгаа хэрэг юм. Их Эзэн бол амьдралыг, түүнийг өөрийг нь багтаасан бүхий л адислалуудын эх сурвалж юм.

Аравны нэг төлөх гэдэг нь нэгэн зарлиг ба энэ нь амлалттай зарлиг юм. Хэрэв бид энэ зарлигт дуулгавартай байх аваас бид “амлалтын нутаг дэгжих” болно хэмээн амлагдсан билээ. Энэхүү хөгжил цэцэглэлт нь материаллаг эд баялгаас илүү чухал зүйлсээс бүрддэг—энэ нь сайн эрүүл мэндэд баярлах ба оюун санааны эрч хүчийг агуулдаг байж магад. Энэ нь гэр бүлийн эв нэгдэл болон сүнслэг байдлыг нэмэгдүүлэхийг багтаадаг. Эдүгээ аравны нэгээ бүрэн төлөөгүй хүмүүс та нарыг эдгээрийг хийх итгэл болон хүч чадлыг эрэн хайгаасай хэмээн би найдаж байна. Та нар Бүтээгчдээ харуулж энэхүү үүрэг хариуцлагыг

гүйцэлдүүлснээр, энэ зарлигт үнэнч байдаг зөвхөн тэдгээр хүмүүсийн мэддэгийн адил агуу гайхамшигтай аз жаргалыг та нар олох болно.

### Аривч Хямгач Амьдрах нь

*Тогтолцоо #2: Олноосоо багыг зарцуулж амьдрах нь.* Та зарцуулдагаасаа илүүг хэзээ ч олж чадах ямар ч арга замгүй гэдгийг би мэдэж авсан. Би хувь хүний олж авсан тодорхой хэмжээний мөнгө сэтгэл санааны тайван байдлыг авчрахаас илүү мөнгөндөө *хяналттай* байдгаас сэтгэл санаанд амар амгалан байна гэдэгт би туйлын их итгэдэг. Мөнгө нь дуулгавартай үйлчлэгч байж болох боловч олоход хүнд хэцүү үүрэг өгөгч билээ. Амьжиргааныхаа түвшингээс бага зэрэг илүү зүйлийг өөрсөддөө зориулан зохицуулдаг хүмүүс нөхцөл байдлаа хянадаг. Харин олдог мөнгөнөөс арай илүүг зарцуулдаг тэдгээр хүмүүсийг нөхцөл байдал нь хяналтандаа авдаг. Тэд боолчлогдсон юм. Ерөнхийлөгч Хибер Ж. Грант нэг удаа хэлэхдээ: “Хэрэв хүмүүний зүрх сэтгэлд болон гэр бүлд амар амгалан хийгээд сэтгэл хангалуун байдал авчрах ямар нэг зүйл байх юм бол энэ нь хэрэгцээнийхээ дагуу амьдрах юм. Мөн хэрэв зовлонтой, шантарсан мөн гутралд оруулах ямар нэг зүйл байх юм бол тэр нь өртэй байх ба үүрэг хариуцлагуудаа хүлээж чадахгүй байхыг хэлнэ” (*Gospel Standards*, товч. G. Homer Durham [1941], 111).

Бид олдгоосоо багыг зарцуулах гол арга зам нь энгийн ба—үүнийг сахилга бат, эмх журамтай байдал гэж нэрлэж болно. Эцсийн эцэст, амьдралын эхэн үед эсвээс хожим нь ч бай бид өөрсдийгөө, хооллох зуршлаа мөн эдийн засгийн хэрэгцээ хүслээ хүмүүжүүлэн суралцах ёстой. Олдгоосоо багыг зарцуулж мөн хэрэгцээтэй үед хэрэглэх зүйлсээ хадгалдаг тэр хүн хичнээн их адислагддаг билээ.

### Хэрэгцээ болон Хүслээ Ялгаж Сурах нь

*Тогтолцоо #3: Хэрэгцээ болон хүслээ ялгаж сурах нь.* Хэрэглэгчдийн хүслүүд нь хүмүүсийн хийсэн зүйл байдаг. Бидний өрсөлдөөнтэй чөлөөт үйлдвэрлэлийн систем нь хязгааргүй их бүтээгдхүүн, үйлчилгээг боловсруулж биднийг илүү тав тухтай мөн тансаг байдлыг хүсэхэд хүргэдэг. Би энэ системийн буюу эдгээр бүтээгдэхүүний, үйлчилгээний хангамжийг шүүмжлээгүй. Зөвхөн хүмүүс маань худалдан авсан зүйлдээ шүүмжлэл гаргадагт би санаа зовдог. Золиослол нь мөнхийн сахилга бат, эмх журмын чухал хэсэг гэдэгт бид суралцах ёстой.

Энд мөн бусад олон орнуудад Дэлхийн Хоёрдугаар Дайнаас хойш төрсөн олон эцэг

эхчүүд болон хүүхдүүдэд зөвхөн баян чинээлэг байдал танил болжээ. Олонхи нь агшин зуурт хүслээ биелэхийг шаарддаг. Ажиллах боломжтой хэн бүхэнд хангалттай ажлын боломжууд байна. Өчигдөрийн тансаг байдал нь ихэнх хүмүүсийн хувьд өнөөдрийн хэрэгцээ нь болж байдаг.

Залуу хосуудын хэв маягаар бол энэ нь гэрлэлтээ эхлэхдээ гэр орноо тохижуулан мөн өөрсдийгөө тансаг байлгахыг хүсэж байхад зөвхөн эдгээрийг гэхэд эцэг эхчүүд нь олон жилийн хөдөлмөр, золиослолоор олж авсны дараа эдэлдэг байв. Түргэн хугацаанд хэтэрхий ихийг хүссэнээр залуу хосууд зээлийн амар хялбар төлөвлөгөөнд бууж өгч өөрсдийгөө өрөнд оруулдаг. Сүмийн зөвлөж буй хүнсний нөөц болон бусад аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр энэ нь тэднийг санхүүгийн хэрэгцээ шаардлагаас хамгаална.

Хэтэрхий ихийг хүсэх мөн мөнгөө зохицуулан зарцуулж чадахгүй байдал нь гэрлэлтийн харилцаанд хүнд хэцүү ачааллыг өгдөг. Ихэнх гэрлэлтийн асуудлууд нь эдийн засгийн байдлаас үүдэлтэй мэт санагддаг—эсвэл гэр бүлийг тэтгэх дутмаг орлогоос, аль эсвэл олсон орлогоо буруу зарцуулдаг болдог.

Нэгэн залуу эцэг хүн санхүүгийн зөвлөгөө авахаар бишоп дээрээ очиж нөгөө нэг байнга тохиолдох түүхийг ярьж: “Бишоп оо, би инженерийн хувьд сайн бэлтгэгдсэн, би сайн цалин авдаг. Бүх сургуульд суралцаж байх турш мөнгийг хэрхэн олохыг заалгасан шиг санагддаг боловч хэн ч мөнгийг хэрхэн зарцуулахыг надад заасангүй” гэжээ.

Оюутан бүр хэрэглэгчийн боловсролын хичээлийг үзэх хэрэгтэй байдагт бид итгэдэг ч гэсэн анхны суурь бэлтгэлийг эцэг эхчүүд өгдөг юм. Эцэг эхчүүд энэхүү амин чухал бэлтгэлийг аз туршин орхих эсвээс, тэр хариуцлага, үүрэг даалгаврыг бүхэлд нь улсын сургууль болон их сургуулиудад шилжүүлж болохгүй.

Энэхүү бэлтгэлийн нэгэн чухал хэсэг нь өр авлагыг тайлбарлах явдал. Бидний ихэнхэд хоёр янзын санхүүгийн өр авлага байдаг—хэрэглээний өр болон хөрөнгө оруулалт буюу бизнесийн өр авлага. Хэрэглээний өр гэдэг нь бидний өдөр тутмын хэрэгцээнд ашиглан хэрэглэж буй тэдгээр зүйлсийг өр тавин худалдан авахтай хамаатай юм. Жишээ нь: хувцас хунар, электрон бараа, тавилга г.м. худалдан авах барааны үнийг хэсэгчлэн төлөхийг багтаах болно. Ирээдүйд авах цалин орлогоо барьцаалуулан зээлүүлснээр баталгаатай хэрэглээний өрөнд оруулдаг. Энэ нь их аюултай байж болно. Хэрэв бид ажлаас халагдах, бэртэх

эсвэл гэнэтийн бэрхшээл, урьдчилан тооцоогүй ноцтой явдалтай тулгарах юм бол бид үүрэг хариуцлагаа хүлээхэд хүндрэлтэй байх болно. Худалдан авсан барааны үнийг хэсэгчлэн төлөх гэдэг нь барааг хамгийн үнэтэйгээр худалдан авах арга зам юм. Мөн бидний худалдан авах гэж буй барааны үнэд их хүү бас үйлчилгээний хөлсийг нэмсэн байх ёстой.

Заримдаа залуу гэр бүлүүд зээлээр юм худалдан авахыг шаардлагатай гэж үздэгийг би ойлгож байна. Гэхдээ үнэхээр хэрэгцээтэй байгаагаас илүү ихийг бүү худалдан ав, мөн аль болох тэр даруй өр ширээ буцааж төлөхийг бид анхааруулдаг. Мөнгө муутай үед нэмэлт ачаа хүндрэл болох илүү хүү төлөхөөс зайлсхий.

Барааны үнийг хэсэгчлэн төлөх өр нь гэр бүлийн аюулгүй байдалд саад учруулахгүйгээр аюулгүй байдлыг бүрэн хангасан байх хэрэгтэй. Дамлан худалдаалах, эрсдэлтэй байгууллагуудад бүү хөрөнгө оруул. Дамлан худалдаалах нь хүнийг хөөргөж толгойг нь эргүүлэхэд хүргэдэг. Дахин ахиулах шунах хүслийг хянаж чадахгүйгээгээс болж олон аз жаргал, заяа төөргөө алдан азгүйдэлд хүргэсэн байдаг. Өнгөрсний харуусал гэмшлээс суралцацгаая, мөн цаг хугацаа, эрч хүч болон ерөнхий эрүүл мэндээ, нэмэгдээд байдаг материаллаг эд зүйлсийг шаардаж, ханаж цаддаггүй хүсэлд зориулан боолчлогдохоос зайлсхий.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл энэхүү бодож үзмээр зөвлөгөөг өгчээ:

“Өнгөрсөн үед урьд өмнө байгаагүйгээр Их Эзэн хүмүүний хувьд биднийг хүүхдүүдтэй болгож, хөгжил цэцэглэлтээр адисалсан билээ. Бидний эрх мэдэлд өгсөн энэхүү эх сурвалжууд нь энэ газар дэлхий дээр өөрсдийн ажлыг явуулахад сайн байх ба энэ нь шаардлагатай байгаа юм. Гэтэл бидний ихэнх нь хонь мал, амьтан, газар тариалан, амбаар сав болон эд баялагаар хангагдан цадсан байдаг ба бид тэдгээрийг хуурамч бурхан болгон шүтэн биширч эхэлсэн мөн тэдгээр нь биднийг удирдах хүчтэй болж байгаад би санаа зовж байна. Эдгээр сайхан зүйлүүдээс илүү итгэх итгэлийг маань туйлбартай байлгах зүйлс бидэнд байна уу? Олон хүмүүс хангалттай мөнгө, хувьцаа, бонд, үнэт цаасны хөрөнгө оруулалт, өмч хөрөнгө, зээлийн карт, тохижуулалт, тоноглол, автомашиныг багтаасан өөрийн төсөөлөл, хүслийн үйлчлэлд ихэнх цагаа хөдөлмөрлөн зарцуулдаг мөн үүний турш бие, сэтгэлийн аюулгүй байдлын баталгааг өгөхдөө дуртай байж, урт удаан үргэлжлэх аз жаргалтай амьдралд итгэн найддаг. Үүнд мартагдсан гол баримт бол эдгээр олон эх сурвалжуудыг гэр бүлүүд болон Бурханы хаант улсыг байгуулах чуулгуудад ашиглах нь

бидний үүрэг даалгавар мөн” (“The False Gods We Worship,” *Ensign*, 1976 оны Зургадугаар сар, 4).

Ерөнхийлөгч Кимбаллын хэлсэн мэдэгдэлд, гэрчлэлийн хэлбэрээр би дараах зүйлийг нэмж болох уу. Гэр бүлийн хэрэгцээ, ухаалаг хүслээс дээгүүр давсан эд хөрөнгө хураасны зэрэгцээгээр аз жаргал болон сэтгэл санааны тайван байдал нь нэмэгдэж буй тэр нөхцөл байдал хаана ч байдаггүй гэдгийг би мэднэ.

### Ухаалгаар Төсөвлөн Тооцоол

*Тогтолцоо #4: Төсөвтөө багтаан амьдарч, хөгжүүл.* Миний найз гадаадад суралцах хөтөлбөртэй БЯИС-ийн нэг семестерээр гадаад руу явсан охинтой байв. Тэр охин нь мөнгөний талаар байнга гэр лүүгээ захиа бичдэг байв. Найзын маань санаа зовоож байгаа зүйл гэвэл охинтойгоо холын дуудлагаар тэрээр ярихдаа охиноосоо тэр нэмэлт мөнгөний хэрэгцээний талаар түүнээс асуужээ. Ярианы гол утгыг охин тайлбарлахдаа: “Гэхдээ аав аа, таны илгээсэн мөнгөний зоос бүрийг юунд зарцуулсныг танд хэлж чадна” гэхэд,

“Гол учрыг нь чи ойлгосонгүй юм шиг байна. Мөнгө хаашаа үрэгдсэний өдрийн тэмдэглэл биш харин—зарцуулалтын төлөвлөгөө—болох төсөвлөлт надад сонирхолтой байна” гэж тэрээр хариулжээ.

Магадгүй эцэг эхчүүд нь, “Ямар ч мөнгөгүй, баяр хөөргүй байна, хүү чинь” хэмээн гэр рүүгээ цахилгаан илгээсэн коллежид явдаг хүүд, эцэг нь, “Ямар харамсалтай юм бэ, маш муу байна даа, аав чинь” хэмээн буцаагаад цахилгаан илгээсэн аавын адил байх хэрэгтэй.

Хэтэрхий олон хүмүүс хэрэгжүүлж буй төсөвгүй мөн нөөц хангамжиндаа тааруулж амьдрахаар өөрсдийгөө хүмүүжүүлээгүйг би олон жилийн турш олон хүмүүстэй ярилцлага хийж ажигласан юм. Олон хүмүүс төсөв нь тэдний эрх чөлөөг боогдуулдаг гэж боддог. Үүний эсрэг, амжилт гаргаж буй хүмүүс төсөв нь үнэхээр эдийн засгийн эрх чөлөөтэй болгодог гэдгийг сурч авсан байдаг.

Төсөвлөлт болон санхүүгийн удирдлага нь хэт их хэцүү, эсвэл цаг хугацаа шаардсан байх хэрэггүй. Төлбөр хийсэн баримтуудыг гулсын саванд, төлбөр хүлээн авсан баримтуудыг ээрүүлийн машин дотор мөн бэлэн мөнгөө кассанд хадгалдаг байсан нэгэн цагаачин эцгийн тухай түүх өгүүлсэн байдаг.

“Иймэрхүү байдлаар ажил хэргээ та хэрхэн явуулдгийг би мэдэхгүй л юм байна?” “Ашиг тань ямар байгааг та яаж мэддэг юм бэ?” хэмээн түүний хүү асуужээ.

“Хүү минь, би завин дээрээс буухад надад зөвхөн өмсөж байсан өмднөөс өөр юм байсангүй. Өнөөдөр эгч чинь зургийн багш, ах чинь эмч мөн чи өөрөө нягтлан. Надад машин, гэр орон бас сайхан бизнесийн ажил бий. Бүх зүйлсийн төлбөрийг хийчихсэн. Тиймээс тэдгээр бүхнийг нэмж үзээд, өмдний үнийг хасахад миний ашиг гарч ирнэ” хэмээн ажил хэрэгч тэр хүн хэлжээ.

Ухаалаг санхүүгийн зөвлөхүүд ямар ч сайн төсөв нь дөрөв янзын бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг хэмээн заадаг билээ. Нөөц хангамжийг *нэгдүгээрт*, хоол хүнс, хувцас хунар, г.м нөлөөлж буй үндсэн хэрэгцээг хангахад зориулсан байх; *хоёрдугаарт*, байшин сав, газрын төлбөрт; *гурвдугаарт*, хадгаламж, эрүүл мэндийн даатгал, амьдралын даатгал гэх урьдчилан тооцоогүй гэнэтийн нөхцөлд зориулсан байх; мөн *дөрөвдүгээрт*, ухаалаг хөрөнгө оруулалтанд болон ирээдүйн нөөцлөх хөтөлбөрт оруулсан байх ёстой.

Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн хоёрын тухайд би санал бодлоо хэлье. Бидний амьдралд дахь гэнэтийн зүйлүүдийн адил бүх зүйл тийм тодорхой байдаггүй хэмээн санагддаг. Эмчилгээний төлбөр өсөн нэмэгдэж буй үед ихэнх гэр бүлүүдийн хувьд ноцтой аюул осол, өвчин зовлон эсвэл төрөлтөд зарцуулагдах зардлууд, ялангуяа цагаас өмнө төрөх хүндрэлүүдийг даван гарах цорын ганц зам нь эрүүл мэндийн даатгал болж байдаг. Тэтгэн тэжээгч нь гэнэт нас барах үед амьдралын даатгал нь үргэлжлүүлэн тэтгэмжээр хангах болно. Гэр бүл болгон тухайн эрүүл мэнд ба амьдралын даатгалд зохих ёсны нөөц, хангамжийг бэлтгэсэн байх ёстой.

Эдгээр үндсэн хэрэгцээг хангасны дараа, аривч хямгач менежментийг мөрдөж мөнгө тогтмол хурааснаар хөрөнгө оруулалтанд зориулах санг бид бий болгож чадна. Миний ажигласнаар эхэндээ мөнгө тогтмол хураах зуршлыг хөгжүүлээгүй байсан хэдэн хүмүүс хөрөнгө оруулалтын хувьд амжилттай байв. Энэ нь хүмүүжил, гярхай шүүлтгийг шаарддаг. Хөрөнгө оруулах олон арга зам бий. Миний зөвлөмж бол хөрөнгө оруулалтын зөвлөхүүдээ ухаалгаар сонго. Тэд таны итгэлийг авч, амжилт бүхий хөрөнгө оруулалтын тоо баримт тэмдэглэлийг хөтөлж буйг анхаарч бай.

### Үнэнч Шударга Бай

*Тогтолцоо #5: Өөрийн бүх санхүүгийн ажил хэрэгт үнэнч шударга бай.* Шударга байх ойлголт нь хэзээ ч хоцрогдохгүй. Энэ нь бидний хийж буй бүх зүйлд хамаатай. Энэхүү Сүмийн удирдагч, гишүүдийн хувьд бид шударга байдлын амьд жишээ байх хэрэгтэй.

Ах эгч нар аа, эдгээр таван зарчмуудаар дамжуулж би санхүүгийн болон эх сурвалжийн удирдлагын бодит арга зам нь ямар байж болохыг тодорхойлж, дүрслэн үзүүлэхийг хичээсэн юм.

Хэрэгжүүлэхэд зориулсан уриа, санаанууд бид бүгдэд ач тустай байх гэдэгт би найдаж байна. Тэдгээр нь үнэн бодит ба энэ Сүм мөн бидний хийж буй энэхүү ажил үнэн гэдгийг би гэрчилж байна.

1979 оны Аравдугаар сарын Сүмийн ерөнхий чуулганы Ерөнхий Нийгмийн Халамжийн Бүлгийн хуралдаанд Ерөнхийлөгч Таннерын хэлсэн үгнээс (Conference Report, 1979 оны Аравдугаар сар, 177–21; эсвэл *Ensign*, 1979 оны Аравдугаар сар, х. 80–82–г үз).

<b>ОРЛОГО</b>	ТӨЛӨВЛӨСНӨӨР	БОДИТ БАЙДАЛД
Татвар төлсний дараах цалин буюу хөлс		
Бусад орлогууд		
<b>Нийт орлого</b>		
<b>ЗАРДЛУУД</b>	ТӨЛӨВЛӨСНӨӨР	БОДИТ БАЙДАЛД
Аравны нэг		
Сүмийн бусад хандивууд		
Урт хугацааны хадгаламж		
Гэнэтийн аюул, нөхцөл байдалд зориулсан хадгаламж		
Хоол хүнс		
Зээл барьцаа буюу түрээс		
Цахилгаан, дулаанд		
Нийтийн тээвэрт		
Өр төлөхөд		
Даатгал		
Эмчилгээний зардлууд		
Хувцас хунарт		
Бусад		
Бусад		
Бусад		
<b>Нийт зардлууд</b>		

# Б ХЭСЭГ ГЭР БҮЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭЦЭГ ЭХИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГУУД





# “ҮР ХҮҮХЭД БОЛ ИХ ЭЗЭНИЙ ӨВ ЮМ”

9

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Өнөр өтгөн гэр бүлийнхээ хүүхэд бүртэй эсвэл хүүхэд тус бүрт тусгай цаг гаргах амлалтыг өг. Хүүхэд тус бүртэй ярих үед түүний сонирхол, хэрэгцээ болон бэршээлүүдийн талаар ямар нэгэн шинэ зүйлийг суралцахыг эрмэлз.
- Эхнэр нөхөртэйгээ хүүхдүүдийнхээ талаар ярилцахаар цаг гарга. Хүүхэд тус бүрийн хүчин чадал болон бэрхшээлүүдийн талаар бод. Та хүүхэд тус бүрийн хэрэгцээг нийцүүлэхийн тулд юу хийж чадахаа тодорхойл.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### ҮНЭ ЦЭНЭ БҮХИЙ ХҮҮХДҮҮД БУРХАНЫ БЭЛЭГ ЮМ

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Ерөнхийлөгч Томас С.Монсон

Бид Матайн номноос Есүс болон Түүний дагалдагч нар Хувиралтын Уулнаас буусны дараа Галилд саатан, дараа нь Капернаумд ирснийг мэдэж авсан. Шавь нар нь Есүсээс “Тэнгэрийн хаанчлалд хэн нь хамгийн агуу нь вэ?” хэмээн асуужээ.

“Тэр нэгэн хүүхдийг өөр уруугаа дуудаад, тэдний дунд суулгаж айлдсан нь,

“Үнэнээр Би та нарт хэлье. Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй.

“Иймээс хэн өөрийгөө энэ хүүхдийн адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно.

“Миний нэрээр ийм хүүхдийг хүлээн авсан хэн боловч Намайг хүлээн авсан хэрэг.

“Харин хэн Надад итгэгч эдгээр багачуудаас нэгийг нь бүдрүүлнэ, түүний хувьд хүзүүндээ тээрмийн хүнд чулуу зүүгээд тэнгисийн гүнд живсэн нь дээр.”<sup>1</sup>

Газар дэлхийд ирэхийн тулд саяхан өмнөх амьдралаа орхин ирсэн эдгээр багачуудыг Есүс хайрладаг байсан нь гайхалтай гэж би бодож байна. Хүүхдүүд тэр үед ч, мөн өнөө үед ч бидний амьдралыг адисалж, хайрыг маань бадрааж, мөн сайн үйлс хийхийг урамшуулдаг.

Яруу найрагч Уордзворт бидний төрөлтийн талаар хэлэхдээ: “Орон гэр маань болох Бурханаас алдар сууны үүлэнд дайгдан Бурханаас бид ирдэг үү”<sup>2</sup> гэдэгт ямар нэг гайхах зүйл бий гэж үү гэжээ.

Эдгээр багачуудын ихэнх нь тэдний ирэхийг тэсэн ядан хүлээж буй эцэг эхчүүд мөн бидний төрөлт хэмээн нэрлэдэг тэрхүү гайхамшгийн нэгэн хэсэг болохын төлөө байрлаж буй ээж аав нар дээр ирдэг билээ. Үүний төлөө ямар ч золиослол хэт их биш, ямар ч өвчин хүнд биш, ямар ч хүлээлт удаан биш юм.

Мэдээллийн хэрэгслээр Америк дахь нэгэн хотоос гаралтай түүх нь “нэгэн хогийн саванд цаасан уутаар ороож хаясан дөнгөж төрсөн нялх охин эмнэлгийн хатуу хяналтанд байгааг мэдэгдэх үед бид цочирдсон гэдэгт гайхаад байх зүйл алга. Хүүхэд сайн байгаа. ‘Тэр үнэхээр үзэсгэлэнтэй эрүүл бяцхан охин’ хэмээн эмнэлгийн төлөөлөгч Лхагва гарагт хэлсэн. Хог ачигч хүмүүс хогийн савыг ачааны машиныхаа ард хэсэгт суллахдаа хогон дунд ямар нэгэн юм хөдлөхийг олж харж, энэ бяцхан охиныг олсон гэж цагдаагийнханд хэлжээ. Эрх мэдэл бүхий хүмүүс эхийг нь хайж байна.”

Амьдралыг маань ивээх хүүхдүүдийг өөрсдийн гэр орон мөн зүрх сэтгэлд урин тааламжтай байлгах нь—бидний чин сэтгэлийн үүрэг, бидний эрхэм эрх мэдэл—тэр ч бүү хэл бидний ариун нандин боломж юм.

Хүүхдүүд маань нэг нэгнээсээ нэлээд ялгаатай гурван суралцах танхимтай. Би сургууль дахь танхим, сүм дэх танхим мөн гэр орон дахь танхимын тухай ярьж.



## Сургууль дахь Танхим

Сүм үргэлж ерөнхий боловсролыг чухалд авч үздэг ба гишүүдийг эцэг, эх, багшийн үйл ажиллагаа мөн залуучуудынхаа боловсролыг сайжруулахад зориулсан бусад арга хэмжээнд оролцохыг уриалан дэмждэг.

Залуу эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд болон хүссэн охид, хөвгүүдийг багш хүн урамшуулах мөн тэднийг хайрлаж, заах боломжтойгоос илүү өөр чухал ерөнхий боловсролын бодлого гэж хаа ч үгүй билээ. Ерөнхийлөгч Давид О.МакКей хэлэхдээ: “Багшлах гэдэг нь энэ дэлхийн хамгийн эрхэм хүндэт мэргэжил юм. Залуучуудын жинхэнэ боловсролд цэвэр ариун хийгээд тогтвортой гэр бүл, аюулгүй, мөнх баттай үндэстэн хамаарна. Эцэг, эхчүүд хүүхдэд амьдрах боломж өгдөг; багш нар хүүхдэд сайн амьдрах эрх олгодог”<sup>3</sup> гэв. Хангалттай тоног төхөөрөмж, сайн номууд болон талархал, итгэлээ харуулдаг цалингаар хангаснаар тэдний чухлыг мөн тэдний нэн чухал номлолыг бид танин мэдэх болно гэдэгт би итгэж байна.

Бид бүхэн багынхаа багш нарыг хайр, хүндэтгэлтэйгээр санадаг. Миний бага ангийн хөгжмийн багш Хатагтай Шарп байсан нь хөгжилтэй байдаг байсан гэж би боддог. Тэрээр өөрийнхөө сурагчдыг хөгжимд дуртай болоход нь итгэл төрүүлж мөн хөгжмийн зэмсгүүд болон ая тодорхойлохыг бидэнд заасан чадварлаг хүн байсан юм. Эрүүл мэндийн хичээл заадаг байсан Хатагтай Рут Кроугийн нөлөөг би сайн санаж байна. Хэдийгээр энэ нь Эдийн Засгийн Зогсонги үе байсан ч тэрээр бүх зургадугаар ангийн сурагчдад шүдний эрүүл мэндийн картыг авсан байхад анхаарсан юм. Тэрээр сурагч бүрийн шүдний эрүүл мэндийн хувийн үзлэг хийж, улсын болон хувийн нөөц, эх сурвалжаар дамжуулж ямар ч хүүхдийг шүдний тодорхой хэмжээний эмчилгээгүйгээр явуулахгүй гэдгийг шийдсэн байв. Газарзүй ордог байсан Хатагтай Бөркхаус шиг дэлхийн газрын зургийг гаргаж, заагчаараа улс, үндэстний нийслэл хотуудыг заан, улс орон, хэл, ёс заншил бүрийн онцлог шинж чанарыг тэмдэглэхэд хэзээ нэгэн цагт эдгээр газар болон хүмүүстэй би уулзана гэж таамаглан мөрөөдөж байж билээ!

Хүүхдүүдийн маань амьдралд сэтгэл санаа, сүнснийг нь дээшлүүлэн урамшуулдаг, оюун ухааныг нь хөгжүүлж, үнэндээ амьдралыг сонирхолтой болгодог багш нар хичнээн чухал билээ.

## Сүм дэх Танхим

Сүм дэх танхим нь бүх хүүхэд болон залуучуудын боловсролын амин чухал цар хүрээг нэмдэг. Ийнхүү орчинд байгаа бүх багш нар нь хичээлийг нь сонсож буй тэдгээр хүмүүст урагш тэмүүлэн өндөрлөгт гаргахад нь хангаж мөн өөрс-

дийн гэрчлэлийн нөлөөг мэдэрч чадна. Их Эзэний сүнслэг урмаар дуудагдсан Хүүхдийн Хэсэг, Ням Гарагийн Хичээл, Залуу Эмэгтэйчүүдийн цуглааны мөн Аароны Санваарын тэдгээр сайн бэлтгэгдсэн багш нар хүүхэд, залуучууд бүрт хүрч мөн бүгдэд нь, “мэргэн ухааны үгсийг шилдэг номнуудаас эрэлхийлэгтүн . . . ; бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн”<sup>4</sup> гэж санааг хэлж болно. Энд урам өгөх үг, тэнд сүнслэг бодол нь үнэ цэнэтэй амьдралд нь нөлөөлж, үхэшгүй сүнсэнд мартагдашгүй ул мөрийг үлдээж чадна.

Олон жилийн өмнө Сүмийн сэтгүүлийн шагнал гардуулах хүндэтгэлийн зоог дээр бид Ерөнхийлөгч болон Харолд Б.Ли Эгчтэй цуг суусан. Ерөнхийлөгч Лий манай өсвөр насны охин Аннад: “Их Эзэн чамайг сайхан бие болон царай зүсээр адисалсан байна. Дотор талаа ч гэсэн гадна тал шигээ байлга, тэгвэл чи жинхэнэ аз жаргалаар адислагдана” гэж хэлж билээ. Энэ ахмад багш Тэнгэрлэг Эцэгийн маань сэлэстиэл хаант улс руу урамтайгаар хөтлөх удирдамжийг Аннад үлдээсэн юм.

Сүм дэх танхимын даруу, сүнслэгээр урамшуулсан багш нар нь сурагчдаа сударт хайртай байхыг сургаж чадна. Яагаад багш нар хуучны Төлөөлөгчид болон дэлхийн Аврагчийн талаар зөвхөн ангид биш, харин хүүхдүүдийн маань зүрх сэтгэл, оюун ухаан, сэтгэл зүрхэнд нь хөндөж болохгүй гэж.

## Гэр дэх Танхим

Магадгүй бүх танхимын хамгийн чухал нь гэр дэх танхим юм. Бид гэртээ л харьцах харьцаагаа, гүн гүнзгий итгэж буй шүтлэг бэшрэлээ хөгжүүлэн бий болгодог. Энэ нь бид гэртээ л итгэл найдварыг устгаж, аль эсвэл хөгжүүлж байдаг юм. Өрх гэр маань амьдралын маань лаборатори юм. Бид орон гэрээ орхин явах үед гэртээ юу хийж байсан нь амьдралын маань чиг хандлагыг шийддэг. Доктор Стюарт И.Розенберг, “Өөртөө Итгэх Итгэлийн Арга Зам” хэмээх номондоо, “Орчин үеийн загварууд болон бүх шинэ зохион бүтээлтүүд, гойд эрхэмлэх зүйл хийгээд цамаан занг үл харгалзан гэр бүлийнхээ санаанд нийцэх зүйлийг эдүгээ хэн ч зохион бүтээгээгүй мөн цаашид ч зохион бүтээхгүй”<sup>5</sup> хэмээн бичсэн байдаг.

Аз жаргалтай өрх гэр бүл нь харин ч өмнөх тэнгэр юм. Ерөнхийлөгч Жорж Алберт Смит: “Бид өрх гэрээ аз жаргалтай байлгахыг хүсэж байна [уу?] Хэрэв тийм бол, бид түүнийг талархал ба хүндэтгэлээ үзүүлэх, залбирал орших газар болгоё”<sup>6</sup> гэжээ.

Бие махбод буюу оюун ухааны согогтой хүүхдүүд энэхүү зуурдын амьдралд ирдэг нөхцөл

байдлууд бий. Бид мэдэхийг хичээсэн ч яагаад, эсвээс хэрхэн ийнхүү зүйлүүд тохиолддогийг мэдэх боломжгүй юм. Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхдүүдийн нэг болох тэрхүү хүүхдийг хайрлаж, золиослолын илүү хэмжээг гарган ямар ч гомдол гаргалгүй гар дээрээ авч, амьдралдаа хүлээн авсан тэдгээр эцэг эхчүүдэд би хүндэтгэн ёсолж байна.

Нэг зун Аспен Гровийн Гэр Бүлийн Зугаалганд, би төрөхдөө гэмтсэн зөвхөн эхийн харьяа хяналтанд байдаг нэгэн өсвөр насны охиныг ээж нь анхаарал болгоомжтойгоор хооллож байхыг би харж байв. Охиныхоо толгой, хүзүүг тэгш барих зуураа эх нь хоолтой халбагыг бүр, ус залгих болгонд үйлчилж байв. *17 жилийн турш өөрийн хоол хүнс, зугаа цэнгэл, ая тухыг бодолгүйгээр охиндоо энэхүү үйлчлэл болоод бусад зүйлээр хангаж байсан Эх хүнийг* би дотроо чимээгүйхэн бодож байлаа. Ийм эцэг, эхчүүд болон ийм хүүхдүүдийг Бурхан адислах болтугай. Тиймээс Тэрээр адислах болно.

### Хүүхдүүдийн Гэнэн Сэтгэл

Дэлхий дээрх хамгийн хүчтэй олон сэтгэлийн хөдөлгөөн хослох сэтгэл хөдлөлт нь ямар нэг агуу их сансрын үйл явдлаас бий болох биш, роман буюу түүхийн номноос олддоггүй, харин энэ нь зөвхөн унтаж буй хүүхдийн дээрээс ширтэн харж буй эцэг эхүүд олж мэддэгийг газар бүрт байгаа эцэг эхчүүд ойлгодог.

Унтаж буй хүүхдийг дээрээс нь ширтэн харж байх үед Чарльз М.Диксоны үнэн үгс бодолд орж ирдэг:

*Тэд бол өрх гэрийн мөн сэтгэл зүрхний шүтээн,  
Тэд бол зүсээ хувиргасан Бурханы тэнгэрийн элч нар;  
Тэдний сүлжсэн гэзгэн дээр нарны туга нойрссоор,  
Тэдний нүдэнд Түүний алдар суу гялалзсаар байна;  
Тэд Тэнгэрээс мөн гэрээс ирсэн хичээл таслагчид ч,  
Тэд намайг улам зөөллөж бас даруусгасан болой;  
Тиймд Есүс юунд тэднийг хайрлагдгийг эдүгээ мэднэ би  
Учир нь Бурханы хаант улс хүүхдүүдийнх билээ.<sup>7</sup>*

Хүүхэдтэй харьцах өдөр тутмын туршлагаас, тэд бол хамгийн их ирээдүйтэй, ихэнхдээ тэд гүн хүчтэйгээр үнэнг илтгэгчид гэдгийг бид олж мэддэг. Христийн Мэндэлсний Баярын Дууг зохиосон сонгодог бүтээлийн зохиолч Чарльз Диксон, хэдийгээр ядуу тарчиг байсан ч урт удаан горьдон хүлээлгэсэн Христийн Мэндэлсний Баярын оройн зоог дээр тэр даруу Боб Кратчитын гэр бүл цугларч буйг тэрээр тайлбарлахад энэхүү баримтыг дүрслэн үзүүлжээ. Эцэг нь болох Боб нь мөрөн дээрээ бие муутай хүү Тайни Тимийг суулган гэртээ орж ирэв. Тайни Тими нь “сугандаа жижигхэн таягтай мөн үе мөчийг нь төмөр рамаар бэхэлсэн

байлаа.” Бобын эхнэр түүний тухай асуухдаа: “За, жижиг Тим ямар шуу байсан вэ?” гэв.

“Алт шиг сайн байсан” хэмээн Боб хариулангаа, “тэр ч бүү хэл илүү сайн байсан. Яагаад ч юм ганцаар их суухдаа тэрээр бодлогошронгүй болчихдог мөн чиний урьд өмнө хэзээ ч сонсож байгаагүй сонин зүйлийг боддог. Тэрээр надад гэр лүү явж байхад хүмүүс түүнийг сүмд хараасай хэмээн найдаж буйгаа надад хэлсэн. Тэр тахир дутуу хүн учраас энэ нь Христийн Мэндэлсний Баярын Өдөрт доглон гуйлгачинг алхуулж мөн сохор хүмүүсийн харааг оруулсан хэн болохыг тэдэнд сануулах сайхан зүйл байх болно гэдгийг хэлсэн ажээ.”<sup>8</sup>

Чарльз Диксон өөрөө өөртөө “Би эдгээр бяцхан хүмүүст хайртай, Бурханаас дөнгөж сая ирсэн тэд бидэнд хайртай байдаг нь ялихгүй зүйл биш юм” гэж хэлсэн байдаг.

Хүүхдүүд хайраа шинэ арга замаар мөн бодитойгоор илэрхийлдэг. Хэдэн жилийн өмнө миний төрсөн өдөр дээр өхөөрдөм бяцхан охин надад гараараа бичсэн төрсөн өдрийн мэндчилгээг өөрийнхөө дуртай жижигхэн тоглоомон зүүдэг цоожоор дугтуйгаа цоожлон бэлэглээд, үүнийг бэлэг хэмээн болгооход намайг баярлана гэж бодсон юм.

“Мөн ямар ч жижиг зүйл өгсөн ч гэсэн, хүүхдийн өгөх ямар нэгэн зүйл нь дэлхий дээр байгаа бүх хүндэт зүйлүүдийн алинтай нь зүйрлэшгүй сайхан байдаг билээ. Хүүхэд танд дэлхийг өгнө. Таны хэзээ ч унших боломжгүй байсан ном шиг тэд танд дэлхийг нээж өгнө. Гэхдээ бэлэг олдох үед, энэ нь үргэлж жижигхэн дэгээн дээр зүүсэн сонин хачин . . . жишээ нь тэнгэр элч нар алиалагч мэтээр байгаа . . . тийм жижиг зүйл байдаг. Өөрийн өгч чадах зүйл нь хүүхдэд үнэхээр бага байдаг боловч энэ нь танд бүхнийг өгснийг хэзээ ч мэдэгдэхгүй.”<sup>9</sup>

Яг л Женнигийн надад өгсөн бэлэг шиг билээ.

Тэнгэрлэг Эцэгтээ удаан үргэлжилсэн итгэх итгэлээр хүүхдүүд ивээгдсэн мэт санагддаг харин Түүний хүчин чадал ба хүсэл нь тэдний өхөөрдөм залбирлыг хариулахад байдаг. Хүүхэд залбирах үед Бурхан сонсдог гэдгийг би хувийн туршлагаасаа хэлж байна.

Урьд нь Атланта Брейвс бейсболын клубд байсан нэрд гарсан мэргэжлийн бейсболын тоглогчид болох Барри Боннелл ба Дейл Мөрфигийн тухай түүхийг би та нартай хуваалцаа. Дейл Мөрфт Барри Боннелл баптисм хүртээж, тэд хоёулаа Сүмд хөрвүүлэгдсэн юм.

“Энэ үйл явдал нь 1978 онд Барригийн тодорхойлсноор ‘амьдрал өөрчлөгдмөөр’ улиралд болсон. Тэр ойролцоогоор хоёр зуу орчим бөмбөгийг

оруулахын тулд маш ихээр тэмцэж байлаа. Учир нь өөрийн тааруу тоглолтоос болж тэр өөрийгөө доогуур үнэлж, гутарч байсан. Дейл Мөрфи түүнтэй цуг эмнэлэг рүү явахыг хүсэхэд тэрээр үнэхээр явахыг хүсээгүй ч гэсэн тэр ямар ч л байсан хамт явсан. Тэнд цус багадалт өвчнөөр шаналж буй хүү, [Атланта] Брейвсийн үнэнч хөгжөөн дэмжигч Рики Литтлтэй тэрээр танилцжээ. Рикийг үхэл дайрах гэж байгаа нь бараг илт байлаа. Баррийд сэтгэлийг тайвшруулан тайтгаруулах ямар нэгэн үгийг хэлэх маш их хүсэл төрсөн боловч тохирох үг байхгүй мэт санагдав. Эцэст нь, тэд юугаар түүнд тусалж болохыг тэрээр асуужээ. Хүү жаал тээнэгэлзэн түгдэрсний эцэст тэд тус бүрдээ дараагийн тоглолтын үеэр түүнд зориулан сүүлчийн шийдвэрлэх бөмбөгийг оруулахыг хүсэв. Барри [хожим] нь хэлэхдээ: “Үнэндээ тэр үдэш хоёр шийдвэрлэх бөмбөг хийсэн Дейлийн хувьд тэрхүү хүсэлт нь тийм ч хэцүү байсангүй, харин бүхэл жилийн турш шийдвэрлэх бөмбөг хийж байгаагүй миний хувьд нэг л болж өгөхгүй хэцүү байлаа. Тэгээд надад нэгэн дулаахан мэдрэмж төрөхийг би мэдрээд би Рикид үүнд итгэн найдахыг хэлсэн юм.” Тэр орой, Барри тэр улирлын өөрийн ганц шийдвэрлэх бөмбөгийг оруулжээ.<sup>10</sup> Хүүхдийн залбирал хариулагдаж, хүүгийн хүсэл биелэгджээ.

### Аюулгүй Байдлын Хэрэгцээ

Хэрэв хүүхэд бүхэн хайраа үзүүлдэг эцэг эх, аюулгүй байдлыг хангасан гэр орон хийгээд хайр халамжтай найз нөхөдтэй байдаг сан бол дэлхий ямар гайхалтай сайхан байх билээ. Харамсалтай нь хүүхэд бүхэн их өгөөмрөөр адислагдаагүй байдаг. Зарим хүүхдүүд ээжүүдийг нь аав нар нь зэрлэгээр зодож байхыг гэрчилж байхад бусад нь ийнхүү хүчэрхийлэл доромжлолын төгсгөлийг хүлээн авдаг. Ямар хулчгар байдал вэ, ямар нүгэлтэй, жигшмээр зүйл вэ!

Ул үндэсгүй хуурамч царайтууд нь хүүхэд “хаалганд цохиулчихсан” эсвээс “шатан дээрээс унчихсан” гэх худал ярьж, хөхрүүлэн бэртээж, зодсон эдгээр багачуудыг авчрахад газар сайгүй орон нутгийн олон эмнэлэг хүлээн аваад байгаа. Хүүхдэд хүч хэрэглэн доромжилдог дээрэлхүү худалч тэд хэзээ нэгэн цагт бохир, заваан үйлдлүүдийнхээ төлөө шагналаа хүртэх болно. Хүчирхийллийн золиос болсон чимээгүй байгаа бэртсэн, мөн гомдсон хүүхдүүд тусламж авах ёстой.

Надад хаягласан захианд бүсийн шүүгч: “Бэлгийн харьцааны хүүхдийн хүчирхийлэл нь соёлтой нийгмийн хамгийн ёс суртахуунгүй, хөнөөл үзүүлэх мөн зүрх шимшрүүлсэн гэмт хэрэг юм. Бие махбод сэтгэлзүйн болон бэлгийн харьцааны хувьд хүүхдийг хүчирхийлсэн тухай мэдээ-

лэл нэмэгдэж буй нь түгшүүртэй байна. Шүүх хурлууд маань тийнхүү зэвүүн, бузар үйлдлийн хэргүүдээр дарагдаж байна” хэмээн мэдэгдсэн юм.

Сүм нь тийнхүү жигшүүртэй, ой гутам байдлыг өршөөдөггүй. Үүний оронд, бид Бурханы үнэ цэнэ бүхий хүүхдүүдэд тийнхүү хандсан тэрхүү жигшүүрт хэргүүдийг зэмлэн цээрлүүлдэг. Хүүхдийг хайрлан, энхрийлж, авран эдгээж, тэтгэн халамжилцгаая. Гэмт этгээдүүдийг үйлдлүүдийнх нь төлөө шүүхэд татаж, тийнхүү ёс суртахуунгүй, хорон санаатай байдлыг багасгахаар мэргэжлийн хуульзүйн арга хэмжээ авсугай. Ийнхүү үйлдлийг мэддэг мөртлөө үүнийг таслан зогсоох арга хэмжээ авахаасаа айн хулчийсан үед та бид тэрхүү асуудлын нэг хэсэг нь болдог. Бид тэр гэм буруугийн нэг хэсгийг хүлээдэг. Бид тэр шийтгэлийн нэг хэсгийг мэдэрдэг.

Би эдгээр багачуудад хайртай бас Их Эзэн тэдэнд хайртай учраас би хэт их хатуу ширүүн хэлээгүй байх гэдэгт найдъя. 3 Нифайд дүрслэн үзүүлсэн Есүс хүүхдүүдийг адисалж буй туршлагаас илүү сэтгэл хөдөлгөм ийнхүү хайрыг өгүүлснийг хаанаас ч олж чадахгүй билээ. Энэ нь Есүс өвчтэйг эдгээж, хүмүүст зааж, тэдний төлөө Тэнгэрлэг Эцэгт залбирч байсныг өгүүлдэг. Тэгээд түүний үнэт үгсийг та нарт би иш татахыг болгооно уу:

“[Есүс] тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

“Мөн тэр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав;

“Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Өөрсдийн бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.

“Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг үзэв, мөн тэд тэнгэр элчүүд тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; . . . мөн тэнгэр элчүүд тэдэнд тохинуулсан болой.”<sup>11</sup>

*Ийнхүү үйл явдал өнөө үед ч тохиолддог уу?* хэмээн та асууж болно. Олон жилийн өмнө номлолд үйлчилж байсан нэгэн өвөг дээдсийн ярьсан тэр сайхан түүхэнд, тэдний бяцхан ач хүү адислагдсан тэрхүү сургамжийн талаар та нартай хуваалцахыг болгооно уу. Тэрхүү номлогч өвөө бичихдээ:

“Эдүгээ миний эхнэр Деанна, бид хоёр Огайо дахь Жаксоны номлолд үйлчилж байна. Бид номлолын дуудлагыг хүлээн зөвшөөрөх үед бидний хамгийн их санаа зовоож байсан зүйлүүдийн маань нэг нь гэр бүл маань байв. Гэр бүлийхэнд асуудалтай байх үед бид тэдэнтэй хамт байж чадахгүй байлаа.

“Бид номлолдоо очихоос яг өмнөх нь хоёр ой хагастай Р. Ж. ач хүүгийг маань солир нүдийг захаар хагалгаанд орох ёстой байв. Р. Ж. бид хоёр

үнэхээр сайн найзууд байсан учир эх нь намайг тэдэнтэй хамт явахыг хүссэн билээ. Мэс засал сайхан өнгөрсөн, гэхдээ гэр бүлийнхэн нь мэс заслын өрөөнд орох боломжгүй байсан учраас, тэрээр их айж байсан болохоор Р. Ж. хагалгааны ч өмнө нь мөн хойно нь ч үнэхээр их уйлж байлаа.

“Хожим биднийг номлолдоо байх зуур ойролцоогоор зургаан сарын дараа Р. Ж.–гийн нөгөө нэг солир нүдийг засах ёстой байв. Эх нь над руу утасдаад хоёр дахь хагалгаанд намайг тэдэнтэй хамт тэнд байхыг хүсэхэд, мэдээж холын зай, номлол намайг түүнтэй хамт байхад саад болсон. Деанна бид хоёр мэс заслын турш ач хүүг маань тайвшруулан тайтгаруулж өгөхийг Их Эзэнээс мацаг барьж мөн залбиран гуйсан юм.

“Р. Ж. өмнөх явдлыг сайн санаж байсан болохоор эцэг эхээ орхихыг хүсэхгүй байсныг мэс засал дууссаных нь дараахан бид утасдаж олж мэдсэн. Гэтэл тэрээр мэс заслын өрөөнд оронгуутаа чимээгүй болсон байна. Тэрбээр мэс заслын ширээн дээр гарч хэвтээд, тэдэнд нүднийхээ шилээ тайлж өгөөд, хагалгаанд амар тайван мэдэрэмжтэйгээр орсон байна. Бид маш их талархаж байв; залбирлуудад маань хариу өгчээ.

“Хэд хоногийн дараа бид охин руугаа утастаж Р. Ж.–гийн талаар асуухад, түүнийг сайн гээд, охин маань энэхүү сонин явдлыг бидэнтэй холбож ярьсан юм. Мэс заслын дараа үдээс хойш, Р. Ж. сэрээд ээждээ хагалгааны турш Өвөө нь тэнд байсныг хэлжээ. Тэрбээр хэлэхдээ: ‘Өвөө тэнд байж бүх зүйлийг зөв болгосон’ гэв. За тэр, өвөө эмээ нь 1,800 бээр орчим хол номлолд байхад Их Эзэн мэдээ алдуулагч эмчийг тэрхүү жаал хүүд яг өвөө нь түүнтэй хамт байгаа мэтээр үзүүлж.”

Р. Ж. өвөө нь чиний орны хажууд байхгүй байж болох ч, гэхдээ түүний залбирал, санаа болдог нь чи байсан. Их Эзэн гартаа чамайг бүүвэйлж, чи бид бүхний Эцэгээр адислагдсан юм.

Хайрт ах эгч нар аа, зүрх сэтгэлийг маань хүүхдийн инээмсэглэл баярлуулж байг. Хүүхдүүдийн итгэх итгэл нь сүнс буюу сэтгэлийг маань тайтгаруулагч. Хүүхдүүдийн хайр нь сайн үйлсийг маань урамшуулагч. “Үр Хүүхэд Бол Их Эзэний Өв юм.”<sup>12</sup> Их Эзэний эдгээр онцгой найз нөхөд нь болох эдгээр өхөөрдөм хөөрхөн хүүхдүүдийг Тэнгэрлэг Эцэг маань хэзээ ч байгаагүйгээр адислах болтугай.

2000 оны Зургадугаар сарын *Ensign*–аас, хуудас 2–5.

#### ТЭМДЭГЛЭЛ

1. Матай 18:1–6.
2. “Ode: Intimations of Immortality from Recollections of Early Childhood.”
3. *Gospel Ideals* (1954), 436.
4. Сургаал ба Гэрээ 88:118.
5. *The Road to Confidence* (1959), 121.
6. Conference Report–нд, 1944 оны Дөрөвдүгээр сар, 32.
7. Jack M. Lyon–ны *The Children*, мөн бусад, редак., *Best-Loved Poems of the LDS People* (1996), 21.
8. *A Christmas Carol and Cricket on the Hearth* (огноо байхгүй.), 50–51.
9. Margaret Lee Runbeck, *Bits & Pieces*, 1990 оны Есдүгээр сарын 20.
10. James L. Ison, *Mormons in the Major Leagues* (1991), 21.
11. 3 Нифай 17:21–24.
12. Дуулал 127:3.

# ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН АРИУН ҮҮРГҮҮД

# 10

Хэсэг 1: Эцгийн Үүргүүд

Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- “Тэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагийн” долдугаар догол мөрд илэрхийлсэн эцэг эхчүүдийн үүргүүдийг давт (хуудас iv-г үз). Тэр зөвлөгөө нь таны гэр бүлд хэрхэн хамаарах мөн

үүнийг даган мөрдөхийн тулд та юу хийх ёстойг залбирч тодорхойл.

- Эцэг буюу өвөг эцэгтээ захиа бич.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### Израилын Эцгүүдэд Зориулав

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч  
Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон

Хүндэт ах нар аа, энэхүү Бурханы санваартнуудын сүрлэг сайхан чуулганд би энд та бүхэнтэй хамт байгаадаа баяртай байна. Би хамгийн амин чухал зүйлийн талаар та нарт хандан ярих үед Их Эзэний Сүнс та нартай болон надтай хамт байгаасай гэж би залбирч байна. Энэ үдэш энд мөн Сүмд нийтээр цугласан эцгүүдэд хандан тэдний дуудлагын талаар ярих гэсэн юм.

Залуу эрэгтэйчүүд хэдийгээр та нар эдүгээ Сүмийн ирээдүйн эцгүүд болох гэж бэлтгэж байгаа учраас анхааралтай сонсоно гэдэгт итгэн найдаж байна.

### Мөнхийн Дуудлага

Эцгүүд ээ, та нарын дуудлага бол хэзээ ч чөлөөлөгдөшгүй мөнхийн дуудлага юм. Сүм дэх дуудлага нь, үүний адил чухал байдаг ч мөн чанарын хувьд зөвхөн хэсэгхэн хугацааны турш байх ба тэгээд цаг нь болоход чөлөөлөгдөж өөр байрыг эзэлдэг. Гэвч эцэг хүний дуудлага бол мөнхийнх мөн үүний ач холбогдол нь зааг хязгаарыг даван гардаг. Энэ дуудлага нь эдүгээ болоод үүрд мөнхөд үргэлжлэх болно.

Ерөнхийлөгч Харолд Б.Ли, “[Аавууд] болох та нарын хэзээ нэгэн цагт хийх гэж буй Их Эзэний хамгийн чухал ажил нь та нарын өөрсдийн гэр бүлд хийж буй тэр ажил байх болно. Гэрийн багшлалт, бишопын ажил болон Сүмийн бусад үүргүүд нь бүгд чухал боловч хамгийн чухал ажил бол гэр

орондоо хийж буй тэр ажил юм” хэмээн чин сэтгэлээсээ мэдэгдсэн юм (*Strengthening the Home* [pamphlet, 1973], 7).

Тэгвэл ариун нандин гэр бүлд хийж буй ажилд аавуудын онцгой үүрэг хариуцлага юунд байгаа юм бэ? Израилын эцэг болгонд хоёр үндсэн үүрэг хариуцлагыг би санал болгомоор байна.

### Материаллаг Эд Зүйлээр Хангах

Нэгдүгээрт, гэр бүлээ материаллаг эд зүйлсээр хангах нандин үүрэг хариуцлага танд байдаг билээ.

Их Эзэн үнэнч шударга үр удмаа өсгөж, ханган тэтгэх үүргийг ойлгомжтойгоор тодорхойлсон юм. Евад бус, харин Адамд духныхаа хөлсөөр талхаа олж идэхийг зааварласан билээ.

Төлөөлөгч Паул нөхрүүд, эцэгүүдэд, “Харин хэрэв хэн нэгэн нь өөрийнхнийгөө, ялангуяа төрсөн гэр бүлийнхээ хүмүүсийг тэтгэхгүй байвал тэр хүн итгэлийг үгүйсгэсэн хэрэг болох бөгөөд итгэгч бус хүнээс ч бүр дор юм” гэж зөвлөсөн байдаг (1 Тимот 5:8).

Сэргээгдсэн Сүмийн түүхийн эхэн үед, Их Эзэн эрчүүдийг эхнэрүүд ба гэр бүлээ ханган тэтгэх үүрэгт онцгойлон томилсон. 1832 оны Нэгдүгээр сард Тэрбээр, “Үнэнээр би та нарт хэлнэ, гэр бүлийн хангах үүрэг хүлээсэн хүн болгон, тэрээр хангаг, мөн ямар ч байдлаар тэрээр титмээ алдах нь үгүй” (С ба Г 15: 28) гэж хэлжээ. Гурван сарын дараа Их Эзэн дахин, “Эмэгтэйчүүд өөрсдийнхөө нөхрийг авагдах хүртэл нь өөрсдийгөө тэтгүүлэхийн тулд нөхрөөсөө нэхэх эрхтэй” (С ба Г 83:2) гэж хэлсэн. Энэ бол эхнэр ба эхийн тэнгэрлэг эрх нь юм. Эхнэр нь гэр орондоо хүүхдүүдээ асран

тэжээж байхад, нөхөр нь гэр бүлийг тэжээн тэтгэхэд хүрэлцэх мөнгийг олж байдаг.

Гэр оронд биеийн чадвартай нөхөр байхад, тэрээр гэр бүлийн тэжээгчээр тооцогдоно. Эдийн засгийн нөхцөл байдлаас болж ажлаа алдсан нөхрүүд, хэдийгээр гэр бүлээ тэтгэн хангах чадвартай хэвээр байгаа ч, эхнэрүүдээ ажил хийлгэхээр гэрээсээ явуулдаг нөхрүүдийн талаар бид заримдаа сонсдог. Ийм нөхцөлд, нөхрүүдийн олж авч, эрхэлж буй ажил нь баталгаатай биш мөн гэр бүлийн төсөв нь илүү нарийн байх ёстой ч гэсэн тэд өөрийн гэр бүлийг чадах чинээгээрээ хангаж байхад эхнэр нь хүүхдүүдээ асран орон гэртээ үлдэхэд нь бүх зүйлийг өөрийнхөө хүчээр хийхийг бид нөхрүүдэд уриалж байна.

Түүнчлэн боловсрол буюу материаллаг эд зүйлсийн хэрэгцээнээс болж эхнэрийг гэр бүлийн тэжээгчээр ажиллуулахаар хүүхэд гаргахыг хойш тавихыг зөвтгөх үндэслэлгүй.

### Ерөнхийлөгч Кимбаллын Зөвлөгөө

Бидний хайрт бошиглогч Спенсер В.Кимбалл гэрлэсэн оюутнуудад өгсөн зөвлөгөөг би санаж байна. Тэрээр хэлэхдээ: “Гэрлэх л юм бол сургуулиа төгсөж, санхүүгийн боломжтой болохыг хүлээж хүүхэдтэй болохыг бүү хойшлуул гэж олон олон залуу хүмүүст би хэлсэн. . . . Тэд энгийнээр хамтдаа амьдарч, хүүхдүүдтэй болох хэрэгтэй . . . хэмээжээ.

Ерөнхийлөгч Кимбалл үргэлжлүүлэн, “Залуу эхнэрүүд гэр бүлээс татгалзан, нөхрүүдээ сургууль төгсгөхийн тулд ажиллахаар яв гэсэн эрх мэдэл бүхий зөвшөөрөл өгсөн судрыг би мэдэхгүй л юм байна. Өөрийн арга замаар сургуулийнхаа хажуугаар ажиллахын зэрэгцээ гэр бүлээ тэтгэн тэжээж байсан мянга мянган нөхрүүд байна” гэжээ (*Marriage Is Honorable*, *Speeches of the year*, 1973 [1974], 263).

### Гэр Бүлд дэх Эхийн Үүрэг

Санваартан ах нарт, гэр бүлээ тэтгэх, хайрлан халамжлах хийгээд хүүхдүүдээ зөв шударгын зарчмуудаар бэлтгэн хүмүүжүүлэх эхчүүдийн гэртээ байхын ач холбогдлыг би үргэлжлүүлэн онцлон тэмдэглэж байна.

Би Сүм нийтээр аялахад, Хожмын Үеийн Гэгээнтэн Эхчүүдийн зонхилох хэсэг нь энэхүү зөвлөгөөг дагахыг чин сэтгэлээсээ хүсч байгааг би мэдэрсэн. Гэтэл тэдгээр эхчүүд заримдаа тэдний нөхрүүдийн шахалт шаардлагаас болж аль эсвэл гэрээс гадуур ажил хийхийг дэмждэгээс болж ажил хийдэг гэдгийг бид мэднэ. Эрэгтэйчүүд илүү орлогоор өөрийн хүссэн тав тухтай байдлыг хан-

гах зүйлсийг худалдан авахыг хүсдэг. Иймэрхүү нөхцөл байдалд зөвхөн тэр гэр бүл л зовох юм, ах нар аа, энэ нь сүнслэг өсөлт болон урагш дэвшихэд тань саад болно. Эхнэр нь эх хүний хувьд гэр орондоо байж үүргээ биелүүлэх замаар Их Эзэн эрчүүдэд гэр бүлээ хангах хариуцлагыг өгсөн гэдгийг би та бүхэнд хэлж байна.

### Өнөөдөр Гэр Бүлийн Бэлтгэгдсэн Байдал Илүү Чухал байна

Эцгүүд ээ, гэр бүлээ материаллаг эд зүйлээр хангах өөр нэг амин чухал хэсэг бол гэнэтийн яаралтай тусламжийн нөхцөлд хоол хүнс, нөөцийг гэр бүлийнхээ төлөө бэлтгэх юм. Гэр бүл дэх бэлтгэлтэй байдал нь урт удаан хагацааны өмнө бий болсон халамжийн зарчим юм. Тэр ч бүү хэл өнөө үед энэ нь нэн чухал байна.

Та нар гэр бүлийнхээ нэг жилийн хоол хүнс, хувцас хунар мөн бололцоотой бол шатахуунаа нөөцөлсөн үү хэмээн би чин сэтгэлээсээ та нараас асууж байна. Хоол хүнс хийж, хадгалах илчлэлт нь Ноагийн өдрүүдэд хүмүүс хөвөгч авдарт идэх хүнсээ хадгалсны адилаар өнөө үеийн бидний түр зуурын сайн сайхны төлөөх үндсэн чухал зүйл байж болно.

Түүнчлэн та бага зэрэг хадгалж, орлогоосоо хэтрэхгүйгээр амьдарч байна уу?

Та нар аравны нэгийн өргөлөө Их Эзэнд шударгаар төлж байна уу? Энэхүү тэнгэрлэг хуулиар амьдрахад танд сүнслэг болон материаллаг адислалуудыг хоёуланг нь өгөх болно.

Тийм ээ, ах нар аа, Израилын эцгүүдийн хувьд та нар гэнэтийн, яаралтай тусламжийн нөхцөлд хэрэгцээтэй хоол хүнсийг бэлтгэж мөн гэр бүлээ материаллаг хэрэгцээгээр нь хангах асар их хариуцлагатай билээ.

### Сүнслэг Удирдлагаар Тэтгэ

Хоёрдугаарт, та нар гэр бүлдээ сүнслэг удирдамжийг өгөх ариун нандин үүрэгтэй.

Хэдэн жилийн өмнө Арванхоёрын Зөвлөлийн хэвлэсэн товхимол дээр бид доорх зүйлийг хэлсэн. “Эцэг байх нь удирдах авьяас чадвар мөн; энэ нь удирдах авьяас чадварын хамгийн чухал төрөл юм. Энэ нь үргэлж ийм байсан мөн үргэлж тийм байна. Аав нар аа, мөнхийн хамтрагчийнхаа зөвлөгөө, урамшуулалт хийгээд тусламж дэмжлэгээр та нар гэр орноо тэргүүлдэг” (*Father, Consider Your Ways* [товхимол, 1973], 4–5).

Гэсэн хэдийд ч, тэрхүү тэргүүлэх байр суурийн хамтаар чухал үүрэг даалгаврууд ирдэг. Өрх гэрийн тэргүүн болох гэдэг нь ямар нэгэн байдлаар

эрэгтэйчүүдэд тэргүүлэх үүрэг оногдуулснаар тэд гэр бүлийнхэндээ тушаан зааварлаж, шаардаж болно хэмээн хүмүүс ярьж байхыг, тэр ч байтугай Сүмд дээр үүнийг сонсдог.

“Учир нь Христ чуулганы тэргүүн байдгийн *адил* нөхөр нь эхнэрийнхээ тэргүүн юм” хэмээн Төлөөлөгч Паул цохон тэмдэглэжээ (Ефес 5:23; налуу бичлэгийг нэмэв). Гэр орноо тэргүүлэх үүргээ биелүүлэхэд бид тэр загварыг мөрдөх ёстой. Сүмийг удирдахад Аврагч хатуу, ширүүн гараар удирдаж байхыг бид олж хараагүй л юм байна. Өөрийн Сүмийнхнийг үл хүндэтгэн эсвээс хайхрамжгүй байдалтайгаар Аврагч хандаж байхыг бид олж хараагүй. Аврагч зорилгууддаа хүрэхийн тулд хүч хэрэглэх эсвээс албадан шахахыг бид хараагүй юм байна. Сүмийг гэгээрүүлэн сэнхрүүлж, урамшуулан тайтгаруулж, өргөмжлөхөөс бусдаар Аврагчийг ямар нэгэн зүйл хийхийг бид хараагүй. Ах нар аа, бид гэр бүлдээ зориулан сүнслэг удирдамжийг авахад бидний дагах ёстой тэр загвар нь бол Тэр гэдгийг би та нарт өөрийн эрүүл ухаанаар хэлж байна.

Ялангуяа энэ нь эхнэртэйгээ харьцах харьцаанд үнэн юм.

### Эхнэрээ Хайрла

Энд дахиад Төлөөлөгч Паулын зөвлөмж нь хамгийн сайхан тохирох юм байна. “Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла” (Ефес 5:25) хэмээн тэрээр энгийнээр хэлжээ.

Хожмын үеийн илчлэлд Их Эзэн уг үүрэг хариуцлагын талаар дахин ярьдаг. Тэрээр хэлэхдээ: “Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж мөн өөр хэнтэй ч биш харин түүнтэй нэгдэн нийлэх ёстой” гэжээ (С ба Г 42:22). Миний бодлоор бүх зүрх сэтгэлээрээ хайрлахыг бидэнд зарлигласан бүх сударт байдаг бас нэг өөр ганц зүйл бол Бурханыг Өөрийг нь хайрлах явдал юм. Энэ нь ямар утгатай гэдгийг бодоод үз!

Үнэхээр олон арга замаар ийнхүү хайрыг эхнэртээ үзүүлж болно. Нэн тэргүүнд байх нэн чухал зүйл бол—ажил хөдөлмөр, амралт чөлөөт цаг, сонирхдог зүйл биш—гагцхүү Бурхан Өөрөө, өөр хэн ч биш, эхнэрийг тань амьдралын тань эн тэргүүнд тавьдаг. Эхнэр тань үнэ цэнэ бүхий мөнхийн хань ижил болох таны хамтрагч юм.

Хэн нэгнийг бүх зүрх сэтгэлээсээ хайрлах гэдэг нь ямар утгатай вэ? Энэ нь сэтгэлийнхээ хөдлөл буюу мэдрэмжээрээ, бүхнээ зориулан хайрлах гэсэн утгатай. Мэдээж эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлах үед түүнийгээ доромжлон шүүмжилж, алдаа дутагдлыг нь тоочих, эсвээс үг хэлээр буюу

уур уцаартай байдал буюу үйлдлээр доромжилж болохгүй.

“Түүнтэй нэгдэн нийлэх” гэдэг нь ямар утгатай вэ? Энэ нь түүнтэй ойр дотно, үнэнч, шударга байж түүнтэй ярилцан хайртай гэдгээ илэрхийлэх гэсэн утгатай.

Хайрлах гэдэг нь түүний мэдрэмж хийгээд хэрэгцээг ойлгоход мэдрэмтгий бай гэсэн үг. Өөрийг нь анзаарч мөн нандигнан хайрлаасай хэмээн тэрээр хүсэж байгаа. Түүнийг хайр булаам, сэтгэл татсан мөн танд чухал хүн гэж танаар дүгнэн хэлүүлэхийг тэрээр хүсэж байгаа. Хайрлах гэдэг нь түүнийг сайн сайхан болон өөрийгөө үнэлэх үнэлгээг нь та өөрийн амьдралд эн тэргүүнд тавина гэсэн үг юм.

Тэрээр хүүхдүүдийн тань эх, мөн өрх гэрийн тань эзэгтэй гэдэгт та түүнд талархан, хүүхдүүдийг тань асран хүмүүжилж, хайрлахаар тэрээр—бүх дуудлагуудаас хамгийн эрхэм хүндэт дуудлага болох—гэр орноо тохинуулан эх хүн байхыг сонгосонд та түүнд баярлаж явах хэрэгтэй.

Нөхрүүд ээ, гэр бүлийн төлөвлөгөө, гэр бүлийн үйл ажиллагаа болон гэр бүлийн төсвөө гаргах үед жинхэнэ хамтрагчийн хувьд зөвлөгөө өгөх чадвартай эхнэрийнхээ оюун ухааныг таньж мэд.

Оюун ухаан, сэтгэл санаа, нийгэмтэй харьцах харьцаа мөн сүнслэг байдлын хувьд өсөн хөгжих боломжийг түүнд олго.

Ах нар аа, хайр бага шинж тэмдгээр хөгжин нэмэгддэг юм. Онцгой үйл явдалд цэцэг гайхамшигтай байдгийн адилаар сайн дураараа аяга таваг угаах, шөнө дунд босч уйлж буй хүүхдийн живхийг солих мөн уншиж буй зураг буюу сонин сэтгүүлээ орхин оройн хоол хийхэд нь туслах хүсэлтэй байх нь зүйтэй. Эдгээр нь “Би чамд хайртай” хэмээн үйлдлээр хэлэх чимээгүй арга юм. Ийм жаахан хичээл зүтгэл гаргасны төлөө энэ нь багагүй ач тусыг авчирдаг.

Иймэрхүү хайрын санваарын удирдамж нь хүүхдүүд болоод түүнчлэн эхнэр танд хамаатай байх болно.

### Гэр дэх Эцгийн Үүрэг

Эхчүүд нь өрх гэрийн өнгө зүс байдгийн хувьд чухал үүрэг гүйцэтгэдэг, гэхдээ энэ нь өрх гэрийн тэргүүний хувьд хүүхдүүдээ хайрлан хүмүүжүүлж, бэлтгэн сургах тэгш эрх бүхий эцгүүдийн гүйцэтгэх чухал үүргийг багасгах ямар ч үндэслэлгүй юм.

Өрх гэрийнхээ патриархийн хувьд, хүүхдүүдтэйгээ ажиллахаар та нарт удирдлагыг гартаа авах чухал үүрэг хариуцлага бий. Та нар Их Эзэний

Сүнс оршиж болохуйц өрх гэрийг бий болгоход туслах ёстой. Таны байр суурь бол бүх гэр бүлийн амьдралд удирдамж өгөхөд байдаг билээ. Гэр бүлийн хууль дүрэм хийгээд сахилга батыг үүсгэн бий болгоход та идэвхтэй оролцож байх хэрэгтэй.

Өрх гэр тань гэр бүлийн чинь тэнгэрийн амар амгалан хийгээд баяр баясгалан нь байх хэрэгтэй. Мэдээж хэрэг ямар ч хүүхэд өөрийн эцгээс—ялангуяа санваартан эцгээс айж эмээхгүй байх ёстой. Эцэг хүний үүрэг нь өрх гэрээ аз жаргал, баяр баясгалангийн газар болгох явдал юм. Дэмий юмнаас болж хэрүүл маргаан үүсэж, өрсөн хэрүүл хийх буюу шударга бус байх үед тэрээр үүнийг бий болгож чадахгүй. Хайрлан халамжилж мөн сурган хүмүүжүүлэхдээ үлгэр дуурайлаа үзүүлж буй зөв шударга эцгүүдийн хүчирхэг нөлөө нь хүүхдүүдийн сүнслэг байдалд амин чухал байдаг билээ.

### Сүнслэгээр Удирд

Израилын Эцгүүдийг зүрх сэтгэлээрээ хайрлахын хамтаар, аавууд хүүхдүүдээ сүнслэгээр удирдах тодорхой арван арга замыг би зөвлөмөөр байна. Үүнд:

1. Хүүхдүүдээ эцгийн адислал хүртээ. Хүүхдүүдээ баптисм хүртээж, гишүүнээр батал. Хөвгүүдээ санваартнаар томил. Эдгээр нь хүүхдүүдийн тань амьдрал дахь сүнслэг онцгой үйл явдлууд болж өгнө.

2. Гэр бүлийн залбирал, өдөр тутам судраас уншин суралцах хийгээд долоо хоног бүр гэр бүлийн цуглааны үдшийг биечлэн удирд. Таны хувийн оролцоо, хувь нэмэр эдгээр үйл ажиллагаа үнэхээр хэрхэн чухал байдгийг хүүхдүүдэд тань үзүүлэх болно.

3. Боломжтой үед гэр бүлээрээ Сүмийн цуглаануудад хамтдаа оролцож бай. Таны удирлага дор гэр бүлээрээ хүндэтгэл бишрэлийг үйлдэх нь хүүхдүүдийн тань сүнслэг сайн сайхан байдалд амин чухал юм.

4. Охин-аав нарын үерхэл болон хүү-эцгийн зугаалгад хүүхдүүдтэйгээ хамт явч бай. Зуслан гарч, зугаалганд явах, бөмбөгтэй спортын тоглолт болон хөгжмийн концерт мөн сургуулийн хөтөлбөрүүд гэх мэтийг үзэхээр гэр бүлээрээ явцгаа. Аав нь тэнд байхад бүх зүйл өөрөөр харагддаг билээ.

5. Гэр бүлийн заншил болгохоор амралт, аялал болон зугаалгыг бий болго. Эдгээр дурсамжуудыг хүүхдүүд тань хэзээ ч мартахгүй байх болно.

6. Хүүхдүүдтэйгээ ганцаарчлан тогтмол биечлэн уулзаж бай. Тэд юу хүсэж байгааг өөрсдөөр нь яриул. Сайн мэдээний зарчмуудыг тэдэнд зааж бай. Жинхэнэ шинж чанаруудыг тэдэнд зааж бай. Та тэдэнд хайртай гэдгээ хэлж бай. Хүүхдүүдээ биечлэн цаг заваа гарган уулзах нь аав нь нэн тэргүүнд юуг тавьдгийг тэдэнд хэлж байгаа нь тэр.

7. Хүүхдүүдээ ажиллаж хөдөлмөрлөхийг зааж, зохистой зорилгынхоо төлөө хөдөлмөрлөхийн үнэ цэнийг тэдэнд үзүүлж бай. Хүүхдүүдээ зоориулан номлол, боловсролын сан бий болгосноор Аав хүн юуг чухалчилдгийг тэдэнд харуулдаг.

8. Гэр орондоо зохистой хөгжим, соёл урлаг мөн уран зохиолыг урамшуулан дэмжиж бай. Гоо үзэсгэлэн мөн гэгээрүүлэн цэвэршүүлэгч уур амьсгалтай өрх гэр нь хүүхдүүдийнхээ амьдралыг мөнхөд адислах болно.

9. Хэрэв боломжтой байвал эхнэртэйгээ тогтмол ариун сүмд орж бай. Ингэснээр хүүхдүүд тань ариун сүмийн гэрлэлт, ариун сүмийн амлалт тангараг болон мөнхийн гэр бүлийн нэгжийн чухал ач холбогдлыг илүүгээр ойлгох болно.

10. Сүмд зориулж буй үйлчлэлд таны сэтгэл хангалуун, баяр баясгалантай байдлыг хүүхдүүд тань олж хараг. Энэ нь тэднийг ч бас Сүмд үйлчилж, хаант улсаа хайрлахыг хүсэх хандлагатай болгоно.

### Таны Хамгийн Чухал Дуудлага

Израилын эцгүүд мөн нөхрүүд ээ, гэр бүлийнхээ аврал, өргөмжлөлд та нар хичнээн ихийг хийж чадах билээ. Таны үүрэг хариуцлагууд үнэхээр чухал юм.

Энэ амьдралд ба үүрд мөнхөд—таныг хэзээ ч чөлөөлөхгүй—нэн чухал дуудлага болох—Израилын Эцэг хэмээх ариун нандин дуудлагаа санагтун.

Гэр бүлээ материаллаг хэрэгцээгээр байнга хангаж, гэр бүлдээ сүнслэг удирлага мөнхийн хамтрагчийнхаа хамтаар өгөхөөр ариун нандин дуудлагаа биелүүлэх болтугай.

1987 оны Аравдугаар сарын Сүмийн ерөнхий чуулганы санваартнуудын хуралдаанд Ерөнхийлөгч Бенсоны хэлсэн үгнээс (Conference Report, 1987 оны Аравдугаар сар, 59–63; эсвэл *Ensign*, 1987 оны Аравдугаар сар, х. 48–51–г үз).



# ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН АРИУН ҮҮРГҮҮД

# 11

Хэсэг 2: Эхчүүдийн Үүргүүд

Хэрэгжүүлэхэд Зориулсан Санаанууд

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхагт “эцэг эхчүүд харилцан бие биендээ адил тэгш туслах ёстой” хэмээн бидэнд зөвлөсөн байдаг (энэ суралцах гарын авлагын хуудас iv-г үз). Эхнэртэйгээ хамт уг суралцах гарын авлагын 47-р хуудсан дээр байгаа Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны эцгүүдэд зориулсан 10 зөвлөгөө мөн энэ суралцах гарын авлагын 51–53-р

хуудсан дээр байгаа эхчүүдэд зориулсан 10 зөвлөгөөг уншиж давт. Эдгээр үүрэг хариуцлагуудад хамтдаа хичээн зүтгэж бие биенээ дэмжиж болох арга замуудыг та нар ярилц.

- Эх буюу эмэг эхдээ захиа бич.

## Унших Даалгавар

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### “Учир нь Тэрээр Эх Хүн”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Жеффри Р.Холланд

#### Эхчүүдэд Үзүүлэх Хүндэтгэл

Виктор Хьюгогийн онцгойлон бичсэн зарим мөрийг уншвал:

“Тэр эмэгтэй идэхийг хүсэн хүлээж байсан хүүхдүүддээ талхыг хоёр хэсэг болгон хувааж өгөв.” “Тэр өөртөө юу ч үлдээсэнгүй” гэж түрүүч амандаа бувтнан өгүүлэв.

“ ‘Яагаад гэвэл тэр өлсөөгүй байлгүй’ хэмээн цэрэг хэлэв.

“ ‘Үгүй ээ, учир нь тэрээр эх хүн’ ” гэж түрүүч өгүүлэв.

Айова, Небраска, Виоминг гатлахаар хүнд хэцүү аялал хийсэн тэдгээр хүмүүсийн эр зориг ба итгэлийг бид ёслон тэмдэглэх жилд, хүүхдээ асран тэдний төлөө залбирч байсан хийгээд мөн ч олон удаа нялх үрсээ тэр урт аялалд нутаглуулсан тэдгээр анхдагч эхчүүдийн нэг адил орчин үеийн эхчүүдэд хүндэтгэл үзүүлэхийг би хүсэж байна. Эх хүн болж амжаагүй мөн болохыг туйлын их хүсэж байгаа энэ сэдвийн тухайд бидний хамт нулимсаа дусааж, миний дуу хоолойг сонсож буй эмэгтэйчүүдэд, та нарын өмнө байгаа нэгэн өдрүүдэд Бурхан “[тэр] ганцаардсан зүрх сэтгэлд итгэлийг”<sup>1</sup> авчрах л болно гэдгийг би хэлж байна. Хэдийгээр

тэдгээр адислалууд нь тэр даруй ирдэггүй ч, итгэлтэй нэгэнд “ямар ч адислалуудыг татгалзалгүйгээр өгөх болно” хэмээн энэхүү индэр дээрээс бошиглогчид ахин дахин заасаар байгаа.<sup>2</sup> Үүний хажуугаар хүүхдүүдээ хайрлан халамжлах дуудлагад хязгаарлалт байдаггүйд бид баярладаг билээ.

Эхчүүдийн тухайд ярихад, ялангуяа орчин үеийн айлуудад эцэггүй байх нь зарим хүмүүсийн тооцоолж байгаагаар “манай цаг үеийн нийгмийн гол асуудал”<sup>3</sup> болсон тул би эцгүүдийн чухал үүргийг үгүйсгээгүй. Үнэн хэрэгтээ, эцэггүй байх нь—амьдралд ямар ч оролцоогүй, хүмүүсийн ярьдгаар “удирдлагаар” идээд л унтаад л байдаг—эцэг нь байгаа тэр гэр бүлд ч гэсэн асуудал болоод байгаа. Гэхдээ энэ нь өөр нэг өдөр яригдах санваартнуудад зориулсан сэдэв юм. Өнөөдөр би нялх хүүхдээ тэргэнд нь бүүвэйлж, Их Эзэний зорилгуудын яг төв нь болох зуурдын амьдралд хүүхдүүдээ зөв шударга байдлаар хүмүүжүүлэн зааж буй тэдгээр эхчүүдийн хувь нэмрийг (тусалдаг гарнуудыг) магтахыг хүсэж байна.

Тийнхүү ярихдаа, Тимотыг магтан дуулж буй “чин сэтгэлийн итгэл нь . . . , анх чиний эмэг эх Лой, чиний эх Юник нарт байсан”<sup>4</sup> хэмээх үгсийг бичсэн Паулыг цуурайтуулан давтан хэлж байна. Мөн “чи хүүхэд байх [бага наснаасаа] ариун бичээсүүдийг мэдэх болсон”<sup>5</sup> хэмээн Паул хэлсэн байдаг. Тийнхүү бага насандаа тэр үнэнийг заалгуулж байсан бүх эхчүүд болон эмэг эхчүүдэд бид талархлаа илэрхийлж байна.

## Залуу Эхчүүдийн Гаргасан Золиослол

Ер нь эхчүүдийн талаар яривал, би ялангуяа *залуу* эхчүүдийг урамшуулан магтахыг хүсэж байна. Эх хүний ажил хэцүү байдаг ба үүнийг олонтаа анзааран үнэлдэггүй юм. Бидний залуу нас ихэнхдээ эхнэр, нөхрийн аль алин нь—эсвээс хоёулаа—сургуульд явж байгаа, аль эсвэл нөхөр нь идэх талхыг олж, сурах чадвараа хөгжүүлж буй туршлага суугаагүй, бэл бэнчин муутай жилүүд байдаг юм. Санхүү нь гэхэд өдөр бүр багаас хэлбэлзэн бүр юу ч үгүйд хүргэдэг. Байр орон сууц нь ихэвчлэн хоёр ухаалаг тохижуулалт болох—Дезерет Үйлдвэрийн тусламжийн бараагаар эсвээс бүр хоосон байдлаар—аль нэгээр тохижуулалт байдаг. Хэрэв машинтай бол, үнэхээр байдаг л бол, тэр нь элэгдчихсэн дугуйнуудтай, шатахууны хоосон савтай давхиж байгаа. Гэтэл орой бүр оройн хоол хийж, орой бүр шүд зуун ажиллах нь ихэнхдээ юм бүхний хамгийн хүнд хэцүү бэршээл нь болж залуу эхчүүдийг хялбархнаар ядаргаанд оруулдаг. Эдгээр жилүүдийн турш эхчүүдийн бага унтах нь ихсэж, миний мэдэхээс амьдралын ямар ч цаг хугацаанд өөр ямар ч хүмүүсээс илүүгээр өөрсдийн хувийн эрх ашиг бодолгүйгээр тэд бусдын төлөө илүү ихийг хийж байдаг юм. Нүдний зовхийг нь тойрсон үрчлээс нь заримдаа Рөүд Аралын муж улстай төстэй байдлаар тодрон ихсэж байхыг харахад гайхах зүйл алга.

Бидний ажилд дуудахыг хүсэж буй,—аль эсвэл дуудах хэрэгтэй—тэр эгч нь хэсэг болон гадасны хавсралт байгууллагуудад үйлчилж байдаг нь мэдээж егөөдөл юм. Энэ бол ойлгомжтой. Эдгээр залуу Лой болон Юник нарын адил үлгэр дууриаллын нөлөө үзүүлж буй хүмүүсээс хэн татгалзах юм бэ? Хүн бүхэн ухаалаг бай. Гэр бүлүүд нь ялангуяа эдгээр төлөвшилийн үеүдэд бүгдийн нэн тэргүүнд нь байдгийг санагтун. Хэдийгээр тийм боловч, бусад хүмүүс гэр бүлийнхнээ бас тэдгээр хүмүүсийг хүчирхэгжүүлж, үйлчилдгийн адилаар мөн ийм маягаар залуу эхчүүд итгэлтэйгээр үнэнчээр Сүмд үйлчлэх гайхамшигтай арга замуудыг олсоор л байх болно.

Эдгээр жилүүдийн турш өөрийн чадах бүхнийг хий, гэхдээ та болон багачуудыг тань хайрлан хамгаалахаар тэнгэр өөрийн ариун тэнгэр элч нарыг илгээдэг болохоор бусад хийх бүх зүйлд үнэнхүү өөрийн онцгой гэгдэх үүргийг нандингаж яв. Нөхрүүд—онцгойлон нөхрүүд—түүнчлэн бүх удирдлагын Сүмийн удирдагчид болон найз нөхөддөө, тусархаг, мэдрэмжтэй мөн ухаалаг байцгаа. “Тэнгэрийн доорх бүх юмс цаг хугацаатай бөгөөд бүх юм тогтоогдсон цаг хугацаатай ажээ.”<sup>6</sup>

Эхчүүд ээ, алхам бүрт та бүхний итгэлийг бид хайрлан хүндэтгэж мөн талархаж явдаг. Өмнө нь ч үүнийг үнэлдэг байсан шиг, эдүгээ бас үүрд мөнхөд ч үнэлнэ гэдгийг мэдэж яваарай. Хэрэв ямар нэгэн шалтгааны улмаас хажууд тань байх нөхөргүйгээр тэр зоригтой оролдлогыг та ганцаараа хийх юм бол, залбирлууд маань таны бүх сайн сайхны төлөө байх ба үүнээс ч илүү шийдэмгийгээр бид гараа сунган туслах шийдвэр гаргана.

## Эхчүүд Бурханы Ажлыг Хийдэг

Саяхан нэгэн залуу эх санааг нь зовоож буй асуудал нь гурван хэлбэрээр илэрдэг гэдгээ тэрээр надад бичсэн. Нэг дэх нь тэрээр ХҮГ эх хүн байх талаарх яриаг сонсох бүрт сэтгэл санаа нь зовдог байсан, учир нь өөрт нь шаардлагатай ур чадвар байхгүй эсвээс ямар нэгэн байдлаар өгсөн даалгаварт тэнцэхгүй байх хэмээн боддог байв. Хоёрдугаарт, тэрээр хүүхэд ямар нэгэн зүйлийг, тухайлбал тун энгийн “гүү-гүү” гэж хэлэхээс нь өмнө—бүгдийг: унших, бичих, дотоод засал хийх, Латин хэл заах, тооцоо хийх мөн Интернетийг хүүхдүүддээ зааж сургасан байхыг энэ дэлхий түүнээс хүсээд байгаа мэт түүнд мэдрэгдсэн. Гуравдугаарт, заримдаа хүмүүс бараг үргэлж санамсаргүйгээр түүнтэй өөрсдийгөө дээгүүр тавин харьцаад байгаа мэт түүнд олонтаа мэдрэгддэг байсан, учир нь түүний хүлээн авсан зөвлөгөө, тэр ч байтугай сонсож байсан магтаалууд нь заримдаа өдөр шөнөжингөө сунатлаа ажиллах эрч хүчийг шаардсан түүнээс Бурханы хүсэж буй эх хүн болох хүсэл болон хичээл зүтгэлд нь сүнслэг хийгээд сэтгэл хөдлөлийн хүч гаргахад мөн сэтгэл санаанд ямар нэгэн хувь нэмэр үзүүлдэггүй байсан мэт санагддаг байв.

Гэвч түүний хэлснээр нэг л зүйл түүнийг урагш хөтөлдөг: “Сайнтай ч, муутай ч цаг хугацааг давж, энэ бүхэнд үе үе нулимс асгаруулж, *зүрх сэтгэлийн гүнд би Бурханы ажлыг хийж байгаа гэдгээ мэддэг билээ*. Би эх хүн байх үеэр Түүнтэй мөнхөд хамтран зүтгэж байгаагаа мэддэг. Хэдийгээр хэрэв Түүний зарим хүүхдүүд нь Түүнийг уйлуулахад хүргэдэг зүйл хийсэн ч гэсэн, Бурхан Өөрийн үндсэн зорилго мөн хамтрагч байх ач холбогдлыг олж мэддэг гэдэг нь сэтгэлийг маань ихэд догдлуулдаг.”

“Эдгээр бүх зүйлүүдийг бага зэрэг туулж баршгүй байх үед, би тэдгээр зайлшгүй байсан хүнд өдрүүдийг дурсахыг хичээдэг байсан нь “тэр ухаарал мөн” хэмээн тэрээр хэлжээ. “Үүнийг нарийвчилбал чадваргүй мөн сэтгэл түгшээсэн байдал маань Түүнд гар сунган хүрч, буцаагаад бидэнд хүрч тусалдаг Түүний чадварыг өөрсөддөө хөгжүүлэн нэмэгдүүлэхийг биднээс өдөөж байж

магад. Магадгүй бид сэтгэл зовон байхдаа Түүний тусламжийг гуйн хүсээсэй хэмээн Тэрээр нууцханаар найддаг байх” гэж тэр эмэгтэй хэлж билээ. “Тэгээд, Тэрээр юунд ч түдгэлзэлгүйгээр биднээр дамжуулж эдгээр хүүхдүүдийг шууд заан сургаж чаддаг гэдэгт би итгэж байна. Тэр санаа, арга барил нь надад таалагддаг” гэж тэр дуусгав. “Энэ нь надад найдвар төрүүлдэг. Хэрэв би Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө зөв шударга байх юм бол, магадгүй хүүхдүүдэд маань зориулсан Түүний удирдамж нь саад тотгоргүй байх болно. Тэгээд магадгүй энэ нь шууд утгаараа Түүний ажил мөн Түүний алдар суу нь байж болох юм.”<sup>77</sup>

### Хүүхдүүд Тань Та нарыг Адислагдсан хэмээн Нэрлэнэ

Иймэрхүү хэллэгийг энгийнээр авч үзвэл Рөүд Арал шиг хэмжээтэй зурааснуудын зарим нь зөвхөн хүүхдийн живхийг сольж, хүүхдүүдийг сургуульд нь машинаар ээлжлэн хүргэж өгөхөөс бий болоогүй харин Бурханы хүсэж буй тэр хүн болгохын төлөө эдгээр хүүхдүүдийг хүмүүжүүлэх чадвар боломжийг чин сэтгэлээсээ эрж хайж, дор хаяж тэр хүүхдээ хайн хэдхэн шөнийг нойргүй өнгөрүүлэхээс бий болдог гэдэг нь тодорхой юм. Сэтгэлийг маань хөндсөн тэр үнэнч мөн шийдэмгий байдалтай эхчүүд та бүгдэд Их Эзэний нэрээр та нар гайхамшигтай хүмүүс гэдгийг би хэлмээр байна. Та нар маш сайн аж төрж байна. Та нарт тийнхүү үүрэг хариуцлагыг ноогдуулах болсон тэр баримт нь Тэнгэрлэг Эцэг тань, та нарт итгэл хүлээлгэсэн нь мөнхөд үргэлжлэх нотолгоо юм. Тэрээр таны хүүхэд төрүүлэх явдал нь шууд бүхнийг мэдэгчийн эгнээнд оруулахгүй гэдгийг мэддэг. Хэрэв та болон нөхөр тань Бурханыг хайрлаж, өөрсдөө сайн мэдээний дагуу амьдрах аваас; хэрэв та итгэлтэй нэгэнд амлагдсан Ариун Сүнсний удирдамж мөн тайтгарлыг гуйн хүсэх аваас; хэрэв та энэ дэлхийд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хийж болох хамгийн нандин гэрээнүүдийн амлалтуудыг аль алиныг хийж харуулахаар ариун сүм рүү орох аваас; хэрэв та бусдад, үүнд хүүхдүүдийгээ хамааруулж тэнгэр танд үзүүлээсэй хэмээн хүсдэг адилхан хайр халамж, өрөвчхөн хийгээд өршөөлийн зүрх сэтгэлийг үзүүлэх аваас; хэрэв та өөрийн чадах хэрээр хамгийн сайн эцэг эх болохын тулд чадах бүхнийг хийх аваас, хүмүүний хийж чадах бүхнийг мөн Бурхан танаас хүсэн хүлээж буй бүхнийг та хийсэн байх болно.

Заримдаа таны хүүхэд мөн ач хүүхдийн гаргасан шийдвэр нь таны зүрх сэтгэлийг шимшрүүлэх болно. Заримдаа хүсэн хүлээж байсан чинь тэр даруй биелэхгүй байж болно. Эцэг эх бүр үүний талаар санаа зовдог. Тэр ч байтугай

бидний хайртай, гайхалтай сайн эцэг болох Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит “Бурхан минь ээ, өөрийн үрийг алдахгүй байлгаач!”<sup>78</sup> хэмээн гуйдаг байсан. Тэр нь эцэг эх бүрийн гуйлт юм. Энэ нь эцэг эх бүрийн айдас дотор байдаг ямар нэг зүйл юм. Гэхдээ үргэлжлүүлэн оролдлого хийж, залбирдаг хэн ч бүтэлгүйтэж байгаагүй юм. Таны адил итгэн найдаж байсан тэр горьдлогууд мөн таны ижил мэдэрч байсан тэр айдсыг таны өмнөх элэнц эхчүүдийн тэдгээр үр удмуудын мэдэрсний адилаар эцэст нь хүүхдүүд чинь та нарыг адислагдсан хэмээн нэрлэхийг мэдэж авах мөн урамшууллыг хүлээн авах бүх эрх танд бий.

“Эрэгтэй [эмэгтэй] хүмүүн байж болохын”<sup>79</sup> тулд мөн баясгалантай байж болохын тулд Адам Ева хоёр унах ёстой байсныг ухааран ойлгосон тэрээр бүх хүмүүний гэр бүлийн эх болох Евагийн асар том үр удам нь та нар юм. Сара, Ребека мөн Рахелгүйгээр, бид бүгдийг адисладаг Аврахам, Исаак мөн Иаковын тэдгээр гайхамшигт патриархийн амлалтууд байхгүй байсан тэр асар том удам нь та нар юм. Лой, Юник болон 2,000 залуу цэргийн эхчүүд асар том удам нь та нар юм. Энэхүү дэлхий бий болохоос өмнө Бурханы Хүүг өөртөө тээж явч, төрүүлэхээр сонгогдож, урьдаас томилогдсон Марийн асар том удам нь та нар юм. Бид та бүхэнд, үүнд өөрсдийн эхчүүдийг хамруулж талархлаа илэрхийлж байна. Бид мөнх бус байдал хийгээд дэлхийн амьдралыг Түүний охид, хөвгүүдэд тохиолгож, тэгснээр үхэшгүй байдал хийгээд мөнх амьдрал нь тэдгээр сэлэстиэл дээд хаант улсад байж болохын тулд энэ дэлхийд Бурханы алдар суу, ажилд шууд оролцох шиг илүү ач холбогдолтой ямар ч зүйл энд байхгүй гэдгийг та нарт хэлж байна.

### Аврагчид Үүрд Мөнх Итгэн Найд

Та нар даруу байдал хийгээд зүрх сэтгэлийн хүлцэнгүй байдалд Их Эзэнд ирэх үед мөн нэгэн эх хүний хэлснээр, “энэхүү гайхамшигт даалгаврын удирдамж, мэргэн ухаан мөн тусламжийг гуйхаар, хүсэхээр, шаардан нэхэхээр тэнгэрийн хаалгыг тогших үед” тэр хаалга та нарыг бүх мөнх оршихуйн нөлөө хийгээд тусламжаар ханган тэтгэхийн тулд нээлттэй байдаг билээ. Дэлхийн Аврагчийн амлалтуудыг нэхэн шаардагтун. Та нарыг эсвээс хүүхдүүдийг тань юу ч зовоож байсан, Цагаатгалын гарыг гуйн хүсэгтүн. Итгэлтэй байхад та нараас үл хамаарч буюу илүү зөв болгож хэлбэл учир нь та нараас болж бүх зүйл зөв зүйтэй гэдгийг мэдэж яваарай.

Та нар үүнийг ганцаархнаа хийх нь боломжгүй зүйл та нарт *үнэхээр* тусалцаа ирдэг. Тэнгэр, Газар Дэлхийн Эзэн та нарыг адислахаар тэнд байдаг—

Тэрээр шийдвэр төгс байдалтайгаар алдагдсан хонины араас явдаг, алдчихсан зоосоо олглоо гэрээ шүүрдэн хайдаг, үрэлгэн хүүг буцаж иртэл нь мөнхөд хүлээж байдаг. Авралын ажил бол та нар бөлгөө. Та үнэнч шударга оролдлого хийдэг ч гэсэн зарим үед та өөрийгөө өчүүхэн гэдгийг мэдэрдэг, тиймээс та нарыг байгаагаас чинь илүүгээр хүндэтгэн эрхэмлэж, ачийг тань хариулж, урьд өмнө байгаагүйгээр илүү сайн болгох болно.

“Аврах чадал бүхий түүний гавьяанд та нар бүрэн дүүрнээр даатган, түүнд хэлбэрэлтгүй итгэлтэйгээр Христийн үгсээр бус аваас өдий зэрэгт хүрээгүй болой”<sup>10</sup> гэдгийг эх хүн байх бүхий л өдрүүдэд санагтун.

Түүнд итгэн найд. Түүнд маш их итгэн найд. Түүнд мөнхөд итгэн найд. Мөн “найдарын төгс гэрэлтэйгээр . . . Христэд тууштайгаар итгэн урагш тэмүүл.”<sup>11</sup> Та нар Бурханы ажлыг хийж байна. Та нар үүнийг гайхамшигтай сайн хийж

байна. Тэрээр та нарыг адисалж байгаа мөн хэдийгээр—үгүй, *ялангуяа*—өдрүүд мөн орой үдэш тань магадгүй хамгийн хүнд, хэцүү байх үед Тэрээр та нарыг адислах болно. Зөвхөн Их Эзэний дээлэнд нь хүрэхээр нууцхан даруухнаар магадгүй эргэлзэж, бага зэрэг ичингүүрсэн ч гэсэн олон хүмүүсийн дундуур хувь заяагаа шийдвэрлэсэн тэр эмэгтэйн адил эх хүмүүсийн хувьд үүрэг хариуцлагынхаа төлөө санаа зовж, гайхширан мөн заримдаа уйлах ч үед тэр эмэгтэйчүүдэд ч гэсэн Христ “Охин минь, зоригтой бай. Итгэл чинь чамайг бүрэн бүтэн болгож эдгээлээ”<sup>12</sup> хэмээн хэлэх болно.

1997 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулган дээр Ахлагч Холландын хэлсэн үгнээс (Conference Report, 1997 оны Дөрөвдүгээр сар, 46–49; эсвэл *Ensign*, 1997 оны Тавдугаар сар, х. 35–37–г үз).

## ТЭМДЭГЛЭЛ

1. “Израилын Цагаатгагч,” *Дуулал*, дуг. 6; мөн түүнчлэн 3 Нифай 22:1–г үз.
2. Joseph Fielding Smith, *Doctrines of Salvation*–г үз, эмэтгэл. Bruce R. McConkie, 3 боть. (1954–56), 2:76; Harold B. Lee, *Ye Are the Light of the World: Selected Sermons and Writings of President Harold B. Lee* (1974), 292; мөн Гордон Б.Хинкли, Conference Report, 1991 оны Дөрөвдүгээр сар, 94.
3. Tom Lowe, “Fatherlessness: The Central Social Problem of Our Time,” Claremont Institute Home Page Editorial, 1996 оны Нэгдүгээр сар.
4. 2 Тимот 1:5.
5. 2 Тимот 3:15.
6. Номлогчийн үгс 3:1.
7. Хувийн харилцаа.
8. Жозеф Ф.Смит, *Gospel Doctrine*, 5 дугаар хэвл. (1939), 462.
9. 2 Нифай 2:25.
10. 2 Нифай 31:19.
11. 2 Нифай 31:20.
12. Матай 9:22.

## СИОН ДАХЬ ЭХЧҮҮДЭД

Сүмийн 13 дахь Ерөнхийлөгч  
Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон

Сион дахь эхчүүд ээ, Бурханаар өгөгдсөн үүргүүд тань гэр бүлийн тань өргөмжлөл болон өөрийн хувийн аврал, өргөмжлөлд тань амин чухал билээ. Мөнгөөр худалдан авч болох бүх юмсаас илүүгээр хүүхдэд эх нь хэрэгтэй байдаг. Үр хүүхдүүдтэйгээ цугтаа хамт байх нь бүхнээс агуу том бэлэг юм.

Сион дахь эхчүүдийг зүрх сэтгэлээсээ хайрлаж, эхчүүд маань хүүхдүүтэйгээ ашигтай цаг хугацааг өнгөрүүлж болох 10 арга замыг би санал болгомоор байна.

*Амьдралынх нь Туриш Хамт Бай.* Нэгдүгээрт, хүүхдүүд тань—сургууль руу явах буюу ирэх үед, тэд болзоонд явж, ирэх үед, тэд найз нөхдийгөө

гэртээ авчрах үед—явж, ирэх ямар ч үед цаг гаргаж амьдралынх нь туршид хамт бай. Хүүхэд тань зургаа эсвээс арван зургаан настай ч бай үргэлж амьдралынх нь турш хамт бай. Сургаалт үгсээс бид “Дур зоргоороо аашлагч хүүхэд эхийгээ ичгүүрт оруулна” (Сургаалт Үгс 29:15) гэдгийг уншдаг. Манай нийгэм дэх хамгийн том асуудлууд дотроос хурцадмал асуудал бол өдөр тутам эзгүй гэр орондоо ирдэг, ажилтай эцэг эхчүүдийн хараа хяналтгүй байгаа сая сая хүүхдүүд болоод байна.

*Жинхэнэ Найз нь Бай.* Хоёрдугаарт, эхчүүд ээ, хүүхдүүдийнхээ жинхэнэ найз нь болохын тулд цаг гарга. Хүүхдүүдийгээ сонс, үнэн сэтгэлээсээ сонс. Тэдэнтэй ярилц, тэдэнтэйгээ тоглож, тоглоом хийн инээж бай, дуулж хамтдаа тогло, хамтдаа уйлж үнэнээсээ магтан тэднийг тэвэрч ав. Тийм ээ, хүүхэд бүртэйгээ тогтмол биечлэн яаралгүйгээр цагийг өнгөрүүл. Хүүхдүүдийнхээ жинхэнэ найз нь бай.

Хүүхдүүддээ зориулан Ном Уншиж Өг.  
Гуравдугаарт, эхчүүд ээ, цаг гарган хүүхдүүддээ ном уншиж өг. Хүүхдийн тэргэнд байхаас авахуулан охид, хөвгүүддээ ном уншиж өгч бай. Яруу найрагчийн юу гэж хэлсэнийг сана:

Хэмжээлшгүй их эд баялаг таных байж болох юм;

Авдар, авдар дүүрэн алт, үнэт эдлэл ч тэр ч бүү хэл,

Харин ном уншиж өгч байсан ээжээс маань илүү  
Хэзээ ч урьд өмнө нь байгаагүйгээр би баян байж билээ.

(Strickland Gillilan, "The Reading Mother.")

Хэрэв та хүүхдүүддээ тогтмол ном уншиж өгч байх юм бол, та сайн уран зохиолд дуртай болгож, судруудад үнэн голоос хайрлах хайрыг тэдэнд суулгах болно.

Хүүхдүүдтэйгээ *Залбирч Бай*. Дөрөвдүгээрт, хүүхдүүдтэйгээ залбирахаар цаг гарга. Эцэгийн удирдлага дор өглөө, орой гэр бүлийн залбирал хийж байх хэрэгтэй. Та тэнгэрээс тэдэнд дээр ирэх адислалуудыг гуйхдаа хүүхдүүддээ итгэх итгэлээ мэдрүүл. Иаковын "Зөвт [эх] хүний залбирал нь . . . ихийг гүйцэлдүүлж чадна" (Иаков 5:16) хэмээн үгсийн утгыг ойлгогдохоор хэлж болно. Хүүхдүүдийгээ гэр бүлийн мөн хувийн залбиралыг хийхэд оролцуулж, Тэнгэрлэг Эцэгтээ санаагаа гарган хэлж байгаа тэдний өхөөрдөм гуйлганд баярлан баясаж бай.

*Долоо Хоног Тутам Гэр Бүлийн Үдшийг Хий*. Тавдугаарт, утга учиртай долоо хоног тутмын гэр бүлийн үдэш хийх цагийг зориул. Нөхрөөрөө тэргүүлэн удирдуулж долоо хоног бүрийн сүнс-лэг хийгээд урам хайрласан гэр бүлийн үдэшт оролц. Хүүхдүүдээ идэвхтэйгээр оролцуул. Тэдэнд зөв зарчмуудыг заа. Үүнийгээ гэр бүлийн хамгийн том уламжлал болго. Гэр бүлийн үдшийг анх Сүмд танилцуулахад: "Хэрэв Гэгээнтнүүд энэхүү зөвлөгөөг дуулгавартай дагах юм бол, агуу их адислалууд үр шимээ өгөх болно. Гэр бүлд хайр хийгээд эцэг эхчүүдэд дуулгавартай байдал нь нэмэгдэх болно. Итгэл нь Израилын залуучуудын зүрх сэтгэлд хөгжих ба тэд хилэнцэт нөлөөлөл хийгээд тэднийг хүрээлж буй уруу таталтуудын эсрэг тэмцэх хүчийг хөгжүүлэх болно" хэмээх Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн гайхамшигтай амлалтуудыг дурсан санаарай. (James R. Clark-ийн, эмхэтгэл., *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, 6 боть. [1965–75], 4:339). Энэхүү гайхамшигтай амлалт нь өнөөг хүртэл хүчинтэй байгаа юм.

*Хоолны Цагаар Хамтдаа Бай*. Зургадугаарт, хоолны цагаар хамтдаа байх цагийг аль болох олон удаа гарга. Энэ нь хүүхдүүд том болж, амьдрал илүү зав муутай болох үед хэцүү байдаг. Гэхдээ найрсаг сайхан яриа өрнүүлж, өдрийн төлөвлөгөө болон үйл ажиллагаануудыг хуваалцах хийгээд заан сургах онцгой мөчүүд нь хоол ундны үед тохиолддог, учир нь эцэг, эхчүүд болон хүүхдүүд нь үүнийхээ төлөө хамтдаа хичээнгүйлэн зүтгэдэг юм.

*Өдөр Тутам Судруудыг Унш*. Долдугаарт нь гэр бүлээрээ хамтдаа судруудаас уншихаар цаг гарга. Ганцаараа судраас унших нь чухал байдаг боловч гэр бүлээрээ судраас унших нь нэн чухал юм. Гэр бүлээрээ Мормоны Номыг уншихад, ялангуяа гэр оронд сүнс-лэг байдлыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь Ариун Сүнсийг тогтмол хамтрагчаа болгоход мөн эцэг эхчүүд болон хүүхдүүд аль аль нь уруу таталтыг эсэргүүцэх хүч өгөх болно. Би Мормоны Ном нь гэр бүлийн тань амьдралыг өөрчлөх болно гэдгийг та нарт амлаж байна.

*Аливаа Зүйлийг Гэр Бүлээрээ Хийж Бай*. Наймдугаарт, аливаа зүйлийг гэр бүлийн хувьд хамтдаа хийж бай. Гэр бүлээр гадагш салхинд гарах мөн зугаалах, төрсөн өдрийг тэмдэглэх ба аялал хийх, онцгой үеүд болон дурсамжийг бий болгох зэргийг хийж бай. Хэзээ ч хамаагүй, боломжтой л байвал, гэр бүлийн гишүүдийн аль нэг нь оролцсон тэр сургуулийн тоглолт, спортын бөмбөгийн тоглолт, яриа өгөх, хөгжмийн тоглолт гэх зэрэг үйл явдлуудад гэр бүлээрээ оролцож бай. Сүмийн цугларалтанд хамтдаа оролцож бай мөн болж өгвөл та нар гэр бүлээрээ хамтдаа сууж бай. Гэр бүлүүдийг хамтран залбирах хийгээд тоглоход тусалдаг эхчүүд хамтаа үлдэж, хүүхдүүдийн амьдралыг мөнхөд адислах болно.

*Хүүхдүүддээ Заан Сургаж Бай*. Ёсдүгээрт, эхчүүд ээ, хүүхдүүдийгээ заан сургахаар цагийг зориул. Заах боломжуудыг ашигла. Үүнийг өдрийн турш ямар ч үед—хоол ундны үеэр, ердийн үед буюу онцгой тохиолдлуудад хамтдаа суухдаа, өдрийн төгсгөлд орны хажууд суухад аль эсвэл өглөө эрт хамтдаа алхах зуураа хийж болно. Эхчүүд ээ, та нар хүүхдүүдийнхээ хамгийн сайн багш нь юм. Энэхүү үнэтэй үүрэг хариуцлагыг хүүхэд саатуулах төвүүд буюу хүүхдийн асрагчид руу бүү даатга. Эхийн хайр хийгээд хүүхдүүдийнхээ төлөө залбиралтайгаар санаа тавих нь өөрийн хүүхдүүдийг сургахад хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж өгдөг.

Хүүхдүүдэд сайн мэдээний зарчмуудыг заа. Энэ нь сайн сайхныг өгдгийг тэдэнд заа. Гэм нүгэлд

аюулгүй байдлын баталгааг олгохгүйг тэдэнд заа. Есүс Христийн сайн мэдээн дэх хайр хийгээд гэрчлэлийн бурханлиг шинжийг тэдэнд заа.

Охид, хөвгүүддээ даруу төлөв байхыг зааж, тэдэнд эцэг, эх хүн байхыг дээдлэхийг заа. Хүүхдүүддээ бэлгийн харьцааны цэвэр байдал, зөв зохистой болзооны жишгүүд, ариун сүмийн гэрлэлт, номлогчийн үйлчлэл хийгээд Сүмийн дуудлагуудыг хүлээн авах ба хүндлэн дээдлэхийн ач холбогдлыг заах.

Ажилд дуртай байх, чанартай боловсролын үнэ цэнийг тэдэнд заа.

Зохистой кино, видео бичлэг, хөгжим, ном сэтгүүлүүдийг багтаасан зохистой үзвэр үйлчилгээний ач холбогдлыг тэдэнд заа. Порнографи, мансууруулах бодисын хилэнцэт байдлыг ярилц, мөн цэвэр ариун амьдралын үнэ цэнийг тэдэнд зааж өг.

Тийм ээ, эхчүүд ээ, өөрийн гэрт, өөрийн гал голмотод сайн мэдээг хүүхдүүддээ заа. Энэ нь хүүхдүүдийн тань урьд өмнө хүлээн авч байгаагүй хамгийн үр дүнтэй сургамж нь байх болно. Энэ нь Их Эзэний заах арга юм. Сүм таны заадгийн адилаар зааж өгч чадахгүй. Сургууль ч үүнийг хийж чадахгүй. Хүүхэд саатуулах төв үүнийг хийж чадахгүй. Харин та бол чадна, мөн Их Эзэн таныг дэмжих болно. Хүүхдүүд тань та нарын заасан зүйлсийг мөнхөд санах ба тэд том болохдоо ч тэдгээрээс холдохгүй билээ. Тэд—жинхэнэ тэнгэр элч болох эхчүүдийгээ тэдний хувьд адислагдсан хэмээн та нарыг дуудах болно.

Эхчүүд ээ, ийнхүү төрлийн тэнгэрлэг эх хүний сургамжууд—асар их цаг хугацаа шаарддаг билээ. Үүнийг хагас цагаар хийх нь амжилт гарахгүй. Хүүхдүүдээ аварч, өргөмжлөлийг хүртээхийн тулд үүнийг байнга хийдэг байх ёстой. Энэ нь таны бурханлиг дуудлага юм.

Хүүхдүүдээ *Үнэн Голоосоо Хайрла*. Арав дахь бөгөөд эцсийнх нь хүүхдүүдээ үнэн голоосоо хайрлахаар цагаа зориулаарай, эхчүүд ээ. Мэдээж эхийн хайр нь Христийн хайртай дүйцдэг юм.

Эхдээ зориулсан нэгэн хүүгийн гайхалтай сайхан хүндэтгэл нь энд ийнхүү харуулав. “Би түүний сонгуульд өгөх санал, нийгэм дэх түүний нэр хүндийн аль алины тухай ихийг санахгүй байна; мөн би хүүхэд хүмүүжүүлэх, хоолных нь

дэглэмийг сахиулах мөн өсгөн хүмүүжүүлэх онолын талаарх түүний санал бодлыг санахгүй байна. Он удаан жилийн турш намайг анхаарч, халамжилж байсан гол зүйл бол тэрээр намайг хайрладаг байсан юм. Тэрээр надтай хамт зүлгэн дээр хэвтэж, түүхүүдийг ярьж өгөх эсвэл хүүхдүүд бидэнтэй хамт гүйж, нуугдаж тоглох дуртай байсан юм. Тэрээр үргэлж намайг тэвэрч байсан. Надад энэ нь таалагддаг байсан. Тэр үргэлж нүүрний баясгалантай байв. Миний хувьд энэ нь Бурхан мэт байсан бөгөөд бүх аз жаргалтай гэгээнтнүүд Түүний тухай ярьдаг билээ. Мөн дуулцгаадаг! Амьдралын маань сэтгэлд нийцсэн аятайхан сайхан бүх мэдрэмжүүдээс баяр хөөртэйгөөр ээжийнхээ өвөр лүү мөлхөн очиж, түүнийг дүүжин сандал дээр сууж дуу дуулж бүүвэйлэх зуур унтах шиг сайхан зүйл хаа ч үгүй билээ. Би үүнийг бодохдоо, бүх гайхамшигтай бүтээл болон төлөвлөгөөнүүдтэй өнөө үеийн эмэгтэй хүүхдээ зовлон уй гашуунд хандах хандлагыг төлөвшүүлэхэд нь тэрээр ямар том хөдөлгөгч хүч нь болдог эсэхийг тэрээр ухаардаг болов уу хэмээн гайхаж байна. Би тэрээр хүүхдийн амьдралд хичнээн их жинхэнэ хайр, анхаарлыг хандуулсаныг ухаардаг болов уу хэмээн би гайхаж байна.”

Эхчүүд ээ, таны өсвөр насны хүүхдүүдэд ч үүний адил хайр, анхаарал хэрэгтэй билээ. Олон эцэг эхчүүд хайраа хүүхдүүдээ бага байхад илэрхийлэх нь илүү хялбар байгаа мэт санагддаг боловч тэднийг том болох тусам үүнийг хийх нь илүү хүнд байдаг юм байна. Үүнийхээ төлөө залбиралтайгаар хичээнгүйлэн зүтгэгтүн. Үүнд үр удмын хоорондох ангал бий болох ёсгүй бөгөөд гол түлхүүр нь хайр байдаг билээ. Манай залуу хүмүүст хайр болон анхаарал хэрэгтэй ч өөгшүүлэн давруулж үл болно. Тэдэнд эцэг эхчүүдийн хайхрамжгүй байдал биш, харин тэдний зовлонг ойлгон ухаарч, тэдэнд хайраа илэрхийлдэг байх хэрэгтэй. Тэдэнд эцэг эхийн цаг зав, анхаарал хэрэгтэй байдаг. Нэгэн эхийн сайхан сэтгэлийн сургамж хийгээд өсвөр насны хөвгүүн буюу охинд зориулах түүний хайр ба итгэл нь бодитойгоор хилэнцэт ертөнцөөс тэднийг аварч чаддаг юм.

1987 оны Хоёрдугаар сарын 22-нд эцэг эхчүүдэд зориулсан галын дэргэдэх ярилцлага дээр Ерөнхийлөгч Бенсоны хэлсэн үгнээс.

# ҮЛГЭР ЖИШЭЭ, ЗААВАРЧИЛГААГААР ДАМЖУУЛАН ХҮҮХДҮҮДЭД ЗААХ НЬ

# 12

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Өөрсдийн хүүхдүүд буюу ач хүүхдүүдийнхээ хэрэгцээг мөн зээ дүү нар буюу таны мэдэх бусад хүүхдүүдийн хэрэгцээг тунгааж бод. Та өөрийн үйлдэл болон үг яриагаар эдгээр хүүхдүүдэд зааж сургах боломжуудыг төлөвлө.
- *Teaching, No Greater Call* (36123), хуудас 127–43 мөн *Гэр Бүлийн Удирдамж* (31180), хуудас 5–13 дээр байгаа гэр бүлд заах материалуудыг давтаж хар. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ уг материалыг уншиж ярилц.

## УНШИХ ЦААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв та гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### Сайн Эцэг Эх Байх нь—Дэлхийн Хамгийн Хүч Сорьсон Зүйл Билээ

Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын  
Ахлагч Жеймс И.Фауст

#### Эцэг Эх Байх нь Тэнгэрлэг Дуудлага юм

Би дэлхийн агуу их хүч сорьсон зүйл хэмээн нэрлэхээр сонгосон энэ сэдвийг ярилцах болсондоо сэтгэл маш их догдолж байна. Энэ нь сайн эцэг эх байх боломж хийгээд үүрэг хариуцлага, онцгой эрхтэй холбоотой билээ. Энэ сэдвийн тухайд гэвэл олон эцэг эх байдагтай адил олон санаа бодол байдаг ч, бүх зүйлийн хариуцлыг авахыг хүсэж буй цөөхөн хэд бий. Би мэдээж тэдний нэг нь биш.

Би өөрийн амьдрал дахь өөр ямар ч бусад мөчүүдээс илүү өнөөдөр илүү их шилдэг залуу эрэгтэй эмэгтэй хүмүүс байгаа гэдгийг мэдэрдэг. Энэ нь эдгээр хамгийн сайхан залуу хүмүүсийн ихэнх нь үзэл бодолдоо үнэнч, ажил үйлстээ бие сэтгэлээ зориулсан халамжтай эцэг эхчүүд хийгээд сайн гэр бүлээс гаралтай байдгийг урьдчилан таамаглаж байна. Хэдий тийм ч, хамгийн их ухамсартай эцэг эхчүүд алдаа гаргаж болно гэж боддог. Нэг удаа намайг бодлогогүй юм хийхэд, “Би хаана нь алдчихаа вэ?” гэж ээжийнхээ уулга алдсаныг санаж байна.

“Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүл” (С ба Г 93:40) хэмээн Их Эзэн сургамжилсан билээ. Миний хувьд, үүнээс илүү чухал хүмүүний хичээл зүтгэл гэж үгүй.

Эцэг, эх байх нь агуу их хүч сорьсон хэрэг байгаад зогсохгүй, энэ нь тэнгэрлэг дуудлага юм. Энэ нь өөрийгөө бүрэн зориулахыг шаарддаг хичээл зүтгэл юм. Ерөнхийлөгч Давид О.МакКей эцэг, эх байх нь “хүмүүнд өгөгдсөн хамгийн итгэл авсан хэрэг юм” хэмээн мэдэгдсэн билээ (*The Responsibility of Parents to Their Children* [товхимол, огноо нь тодорхойгүй.], 1).

#### Амжилт Дүүрэн Өрх Гэрийг Бий Болгох нь

Хэдхэн л хүмүүний бэрхшээл сайн эцэг эх байхаас их байхад, цөөхөн боломжууд баяр баясгалангийн төлөө их чадавхийг санал болгодог. Мэдээж хүүхдүүдээ Бурханаас эмээдэг, аз жаргалтай, хүндэтгэлтэй, үр өгөөжтэй байхад бэлтгэхээс илүү энэ дэлхий дээр хийгдэх өөр ямар ч чухал ажил үгүй билээ. Эцэг эхчүүд өөрсдийгөө болоод, захиас сургамжаа хүүхдүүдээрээ хүндлүүлэхээс илүү биелж буй аз жаргалыг олох нь үгүй. Энэ нь эцэг эх байхын алдар юм. Иохан гэрчлэхдээ: “Миний хүүхдүүд үнэн дотор явж байгааг сонсохоос илүү эрхэм баяр баясгалан надад байхгүй билээ” (3 Иохан 1:4) гэжээ. Миний бодлоор хүүхдийг зааж, сургаж, хүмүүжүүлэхэд бидний амьдралд тулгарч болох өөр бусад бэрхшээлээс илүүтэйгээр ухаан, зөн совингоороо ойлгох, хүн чанар, хүч чадал, мэргэн ухаан, сүнслэг байдал, шургуу хичээнгүй байдал хийгээд ажилсаг чанарыг шаарддаг. Энэ нь ялангуяа хүндэтгэл хийгээд боловсон зан байдлын ёс суртахууны суурь үндэс нь бидний эргэн тойронд бага багаар зэврэн алга болж байхад оршино. Амжилт бүтээлээр дүүрэн гэртэй болохын тулд үнэ цэнийн талаар заасан

байх ёстой бөгөөд дүрэм журам байх ёстой, жишиг стандарт байх ёстой, мөн үнэмлэхүй бүрэн дүүрэн байдал байх ёстой. Олон нийгэм эцэг эхчүүд ёс суртахууны үнэ цэнийг хүндэтгэх болон заахад маш бага дэмжлэг үзүүлдэг. Тоологдохуйц соёл үнэн хэрэгтээ үнэ цэнэгүй болж байна, түүнчлэн тэрхүү нийгэм дэх залуучуудын олонх нь ёс суртахууны хувьд увайгүй дорой болж байна.

Нийгэм бүхлээрээ ялзралд орж, ёс суртахууны жинхэнэ байдлаа гээчихээд байна, мөн маш олон гэр бүл салж сарнисан, хамгийн сайн найдвар бол—бидний хүүхдүүд—дараагийн үеийнхэндээ зааж сургахад агуу их анхаарал хийгээд хичээл зүтгэлийг буцаахад байгаа юм. Үүнийг хийхийн тулд, бид эхлээд хүүхдийн хэсгийн багш нарыг хүчирхэгжүүлэх ёстой. Эдгээрийн доторх тэргүүлэгчид нь эцэг эх болон бусад гэр бүлийн гишүүд, бөгөөд хамгийн сайн хүрээлэн буй орчин нь гэр орон байх ёстой. Ямар нэгэн байдлаар, яаж ийгээд бид гэр бүлээ илүү хүчирхэг болгохын тулд сайн хичээх ёстой, тэгвэл тэд бидний эргэн тойронд буй нийгэмд сүйрэл тарьж буй ёс суртахууны олныг хамарсан бузар булайн эсрэг ариун дагшин дуган мэт зогсох болно. Гэр бүл дэх нийцэл зохицол, аз жаргал, амар амгалан хийгээд хайр нь хүүхдүүдэд амьдралын бэрхшээлүүдийг ялан дийлэхэд шаардагдах дотоод хүч чадлыг өгөхөд тусалдаг. Хэдхэн сарын өмнө [Нэгдсэн Улсын] Ерөнхийлөгч Жорж Бушийн гэргий Барбара Буш Веллеслей Коллежийн төгсөгчдөд хандан хэлэхдээ:

“Гэхдээ ямар ч эрин, ямар ч цаг үед нэг л зүйл хэзээ ч өөрчлөгддөггүй: Аавууд, ээжүүд ээ, хэрвээ та нар хүүхдүүдтэй бол хамгийн түрүүнд байх ёстой. Та нар хүүхдүүдээ уншиж өгөх ёстой, та нар хүүхдүүдээ гэвэрэх ёстой, та нар хүүхдүүдээ хайрлах ёстой. Та нарын амжилт гэр бүлээрээ, бидний амжилт нийгмээрээ, Цагаан Ордонд юу болдог гэдэгт хамааралтай биш, харин танай гэрийн дотор юу болдогт хамааралтай” гэжээ (*Washington Post*, 1990 оны Зургадугаар сарын 2, 2).

Сайн аав, ээж байна гэдэг бол эцэг эх өөрсдийнхөө ихэнх хэрэгцээ болон хүслээ хүүхдүүдийнхээ хэрэгцээнд нийцүүлэн тэдний санал бодлыг тооцон үзэхэд шаардагддаг. Энэхүү золиослолын үр дагавраар ухамсартай эцэг эх зан сайхан, сэтгэлт өгөөмөр зан төлвөө хөгжүүлдэг бөгөөд Аврагчийн Түүгээр заалгасан амиа үл бодох үнэнийг хэрэгжүүлэхээр сурдаг.

Надад гэр бүлээ хамтат нь барихын тулд бараг л хүний хэрээс хэтэрсэн бололцооны эсрэг тулан золиослол хийж тэмцдэг ганц бие аав, ээжүүдийг хүндэтгэх гүн хүндэтгэл бий. Тэдний баатарлаг хичээл зүтгэлд нь хүндэтгэл үзүүлэн туслах ёстой.

Гэхдээ гэрт эцэг эх нь хоёулаа үүргээ хамтран хүлээлцэж байвал, ямар ч аав, ээжийн үүрэг даалгавар нь хөнгөвтөр байдаг. Хүүхдүүд үргэлж бэрхшээл учруулдаг, ба түүнчлэн эцэг эх хоёрынхоо мэргэн ухаан, хүч чадлыг сорьж туршдаг.

### **Гэр Бүлийн Залбирлыг Хэр Зэрэг Ойрхон Хийдэг вэ?**

Хэдхэн жилийн өмнө, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Бишоп Стейнли Смүүттэй ярилцлага хийхэд Ерөнхийлөгч Кимбалл, “Гэр бүлийн залбирлыг та хэр зэрэг ойрхон хийдэг вэ?” гэж асуулаа.

Бишоп Смүүт, “Бид гэр бүлийн залбирлаа өдөрт хоёр удаа хийхийг хичээдэг, гэхдээ дунджаар нэг л юм даа” гэлээ.

Ерөнхийлөгч Кимбалл “Өнгөрсөн үед, гэр бүлийн залбирлыг өдөрт нэг удаа хийхэд болдог л байсан. Харин ирээдүйд хэрвээ бид гэр бүлээ аврах гэж байгаа бол энэ нь хангалттай биш байна” гэж хариуллаа.

Хүүхдүүдээ хангалттай ёс суртахууны хүч чадлаар батжуулахын тулд үл тоомсорлосон ба тогтмол бус гэр бүлийн үдшийн цуглаан хийх нь ирээдүйд хангалттай байх болов уу хэмээн би бодож байна. Хүүхдүүдийнхээ амьдарч болох хүрээлэн буй орчны ёс суртахууны ялзралын эсрэг зогсохын тулд шаардлагатай сайн үйлээр хүүхдүүдээ цэнэглэхэд тогтмол бус гэр бүлийн судрын судлал ирээдүйд тохиромжгүй, мөн шаардлага хангахгүй байж болно. Хэрэв гэрт л биш бол, энэ дэлхийн хаана хүүхдүүд ариун явдал, зарчимч байдал, үнэнч болоод суурь хүмүүжил, хүмүүний ёс журмыг авч болох вэ? Эдгээр үнэ цэнийг, мэдээж хэрэг, сүм дээр бэхжүүлж болно, гэхдээ эцэг эхийн сургамж илүү тогтмол байдаг.

### **Эцэг Эхчүүд Үлгэр Жишээ Үзүүлэх Ёстой**

Эцэг эхчүүд аюулаас зайлсхийхийг хүүхдүүдээ заахыг шамдах үед, “Бид дэлхийн арга барилд туршлагжиж, мэргэн болсон бөгөөд та нараас илүү азаа турших боломжтой байж чаддаг” гэж хүүхдүүдээ хэлэх нь эцэг эхчүүдийн хувьд хариулт биш юм. Эцэг эхийн хоёр нүүр гаргах байдал нь хүүхдүүдээ гэртээ заасан зүйлдээ үл итгэдэг, ичгүүргүй, увайгүй болгодог. Тухайлбал, хүүхдүүдээ үзэхийг хориглодог киног эцэг эхчүүд өөрсөдөө үзэхэд, эцэг эхийн зүгээс итгэл хэрэг алдарсан болдог. Хэрэв хүүхдүүдээ үнэнч шударга байхыг хүсвэл, эцэг эх үнэнч шударга байх ёстой. Хэрэв хүүхдүүдээ ёс журам баримталдаг, дэг жаягтай байлгахыг хүсвэл, эцэг эх дэг жаягтай байх ёстой. Хэрэв хүүхдүүдээ хүндэтгэл-



тэй байлгахыг хүсвэл, та өөрөө хүндэтгэл хүлээхээр байх ёстой.

Бусад үнэ цэнийн дунд хүүхдүүдээ өөрийн эцэг эх болоод гэр бүлээсээ эхлэн, бусдад хүндлэлтэй, бусдын эх оронч итгэл бишрэл болоод итгэлийн бэлэгдэлд хүндэтгэлтэй, хууль журам, эмх цэгцэд хүндэтгэлтэй, бусдын эд хөрөнгөнд хүндэтгэлтэй, эрх мэдэлд хүндэтгэлтэй хандаж сурахыг заах хэрэгтэй. Паул хүүхдүүд "юуны өмнө өөрсдийн төрсөн гэр бүлийнхнийг хүндлэхэд . . . суралцуул" (1 Тимот 5:4) гэдгийг бидэнд сануулдаг.

### Хүүхдийг Хүмүүжүүлэх нь

Эцэг эхийн хамгийн хэцүү бэрхшээлүүдийн нэг нь хүүхдүүдийг зөв зохистойгоор хүмүүжүүлэх юм. Хүүхэд хүмүүжүүлэх нь ганцаарчилсан халамжийг хэлнэ. Хүүхэд бүр өөрийн гэсэн онцлогтой байдаг. Нэгэнд нь тохирч байхад, нөгөөд нь тохирдоггүй. Тэднийг хамгийн их хайрладаг эцэг эхчүүдээс нь өөр ямар сахилга бат хэт их хатуу эсвэл ямар нь хэтэрхий зөөлөн гэдгийг хэлэх хангалттай ухаантай нэгнийг би мэдэхгүй. Энэ нь эцэг эхчүүдийн хувьд залбиралтайгаар хийгдэх танин мэдэх чадвартай холбоотой. Мэдээж хэрэг давамгайлсан мөн дэмжлэг үзүүлдэг зарчим нь хүүхдийн хүмүүжил шийтгэлээс илүү хайраар урам өгөх ёстой байдаг байна. Бригам Янг зөвлөхдөө: "Хэрэв чи хүнийг зэмлэхээр болбол, хэзээ ч битгий сэтгэлд нь сэв суутал зэмлэ" гэжээ (*Discourses of Brigham Young*, сонг. John A. Widtsoe [1954], 278). Чиглэл удирдамж болон сахилга бат нь хүүхэд өсгөх зайлшгүй хэсэг юм. Хэрэв эцэг эхчүүд нь үр хүүхдээ хүмүүжүүлдэггүй бол, улс тэднийг эцэг эхийн дургүй замаар хүмүүжүүлэх болно. Сахилга батгүйгээр, хүүхдүүд гэрийн ч бай нийгмийнхээ ч бай дүрэм журмыг хүндэлж үзэхгүй.

Хүмүүжүүлэх үндсэн зарчим бол дуулгавартай байдлыг заах юм. Ерөнхийлөгч Давид О.МакКей: "Хүүхдүүддээ дуулгавартай байдлыг зааж чаддаггүй эцэг эхчүүд хэрэв [өөрсдийн] гэр оронд дуулгавартай байдлыг хөгжүүлэхгүй юм бол, нийгэм тэднээс үүнийг шаардаж, тэднийг дуулгавартай болгох болно. Үүрэг даалгавраа одоог хүртэл биелүүлээгүй гэр бүлийн хайхрамжгүй орхисон хүүхдэдээ нийгмийн тэрхүү гашуун хатуу мөн өрөвдөх сэтгэлгүй сахилга батыг түүнд ноогдуулж байхаар гэртээ сайхан сэтгэл, энэрэнгүй байдал болон ухамсраар дуулгавартай байдалд хүүхдээ сургах нь илүү дээр юм" хэмээн цохон тэмдэглэжээ (*The Responsibility of Parents to Their Children*, 3).

### Хөдөлмөрлөхийг Хүүхдүүдэд Заах нь

Хүүхдэд хүмүүжил, хариуцлагын мэдрэмжийг заах чухал хэсэг бол тэднийг хөдөлмөрлөхөд сургах явдал юм. Бид том болоход, бидний ихэнх нь, "Би ажилд дуртай; энэ нь намайг бишрүүлдэг юм. Би суугаад, хэдэн цагийн турш үүнийг шимтэн харж чадна" гэж хэлсэн хүнтэй адил юм (Jerome Klapka Jerome, *The International Dictionary of Thoughts*, хэвл. John P. Bradley, Leo F. Daniels, ба Thomas C. Jones [1969], 782). Дахин хэлэхэд, ажлын зарчмын хамгийн сайн багш нар бол эцэг эх өөрсдөө юм. Би аав, өвөө, нагац ах болон ах нарынхаа хажууд анх удаагаа ажиллахад ажил хөдөлмөр миний хувьд баяр баясгалан болсон юм. Би ихэнхдээ туслах гэхээсээ илүү хүндрэл учруулдаг байсан гэдэгтэй итгэлтэй байна. Гэлээ ч гэсэн дурсамжууд нь амттай хийгээд сурсан хичээлүүд нь үнэ цэнэтэй байдаг. Хүүхдүүд үүрэг хариуцлага мөн бие даалтад суралцах хэрэгтэй. "Өөрсдийн тул үйлдэх . . . бусдаар дээрээ үйлдүүлэх нь үгүй болой" (2 Нифай 2:26) хэмээн Лихайн заасан шиг хүүхдүүд нь хийж чадахын тулд эцэг эхчүүд, тэдэнд харуулж үзүүлж, тайлбарлахад биечлэн цаг гаргаж байна уу?

Дэлхийн хамгийн шилдэг цэцэрлэгжүүлэгчдийн нэг Лютер Бүрбанк "Бид хүүхдүүддээ ургамал дээр тавьдаг шиг анхаарлыг тавьдаггүй байсан бол бид одоо хогийн ургамлын ширэнгэн дунд амьдарч байх байсан" хэмээн хэлсэн юм (*Elbert Hubbard's Scrap Book* [1923], 227).

### Эцэг Эхчүүдэд Тулгарах Онцгой Бэрхшээлүүд

Хүүхдүүд нь мөн ёс суртахууны сонголтын хүлээн авагчид болохоор, бид бүгдэд үүнээс үүдэн өсөж, хөгжих, дэвших боломж олгогддог. Түүнчлэн тэрхүү сонголт нь хүүхдүүдийг хувиа хичээх, арвич хямгач биш, үрэлгэн байх, дур зоргоороо аашлах хийгээд амиа хорлох мэтийн хувьсах сонголтын араас явахыг зөвшөөрдөг. Хүүхдүүд ихэнхдээ энэхүү сонголтоо бага балчир байхдаа илэрхийлдэг.

Ухамсартай, энхрий ялдам, хайр халамжтай болоод зөв шударгын зарчмаар чадах ядахаараа амьдарсан эцэг эхчүүд зарим хүүхдүүдийн чинь үйлдлүүдийг үл харгалзан та нар сайн эцэг эх гэдгээ мэдэн тайтгарцгаа. Хүүхдүүд өөрсдөд нь сонсох, дуулгавартай дагах, заалгах, болоод суралцах хариуцлага байдаг. Эцэг эхчүүд үргэлж хүүхдүүдийнхээ бүх эвгүй ааш, сахилга батгүй байдалд хариулт өгч чадахгүйн учир тэд хүүхдүүдийнхээ сайн биеэ авч явах байдлын талаар баталж чадах-

гүй. Зарим хүүхдүүд бүр Соломоны мэргэн ухаан хийгээд Иовын тэвчээр шаарддаг.

Онцгой бэрхшээл нь үргэлжид баян чинээлэг буюу хэт их дур зоргоороо авирлагч тэдгээр эцэг эхчүүдэд тулгардаг. Ер нь ийм тохиолдолд зарим хүүхдүүд эцэг эхчүүд нь хүүхдүүдийнхээ шаардлагуудад эвлэрэхгүй бол эцэг эхийн дүрэм журмын дэмжлэгийг эсэргүүцэн эцэг эхээ барьцаанд авдаг. Ахлагч Нийл А.Максвелл, “Хүүхдүүдийнхээ төлөө хэт их юм хийдэг тэдгээр хүмүүс хүүхдүүд нь үгэнд орохгүй болсон гэдгийг удахгүй мэдэж авах болно. Маш олон хүүхдүүд бараг амьдралаа сүйрүүлж болохоор их зүйлийг хийсээр байна” хэмээн хэлсэн байдаг (Conference Report–нд, 1975 оны Дөрөвдүгээр сар, 150; мөн *Ensign*, 1975 оны Тавдугаар сар, 101). Бид өөрсдөө олж аваагүй материаллаг зүйлдээ бүрнээр талархалтай байдаггүй нь хүмүүний төрөлх зан байх шиг санагддаг.

Зарим эцэг эхчүүд хүүхдүүдээ үеийнхнийх нь дунд нэрд гаргах болоод хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэдний сэтгэл ихэд зовдог хэдий ч тэдгээр эцэг эхчүүд хүүхдүүд нь нас чацуутныхаа хийж байгаа зүйлийг хийж болдгоос айдаг гэсэн баримтанд тодорхой егөөдөлтэй байдаг.

#### Үнэ Цэнийг Тогтооход Хүүхдүүдээ Туслах нь

Ерөнхийдөө, шийдвэр гаргадаг хийгээд хар тамхи, архи болоод хууль бус бэлгийн харьцаанаас зайлсхийх зоригтой байдаг хүүхдүүд бол эцэг эхтэйгээ хамт амьдарч, гэр орныхоо бат бөх үнэ цэнийг тогтоож, дэмжин сайшаадаг байсан тэдгээр хүүхдүүд юм. Хэцүү шийдвэрийн үед тэд үеийнхнийхээ жишээ эсвэл архины хэрэглээ, хууль бус бэлгийн харьцаа, шашингүйн үзэл, үнэнч бус байдал, бусад хорт явуулгыг чимэглэн ярьдаг хэвлэл мэдээллийн заль мэх гэхээс илүү эцэг эхийнхээ сургамжийг дагах нь олонтаа байдаг. Тэд “эхчүүдээрээ, хэрэв тэд эргэлзэхгүй аваас, Бурхан тэднийг (үхлээс) чөлөөлнө гэдгийг сургагдсан” (Алма 56:47) яг л Хиламаны хоёр мянган залуу эрчүүдийн адил юм. “Мөн тэд эхчүүдийнхээ үгсийг . . . давтаж, хэлрүүн: Эхчүүд маань үүнийг мэдэж байсан гэдэгт бид эргэлзэхгүй байна” (Алма 56:48).

Хүүхдүүдийн амьдралд эцэг эхийн бат бэх сургамж болоод үнэ цэнийг байрлуулахад туслах юм юу байна вэ гэвэл Бурханд итгэх итгэл юм. Энэхүү итгэл нь тэдний мөн чанарын нэгэн хэсэг болох үед тэдэнд дотоод хүч чадал байдаг. Иймээс, эдгээр зайлшгүй заах зүйлүүдээс эцэг эхчүүд чухам юу заах ёстой вэ? Судрууд бидэнд эцэг эхчүүд хүүхдүүдээ “амьд Бурханы Хүү

Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн . . . Ариун Сүнсний бэлгийг” мөн “наманчлалын сургаалыг” (С ба Г 68:25) заах учиртайг хэлдэг. Эдгээр үнэнүүдийг гэрт заах ёстой. Нийтийн сургуульд зааж чадахгүй, бүр засгийн газар болоод нийгэм ч тусалж дэмжихгүй. Мэдээж хэрэг, Сүмийн хөтөлбөрүүд тусалж чадна, гэхдээ гэр оронд хамгийн үр дүнтэйгээр заалгаж болдог.

#### Хайрын Мянга Мянган Утас

Эцэг эхийн сургамжийн мөчүүд нь урт удаан буюу дарамталсан, хиймэл байх хэрэггүй. Бид үүнийг Мастер Багшаасаа суралцдаг. Чарльз Хэнри Паркхөрст хэлэхдээ,

“Христийн амьдралын бүрэн дүүрэн сэтгэл татам байдал нь—худаг дээрх эмэгтэйтэй ярьж буй; . . . нууцгайхан нэр төрд дуртай байдал зүрхэнд нь хурсан тул Тэнгэрлэг хаант улсад орж чадаагүй залуу удирдагчийг үзүүлэн; . . . цөөн хэдэн дагалдагчдаа хэрхэн залбирахыг заасан, . . . загасчилсан, даарсан, ядарсан хийгээд санаагаар унасан шөнөөс эрэгт тэднийг ирэхэд дагалдагчид нь өглөөний цай ууж болохын тулд гал өрдөж, загас шарж буй—гэх гоо сайхны ялихгүй үйлдлийн үзэмжийг зөвхөн нэмсэн юм. Таны харж буй эдгээр, бүгдээрээ, ийм тодорхой, ийм нарийссан, ийм жаахан гэдэг зүйлд нэгдсэн, ийм минутад ч сэтгэлийг нь бүрэн эзэмдсэн жинхэнэ [Христийн] сонирхлын шинж чанар болоод өнгө рүү маш амархнаар орцгооё” гэжээ (“Kindness and Love,” *Leaves of Gold*–ийн [1938], 177).

Энэ нь эцэг эх байхад л юм. Эдгээр жижиг зүйлс нь гэр бүлийн аравчинд хайр, итгэл, сахилга бат, золиослол, тэвчээр хийгээд хөдөлмөрийн мянга мянган утсаар нэхсэн том зүйлс юм.

#### Гэрээн дэх Хүүхдүүд

Энэ сүмийн итгэлтэй эцэг эхчүүдэд тусалж болох зарим агуу сүнслэг амлалтууд байдаг. Мөнхийн лацдалтын хүүхдүүд гэрээнүүдээ нэр төртэйгөөр хадгалсан эрэлхэг зоригтой өвөг дээдстээ хийсэн тэнгэрлэг амлалтуудаар тэдэн дээр зочилсон байж болох юм. Эцэг эхчүүдээр санаж дуурссан гэрээнүүд нь Бурханаар дуурсагдах болно. Тэрхүү хүүхдүүд нь тэдгээр агуу гэрээнүүд хийгээд амлалтуудын өв залгамжлагчид ба хүлээн авагчид болох юм. Яагаад гэвэл тэд гэрээний хүүхдүүд юм (Orson F. Whitney, Conference Report–г үз, 1929 оны Дөрөвдүгээр сар, 110–11).

Бурхан энэ дэлхий дээр тэмцэж буй, золиослол хийж байгаа, хүндлүүштэй эцэг эхчүүдийг адисладаг. Бидний хүмүүсийн дундах гэрээнүүдээ

хадгалсан итгэлтэй эцэг эхчүүдийг ялангуяа хүндэтгэ, мөн Тэрээр гэрээний хүүхдүүдийг харж хамгаалах болтугай.

1990 оны Аравдугаар сарын Сүмийн ерөнхий чуулган дээр Ахлагч Фаустын хэлсэн үгнээс (Conference Report, 1990 оны Аравдугаар сар, 39–43; эсвэл *Ensign*, 1990 оны Арваннэгдүгээр сар, 32–35–ыг үз).

## ХАЙРААР ХҮРЭЭЛЭГДСЭН ШИРЭЭ

Далын

Ахлагч ЛиГранд Р.Көртис

Өрх гэрийн ач холбогдлын талаар маш ихийг бичсэн байдаг. Ахлагч Марион Ж.Ромни бидэнд хэлэхдээ: “Нийгэм дэх гол эмзэг асуудал бол гэр бүлийн тогтворгүй байдал юм”<sup>1</sup> гэжээ. Зарим айл гэр их том, сайхан тавилгатай, тэр ч байтугай баян тансаг байдгийг бид мэднэ. Гэтэл бусад орон гэрүүд нь маш жижиг бөгөөд бага тавилгатай даруухан байдаг. Гэсэн хэдий ч, бидний дуртай сүмийн дуулалд байдагчлан “бид хайраар дүүрэн байх юм бол, . . . бид өөрсдөө байхыг хүсдэг аливаа айл гэр дэлхий дээрх тэнгэрлэг орон болж чадна”<sup>2</sup> хэмээн сануулдаг билээ.

Ихэнх айлын чухал тавилгуудын нэг бол гал тогооны ширээ байдаг. Энэ нь том, жижиг эсвэл хоол унд, сав суулга багтаах төдий жижигхэн лангуу маягийн хэлбэртэй ч байж болох юм. Үүнийг ашиглах гол зорилго нь гэр бүлийн олон гишүүд хоол тэжээлээ олж авахад зориулагдсан газар нь юм.

Энэ онцгой үйл явдлыг тохиолдуулан, би та бүхний анхааралд бидний бие махбодын хоол тэжээл хүлээн авахаас арай илүү их зүйлийг олж авдаг гал тогооны ширээний нилээд чухал үүргийн талаар хүргэхийг хүсэж байна.

### Ширээ Тойрсон Сайн Мэдээний Ярилцлагууд

Ер нь аливаа гэр бүлд насны хувьд өөр хоёр буюу түүнээс дээш гишүүдтэй байдаг. Мөн гэр бүл зөвхөн хооллохын тулд уулздаг төдийгүй, бас хамтдаа залбирч, ярилцаж, сонсож, хэлэлцэн авч үзэж, суралцаж мөн хамтдаа өсөн дээшлэх хэрэгцээтэй байдаг. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли үүний талаар маш сайхан тэмдэглэн хэлсэн билээ.

“Илүү уранаар илэрхийлэх байсан—миний хүсэл гуйлт бол хүүхдүүдийг аврах хүсэл билээ. Тэдний олонх нь өвчин зовлон, айдас түгшүүр, ганцаардал мөн арга тасарч, цөхөрсөн байдалтай явцгаадаг. Хүүхдүүдэд нарны гэрэл, гэгээ хэрэгтэй. Тэдэнд аз жаргал хэрэгтэй. Тэдэнд хайр, халамж хэрэгтэй. Тэдэнд сайхан сэтгэл, хоол унд

болон хайр хэрэгтэй. Айл гэр бүр орон байрны үнэ өртөгөөс үл хамааран авралын орчин болох хайрын орчныг бүрдүүлж чаддаг.”<sup>3</sup>

Ихэнх гэр бүлийн гишүүд гэр орноос гадуур дэлхийн олон хүч нөлөөнд автагддаг, мөн түүнчлэн бид өөрсдөө гэртээ оруулж ирдэг радио, телевиз, видео хуурцаг болон бусад олон зүйлсийн хүчтэй нөлөөнд өртдөг билээ.

Ширээ тойрон суугаа гэр бүлийг төсөөл, гал тогооны ширээг тойрон суугаад сайн мэдээний талаар, мөн ариун ёслолын цуглаанууд, *Лиахонагийн* шинэхэн дугаар буюу Тэргүүн Зөвлөлийн Захиас Бичгүүдийн тухай болон сургууль дээр болсон хэрэг явдал, ерөнхий чуулганы тухай, Ням Гарагийн Хичээл, сайхан дуу хөгжим сонсох мөн Есүс Христ болон Түүний сургаалын тухай ярьцгааж болох юм. Энэ жагсаалт нь бүр өргөн хүрээтэй байж болох юм. Хүн нэг бүр ярианд оролцох өргөн боломж байдаг тул зөвхөн эцэг эхчүүд биш харин гэр бүлийн бүх гишүүд ярих зүйлээ тодорхой болгох нь ухаалаг хэрэг юм.

### Ширээ Тойрон Хийх Гэр Бүлийн Залбирал

(Зурагт асаалгүйгээр) ширээ тойрон өвдөг дээрээ сөхрөн сууж залбирч, Эцэгээс тусламж гуйн, Түүний адислалд нь талархан,—Тэнгэрлэг Эцэгийг хайрлахын чухлыг бүх насныханд заах тухай бодож үз. Бяцхан хүүхдүүдтэй хамт хийх гэр бүлийн залбирал нь томчуудад нь хэзээ нэгэн өдөр өөрийн гэр бүлийнхэнтэй залбирах хүслийг төрүүлэн тэднийг хөгжүүлэх болно.

Ахлагч Томас С.Монсон өгүүлэхдээ:

“Их Эзэн: ‘Гэр бүлдээ Эцэгт миний нэрээр үргэлж залбир, эхнэрүүд чинь, мөн хүүхдүүд чинь ивээгдэж болохын тулд болой’ (3 Нифай 18:21) хэмээн хэлэхдээ гэр бүлийн залбиралыг хийж байхыг бидэнд тушаасан юм.”

“Жирийн нэг Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүл Их Эзэнд хандан залбирч буйг та нар надтай хамт явж харах уу? Эцэг эх, хүүхэд бүр өвдөг сөхрөн, толгойгоо бөхийлгөн нүдээ анин суудаг. Хайр, эв нэгдэл, амар амгалангийн тэрхүү сайхан сүнс гэрээр дүүрсэн байна. [Ямар ч] эцэг хүн бяцхан хүүгээ Бурханд хандан аавыг минь зөв зүйлийг

хийхэд мөн Их Эзэний тушаалуудад дуулгавартай байхад нь туслаач гэж залбирахыг сонсоод, өхөөрдөм хүүгийнхээ залбиралыг хүндэтгэхэд тэр эцэгт хэцүү байна гэж та нар бодож байна уу? Мөн өсвөр насны охин нь хайртай ээжийнхээ Их Эзэнд хандан охиныгоо мөнхийн хамтрагчийг сонгохдоо сүнслэгээр хөтлөгдөөсэй, түүнийг ариун сүмийн гэрлэлтэд бэлтгээсэй хэмээн гуйн залбирч буйг сонсоод, хайрт эхийнхээ даруухнаар хүсэж буй гуйлтыг тэр охин хүндэтгэж үзэхийн аргагүй гэж таньд бодогдох байх. Гэр бүлүүд дэх тэдгээр сайхан хөвгүүдээ зохистой амьдарч, цаг нь болоход Сүмийн номлолын талбарт Их Эзэний элч төлөөлөгчөөр үйлчлэх дуудлагыг хүлээн авч болохын тулд эцэг эх, хүүхэд нэг бүрчлэн чин сэтгэлээсээ залбирах юм бол, бид тэдгээр хөвгүүдийг хэрхэн эрийн цээнд хүрч, номлогчоор үйлчлэх асар их хүсэлтэй болон өсөхийг харахгүй гэж үү?”<sup>4</sup>

Олон хүмүүсийн ярьснаар, “Та нар хамтдаа цугларч Их Эзэнтэй ярилгүйгээр өдөр бүр энэ дэлхий ертөнц рүү юунд эцэг эх, хүүхдүүдээ явуулна вэ?” Ухаалаг эцэг эхчүүд өдрийнхөө төлөвлөгөөг ярилцан, залбиралын адислалуудыг авахын тулд гэр бүлээ дор хаяж өдөрт нэг удаа цуглуулахыг төлөвлөдөг. Удалгүй, залуу гишүүд өөрсдийнх нь ээлж ирэхэд үүнийг сурч, мөн гэр бүлийнхээ залбирал дахь үнэт нандин ёс журмыг сурч авдаг билээ.

### Өрх Гэрээ Аз Жаргалтай Газар Болго

Би өмнө нь, “гэр орон бол аз жаргалтай газар байх ёстой, тиймээс бүгд л ийм л байлгахгаар хөдөлмөрлөдөг” гэж тэмдэглэн хэлсэн юм. Аз жаргал нь гэрт л бий болдог гэж хэлсэн байдаг бөгөөд бид гэр орноо хүүхдүүдийнхээ болон өөрсдөдөө тааламжтай, аз жаргалтай орчин болгоход хичээн чармайх хэрэгтэй. Аз жаргалтай гэр орон нь сайн мэдээний сургаал дээр түшиглэсэн байдаг. Энэ нь бүх талаараа байнга хянуур байхыг шаарддаг.”<sup>5</sup>

Нэгэн өнөр бүлийн зав муутай өсвөр насны хүү гэр бүлийн залбирал хэт их цаг аваад байна гэж гомдолложээ. Ухаалаг ээж нь дараагийн өдөр залбирахдаа санаатайгаар тэр хүүгээ оролцуулалгүй залбирчээ. Залбирал хийж дуусгахад, нөгөө яарч, сандардаг хүү: “Ээж, та залбиралдаа намайг оруулсангүй” гэжээ. Хайрт ээж нь хүүд зүгээр гомдоллосонд нь хариу ингэлээ гэж тайлбарлахад, яарч, сандардаг хүү нь: “Намайг битгий орхиж бай” гэж гомдоллож билээ.

### Ширээ Тойрон Судраас Суралцах нь

Судруудыг нээн гэр бүлээрээ ширээ тойрч суугаад, олон үнэнүүд ба ойлгож авах хичээлүүдийг ярилцаж буй байдлыг төсөөл. Энэ нь үнэн хэрэгтээ хайраар хүрээлэгдсэн ширээ юм.

Хүүхдүүд хичээлээс гадуур илүү их унших хэрэгтэй гэдэгтэй сурган хүмүүжүүлэгчид санал нэг байдаг. Бид—гал тогооны ширээний ард сууж,—өдөр тутам хүүхдүүдтэйгээ хамт судруудаас уншсанаар тэднийг адислах болно.

Гэр бүлээр гал тогооны ширээ тойрон цуглах тэр цагийг олохын тулд, тодорхой хэмжээнд дассан зохицож, няхуур төлөвлөлт шаардагдаж болох юм. Гэвч гэр бүлийн нэгдэл, гэр бүлийнхний сүнслэг өсөлт, хайраар хүрээлэгдэн тэд ярилцаж, сонсож, хариулах үед үүсдэг гэр бүлийн гишүүдийг холбодог гүүрүүдээс илүү чухал зүйл гэж юу билээ? Бидний гол амжилт нь зүгээр—ахин дахин хичээхэд байдаг.

### Гэр Бүлийн Холбоог Бэхжүүлэх нь

Өнөөдөр гэр орон, гэр бүлийг сүйрэлд хүргэх маш олон хүчин зүйл дэлхий дээр байдаг. Ухаалаг эцэг эхчүүд Есүс Христ болон ариун сүмийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулан, гэр оронд сүнслэг байдлыг нэмэгдүүлж, гэр бүлийн холбоог бэхжүүлэхийн төлөө тэмцдэг. Ерөнхийлөгч Ховард В.Хантер бидэнд хэлэхдээ:

“Бид бие биедээ илүү сайхан сэтгэлээр, арай илүү эелдэг, халуун дотноор, илүү хүнлэг даруухнаар, тэвчээртэй, мөн өршөөл уучлалтайгаар хандаж болохын төлөө би залбирч байна. . . .

“Хоёрдугаарт, яг ийм ижил сүнсээр, түүнчлэн би тэдний гишүүнчлэл хийгээд хамгийн эрхэм нандин гэрээнүүдийнх нь гайхамшгийн бэлэгдэл болох Их Эзэний ариун сүмийг барьж байгуулахыг Сүмийн гишүүдэд уриалж байна. Сүмийн гишүүн нэг бүрчлэн ариун сүмд орохуйц зохистой байх нь миний сэтгэл зүрхний хамгийн агуу хүсэл юм”<sup>6</sup> гэжээ.

Ерөнхийлөгч Хантерын өгсөн заавар удирдамж нь гал тогооны ширээ тойрон болж байгаа зүйлд улам их нөлөөлж чадна.

Бусдад хэрхэн үйлчлэхийг эхлээд бид гэр орондоо хэрэгжүүлэх хэрэгтэй. Гётегийн урнаар өгүүлснээр: “Хэрэв та [хувь хүн болох] хэн нэгэнд яг ямар байна яг түүгээр нь хандвал, тэрээр тэр л хэмжээгээр үлдэх болно. Харин та түүнийг ямар . . . байж болох [мөн магадгүй болчихоор]

тэр хэмжээнд хандвал тэрээр [хэн болох ёстой] тийм болох болно.”<sup>7</sup>

### Өрх Гэрийг Үйлчлэлийн Газар Болго

Ахлагч Бойд К.Пакеын хэлсэнчлэн: “Тэнгэрээс зарим нэг зүйлийг гэр орондоо авчрах гэдэг нь гэр бүлийн гишүүдийг сүмийн үйл ажиллагаанд аажмаар оролцуулах гэсний баталгаа юм. Гэр бүлийн үдэш нь, мэдээж—бүх хэрэгцээг хангахаар зохион байгуулагдаж болох ба энэ нь бараг сүмийн цуглаан шиг эсвэл шүтээний байрууд дээр явагддаг тэдгээр цуглаануудын адил байж болдог—эдгээрт нэн тохиромжтой билээ.”<sup>8</sup>

Энэ зөвлөмж нь Ахлагч Дийн Л.Ларсений, “зөвхөн манай сүмийн барилгууд л бидний сүсэглэн биширч болох газар биш, бидний гэр орон ч бас сүсэг бишрэлийн газар байх ёстой. Хэрэв бид ‘гэр болох сүмдээ’ өдөр бүр очдог бол, их сайхан биз дээ. Их Эзэний Сүнс илүү ихээр байх мөн

илүү ихээр мэдрэгдэх газар бидний гэр орноос өөр газар байх ёсгүй”<sup>9</sup> гэж бидэнд хэлсэнтэй дүйж байна.

Энэ бүхнийг гэртээ байлгахын төлөө бид хичээнгүйлэн ажиллах юм бол, Ерөнхийлөгч Харолд Б.Лигийн: “Таны [мөн миний] хэзээ нэгэн цагт хийх гэж буй Их Эзэний хамгийн чухал ажил бол . . . [өөрсдийн] төрөлх гэр оронд хийх зүйл байх болно гэдгийг санаж яваарай”<sup>10</sup> гэж тэмдэглэн хэлсний ач холбогдолыг сайн санах болно.

Өнөөдрийн миний гуйлт бол бид бүгд гэр орноо мөн галын өрөөний ширээг анхааралдаа авч, гэр орондоо тэнгэрлэг байдлыг үргэлжлүүлэн авчрахаар хичээнгүйлэн зүтгэж, Есүс Христэд ирэх явдал юм.

1995 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулган дээр Ахлагч Кортисын хэлсэн үгнээс (Conference Report, 1995 оны Дөрөвдүгээр сар, 109–11; эсвэл *Ensign*, 1995 оны Тавдугаар сар, 82–83-г үз).

---

### ТЭМДЭГЛЭЛ

1. “Scriptures As They Relate to Family Stability,” *Ensign*, 1972 оны Хоёрдугаар сар, 57.
2. “Home Can Be a Heaven on Earth,” *Hymns*, дуг. 298.
3. Conference Report–нд, 1994 оны Аравдугаар сар, 74–75; эсвэл *Ensign*, 1994 оны Арваннэгдүгээр сар, 54.
4. *Pathways to Perfection* (1973), 26–27.
5. Conference Report–нд, 1990 оны Аравдугаар сар, 13; эсвэл *Ensign*, 1990 оны Арваннэгдүгээр сар, 12.
6. “President Howard W. Hunter: Fourteenth President of the Church–ийн,” *Ensign*, 1994 оны Долдугаар сар, 4–5.
7. Emerson Roy West–ийн, *Vital Quotations* (1968), 171.
8. “Begin Where You Are—At Home,” *Ensign*, 1972 оны Хоёрдугаар сар, 71.
9. Conference Report–нд, 1989 оны Аравдугаар сарын, 78; эсвэл *Ensign*, 1989 оны Арваннэгдүгээр сар, 63.
10. *Strengthening the Home* (товхимол, 1973), 7.

# ХҮҮХДҮҮДЭД САЙН МЭДЭЭНИЙ ЗАРЧМУУДЫГ ЗААХ НЬ

# 13

Хэсэг 1

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Сургаал ба Гэрээний 68:25–28–ыг унш. Та уншихдаа, эцэг эхчүүдийг хүүхдүүдээ заахыг тушаасан Их Эзэний зарчмууд болон ёслолуудыг тодорхойл. Эдгээр зарчмууд болон ёслолуудыг хүүхдүүд буюу ач хүүхдүүдээ, зээ дүү нар болон таны мэдэх бусад хүүхдүүдэд заахаар таны хийж чадах хэдэн зүйлийг төлөвлө.
- Та дараах өгүүлийг уншихдаа Ахлагч Роберт Д.Хейлсийн өгсөн зөвлөгөөнүүдийн нэг эсвэл хоёрыг нь сонгон анхааралдаа авна уу. Төрөл бүрийн олон боломжууд гарч ирвэл энэ өгүүлийн бусад зөвлөгөөнүүдэд анхаарлаа хандуул.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүлийг судал. Хэрэв гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүлийг уншиж ярилц.

### ГЭР БҮЛҮҮДИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ: БИДНИЙ НАНДИН ҮҮРЭГ

Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын  
Ахлагч Роберт Д.Хейлс

#### Сүнс Гэр Бүлүүдийг Бэхжүүлдэг

Гэр бүлүүдийг бэхжүүлэх гэдэг нь эцэг эх, хүүхдүүд, өнөр өтгөн гэр бүлийн гишүүд, удирдагчид, багш нар, болон Сүмийн гишүүн нэг бүрийн хувьд нандин үүрэг мөн.

Гэр бүлүүдээ сүнслэгээр бэхжүүлэхийн чухлыг судруудад тодорхой заасан байдаг. Эцэг Адам, Эх Ева нар хөвгүүд болон охидууддаа сайн мэдээг заадаг байв. Абелийн хайрладаг байсан Их Эзэн түүний золиослолуудыг хүлээн зөвшөөрсөн билээ. Гэтэл нөгөө талд Кайн “Сатанд Бурханаас илүү хайртай байсан” бөгөөд ноцтой нүглүүдийг үйлджээ. Адам Ева хоёр “Кайн хийгээд түүний ах нарын улмаас . . . Их Эзэний өмнө гашуудсан” боловч, тэд хүүхдүүдээ сайн мэдээг заахаа хэзээ ч зогсоогоогүй юм (Моисе 5:12, 18, 20, 27, 6:1, 58–ыг үз).

Бидний хүүхэд бүр өөр өөр билиг хийгээд авьяастай гэдгийг бид ойлгох ёстой. Заримд нь Абелийн адил төрөхдөө итгэх итгэлийн бэлгүүд өгөгдсөн мэт санагддаг. Бусад нь хийсэн шийдвэр бүрийнхээ төлөө тэмцдэг юм. Эцэг эхийн хувьд, хүүхдүүдийн маань юмыг эрж хайх, тэмцэх нь бидний Их Эзэнд итгэх итгэлээ хэзээ ч хөсөрдүүлдэггүй, мөн эргэлзэхэд хүргэхгүй байлгах ёстой.

Залуу Алма, “тийн зовлонд тамлагдаж, . . . [мөн] өөрийн олон нүглийн дурсамжиндаа тарчлагдаж байхдаа,” “дэлхийн нүглүүдийг цагаатгахаар, Бурханы Хүү, Есүс Христ гэгч нэгний” (Алма 36:17) ирэлтийн талаар эцгийнхээ зааж байхыг дуулснаа санав. Эцгийнх нь үгс түүнийг хөрвүүлэхэд хүргэсэн юм. Иймэрхүү байдлаар, бидний зааж буй зүйлс ба гэрчлэл өөрсдийн хүүхдүүдээр дурсан санагдах болно.

Хиламаны армийн 2,000 залуу дайчид тэдний зөв шударга эхчүүд сайн мэдээний зарчмуудыг агуу их хүчээр тэдэнд заасан гэдгийг гэрчилсэн билээ (Алма 56:47–48–ыг үз).

Сүнслэг байдлыг маш ихээр эрэлхийлж байсан тэр нэгэн цагт Инос, “мөнхийн амьдралын . . . талаар эцгийнхээ ярьж байхыг олонтоо сонссон тэр үгс, зүрх сэтгэлд минь гүнзгий шингэн байв” (Инос 1:3) хэмээн хэлж билээ.

Сургаал ба Гэрээнд Их Эзэн эцэг эхчүүд хүүхдүүдээ “найман нас хүрэхэд . . . тэдэнд наманчлалын сургаал, амьд Бурханы Хүү Есүс Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүнсний бэлгийг ойлгуулахыг. . . .

“Мөн тэд тэрчлэн хүүхдүүддээ залбирахыг, мөн Их Эзэн Бурханы өмнө цэх шулуун алхахыг заах ёстой” (С ба Г 68:25, 28–ыг үз) хэмээн тушаасан байдаг.

## Сайн Мэдээг Заах нь Гэр Бүлүүдийг Бэхжүүлдэг

Бид үгс болон үлгэр жишээгээр дамжуулан сайн мэдээг хүүхдүүддээ заах үед гэр бүлүүд маань сүнслэг байдлаар хүчирхэгжиж, бат бөх болдог билээ.

Амьд бошиглогч нарын гэр бүлүүдээ сүнслэг байдлаар хүчирхэгжүүлэх бидний ариун үүргүүдийн талаар тодорхойлж хэлсэн үгс бий. 1995 онд Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл дэлхий дахинд өргөх тунхгийг гаргахдаа, “гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг. . . . Нөхөр эхнэр хоёр нь бие биенээ болон үр хүүхдээ хайрлан, халамжлах албан ёсны хариуцлага хүлээнэ. . . . Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударга байдлаар өсгөн хүмүүжүүлж бие бялдар болон оюун санааных нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж . . . байхыг зааж сургах нандин үүрэгтэй юм” гэдгийг тунхагласан юм (“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” *Ensign*, 1995 оны Арваннэгдүгээр сар, 102).

Энэ оны Хоёрдугаар сард, Тэргүүн Зөвлөл “Хүүхдүүдийг Сүмд ойр байлгахын тулд сайн мэдээний зарчмуудаар тэднийг сургамжлахдаа бүхий л хүчин чармайлтаа зориулахыг уриалжээ. Гэр орон бол зөв шударга амьдралын үндэс ба Бурханаар өгөгдсөн хариуцлагыг урагш авч явахад үндсэн үйлдлүүдийг нь гүйцэтгэх буюу үүнийг орлуулах ямар ч зэмсэг гэж үгүй” хэмээх дуудлагыг бүх эцэг эхчүүдэд зориулан гаргасан билээ.

Хоёрдугаар сарын захианд, хүүхдүүдээ сайн мэдээний зарчмуудаар өсгөн хүмүүжүүлж мөн тэдэнд зааснаар, эцэг эхчүүд гэр бүлүүдээ сүйтгэх хүчин зүйлүүдээс хамгаалж чадна гэдгийг Тэргүүн Зөвлөл заасан юм. Тэд үргэлжлүүлэн эцэг эх, хүүхдүүдэд зөвлөхдөө: “Гэр бүлийн залбирал, гэр бүлийн үдэш, сайн мэдээнээс суралцаж мөн зааварчлах, мөн гэр бүлийн бүх үйл ажиллагаанд өндөр ач холбогдлыг өгч бай. Гэсэн хэдий ч, бусад зохистой мөн тохиромжтой шаардлагууд буюу үйл ажиллагаанууд байж болох ч тэдгээр нь зөвхөн эцэг эхчүүд ба гэр бүлүүдийн боломжийнхоо хэрээр биелүүлэх тэнгэрлэгээр тогтоогдсон үүргүүдийг орлохыг зөвшөөрөх ёсгүй” гэсэн юм (Тэргүүн Зөвлөлийн Захиа, 1999 оны Хоёрдугаар сарын 11; *Church News*—ээс иш татсан, 1999 оны Хоёрдугаар сарын 27, 3).

Гэр бүлд тулгарч болох бэрхшээлээс үүдсэн бүх зовиуртай нөлөөллүүд гэр бүлд учирвал, Их Эзэн мөн Түүний сургаалийн тусламжтайгаар тэднийг ойлгож мөн даван туулах болно. Гэр бүлийн

гишүүдэд ямар ч хэрэгцээ гарсан ч, бид бошиглогчдийн өгсөн зөвлөгөөг дагаж, гэр бүлүүдээ бэхжүүлж чадна.

Гэр бүлүүдээ бэхжүүлэх гол зүйл нь Их Эзэний Сүнсийг гэртээ авчрахад байдаг. Гэр бүлүүдийн маань зорилго бол шулуун бөгөөд нарийн зам дээр байх явдал юм.

## Гэр Бүлүүдийг Бэхжүүлэх Санаанууд

Гэр бүлийг бэхжүүлэх тоо томшгүй олон зүйлсийг гэртээ хийж болно. Би та нартай гэр бүлүүдээ бэхжүүлэхэд шаардлагатай зүйлүүдийг тодруулахад туслах хэдэн санаануудыг хуваалцъя. Гэр бүл болгон—мөн гэр бүлийн гишүүн бүр нь—онцгой, давтагдашгүй гэдгийг мэддэг болохоор би эдгээрийг урам зоригийн сүнстэйгээр хуваалцаж байна.

## Өрх Гэр нь Аюулгүй Газар Байх Ёстой

- Өрх гэрээ гэр бүлийн гишүүн бүр хайр болон гэрт хамаарах мэдрэмжтэй байлгахгаар аюулгүй газар болго. Хүүхэд бүр өөр өөр авьяас, чадвартай, ба хувь хүн бүр онцгой хайр, халамжийг шаарддагийг ухаарч ойлго.
- “Элдэг хариулт уур хилэнг зайлуулна” гэдгийг сана (Сургаалт Үг 15:1). Миний хайрт бид хоёр Солт Лейкийн ариун сүмд ладдан холбуулах үед, Ахлагч Харолд Б.Ли бидэнд: “Та нар ууртайгаар дуу хоолойгоо өндөрсгөхөд, Сүнс танай гэрээс салан оддог” гэсэн ухаантай зөвлөгөөг өгч билээ. Бид хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлийг цоожлоод ч, мөн өөрсдийн гэрийн хаалгыг цоожлоод ч уураас хол байж чадахгүй. Үрэлгэн хүүгийн адилаар тэд өөрсдийгөө таньж хайр болоод зөвлөлдөхийн тулд бидэн рүү ирдгийг хүүхдүүд ойлгох хэрэгтэй.
- Хүүхдүүдээрээ үйл ажиллагаа ба ярианы сэдвийг сонгуулж хүүхдүүдтэйгээ биечлэн цагийг өнгөрүүл. Садаа болж байгаа зүйлүүдийг зайлуул.

## Хүүхдүүддээ Залбирах, Судруудаас Унших, мөн Зохистой Хөгжим Сонсохыг Заа

- Хүүхдүүдийнхээ хувийн залбирал, судраас ганцаарчлан суралцах болон онцгой хэрэгцээнийхээ төлөө мацаг барих зэрэг хувийн бишрэн шүтэх харьцаануудыг нь дэмж. Бусдад хандах хандлага, зан харьцаа хийгээд хэл яриаг нь ажиглан тэдний сүнслэг өсөлтийг хэмж.
- Хүүхдүүдтэйгээ өдөр бүр залбир.
- Хамтдаа судраас унш. Ээж, аавыг судраас уншихад хүүхдүүд бид шалан дээр суугаад сондог байснаа санаж байна. Заримдаа тэд “Та нар энэ судрыг юу гэж ойлгож байна вэ?” эсвэл

“Энэ та нарт ямар санагдаж байна вэ?” гэж асуудаг байв. Тэгээд тэд бидний өөрсдийн үгсээр хариулсан хариултыг сонсдог байлаа.

- Сүмийн сэтгүүлүүд дээрх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд зориулсан амьд бошиглогчдын үгс болон урам өгсөн өгүүллэгийг унш.
- Бид *Хүүхдийн Дууны Ном* ба дууллын номнуудаас хамтдаа дуулдаг шиг зөв зохистой дуунуудыг гэр орондоо эгшиглүүлж болно.

### **Гэр Бүлийн Үдэш ба Гэр Бүлийн Зөвлөгөөг Явуулж Бай**

- Долоо хоног бүр гэр бүлийн үдшийг зохион байгуул. Эх эцгийн хувьд бид заримдаа хүүхдүүдээ зааж гэрчлэхээсээ бишүүрхэн жийрхдэг. Би энэ тал дээр өөрөө ч гэсэн амьдралдаа алдаж байлаа. Бид сүнслэг мэдрэмжүүдээ тэдэнтэй хуваалцах ба тэдэнд зааж гэрчлэх нь хүүхдүүдэд хэрэгтэй байдаг.
- Гэр бүлийн зөвлөлийг зохион байгуулж гэр бүлийн төлөвлөгөө, асуудлуудын тухай ярилц. Зарим их үр нөлөөтэй гэр бүлийн зөвлөлүүд нь гэр бүлийн гишүүн бүртээ нэг нэгээрээ харьцана. Хүүхдүүдээ тэдний санаа бодол чухал гэдгийг мэдэхэд тусал. Тэднийг сонс, мөн тэднээс суралц.

### **Сайн Мэдээг Хуваалц, Сүмийн Удирдагчдыг Дэмж, мөн Гэр Бүлээрээ Хамтран Оролц**

- Номлогч нарыг идэвхгүй ба гишүүн бус найз нартаа заалгуулахаар гэртээ урь.
- Бид Сүмийн удирдагчдыг дэмжиж баталж байгаагаа харуул.
- Боломжтой бол хамтдаа хооллож, мөн хоолны цагаар чухал ач холбогдол бүхий ярилцлага өрнүүл.
- Өөрсдөө энэ ажлыг амар хялбар, хурдан хийчих байлаа ч, гэр бүлээрээ хамтдаа хий. Хамтдаа ажиллах зуураа хөвгүүд, охидтойгоо ярилц. Надад аавтайгаа ярилцах энэ боломж долоо хоног бүр байж билээ.

### **Хүүхдүүддээ Сайн Анд Нөхөр Байхыг Зааж, Ирээдүйд нь Бэлтгэ**

- Хүүхдүүддээ сайн нөхөрлөлийг бий болгож сурахад болоод тэдний найз нөхдийг гэртээ тав тухтай байлгах байдлыг мэдрэхэд нь тусал. Хүүхдүүдийнхээ найз нарын эцэг эхтэй танилц.
- Хүүхдүүддээ хэрхэн нөөц боломжууд болон цаг төлөвлөлт гаргахыг өөрсдийнхөө жишээ-

гээр заа. Тэднийг биеэ даахад мөн ирээдүйдээ бэлтгэхийн чухлыг сурахад нь тусал.

### **Гэр Бүлийн Өв ба Уламжлалыг Хуваалц**

- Хүүхдүүддээ гэр бүлийнхээ болон өвөг дээдсийнхээ түүхийг заа.
- Гэр бүлийн уламжлалыг бий болго. Хүүхдүүдийнхээ хэрэгцээ, авьяас, чадварыг харгалзан үзэж ач холбогдол бүхий амралт зугаалгыг хамтдаа төлөвлөж зохион байгуул. Тэдэнд аз жаргалтай дурсамжуудыг бий болгох, авьяас чадварыг нь сайжруулах хийгээд өөрсдийгөө үнэлэх үнэлгээтэй болгоход нь тусал.

### **Зарлигуудыг Дуулгавартай Дагах, мөн Ёслолуудыг Хүлээн Авахын Ач Холбогдлыг Заа**

- Тушаалуудыг дуулгавартай дагах амлалт, ёс суртахууны зарчмуудыг үгсээр болон жишээ үзүүлэн заа.
- Миний баптисм болон гишүүнээр батлагдсаны дараа, ээж минь намайг хажуу тийш дуудаад, “Чи юу мэдэрч байна?” гэж асуухад би надад байсан амар амгалангийн дулаан мэдрэмж, тав тух, ба аз жаргалыг өөрийнхөө чадах чинээгээрээ тайлбарласан. Ээж маань мэдэрч байсан тэр зүйлийг миний дөнгөж хүлээн авсан бэлэг болох Ариун Сүнс байсан гэдгийг тайлбарласан. Хэрэв би зөв зохистойгоор амьдрах юм бол ариун сүнс үргэлжлүүлэн надтай хамт байх болно гэж ээж хэлсэн юм. Энэ нь миний бүх амьдралын турш надтай цуг байсан сургаалын хором байв.

Хүүхдүүддээ баптисм ба гишүүний баталгаа, Ариун Сүнсний бэлгийг хүлээн авах, ариун ёслолоос хүртэх, санваарыг хүндэтгэх, ариун сүмийн гэрээнүүдийг хийж, үүнийг сахихын ач холбогдлыг заа. Тэд ариун сүмийн эрхийн бичгийг авч, ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэгдэхэд зөв зохистой амьдрахын ач холбогдлыг мэдэх хэрэгтэй.

- Хэрэв та хань үр хүүхэдтэйгээ ариун сүмд хараахан лацдагдан холбуулж амжаагүй бол, ариун сүмийн адислалуудыг хүлээн авахын тулд гэр бүлээрээ хөдөлмөрлө. Гэр бүлээрээ ариун сүмийн зорилго тавь.
- Ах нар аа, атгаж буй санваартаа зохистой байж, гэр бүлээ адислахад хэрэглэ.

### **Сүмийн Үйл Ажиллагаа, Сургууль, Хамтын Ажиллагааны Бэлтгэлтэй Бай.**

Нөөц бололцоо нь гэрээс гадуур боломжтой байдаг. Үүнийг гэр бүлээ хүчирхэгжүүлэхэд ухаалгаар ашигла.



- Хүүхдүүдээ Сүмд болон олон нийтэд үйлчлэхэд нь урамшуулан дэмж.
- Хүүхдүүдийнхээ багш, дасгалжуулагч, зөвлөгч, ба Сүмийн удирдагчидтай хүүхдүүдийнхээ хэрэгцээ шаардлага болоод бидний санаа зовоож буй зүйлийн талаар ярилц.
- Хүүхдүүд чөлөөт цагаараа юу хийдгийг мэдэж ав. Тэдний сонгосон кинонууд, телевизийн хөтөлбөр, видеонуудад нөлөөл. Хэрэв тэд Интернетэд холбогдсон бол тэдний юу хийж байгааг мэд. Тэдэнд эрүүл таатай, зугаа цэнгэлийн чухлыг мэдэхэд нь тусал.
- Үр нөлөөтэй сургуулийн үйл ажиллагааг дэмж. Хүүхдүүдийнхээ юу сурч байгааг мэд. Гэрийн даалгавар хийхэд нь тэдэнд тусал. Тэдэнд бие даасан байдал хийгээд боловсрол олж авах, ажилд бэлтгэхийн чухлыг мэдэхэд нь тусал.
- Залуу эмэгтэйчүүд: Арван найман нас хүрэхдээ Нийгмийн Халамжийн Бүлэгт оролц. Магадгүй та нарын зарим нь энэ өөрчлөлтөд дурамжхан байж болно. Та нар үүнд тохирохгүй байх гэсэн айдастай байж магадгүй. Миний залуу эгч нар аа, энэ нь шалтгаан биш юм. Нийгмийн Халамжийн Бүлэгт маш олон зүйл танд зориулагдсан байдаг. Энэ нь амьдралын тань туршид байх адислал байж болно.
- Залуу эрэгтэйчүүд: Аароны Санваарыг хүндэтгэн дээдэл. Энэ нь бэлтгэл санваар бөгөөд, таныг Мелкизедек Санваарт чиглүүлэн бэлтгэдэг. Та нар Мелкизедек Санваартнаар томилогдохдоо ахлагч нарын чуулганд бүрэн идэвхтэй байх хэрэгтэй. Ахан дүүс, чуулганы заавар, бусдад үйлчлэх боломж нь амьдралын тань турш та нарыг болон гэр бүлийг тань адислах болно.

### Их Эзэний Хайрын Жишээг Дага

Хэрэв бид Их Эзэний Сүнснийг гэртээ авчирч, мөн Түүний жишээгээр заах юм бол гэр бүл бүр нэгэн замаар эсвэл өөр ямар нэгэн замаар хүчирхэгжих болно.

- Итгэлтэйгээр үйлд; айдастайгаар бүү хариу үйлд. Манай өсвөр насныхан гэр бүлийнхээ үнэ цэнийг сонжиж туршиж эхлэхэд, эцэг эхчүүд гэр бүлийнхээ гишүүн бүрийн онцгой хэрэгцээнй талаар хэрэгтэй удирдамжийн төлөө Их Эзэнд хандах хэрэгтэй. Энэ нь сонголтыг хэрхэн хийх тал дээр таны сургамжийг бэхжүүлэх дэмжлэг болоод өсөн нэмэгдсэн хайрын цаг болой. Энэ нь хүүхдүүдийнхээ хийж болох алдаанаас сурахыг тэдэнд зөвшөөрөх нь зүрх алдмаар хэдий ч тэдний хувьд Их Эзэний замыг ба гэр бүлийнхээ үнэ цэнийг сонгох хүсэл нь бид тэдгээр үнэ цэнийг тэдэнд хүчээр тулгах сонголтоос

илүү агуу их байна. Их Эзэний хайрын арга зам болоод хүлээн завшөөрөх байдал нь ялангуяа өсвөр насны хүүхдүүдийг хүмүүжүүлэхэд Сатаны дарамт шахалт үзүүлэх арга барилаас илүү байдаг.

- “Яг гараараа барьж буй мэт, энхрий зөөлөн харьцаагаар тэднийг харж хамгаалан нүглийг орхиход нь хүмүүсийг удирдах өөр ямар ч юм илүү ихээр тооцоологдоогүй. Хүмүүс надад өчүүхэн ч гэсэн сайхан сэтгэл мөн хайрыг илчлэх л юм бол, оюун бодлыг маань ямар хүч эзэмдэх билээ. Харин үүний эсрэг байх юм бол тэрхүү хүмүүний оюун бодлыг эзэмддэг бүх хатуу ширүүн мэдрэмжүүд зовоон тамлах хандлагатай байдаг” хэмээн Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн үгсийг санагтун (*Teachings of the Prophet Joseph Smith*, хэвл. Joseph Fielding Smith [1976], 240).

### Төөрөлдсөн Хүүхдүүд Буцаж Ирнэ

- Бид чадах бүхнээ хийсний дараа зарим хүүхдүүд маань зөв шударгын замаас төөрөлдөхөд бид цөхрөн шаналж болох юм. “Хэдийгээр хонинуудын зарим нь хадууран хэсүүчилсэн ч Хоньчин тэдгээрээс нүд салгахгүй байх бөгөөд хожим хойно хэзээ нэгэн цагт тэд Тэнгэр дэх Бурхан тэмтрэн тэдэнд хүрч сүрэгтээ буцаан тэднийг авчрахыг мэдрэнэ. Энэ амьдралд ч бай эсвээс ирэх амьдралд ч бай тэд буцаж ирнэ. Тэд шударга ёсны төлөөх өрөө төлөх ёстой; тэд нүглүүдийнхээ төлөө шанална. Магадгүй өргөстэй замаар замнаж болсон ч эцэст нь хэрэв энэ нь төөрөлдсөн үрлэгэн хүүгийн адилаар тэднийг хайртай, уучлан өршөөдөг зүрх сэтгэлтэй эцэг [эхийн] гэр лүү хөтлөн удирдах юм бол, өвчин шаналал нь талаар нэг болоогүй байна. [Өөрсдийн] хэнэггүй, дуулгаваргүй хүүхдүүдийн төлөө залбир; Итгэлтэйгээр тэдэнд ойр бай. Та нар Бурханы авралыг үзтэл найдаж итгэ” хэмээн Орсон Ф.Витнейн хэлсэн үгс биднийг тайтгаруулж чадна (Иосеф Смитийн хэлсэнээс иш татсан, Conference Report, 1929 оны Дөрөвдүгээр сар, 110)

### Ганц Бие Насанд Хүрэгчид ба Өнөр Өтгөн Гэр Бүл Хүч Чадлыг Олдог

- Та ганц бие эсвэл танд хүүхэдтэй болох адислал өгөгдөөгүй бол яах вэ? Гэр бүлийн тухай зөвлөгөө зөвлөмжинд санаа зовних хэрэг танд байна уу? Тийм. Энэ нь газар дэлхийн амьдралд бид бүгдийн сурах хэрэгтэй зүйл юм. Гэрлээгүй насанд хүрсэн сүмийн гишүүд гэр бүлдээ онцгой төрлийн хүч чадлыг ихэнхдээ үзүүлж, дэмжлэг тусалцааны гайхамшигтай эх сурвалж

болж, улмаар бусдаар хүлээн зөвшөөрөгдөж, гэр бүлээ болон эргэн тойронд байгаа хүмүүсийг хайрладаг.

- Өнөр өтгөн гэр бүлийн насанд хүрсэн олон гишүүд өөрийн хүслийн дагуу эцэг эхийн үүргийг илүү ихээр гүйцэтгэдэг. Эмэг ээж, өвөг эцэг, нагац, авга, ах дүү нар, зээ болон ач нар, үеэл нар болоод гэр бүлийн бусад гишүүд гэр бүлд маш их нөлөө үзүүлдэг. Би гэр бүлийн маань садан төрөлдөө намайг өөрсдийн гэрчлэл болон жишээгээрээ удирдаж байсан тэдгээр хүмүүст талархалаа илэрхийлэхийг хүсч байна. Заримдаа өнөр өтгөн гэр бүлийн маань гишүүд эцэг эхийн маргалдан байж хэлдэг зүйлсийг төвөггүйхэн маргаан үүсгэлгүйгээр хэлж чаддаг. Ээжтэйгээ их удаан ярилцсан чин сэтгэлийн ярианы дараа, нэгэн залуу эмэгтэй: “Таньд мөн аавд би буруу хийсэн зүйлээ хэлэхэд аймаар хэцүү байх байсан. Гэхдээ үүнийг нагац эгч Сюзанд хэлэх нь бүр ч илүү хэцүү байх болно. Би яагаад ч юм түүнийг гомдоохыг хүсээгүй.”

### Төгс Гэр Бүл гэж Байхгүй

Бид зуурдын амьдралд сурч итгэлээ хөгжүүлэхээр байгаагаа мэдсэнээр, бүх зүйлд сөрөг тал байх ёстой гэдгийг ойлгох хэрэгтэй. Өөрийн гэр бүлийн зөвлөлийн үеэр, “Та нар хэн нэгнийг төгс төгөлдөр гэр бүлтэй гэж бодох үедээ та нар ердөө л тэднийг хангалттай сайн мэддэггүй болоод л тэр” хэмээн манай эхнэр хэлж билээ.

### Орон Гэр ба Гэр Бүлээ Эмх Цэгцтэй Байлга

Ах эгч нар аа, 1833 онд Иосеф Смит ба Сүмийн удирдагчдад өгөгдсөн “[өөрсийн] гэр орноо цэгцлэх ёстой” (С ба Г 93:43) хэмээх Их Эзэний

анхааруулга, тэр ч бүү хэл зэмлэлээр сэрэмжлүүлэгдцгээе. “Харин хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүлэхийг би та нарт зарлигласан билээ” (С ба Г 93:40). “[Өөрсдийн] гэр бүлээ эмх цэгцтэй байлга, мөн тэд гэр орондоо илүү хичээнгүй байж мөн санаа зовж байхыг мэдэгтүн, мөн ямагт залбирагтун, эсвэл тэд байрнаасаа хөдөлгөгдөх болно” (С ба Г 93:50).

Манай өнөө үеийн бошиглогчид үүнтэй адил өөрсдийн гэр орныг эмх цэгцтэй байлгах сануулга ба сэрэмжлүүлгийг эцэг эхчүүдэд өгч байгаа. Бид өөрсдийн гэр бүлийнхэний дундах сөргөлдөөнийг итгэлтэйгээр туулах урам зориг ба хайраар бид адислагдсан байх болтугай. Дараа нь бид сорилтууд маань Их Эзэнтэй, мөн бусадтай илүү ойр дотно байлгандгийг бид мэдэх болно. Бид бошиглогчдын үгсийг сонсож өөрсдийн гэр орныг эмх цэгцтэй байлгах болтугай (С ба Г 93:41–49-ийг үз). Бид Их Эзэнтэй илүү ойр дотно байх үед гэр бүл хүчирхэгждэг, мөн бид нэг нэгэндээ хайр халамжтайгаар, сэтгэл санааг нь өөдрөг байлгаж дэмжсэнээр гэр бүлийн гишүүн нэг бүр хүчирхэгждэг билээ. “Та намайг өргө, би таныг өргөе, тэгээд бид хамтдаа дээш өргөгдөнө” (Оточийн сургаалт үг).

Бид гэр бүлүүдээ хүчирхэгжүүлж болохын тул Их Эзэний Сүнснийг гэр орондоо урьж байлгах болтугай. Би гэр бүлийн маань гишүүн бүр “мөнхийн амьдрал руу удирддаг шулуун ба нарийн зам” (2 Нифай 31:18) дээр үлдээсэй хэмээн залбирч байна.

1999 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулган дээр Ахлагч Хейлзийн хэлсэн үгнээс (Conference Report, 1999 оны Дөрөвдүгээр сар, 39–44; эсвэл *Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 32–34-г үз).

# ХҮҮХДҮҮДЭД САЙН МЭДЭЭНИЙ ЗАРЧМУУДЫГ ЗААХ НЬ

# 14

Хэсэг 2

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Гэр бүлээрээ хамтдаа үйлчлэл хийхээр нэгэн үйл ажиллагааг төлөвлө.
- Та хүүхдүүдийнхээ нэгтэй эсвэл ач хүү, зээ дүү аль эсвэл гэр бүлийн тань өөр нэгэн хүүхэдтэй хамт гэрийн ажил хий. Ажиллаж байх зуураа тэр хүүхэдтэй ярилц. Хүүхдийн тусалж байгаа оролдлогыг шүүмжлэхгүйгээр зааж сургах боломжийн давуу талыг ашигла.
- *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* (34285) товхимолд байгаа дараах хэсгүүдийг уншиж өг: “Үзвэр Үйлчилгээ ба Мэдээллийн Хэрэгсэл: Кино, Телевиз, Радио, Видео хальс, Ном болон Сэтгүүлүүд” (хуудас 17–19), “Хөгжим, Бүжиг” (хуудас 20–21), мөн “Бэлгийн Харьцааны Цэвэр Байдал” (хуудас 26–28). Энэ материалыг уншиж хянасны дараа, та нар хамтдаа энэ материалыг уншиж, ярилцаад хүүхдүүдийн тань хэнд нь ач тустай байхыг тодорхойл.

## УНШИХ ЦААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### ХҮҮХДҮҮДЭД ЗААЖ СУРГА

Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч Бойд К.Пакер

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүнчлэлд хамрагдсан үнэнд цангаж буй тоймгүй их хүмүүс энд мөн өөр газарт цуглараад байна.

Би та нарт хамгийн үнэ цэнтэй зүйл юу болох вэ хэмээн залбирч байхдаа гурван долоо хоногийн дараа 75 насны ойн өдөр болох гэж байгааг би санасан ба үүнийгээ *өтлөх насандаа явж* байна гэж нэрлэхээр шийдсэн юм.

Би багш болоод 50 гаруй жил болж байна. Мэдээж миний сурсан ямар нэгэн зүйл та нарт тустай байж болох юм.

Энэ нь би туршлагаадаас сурч авдаг болохоор: Амьдрал бидний мэдэхийг хүсээгүй зарим зүйлийг бодож байгаагүйгээр бидэнд заан сургадаг. Эдгээр хэцүү хичээлүүд нь хамгийн үнэлүүштэй нэг нь болж чаддаг.

Би *өтлөх насандаа хүрэх* үед бас өөр зарим нэгэн зүйлийг сурч авсан. Та бүхэн нэгэн эмч, өвчтөнгийн хооронд болж буй энэ харилцан яриаг тунгаан бодоорой:

Эмч: “Би таньд юугаар туслах вэ? Ямар зовиур таньд байна вэ?”

Өвчтөн: “Миний санамж юм, эмч ээ. Би ямар нэгэн юм уншаад, түүнийгээ санаж чадахгүй байх юм. Би яагаад энэ өрөөнд орж ирсэнээ ч санахгүй юм. Би хаана юмаа тавьсанаа санадаггүй” гэв.

Эмч: “За энэ чинь хэр удаан таныг зовоож байна вэ?”

Өвчтөн: “Ямар зүйл намайг хэр зэрэг удаан зовоож байна гэнэ ээ?”

Одоо, хэрэв энэ та нарыг хөгжөөсөн бол, та эсвэл 60–аас доош насны юм уу эсвэл та нар өөрсдийгөө шоолж байгаа.

### ХҮҮХДҮҮДИЙГ БАГА БАЙХАД НЬ ЗААЖ СУРГА

Нас ахих тусмаа, та нар залуу байсан шигээ сурч, цээжилж мөн судалж хичээллэж чадахгүй. “Өөрийн залууд мэргэн ухааныг суралц; тийм ээ, өөрийн залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун”<sup>1</sup> хэмээн бошиглогч Алма ямар учраас ийнхүү зөвлөх болсонг хэлж байгаа юм.

Надад судрууд болон яруу найргийн шүлэглэсэн мөрүүдийг цээжлэх нь улам их хэцүү байна. Би залуудаа ямар нэгэн зүйлийг нэг юм уу эсвэл хоёр удаа давтахад л цээжилдэг байсан. Хэрэв би

үүнийг олон удаа давтан хэлбэл, ялангуяа би үүнийг бичиж авсан үед миний оюун ухаанд овоо тогтдог байсан.

Залуу нас сурч суралцахад хялбар цаг юм. Ийм учраас хүүхэд, залуучуудын багш нар анхнаасаа Сүмийн удирдагчид үнэнхүү санаа тавьж байсан юм.

Хүүхэд, залуучуудад сайн мэдээ болон амьдралын хичээлийг заах нь нэн чухал билээ.

Их Эзэн анхны үүрэг хариуцлагыг эцэг эхчүүдэд олгож мөн тэд нарыг сэрэмжлүүлэхдээ:

“Сионд . . . эцэг эхчүүд хүүхдүүдтэй байхын хэрээр, тэдэнд наманчлалын сургаал амьд Бурханы Хүү Христэд итгэх итгэл хийгээд баптисм хүртээх мөн гар тавилтаар ирдэг Ариун Сүнсний бэлгийг ойлгохыг тэд заадаггүй бол, найман нас хүрэхэд, уг нүгэл нь тэдгээрийн эцэг эхчүүдийн толгой дээр байх болой”<sup>2</sup> хэмээн хэлсэн.

Энэ нь залуучуудад: эхлээд гэрт нь, дараа нь сүмд зааж сургах нь Сүмийн үндсэн зорилго билээ.

### Мэдлэг Хуримтлуулах нь

Миний сурсан бас өөр нэгэн зүйл бол бид залуудаа юу сурсанаа санаж байдагтай холбоотой юм. Залуу байхдаа оюун ухаандаа хуримтлуулсан мэдлэг нь хэрэг болох хүртлээ олон жил хүлээгдэж болох юм.

Би дүрсэлж үзүүлье. Бишопийн зөвлөгөөг үл тоомсорлодог эсвээс нөгөө талаар түүнд хэт их захирагддаг гишүүдийн хандлага нь миний санааг их зовоож байна.

Би ерөнхий чуулганаар бишопийн талаар ярихаар шийдсэн.

Би залбиралтайгаар бэлтгэсэн бөгөөд бодол санаанд минь 50 жилийн тэртээх ярилцлага орж ирэв. Багш хүний хувьд, миний хэрэгцээнд—гайхалтай сайнаар үйлчилсэн юм. Эдүгээ би энэхүү харилцан яриаг яг л ерөнхий чуулган дээр өгсөн шигээ иш татаж, давтан хэлье:

“Олон жилийн өмнө би Эмери Ваяттай хамт гадасны дээд зөвлөлд үйлчилж байв. Эмери 10 жилийн турш хөдөө нутгийн Харпер Хэсэгт бишопоор үйлчилж байсан юм. Түүний эхнэр, Лусилле, манай гадасны Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгч байсан билээ.

“Лусилле надад нэгэн хаврын өглөө хөрш нь түүний хаалганы хонхыг дарж Эмериг асуусан гэж хэллээ. Лусилле тэр эрэгтэйд түүнийг гадаа газар хагалж байгааг хэлэв. Тэгээд хөрш нь их сэтгэл зовсон байдалтайгаар яриу. Тэр өглөө эрт хөрш нь тал-

байгаар нь өнгөрч явахдаа цулбуур нь анжис дээр сул унжсан Эмеригийн хөлөглөсөн морьд таллаж хагалсан талбай дээр байхыг ажиглажээ. Эмери ойр хавьд байхгүй байв. Дараа нь хөлөглөсөн морьд нь хөдлөөгүй байхыг талбайг дахин өнгөрөх хүртэл хөрш нь юм бодсонгүй. Тэрээр хашааг даван талбайгаар хөндлөн морьдын зүг явав. Эмерийг хаанаас ч олсонгүй. Тэрээр Лусиллегээс лавлахаар гэрийнх нь зүг рүү хурдлав.

“Лусилле тайвуунаар хариулав, ‘Өө, битгий санаа зовоо. Хэн нэгэнд нь хэрэгцээ гараад бишопийг авч явсан байлгүй дээ’ гэв.

“Хэдэн цагийн турш талбай дээрээ зогсож байгаа тэр хөлөглөсөн морьдын дүр төрх нь Сүм дэх бишопууд болон тэдний хажуу талд зогсох зөвлөх нарын хүчин зүтгэл, хувь нэмрийг нь бэлэгдэж байна. Бүр урнаар тайлбарлан хэлбэл, бишоп болон зөвлөх бүр, хүмүүст хэрэгцээ гарсан үед хагалж дуусгаагүй талбайн хамт өөрийнхөө багийг үлдээдэг юм.”<sup>3</sup>

Би урьд нь энэ явдлыг хэзээ ч яриандаа оруулж байгаагүй—үүнийг хэзээ ч бодож байгаагүй.

Би үүнийг чуулган дээр ярихаасаа өмнө бодолдоо засварлахыг хүсэж байсан, тиймээс би Эмери Ваятын охиныг олсон. Тэрээр надтай тэдний амьдарч байсан хуучин гэрт уулзахаар, тэр өдөр эцгийнхээ хагалж байсан тэр талбайг үзүүлэхийг зөвшөөрөв.

Хөвгүүдийн маань нэг нь Бүтэн сайны өглөө эрт намайг тэнд аваачиж, тэр хэдэн зураг авсан юм.

Тэгэхэд хаврын нэг сайхан өглөө байв. Талбайг тэр олон жилийн өмнөх шигээ шинээр хагалсан байв. Цахлай шувууд шинэхэн хагалсан хөрснөөс хооллож байв.

Тэрхүү ярилцлагыг дурсан санаж байгаа толгойд зурсхийсэн санамж нь миний хувьд ер бусын зүйл биш байлаа. Энэ нь залуудаа тохиолдлоор цээжилсэн, нэгэн судрын үнэнийг ахин дахин нотолж байгаа юм.

“Мөн та нар юу хэлэхээ урьдаас бүү бод; харин амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл, мөн хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт та нарт өгөгдөх болно.”<sup>4</sup>

Хэн мэдлэгээ баяжуулна түүнийг даган амлалт ирдэг билээ.

“Та нарыг хэн ч хүлээн авлаа гэсэн тэнд би тэрчлэн байх болно, учир нь би та нарын нүүрний өмнө явах болно. Би та нарын баруун гар талд мөн та нарын зүүнтээ байх болно, мөн миний Сүнс та нарын зүрх сэтгэлд, мөн миний

тэнгэр элчүүд та нарыг дэмжихийн тулд та нарын эргэн тойронд байх болно.”<sup>5</sup>

Энэ нь миний хувьд сайхан сургамж байсан боловч энэ нь үүгээр дуусаагүй юм.

Би залуудаа жаал зураг зурж, сийлбэр хийдэг байв. Би ихэнхдээ бие даан суралцдаг байсан. Хүүхдүүдээ маань өсөн торниж байх хооронд өөрийн амьдралын тухай мөн жаал хүү байхдаа сурч авсан зураг зурах, сийлбэр хийх талаар тэдэнд зааж, сургахын тулд цаг хугацаагаа зориулдаг байсан юм.

Тэднийг өсөн том болсны дараа би амарч, алжаалаа тайлахын тулд модоор сийлж эхэлсэн юм. Би жигүүртэн шувуудийг сийлж, сийлбэрт маш их цагийг зарцуулдаг байв. “Үүнийг сийлэхэд хэр их цаг хугацааг та зориулсан вэ?” хэмээн надаас асуухад, би үргэлж “Мэдэхгүй ээ, хэрэв мэдэж авах юм бол, би хийхээ болих байх” хэмээн хариулдаг байсан.

Гараараа юм хийж байх тэр цаг хугацааны турш би бүтээлийн гайхамшгуудын талаар тунгаан бодоход онгод орж ирдэг байв. Би сийлбэр хийх зуураа өгөх яриануудаа бэлддэг байсан.

Сийлбэр хийх нь надад амралт болдог байсан. Заримдаа намайг бага зэрэг ядарч, мөн бухимдсан байхад, эхнэр маань “За, чи өөр сийлбэр эхэлсэн чинь дээр байх” хэмээн хэлдэг байв.

Хэрэв *өтлөх насны* санамж маань өөрөө бага зэрэг хурц тод болчихдог юм бол, тэдгээр сийлбэрүүдийн нэгийг зааж, энэ нь ямар яриаг төлөөлөх эсэхийг хэлж чадах байсан. Тэдгээр амгалан тайван үеүдэд би нэгэн зэрэг хоёр зүйлийг хийж чаддаг байсан гэдгээ мэдэж авсан юм.

### Заахын Үр Шимийг Үзэх нь

Би тэдгээр сийлбэрүүдийг дахин хийж чадахаа больсон. Хүүхэд насанд полимелитоор өвчилснөөс эдүгээ хурууны үеүд маань бага зэрэг мэдээ алддаг болсон, мөн гурван голчтой нүдний шил зүүдэг над шиг хүний хувьд тэр бол хэтэрхий нарийн ажил юм. Үүний хажуугаар, сийлбэр хийх мөн яриа бэлтгэх хоёуланд өөрийгөө зориулах гэхэд дуудлагын маань нэмэгдэж буй шаардлагууд цаг хугацааг хязгаарлаж байдаг.

Эдүгээ сийлбэр хийх чадвар миний хувьд аль хэдийнээ алдагдсан боловч, хүүхдүүдийн маань хувьд алдагдаагүй. Бид тэднийг бага байхад нь заасан юм.

Тэр талбайд зогсож буй тэрхүү хөллөсөн морьдын төрх миний бодолд үлдсэн. Магадгүй би талбай дээр цулбуур нь анжис дээр сул унжсан

зогсож байгаа бишопийн хөллөсөн морьдыг зурж чадах байх гэж бодож билээ.

Би зураг зурснаас хойш есөн жил болчихсон байсан учраас эргэлзэж байлаа. Ер бусын гоц авьяастай, бурханлиг нөлөөтэй хоёр найзууд маань тэр бишопийн хөллөсөн морьдыг зурахад минь туслахыг санал болгож мөн Долдугаар сард ч аян замын алжаал тайлсан учир би зургаа зурч эхэлсэн.

Би тэр хоёр найзаасаа маш ихийг сурч авсан бөгөөд үнэн хэрэгтээ тэд миний зурсан зурагт гарч ирж байгаа билээ. Гэхдээ би хоёр хүүгээсээ илүү их тусалцааг авсан. Нэг хүү маань хагласан талбайн зурагнуудыг авсан, учир нь аливаа зүйлийг *модон* дээр эсвээс *даавуун* дээр буюу *үгээр* дүрслэн буулгахдаа би үргэлж нягт нямбай байхыг хичээдэг.

Энэ нь бас нэг сургамж байлаа. Хүүхдүүдийн маань бага балчирд сурч авсан зарим зүйлийг би тэднээс буцаагаад сурч чаддаг байв.

Бас нэг хүү маань миний зурсан зургийн дэргэд байлгахгаар бишопийн хөллөсөн морьдын барималыг хүрлээр бүрэхээр шийдсэн. Бид бие биендээ тусалж маш их үр бүтээлтэй цагийг өнгөрүүлэв.

Хүү маань амбаарт өлгөөтэй байсан үндсэндээ 50 гаруй жил гар хүрээгүй хуучин морины тоногийг авч, тэднийг тоосноос нь салгаж гэрт оруулав. Тэрээр маш тэвчээртэй номхон уналгын моринд морины тоногийг нь зөв дэс дараалалтай нь тааруулан мөн түүний нарийвчилсан зургийг гаргаж авах үеэр морь чимээгүйхэн зогсож байлаа.

Түүний хөрш зарим хуучирсан анжисуудыг цуглуулсан байв. Тэдний дотор хүүгийн маань бас зурж авсан хуучирсан эртний анжис байжээ.

Тэдгээр хөвгүүдийг бага байхад нь бидний зааж өгч байсан зүйлүүд тэдэнд эргээд илрэн гарч ирсэн. Бусад хүүхдүүдийн маань хувьд гэвэл тэднийг бага балчир байх үед нь эцэг эхийн хувиар бидний заасан зүйлүүдийг тэд улам сайжруулсан юм. Хэрэв газар дэлхий дээр амьдрах өдрүүд маань уртсах юм бол,—ач хүүхдүүд маань гээд хоёрдугаар үр удам, магадгүй гуч нар гээд л гурав дахь үе эхлэх болно.

### Орхигдсон Авьяас Чадваруудыг Сэргээх нь

Би өөр зарим нэг зүйлийг дахин сурсан. Би хүүхэд байхдаа нэг удаа сонсож байсан санал бодлуудаар урамшуулагдан зураг зурж билээ. Энэ зураг нь Виллард Пийкс хэмээх уулын оргилыг дүрсэлсэн байв. Нас өндөр хүмүүс тэднийг *Ерөнхийлөгчийн Зөвлөлтэй* холбуулан авч үздэгийг

би сонссон. Тэнгэр өөд харсан эдгээр гурван асар том уулын оргилууд нь Сүмийн удирдагчдыг биетээр дүрсэлж байсан юм.

Есөн жилийн өмнө энэ явдал болсон юм. Хүү маань намайг Ютагийн Виллардад авч очиж, тэр уулын оргилын зургийг авч билээ. Биднийг хоёр дахь удаагаа очиход тэнд их сүүдэртэй мөн эрс ялгаатай болчихсон байсан юм.

Тэр хэдэн жилийн дараа би өөрийн орхигдсон авьяас чадваруудаа сэргээх шаардлагатай байлаа. Эхэндээ энэ нь аймшигтай хэцүү байсан юм. Би хэдэн удаа орхихоор болчихсон байтал, найз нарын маань нэг нь “Орхи, орхи! Үүнтэй үүнгүй болчих л байх” гэж хэлж намайг ятгаж билээ.

Би орхиогүй ээ, яагаад гэвэл эхнэр маань тэгэхийг надад зөвшөөрөхгүй байсан юм. Одоо би орхиогүйдээ баяртай байна. Одоо би дахиад чадвартай болсон болохоор магадгүй, хэзээ нэгэн өдөр бас нэг өөр зургийг зурах ч юм уу—хэн мэдэхэв.

Зургаа дахин зурах нь хэн нэгэн олон жил Сүмд идэвхгүй болоод дахин өөрийнхэндээ буцан ирэхээр шийдсэнтэй адилхан байх гэж би бодож байна. Бүр үгүй болоогүй ч тэр орхигдсон авьяасаа дахин мэдрэхэд бэрхшээлтэй болох ч үе байдаг. Энэ нь нэг, хоёр найз нөхөдтэй болоход тусалдаг юм.

Тэр бол амьдралын эгэл туршлагаас иш татаж сурах—бас нэгэн суралцах зарчим юм.

*Бишопийн Хөллөсөн Морьдын тэрхүү зураг удахгүй дуусна. Миний хүүгийн уран баримал цутгамлын үйлдвэрт хүрлээр бүрүүлж байгаа.*

Түүний уран баримал, дашрамд хэлэхэд, миний зургаас хамаагүй дээр юм. Энэ нь байх ёстой зүйл. Залуу хүний хуруунууд болон оюун ухаан нь минийхийг бодвол хүндрэлгүйгээр хөдөлдөг.

Бид *хэвийх, нас өтлөх* үед бидний хөгширч буй яс амархан нугардаггүй болсныг бид мэддэг, хөгширсөн үе мөч тийм хурдан хөдөлдөггүй. Та нар 60 хэвийсэн л байх юм бол, гутлынхаа үдээсийг амархан үдэж чаддаггүй—тэгээд ч шал бүр доошилсон юм шиг санагддаг.

“Өөрийн залууд мэргэн ухааныг суралц; тийм ээ, өөрийн залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун”<sup>6</sup> хэмээх тэрхүү сургамж нь дахин гарч ирж байна.

“Бурханы алдар суу бол оюун билиг, эсвээс, өөрөөр хэлбэл, гэрэл ба үнэн болой.”<sup>7</sup>

“Хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүлэхийг би та нарт зарлигласан билээ.”<sup>8</sup>

Ариун Сүнсний тэнгэрлэг бэлгийг хүүхдүүдийг зөвхөн найм нас хүрэхэд нь хүртээдэг.

“Тайтгаруулагч буюу миний нэрээр Эцэгийн минь илгээх Ариун Сүнс та нарт бүх зүйлсийг заах бөгөөд миний та нарт хэлсэн бүгдийг сануулах болно.”<sup>9</sup>

*Заах ба сануулах* гэсэн үгсийг анхаар.

Хүүхдүүдэд зааснаар гавьяа шагнал ирдэг билээ. Таныг зааж байхад хүүхдүүд тань сурч авахаас илүү заахаасаа та өөрөө суралцаж байдгийг өнөөг хүртэл сурсан байлгүй?

## Сүнслэг Дурсамжуудаа Дурсах нь

Түр зуурын мэдлэгийг эзэмших мөн сүнслэг мэдлэгийг олж авахын хооронд ялгаа бий. Оюутнууд үүнийг шалгалт өгөх өдөр сурч мэддэг. Анхнаасаа сурч аваагүй зүйлийг эргүүлэн санах нь дэндүү хэцүү байдаг.

Түр зуурын мэдлэгийн хувьд энэ бол үнэн, гэхдээ сүнслэг байдлаар бид төрхөөс өмнө нь байдаг дурсамжаа санаж чаддаг. Бид залуудаа ойлгодоггүй байсан зүйлүүдийн мэдрэмжийг бид хөгжүүлж болох юм.

Яруу найрагч Вөрдсворт өмнөх амьдралын талаар тэрээр бичихдээ:

*Бидний төрөлт ердөө л унтаж, мартаход байдаг: Үйл явдал нь үүнээс өөр газарт хүүрнэж байсан Мөн алс холоос ирэх: Бидэнтэй сэргээг байдаг Тэрхүү Сэтгэл амьдралын маань Од мөн бил үү, Бүрэн мартанг байдлаар бус, Мөн бүрэн нүцгэн байдлаар ч биш, Харин гэр голомт маань болох Бурханаас, Нүүж буй алдар суугийн үүлнээс бид ирдэггүй бил үү<sup>10</sup> хэмээн ямар нэгэн зүйлийг мэдэрсэн юм.*

Би коллежид байх өдрүүдийн англи хэлний хичээлийн үеэр цээжилсэн эдгээр мөрнүүдийг оюун ухаанаасаа гарган хэлж байна.

Хамгийн чухал сургамжууд нь амьдралын ердийн үйл явдлуудаас үүдэн гардаг билээ.

Зарим хүмүүс гэрчлэлээ нотлуулахаар үнэмшил төрүүлмээр сүнслэг үйл явдлуудыг шаарддаг. Ийм байдлаар ирэхгүй ээ. Энгийн жирийн зүйлсээс үүдэлтэй дөлгөөн өдөөлтүүд болон аятайхан сайхан сэтгэгдлүүд нь бидэнд Бурханы хүүхдүүдийн хувьд адил төсөөтэй байдлын баталгааг мэдрүүлдэг. Бид гайхамшигтай үйл явдлуудын тэмдгүүдийг хайж мөн “уг зорилгоос алсуур”<sup>11</sup> харснаас болж бид боломжуудаасаа улам холуур амьдардаг билээ.

Бид Бурханы хүүхдүүд мөн. Учир нь бид Түүнтэй хамт зуурдын байдлын өмнөх оршихуйд

амьдарч байсан юм. Үе үе тэрхүү хөшиг нь сөхөгддөг билээ. Тэнд бидний хэн болох мөн бүх зүйлсийн мөнхийн байдалд бидний эзлэх байр суурийн мэдээлэл байдаг. Энэ нь Есүс Христийн сайн мэдээ нь үнэн гэгдэх тэдгээр гэрчлэлүүдийн нэгийг санамж буюу сүнслэг илэрхийлэл хэмээн нэрлэ. Ийнхүү илчлэлтүүд биднийг зааж, сургаж байх үед ирдэг.

Ерөнхийлөгч Марион Ж.Ромнийн (1897–1988) “Би өөрийн хэлсэн зүйлсээс ямар нэгэн юмыг үргэлж сурч авдаг болохоор Ариун Сүнсний нөлөөлөлд ярьж байгаага би үргэлж мэддэг” хэмээн нэг удаа хэлж байхыг би сонссон юм.

Их Эзэн ахлагч нарт хэлэхдээ:

“Та нар заагдсан байхаар бус, харин та нарын гар дээр миний тавьсан тэдгээр зүйлүүдийг миний Сүнсний хүчээр хүмүүний үрст заахаар урагш илгээгддэг буюу;

“Мөн та нар тэнгэрээс заагддаг байх ёстой. Өөрсдийгөө ариусга мөн та нар бүр миний хэлсний адилаар зааж болохын тулд та нар тэнгэрийн хүчээр хишиг хүртээгдсэн байх болно”<sup>12</sup> хэмээжээ.

Хэдийгээр номлогч нарын хөрвөгчдийн үр шимийг үзэх нь бага байдаг ч гэсэн сүнслэг хүч нь тэдэнд мөн Сүмд ирдэг, учир нь тэд зааж байгаагаас нь суралцдаг билээ.

Диконуудын чуулгын ерөнхийлөгч нь зөвлөлд хуралдах, мөн хамтран зүтгэгч диконууддаа заах ёстой.<sup>13</sup> Ахлагч нарын чуулгын ерөнхийлөгч нь гэрээнүүдийн дагуу чуулгын ахлагч нартаа заах үүрэгтэй.<sup>14</sup>

Паул “Олон гэрч нарын өмнө надаас сонссон зүйлсийг бусдад заах чадвартай итгэмжит хүмүүст даатга”<sup>15</sup> хэмээн Тимотод хэлсэн байдаг.

Тэрээр зааж сургах нь хэрхэн гавьяа шагнал болдгийг ёсон үгээр тайлбарлахдаа:

“Тэгвэл бусдад заагч та өөртөө заадаггүй юм уу? Хулгай бүү хий гэж номлодог та өөрөө хулгай хийдэг юм уу?

“Бүү завхайр гэж ярьдаг та өөрөө завхайрдаггүй юм уу?”<sup>16</sup>

### Уриалгахан Суралцагч Байх нь

Олон тохиолдлоор захиа авдаг байсны адилаар нэг өдөр би уучлал эрсэн захиа хүлээн авсан юм. Энэ нь үл таних нэгэн хүнээс ирсэн. Энэхүү захианд миний өгсөн ярианаас болж тэр гишүүн удаан хугацаагаар надад хичнээн их уурлаж, дургүйцсэнийг өгүүлсэн байлаа. Энэ нь уучлалт хүсэн захиа байсан юм.

Би хүнийг уучлахдаа хурдан. Би яриа өгөх мөн уучлал үзүүлэх хоёрын хоорондох зөвхөн биет төлөөлөгч нь юм.

Бошиглогчид болон төлөөлөгчдийн заасан зүйлсийг Израилчууд мөн Нифайчуудад хүргэх нь хичнээн “хэцүү”<sup>17</sup> байсныг илэрхийлсэн олон ишлэлүүдийг судрууд агуулдаг. Заасан сургамжуудыг эсэргүүцэх мөн багшдаа дургүйцэх нь үнэхээр амархан байдаг. Иймэрхүү явдал нь дээр үеэс л бошиглогчид, төлөөлөгчдөд маш ихээр тохиолдож байсан юм.

Ерөөлүүдийн нэг дараах зүйлсийг заадаг:

“Надаас болж та нарыг хүмүүс доромжилж, хавчих, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй еэ!

“Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд тийнхүү хавчсан юм.”<sup>18</sup>

Ерөнхийдөө уучлалт хүссэн тэдгээр захианууд нь “та намайг үнэхээр эвгүйцүүлж, мөн үнэхээр буруутайг минь мэдрүүлэх хэрэгтэй гэдгийг яаж мэдэрсэнийг би ойлгож чадсангүй” гэсэн байдаг. Тэгээд ч, бэрхшээл тэмцэл дотроос шалтгаанууд ба үр нөлөөллүүдийн ойлголт, урам илчлэлт, урамшуулал тодрон гарч ирдэг билээ. Эцэст нь тэд сайн мэдээ нь яагаад иймэрхүү байдгийг ойлгон ухаардаг.

Би хэд хэдэн сэдвүүдийн нэгийг дурьдмаар байна. Бид эхчүүдийг хүүхдүүдтэйгээ гэртээ үлдэж байхын ач холбогдлыг юунд тодотгоод байгааг эцэст нь ямар ч эгч ухаарч болох юм. Хувиа хичээдэггүй эх хүнээс үүдэн гардаг өргөмжлөлийн сайшаалтай ямар ч үйлчилгээ нийцдэггүйг тэрээр ойлгодог. Гэхдээ оюун ухаан, соёл урлаг буюу нийгмийн боловсролоос тэр татгалзах хэрэггүй. Хүүхдүүдэд заахад гарч ирдэг мөнхийн ариун журмыг тэд анхаарах юм бол, эдгээр зүйлүүд нь—тухайн цаг хугацаанд—тохирдог билээ.

Эх хүн хүүхдүүддээ заадаг шиг илүү их сүнслэг ач гавьяатай эсвээс илүү их өргөмжлөлийг хүртэх ямар ч сургаал үүнтэй тэнцэх нь үгүй билээ. Эх хүнд гэр бүлийнхнийгээ сурган зааж завгүй байсан учир судрын мэдлэг нь хангалттай сайн биш гэдгийг тэр мэдэрч болох юм. Гэхдээ тэр хамаагүй бага адислал, шагналыг хүртэнэ гэсэн үг биш юм.

Ерөнхийлөгч Грант Бангертер Бразил дахь номлолд айлчилж байх зуураа Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смиттэй сургаалын талаар ярилцаж явав. Бангертер эгч сонсож байгаад, эцэст нь “Ерөнхийлөгч Смит, би хүүхдүүдээ өсгөн хүмүүжүүлсээр байгаад түүний адил судрын мэдлэгтэй болох цаг хугацаа надад байсангүй. Би Гранттай хамт сэлэстиэл хаант улсад очих болов уу?” хэмээн хэлжээ.

Ерөнхийлөгч Смит хоромхон зуур тайван бодож үзсэнээ, “За, яахав, хэрэв та түүнд зориулж бялуу хийх юм бол магадгүй” гэж дараа нь хэлсэн юм.

Эр хүн өөрийн эхнэрт байгалаас заяагдсан хүүхдүүддээ заан сургах сүнслэг боловсролтой тэнцэхийн тулд маш ихээр зүтгэх ёстой. Хэрэв тэр сайн мэдээг бүрэн ойлгодог бол, тэрээр түүнгүйгээр өргөмжлөгдөх нь үгүй гэдгийг мэднэ.<sup>19</sup> Хүүхдүүддээ заан сургахдаа түүний хамгийн их найдвар нь халамжтай, хариуцлагатай хамтрагчийн хувьд удирдан залах явдал юм.

### Багш нарт Зориулагсан Адислалууд

Одоо энэхүү амлалтыг тунгаан бод:

“[Багш, эцэг, эх] та нар онолд, зарчимд, сургаалд, сайн мэдээний хуулинд, [эцэг, эх] та нарын ойлголтод шаардлагатай Бурханы хаант улсад хамаардаг бүх зүйл илүү төгс зааварлагдсан байж болохын тулд хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл [багш] *та нартай* байх болно.”<sup>20</sup>

Энэ амлалт нь оюутнаас илүү багшид нь зориулагдсан гэдгийг анхаар.

“Хичээнгүйлэн заагтун та нар, мөн миний ач ивээл [хүүхдүүд тань эсвээс Хүүхдийн Хэсэгт, Ням Гарагийн Хичээлд, Залуу Эмэгтэйчүүд болон Эрэгтэйчүүдэд, санваартанд, семинарт, Нийгмийн Халамжийн Бүлэгт зааж буй] та нартай хамт байх болно,” тэгснээр та нар,

“Тэнгэр дэх мөн дэлхий дэх мөн дэлхий доорх зүйлүүдийн тухай; байсаар ирсэн зүйлүүд, байгаа зүйлүүд, удахгүй тохиох зүйлүүд; гэрт байгаа зүйлүүд, гадаа байгаа зүйлүүд; дайнууд болон үндэстнүүдийн ээдрээтэй байдал, мөн уг нутаг дээрх шүүлтүүд; мөн тэрчлэн улс орнуудын тухай хийгээд хаант улсуудын тухай мэдлэг буюу—

“Та нарыг бибээр дуудсан тэрхүү дуудлагыг, би та нарт итгэмжилсэн тэрхүү үүрэг даалгаврыг хичээнгүйлэн гүйцэтгүүлэхээр би та нарыг дахин илгээхэд [зааж буй] та нар бүх зүйлд бэлтгэгдсэн байж болохын тулд буюу”<sup>21</sup> зүйлийг мэдэж авахын тулд болой.

Паул залуу Тимотод, “эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ”<sup>22</sup> хэмээн бошиглосон билээ. Тэрээр хэлэхдээ: “Муу хүмүүс, мэхлэгч нар хуурч, хуурагдан улам бүр бузар муу болно”<sup>23</sup> гэжээ.

Гэсэн ч бид одоо аюулгүй байж болох юм. Бидний аюулгүй байдал нь хүүхдүүдийг сургахад байдаг.

“Явах ёстой замаар нь замнуулахын тулд хүүхдийг сурга. Тэрээр өтөлсөн ч тэр замыг орхихгүй”<sup>24</sup>

Паул Тимотод зөвлөхдөө:

“Чи хэнээс сурснаа мэдэж, юунд итгэсэн болон юу сурсан дотроо бай.

“Христ Есүст итгэх итгэлээр дамжуулан авралд хүргэх мэргэн ухааныг чамд өгөх чадалтай *Ариун Бичээсүүдийг* чи бага наснаасаа мэдэх болсон”<sup>25</sup> гэжээ.

Энэ бол Есүс Христийн Сүм юм. Энэ бол Түүний Сүм мөн. Тэрээр бидний Үлгэр Жишээ мөн Аврагч маань билээ. “Түүний . . . байгаачлан . . . байцгаа”<sup>26</sup> хэмээн бидэнд зарлигласан юм.

Тэрээр хүүхдүүдийн багш нь байсан. Тэрбээр Иерусалимд байгаа Өөрийн шавь нарт, “Хүүхдүүдийг зөвшөөр, над уруу ирэхийг бүү болиул. Учир нь тэнгэрийн хаанчлал бол эдний адил хүмүүсийнх юм”<sup>27</sup> хэмээн зарлигласан билээ.

Нифайчуудын дунд хийсэн Аврагчийн тохиуулын шастирт байдгаас илүү ямар нэгэн өөр газар Түүний сэтгэлийг илүү их гүнзгийгээр харж чадахгүй билээ.

“Мөнхүү улиран тохиох дор тэрбээр тэдний бяцхан хүүхдүүд нь авчруулагдахыг зарлиг болов.

“Иймээс тэд өөрсдийн бяцхан хүүхдүүдээ авчирч мөн тэднийг түүний эргэн тойронд нь газарт доош тавив, мөн Есүс голд нь зогсов; мөн цугласан олон тэднийг түүнд бүгдийг авчирсан байх хүртэл зай тавьж өгөв. . . .

“. . . Тэрээр . . . уйлж, мөн олон түмэн үүнийг нотлон өгүүлэв, мөн тэрээр тэдний бяцхан хүүхдүүдийг нэг нэгээр нь авч, мөн тэднийг адислав, мөн тэдний төлөө Эцэгт хандан залбирав.

“Мөн тэр үүнийг хийгээд тэрээр дахин уйлав;

“Мөн тэр олон түмэнд хандан ярьж, мөн тэдэнд: Өөрсдийн бяцхан үрсээ болгоогтун хэмээн хэлэв.

“Мөн тэд болгоохоор харахдаа харцаа тэнгэрийн зүг хандуулж, мөн тэд тэнгэр нээгдэхийг үзэв, мөн тэд сахиулсан тэнгэр элч нар тэнгэрээс галын дунд байгаа мэт доошлон ирэхийг үзэв; мөн тэдгээр доош ирж мөн уг багачуудыг эргэн тойрон хүрээлж, мөн тэд галаар эргэн тойрондоо хүрээлэгдсэн байв; мөн сахиулсан тэнгэр элч нар тэдэнд тохинуулсан болой.

“Мөн цугласан олон үзэж мөн сонсож мөн нотлон өгүүлэв; мөн тэд өөрсдийн цэдгийг үнэн гэдгийг мэддэг учир нь тэд бүгд . . . үзэж мөн сонссон болой.”<sup>28</sup>

Би энэ цэдгийг үнэн гэдгийг мэднэ. Би Түүнийг гэрчилж, мөн Түүний нэрээр хүүхдүүдэд зааж, сургаж байгаа та бүхнийг адислах болтугай.

1999 оны Наймдугаар сарын 17-ны Бригам Янгийн Их Сургуулийн Боловсролын Долоо Хоногт зориулсан цугларалтанд хэлсэн үгнээс (*Ensign*, 2000 оны Хоёрдугаар сар, 10-17-г үз).



---

## ТЭМДЭГЛЭЛ

1. Алма 37:35.
2. Сургаал ба Гэрээ 68:25.
3. "The Bishop and His Counselors," *Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 57.
4. Сургаал ба Гэрээ 84:85.
5. Сургаал ба Гэрээ 84:88.
6. Алма 37:35.
7. Сургаал ба Гэрээ 93:36
8. Сургаал ба Гэрээ 93:40.
9. Иохан 14:26; налуу бичлэгийг нэмэв.
10. "Ode: Intimations of Immortality," 5 дугаар мөр.
11. Иаков 4:14.
12. Сургаал ба Гэрээ 43:15–16.
13. Сургаал ба Гэрээ 107:85–ыг үз.
14. Сургаал ба Гэрээ 107:89–ийг үз.
15. 2 Тимот 2:2.
16. Ром 2:21–22; налуу бичлэгийг нэмэв.
17. Иохан 6:60; 1 Нифай 16:2; 2 Нифай 9:40; Хиламан 14:10–ыг үз.
18. Матай 5:11–12; мөн Лук 21:12–ыг үз; Иохан 15:20; 3 Нифай 12:12
19. Сургаал ба Гэрээ 131:1–4, 132:19–21–г үз.
20. Сургаал ба Гэрээ 88:78; налуу бичлэгийг нэмэв.
21. Сургаал ба Гэрээ 88:79–80.
22. 2 Тимот 3:1.
23. 2 Тимот 3:13.
24. Сургаалт Үгс 22:6
25. 2 Тимот 3:14–15; налуу бичлэгийг нэмэв.
26. 1 Иохан 3:7.
27. Матай 19:14.
28. 3 Нифай 17:11–12, 21–25.

# ХҮҮХДҮҮДИЙГ ШИЙДВЭР ГАРГАХАД НЬ ХӨТЛӨХ

# 15

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Доор байгаа унших даалгаварт Ахлагч М.Расселл Баллард “гэр орондоо итгэх итгэлийн цайзыг бид барин байгуулж мөн . . . залуучуудыг маань ариун сүмд ороход нь цэвэр, ариун хийгээд ариун байлгахын тулд бэлтгэхэд” туслах дөрвөн арга замыг бидэнд санал болгож байна. Түүний зөвлөгөөг давтаж, эдгээр зөвлөгөөг гэр орондоо

сахиж мөрдөхөөр тодорхой төлөвлөгөөг хийж гарга.

- Гэр бүлийн тань хүүхэд бүрт сургууль, гэр оронд, мөн бусад газарт тулгарч болох шийдвэрүүдийг бод. Хүүхэд бүрийг зөв шударга шийдвэр гаргахад бэлтгэн та юугаар тусалж чадахыг тунгаан бод.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### УНТАРШГҮЙ ГАЛ МЭТ

Арванхоёр Төлөөлөгчдийн Чуулгын  
Ахлагч М.Расселл Баллард

### Ариун Сүмийн Гэрлэлтийн Баяр Баясгалан

Их Эзэний өргөөнд зохистой хоёр залуу хүн гэрлэж, лацдан холбогдож байх үед ариун сүмд ажиллах онцгой боломж надад тохиосон юм. Гэр бүл, найз нөхдийнх нь хувьд энэ нь хэзээд онцгой цаг үе байдаг билээ. Тийм үеүдэд мэдрэх мэдрэмж нь бүх зүрх сэтгэлээрээ энэ өдрийн төлөө залбирсан эхчүүдийн нүдэнд дүүрэх нулимсанд харагдах энэ дэлхийн аз жаргал хийгээд мөнхийн баяр баясгалангийн жаргал цэнгэл болон сэтгэл ханамжтай хамт юм. Энэ олон жилийн турш, анх удаагаа бүх зардлыг хэрхэн төлөхөөс гадна бас өөр зүйлсийн тухай бодож буй эцгүүдийн нүднээс та нар үүнийг харна. Гэвч ихэвчлэн сайн мэдээний заасан зүйлүүдэд үнэнчээр амьдарч, дэлхийн уруу таталтуудаас хол хөндий байсан ариун журамт сүйт бүсгүй, сүйт залуугийн нүднээс үүнийг харна. Цэвэр, ариун, ариун журамтай байсан хүмүүст боломжтой байдаг онцгой татгалзаж боломгүй мэдрэмжүүд байдаг.

### Ёс Суртахууны Жишгүүд нь Хэмжээлшгүй

Хэт их олон манай залуу эрэгтэй, эмэгтэйчүүд хилэнцэт захиасууд мөн ёс суртахуунгүй байдлаар дүүрэн дэлхийн тэдэнд тулгаж буй дарамтанд бууж өгдөг. Люцифер залуу, хөгшин ялгаагүй сүнснүүдийн төлөө ширүүн дайн хийж байгаа

мөн шархдаж алагдсан хүмүүсийн тоо өссөөр байна. Дэлхийн жишгүүд нь салхиар шуурч буй цөлийн элс мэт өөрчлөгдөөд байна. Хэзээ ч нэгэнтээ сонсогддоггүй эсвэл хүлээн зөвшөөрөгддөггүй байсан зүйл нь эдүгээ ердийн зүйл болоод байна. Дэлхийн алсыг харах үзэл нь үнэхээр эмгэнэлтэйгээр өөрчлөгдсөн байгаа, учир нь ёс суртахууны уламжлалт жишгүүдийг баримтлахыг сонгосон, бараг л тэд Бурханы зарлигуудыг сахих өөрсдийн хүсэл сонирхлыг зөвтгөх ёстой гэж үзэж буй тэдгээр хүмүүсийг харийнхан мэтээр үздэг болсон.

Гэтэл нэг зүйл тодорхой байдаг: зарлигууд нь өөрчлөгдөөгүй юм. Энэ талаар ямар ч алдаа, эндүүрэл гаргахгүй л байгаасай. Зөв зүйл нь эцсээ хүртэл зөв байдаг. Хичнээн ухаалгаар хүндэтгэл эсвээс улс төрийн засвартай ч, буруу зүйл нь өнөөг хүртэл буруу байсаар ирсэн билээ. Бид гэрлэлтээс өмнө ариун явах мөн үүнээс хойш үнэнч байх явдалд итгэдэг билээ. Тэрхүү жишиг нь үнэний хамгийн дээд жишиг нь юм. Энэ нь олон нийтийн үзэл бодлыг санал асуулгаас ч биш мөн нөхцөл байдал буюу орчноос үл хамаарах сэдэв билээ. Үүнийг эсвээс бусад сайн мэдээний жишгүүдийг хэлэлцэн маргалдах хэрэггүй юм.

### Гэр Оронд Итгэлийн Цайзыг Байгуулах нь

Харин залуучуудаа сайн мэдээний жишгүүдийг ойлгон ухаарч, хайрлаж үнэлэх хийгээд үүний дагуу амьдрахад нь эцэг эх, удирдагчид болон багш нарын хувьд цөхрөлтгүйгээр туслах шаардлагатай юм. Эцэг эх болон залуучууд хамтдаа овжин зальтай дайсны эсрэг тэмцэхээр зогсох ёстой. Тэрээр

биднийг болоод сайн мэдээг устгахаар оролддог адилаар бид сайн мэдээгээр амьдрах хичээл зүтгэлдээ зөвхөн өөрсдийгөө бүрэн зориулан, үр дүнтэй, шийдвэр төгс байх ёстой.

Бидний өмнө байгаа бэрхшээлүүд агуу том билээ. Эрсдэлтэй нь бидний хайрладаг тэдгээр мөнх бус сүнснүүд байж байдаг. Би гэр орондоо итгэлийн цайзыг бид барин байгуулж болох мөн ялангуяа залуучуудыг маань ариун сүмд орохуйц бүрэн зохистой цэвэр, шударга хийгээд ариун байхын тулд бэлтгэгдэхэд туслах дөрвөн арга замыг та нарт санал болгомоор байна.

### Хүүхдүүдэд Сайн Мэдээг Зааж Өг

Хамгийн эхнийх нь сайн мэдээний мэдээлэл юм. Миний мэдэх амьдралыг өөрчлөх хамгийн чухал мэдээлэлд бид бол Бурхан Мөнхийн Эцэгийн жинхэнэ хүүхдүүд хэмээх мэдлэг билээ. Энэ нь зөвхөн сургаалаар зөв байгаад зогсохгүй мөн сүнслэг байдлын хувьд амин чухал юм. Аврагч Өөрийн хүчирхэг зуучлалын залбиралд, “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) хэмээн хэлсэн билээ. Тэнгэрлэг Эцгээ мэдэж, мөн Түүнийг Эцгээ, Бурханаа хэмээн хандах харьцаагаа ойлгох нь энэ амьдралын утга учир хийгээд ирэх амьдралын итгэл найдварыг олж авах явдал мөн. Гэр бүлүүд маань Түүнийг жинхэнэ бодит гэдгийг мөн үнэндээ бид Түүний хөвгүүд бас Түүний охидууд мөн, эдүгээ мөнхөд ч Түүнд байгаа бүхний үе залгамжлагчид мөн гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Тэрхүү мэдлэгт баттай байх юм бол, гэр бүлийн гишүүд нь чөтгөрийн хазайж буй зам руу арай бага анхаарч мөн Бурханыг хараад амьдрах нь арай илүү байх болно (Тооллого 21:8-ыг үз).

### Тав Тух Хангах бус Гэрээний Дагуу Амьдар

Анхдагч өвөг дээдсийн маань адилаар бид яаж ийгээд зүрх сэтгэлдээ Есүс Христийн сайн мэдээний хүчирхэг гэрчлэлийг суулгах хэрэгтэй. 1846 оны Есдүгээр сард Навуугийн ариун сүмийг сүйрүүлэх үед муухан лагерьт байсан Гэгээнтнүүдийн тэсэхийн аргагүй нөхцөл байдлыг санагтун. Винтер Куартерст үг хүрэхэд Бригам Янг тэр даруй ах нарыг хамтад нь цуглуулжээ. Нөхцөл байдлыг тайлбарласны улмаар Навуугийн Ариун Сүмд хийсэн гэрээнүүдийг тэдэнд сануулсны дараа үгээгүй ядуу ч ирэхийг хүссэн хэнийг ч ард үлдээхгүй байх болно гэсэн энэхүү гайхамшигтай урамшууллыг тэдэнд өгсөн билээ.

“Эдүгээ хөдөлмөрлөх цаг ирлээ. Их Эзэний Өргөөнд таны хийсэн гэрээний гэрэл нь зүрх сэтгэл тань унтаршгүй гэрлээр гэрэлттүгэй” хэмээн тэрээр хэлжээ (Зөвлөгөөний Үеэр Дээд Зөвлөлд өг-

сөн, 1846 оны Есдүгээр сарын 27, Бригам Янгийн Захидлуудаас, Түүхийг Архивлах Хэлтэс, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, 1; налуу бичлэгийн нэмэв). Хэдийд Витер Кватерст нөхцөл байдал, бараг ядуу зүдүү байсныгаа үл хайхран хэдхэн хонгийн дотор Миссиссиппи Голын хөндлөн байгаа ядарсан ядуу Гэгээнтнүүдийг аврахаар олон морин тэрэгнүүдийг баруун хойд хөлөглөсөн юм байна.

Бид тэдгээр эрт үеийн Гэгээнтнүүдийн зовлон шаналал хийгээд золиослолыг тэсвэрлэн гарсан тухай олонтаа сонсдог бөгөөд бид, Тэд яаж үүнийг хийсэн бол? Тийнхүү хүч тэнхээг тэдэнд оруулдаг зүйл нь юу байсан бол хэмээн өөрсдөөсөө асуудаг. Тэр хариуны нэг хэсэг нь Ерөнхийлөгч Янгийн хүчирхэг үгсэд байдаг. Тэдгээр анхны Хожмын Үеийн Гэгээнтнүүд нь Бурхантай гэрээ хийсэн байсан бөгөөд тэдгээр гэрээнүүд нь тэдний зүрх сэтгэлд унтаршгүй гал мэт дүрэлздэг байв.

Заримдаа бид өөрсдийн амьдралыг гэрээнээс илүү ая тухтай, тааламжтай зүйлээр захируулахыг зөвшөөрч уруу татагддаг юм. Сайн мэдээний жишгүүдээр амьдарч, үнэний төлөө тэмцэх мөн Сэргээлтийг гэрчлэх нь үргэлж таатай байдаггүй. Бусадтай сайн мэдээг хуваалцах нь үргэлж тохиромжгүй байдаггүй. Сүмийн дуудлагад ажилд үргэлж автагдах нь ялангуяа бидний чадвар чансааг сорьсон байхад бололцоотой байдаггүй юм. Учир ач холбогдолтой арга замаар, бидний бусдад үйлчлэнэ гэсэн гэрээний дагуу үйлчлэх боломжууд нь тохиромжтой байдлаар бараг ховор ирдэг юм. Гэхдээ тааллаараа амьдрах юм бол сүнслэг хүч гэж үгүй. Биднийг гэрээгээ сахихад тэр хүч ирдэг билээ. Биднийг эдгээр эрт үеийн Гэгээнтнүүдийн амьдралыг харахад тэдний гэрээнүүд нь амьдралынх нь хөдөлгөгч гол хүч нь байсан юм. Тэдний үлгэр жишээ мөн гэрчлэл нь хүүхдүүдийнх нь үр удамд, нэгээс нөгөөхөд нь хангалттайгаар нөлөөлж чадахуйц хүчирхэг байсан юм.

### Хүүхдүүдэд Ёс Суртахууны талаар Заан Сурга

Хүүхдүүд маань өсөж том болох тусам, эцэг эхчүүд тэдэнд шаардлагатай мэдээллийн аль нь зөв мөн зохисгүй байгааг илүү шулуун, шударгаар заах хэрэгтэй. Эцэг эхчүүд ямар ч порнографи зурагнууд эсвээс түүх, яриануудаас зайлсхийхийг хүүхдүүдэд заах хэрэгтэй. Ямар ч төрлийн порнографи нь чөтгөрийн зэмсэг юм гэдгийг эцэг эхээсээ хүүхэд, залуучууд мэдэж авах хэрэгтэй; мөн хэрэв хэн ч үүнд татагдах юм бол, энэ нь донтуулан муутгах, тэр ч бүү хэл хүмүүний сүнсийг хөнөөх хүчтэй юм. Тэдэнд бохир хэл яриаг хэрэглэхгүй байхыг мөн Их Эзэний нэрийг дэмий дуудахгүй байхыг заасан байх ёстой. Санаандгүй сонссон бүдүүлэг шог яриа нь дахин хэзээ ч давтагдахгүй

байх хэрэгтэй. Гэр бүлийн гишүүдэд хэт их сэтгэл хөдөлгөсөн (тачаангүй байдлыг зарлан уриалсан) хөгжмийг сонсохгүй байхыг зааж бай. Тэдэнд бэлгийн харьцааны болон ариун явдлын талаарх сайн мэдээний сургамжуудын тухай илэн далангүй ярилцаж бай. Энэхүү мэдээлэл нь эцэг эхээс зөв байдлаар гэр бүлд хүргэгддэг. Бүх гэр бүлийн гишүүд нь дүрэм журам мэддэг мөн тэднийг сахиж болохын тулд сүнслэгээр зоригжсон байх хэрэгтэй. Харин алдаа гаргасан тохиолдолд, тэрхүү гайхамшигтай Их Эзэн Есүс Христийн Цагаатгалыг ойлгон ухаарч, хүлээн зөвшөөрсөн байх ёстой, тэгснээр наманчлал, өршөөлийн бүхэл бүтэн хаяа хүнд хэцүү үйл явц хийгээд ирээдүйн төлөө үргэлжилж буй итгэл найдвараар дамжуулж үүнийг хүлээн авч болно. Бид мөнх амьдралын төлөөх хувийн болон гэр бүлийнхээ үнэнийг эрж хайхдаа хэзээ ч бууж өгөх ёсгүй билээ.

Харамсалтай нь өнөөдөр дэлхий дээрх маш олон эцэг эхчүүд эдгээр шинж чанаруудыг болон Сүмийн бусад сургаалуудыг бусад хүмүүс, найз, нас чацуутан, сургууль, Сүмийн удирдагчид болон багш нар, тэр ч бүү хэл үзвэр үйлчилгээ заагаад өгчих байх хэмээн найдаж, гэр бүлүүддээ заах үүрэг хариуцлагаас татгалздаг байна. Өдөр бүр хүүхдүүд маань суралцаж, оюун ухаан, зүрх сэтгэлээ хувийн үнэ цэнийг дүгнэх системүүдийг гүнээр хөнддөг туршлагаууд болон ойлголтуудаар дүүргэдэг юм байна.

### **Ёс Бус Зүйлийн Эсрэг Өөрсдийгөө Хүчирхэгжүүл**

Ах эгч нар аа, урьд өмнө байгаагүйгээр нэмэгдэн өсөж буй ёс бус зүйлтэй дэлхийд зарлигуудыг дагах зориг урамшуулалттайгаар зүрх сэтгэлдээ илүү гүн гүнзгий итгэх итгэлийг суулгахаар ятгуулж, нэг нэгэндээ зааварлаж байх хэрэгтэй. Бид Христийн сайн мэдээнд үнэхээр чин сэтгэлээр хөрвөгдсөн байх хэрэгтэй, тэгснээр гэрээний маань гэрэл нь зүрх сэтгэлд маань унтаршгүй гал мэт асаж, мэдрэгдэх болно. Мөн ийнхүү итгэх итгэлтэйгээр бид үнэнч хийгээд зохистой үлдэж болохын тулд шаардлагатай бүхнийг хийх болно.

### **Хүүхдүүдтэй Илэн Далангүй Харьцаж Бай**

Хоёрдугаарт харилцаа юм. Илэн далангүй, үнэнч харилцаанаас илүү чухал зүйл гэж гэр бүлийн гишүүдийн хоорондох харьцаанд байхгүй билээ. Энэ нь ялангуяа хүүхдүүддээ сайн мэдээний зарчмууд болон жишгүүдийг заахыг хичээж буй эцэг эхчүүдэд үнэн байдаг. Залуучуудтайгаа зөвшилцөх чадвар нь—магадгүй үүнээс ч илүү ач холбогдол нь тэдний сэтгэлийг түгшээж буй асуудлыг үнэн голоосоо сонсох нь—амжилт бүхий харилцан холбоог бий болгох үндэс суурь юм. Ихэнхдээ бид

нүд рүү нь эгцэлж, бид зүрх сэтгэлээрээ бидний сонссон эсвээс хэлсэн зүйлээс нь ихийг мэдэрч харилцаж ойлголцдог юм. Хүүхдүүдэд хэлэх тэр үг нь: эцэг эхийгээ ямагт хүндлэгтүн. Түүнчлэн та сонсож сурах ёстой, ялангуяа эцэг, эхийн тань өгсөн зөвлөгөө болон Сүнсний удирдамжуудыг сонсож сурах ёстой. Бидний гэр бүлийн харьцааны хүрээнд онцгой заах боломжууд үргэлж тохиолдогийг бид харж, олж авах хэрэгтэй бөгөөд бид Даваа гараг бүрийн орой гэр бүлийн үдшийг явуулахаа одоо шийдвэрлэх хэрэгтэй.

Гэр бүлийн өдөр тутмын залбирал, гэр бүлээрээ судраас суралцсанаар хоорондын харьцааны гайхамшигтай үе мөчүүд бий болдог билээ. Судрууд нь гэр бүлийн үнэ цэнэ бас зорилгуудыг тодорхойлоход туслах ба тэдгээрийн тухай хамтдаа ярилцсанаар гэр бүлийн гишүүдийг бие даасан, сүнслэг байдлаар хүчирхэг мөн өөрөө өөртөө итгэдэг болохыг заан дэмжих болно. Энэ нь цаг хугацаа шаарддаг, тиймээс бид хамтдаа зурагтыг хичнээн их удаа, хэдэн кино, видео бичлэгүүд, видео тоглоомууд, Интернет дээр хэр их цагийг эсвэл гэрээсээ гадагш үйл ажиллагаанд хичнээн их цагийг зориулахыг зөвшилдсөн байх хэрэгтэй.

### **Эцэг Эх ба Удирдагчид Хөндлөнгөөс Оролцож Байх Ёстой**

Гуравдугаарт хөндлөнгөөс оролцохыг хэлнэ. Буруу сонголт хийж байхыг эцэг, эхчүүд харах юм бол, хөндлөнгөөс оролцох нь та нарын үүрэг юм. Энэ нь эцэг, эхчүүд үнэт бэлэг болох чөлөөт сонголтыг хүүхдүүдээс авах гэсэн утгатай биш юм. Учир нь чөлөөт сонголт нь Бурханаар өгөгдсөн бэлэг бөгөөд эцсийн эцэст тэд юу хийх, хэрхэн бие авч явах хийгээд тэд юунд итгэхийн сонголт нь үргэлж тэднийх байх болно. Харин эцэг эхчүүдийн хувьд, хэрэв тэд өөрсдийн буруу үйлдлийг дагах юм бол, тэдэнд оноогдох үр дагаврууд болон зохистой сахилга баттай байхыг тэд ойлгож байгаа гэдэгт бид баттай байх хэрэгтэй. Гэр бүлд гэмгүй хэмээх шүүмжлэл байх ёсгүйг санагтун. Кино, сэтгүүлүүд, телевиз, видео бичлэгүүд, Интернет болон бусад үзвэр үйлчилгээ нь урилга мэт байдаг бөгөөд зөвхөн гэр бүлийн таашаалд тохирохуйцаар тэдгээрийг ашиглаж болно. Гэр орноо амар амгалан, шударга ёсны диваажин болго. Хилэнцэт нөлөөллүүдээр өөрийн хувийн онцгой сүнслэг байдлаа бохирдуулахыг бүү зөвшөөр. Та хэлж буй зүйлдээ, нэг нэгэндээ харьцах харьцааг анхааралдаа авч, сайхан сэтгэл, халамжтай, эелдэг бай. Тэгвэл сайн мэдээний жишгүүд дээр үндэслэгдсэн гэр бүлийн зорилгууд сайн шийдвэрүүдийг гаргахыг илүү амархан болгоно.

Гэр бүлүүдийг дэмжихээр хичээн зүтгэж буй бишопууд, багш нар болон Сүмийн бусад удирдагчид та нарт мөн ижил зарчмууд хамаатай байдаг билээ. Та нарын хариуцан удирдаж буй тэдгээр хүмүүс ёс суртахууны хувьд муу сонголтууд хийж байхыг хараад зүгээр зогсох ёсгүй. Залуучуудын маань нэг нь амьдрал дахь ёс суртахууны ямар ч үед зогсож байхад хайр, сайхан сэтгэлээр өөрчлөлтийг бий болгох чадвартай—эцэг эх, удирдагч, багш гэх—хэн нэгэн бараг үргэлж тэнд нь байж л байдаг.

### **Хүүхдүүддээ Сайн Үлгэр Жишээ Бай**

Дөрөвдүгээрт үлгэр жишээ юм. Луужингийн тусламжгүйгээр, тэмдэглэгдээгүй тэнгисийг гатлах замаа хайж буй эцэг туйлдсан далайчинд хэцүү байдгийн адилаар, энэ нь амьдралын тэнгисийг гатлахаар удирдан хөтөлж буй үлгэр жишээний гэрэлгүйгээр зам хайдаг хүүхдүүд, залуучуудад бараг боломжгүй зүйл юм. Хэрэв эцэг, эхчүүд нь зарчмуудыг зөрчиж, сайн мэдээний дагуу амьдрахдаа бүтэлгүйтэхийг тэд харах юм бол бид зохисгүй тэдгээр зүйлүүдээс зайлсхийхийг тэднээс шаардаж чадахгүй билээ.

Эцэг, эх, багш, удирдагчдын хувьд, зөв шударгын хүч, эр зориг, золиослол, аминч бус үйлчлэл болоод өөрийгөө хянах байдлын хүчтэй хувийн үлгэр жишээг үзүүлэх нь бидний няцаашгүй үүрэг юм. Эдгээр нь манай залуучуудыг сайн мэдээний төмөр бариулаас барьж, шулуун ба нарийн зам дээр үлдээж болох зан чанарын онцлог шинжүүд юм.

### **Сайн Мэдээний дагуу Амьдрах нь Алдаануудаас Зайлсхийхэд Тусалдаг**

Би та нарыг мэдээлэл, харилцан холбоо, интервенци болон үлгэр дууриалал дээр анхаарлаа төвлөрүүлэх нь сайн мэдээний жишгүүдээс хэзээ ч хазайдаггүй төгс хүүхдүүдтэй, төгс гэр бүлд үргэлж үр дүнгээ үзүүлдэг хэмээн хэлэх юмсан.

Даанч харамсалтай нь тэр нь гол зүйл биш юм. Харин сайн мэдээний зарчмууд болон жишгүүдийг мэддэг, зааж сургадаг мөн хэрэгжүүлэн амьдардаг гэр бүлүүд нь ноцтой алдаануудын өвчнөөс өөрсдийгөө чөлөөлөх боломжтой юм. Урт удаан хугацаагаар бий болгосон эерэг харьцааны арга барил, мөн үнэн зөв үлгэр дууриал давамгайлах үед, хувийн асуудлуудаа хамтдаа зөвшилцөж, гэр бүлийн гишүүд бүрийг адислах шаардлагатай өөрчлөлтүүд дээр ажиллах нь хамаагүй хялбар байдаг юм.

Хаан Бэнжамины чухал ач холбогдолтой зөвлөмжийг сонсогтун:

“[Та нар] тэгснээр нүгэл үйлдэж болох зүйлүүдийг бүгдийг би та нарт хэлж чадахгүй; учир нь маш олон янзын зам мөн аргууд бий, бүр тэднийг би тоолж чадахааргүй тийм олон бөлгөө.

“Тэвч өдий зэргийг би та нарт хэлж чадна, хэрэв [та нар] өөрсдийгөө, мөн өөрсдийн бодлуудаа, мөн үгсээ, мөн үйлүүдээ хянаж, мөн Бурханы зарлигуудыг мөрдөж, мөн Их Эзэний маань ирэлтийн талаар дуулсан түүндээ үргэлж итгэлтэй байж, бүр амьдралынхаа эцсийг хүртэл ингэхгүй аваас та нар мөхөх ёстой болно. Мөн эдүгээ, Ай хүмүүн, санагтун, мөн бүү мөхөгтүн” (Мозая 4:29–30).

Хайрт ах, эгч нар аа, гэрээнүүдийн маань гал нь бидний зүрх сэтгэлд унтаршгүй гэрэл мэт асса наар Бурхан бид бүгдийг адислах болтугай. Бид долоо хоног бүр ариун гэрээнүүдээ шинэчлэхээр ариун ёслолыг хүртэх болгондоо сүнслэг байдлаар бэлтгэгдсэн байх болтугай. Тэгснээр бид Их Эзэнийг хүндэтгэж, эдгээр хамгийн баяр баясгалантай, мөн агуу өдрүүдэд гэр бүлүүдийгээ бэхжүүлэн Түүний Сүмийг байгуулахаар хийх зүйлээ хийхдээ баяртай байхыг энгийн даруухан залбиралдаа оруулж байна.

1999 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулганд Ахлагч Баллардын хэлсэн үгнээс (Conference Report, 1999 оны Дөрөвдүгээр сар, 111–15; эсвэл *Ensign*, 1999 оны Тавдугаар сар, 85–87–г үз).

# ГЭР БҮЛИЙН ЗАЛБИРАЛ, ГЭР БҮЛЭЭРЭЭ СУДРААС СУРАЛЦАХ БА ГЭР БҮЛИЙН ҮДЭШ

# 16

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЗОРИУЛСАН САНААНУУД

Хувийн хэрэгцээ болон нөхцөл байдлын дагуу эдгээр зөвлөгөөнүүдийн нэгийг эсвэл хоёуланг нь дага.

- Хэрэв гэр бүл тань тогтмол гэр бүлийн залбирал хийж, гэр бүлээрээ судраас суралцаж, мөн гэр бүлийн үдшийг хийдэг юм бол, та залбиралтайгаар эдгээр зүйлүүдийн нэг эсвэл түүнээс дээшхийг илүү сайжруулж чадах арга замуудыг бодож үз. Хэрэв танай гэр бүл эдгээр зүйлүүдийг хийдэггүй юм бол, гэртээ эдгээр үйл ажиллагааг бий болгоход нь туслахын тулд та юуг хийхээ бодож үз.
- *Family Home Evening Resource Book* (31106) has not been translated, so it's been deleted.
- Гэр бүлээрээ хамтдаа хийж болох нэгэн үйл ажиллагааг төлөвлө.
- *Teaching, No Greater Call* (36123) хуудас 137–39 дээр байгаа материалыг давтаж хяна.

## УНШИХ ДААЛГАВАР

Дараах өгүүллийг судал. Хэрэв гэрлэсэн бол эхнэр, нөхөртэйгээ энэ өгүүллийг уншиж ярилц.

### ГЭР БҮЛИЙН ЗАЛБИРАЛЫН АДИСЛАЛУУД

Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх  
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли

Төлөөлөгч Паул, Тимотод тунхаглахдаа:

“Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав.

“Учир нь хүмүүс өөрсдийгөө хайрлагчид, мөнхийг хайрлагчид, сагсуурагчид, их зантай, доромжлогчид, эцэг эхдээ захирагдахгүй, үл талархагч, ариун бус,

“Үл хайрлагч, эвлэрэшгүй, гүжирдэгчид, биеэ хянадаггүй, хэрцгий, сайныг үзэн ядагчид,

“Тэрслэгчид, бодлогогүй, биеэ тоодог, Бурханыг хайрлагчид байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагчид болох болно” (2 Тимот 3:1–4) гэжээ.

Өнөө үед үнэнч, шударга байдал, шинж чанар хийгээд шударга зарчимч байдлыг шинээр онцгойлон үзэх хэрэгтэй юм. Жинхэнэ бодит соёл иргэншлийн зайлшгүй хэсэг болох ариун журмуудыг бид амьдралынхаа хатуу журамд дахин төлөвшүүлэхэд л өнөө үеийн цаг хугацааг өөрчлөх арга зам нь болно. Бидэнд тулгараад байгаа асуулт бол, бид хаанаас нь эхлүүлэх ёстой вэ гэдэг асуулт юм.

Энэ нь Бурханыг Мөнхийн Эцэгээ, Түүний хүүхдүүдийн хувьд Түүнтэй харьцах харьцааг, Түүний хэмжээлшгүй том эрх мэдлийн байр суу-

рийг танин мэдэхээр Түүнтэй харилцан холбоотой байгааг мөн ажил үйлсдээ Түүний удирдамжийг өдөр тутам гуйн залбирахыг ухамсарлахаас эхлэх ёстой гэдэгт би сэтгэл хангалуун байдаг.

Би хүмүүсийн гэр орон дахь гэр бүлийн залбирал болох залбирлын хуучны арга барилыг дахин хэрэгжүүлэх нь нийгмийн маань идэгдэн бугласан онцлог шинж чанарын үхлийн өвчнөөс хязгаарлан хамгаалах үндсэн эмчилгээний нэг хэсэг болж байгаа гэдгийг баталж байна. Бид өдөрт нэг гайхамшгийг хүлээн авч чадахгүй ч, үр удамдаа гайхамшгийг хүлээн авах болно.

Нэг буюу хоёр үе үр удмын өмнө дэлхий даяарх Христийн шашинтан хүмүүсийн гэр орны гэр бүлийн залбирал нь хоол иддэгийн адилаар өдөр тутмынх нь үйл ажиллагааны нэгэн хэсэг байсан юм. Уг дадал нь үгүй болоход Төлөөлөгч Паулын ярьж байсан ёс суртахууны доройтол үүдэн гарч иржээ.

Би эцэг, эх, хүүхдүүдтэй—хамтдаа өглөө, орой залбирахаар өвдөг сөгдөх дадлыг орлуулчаар ямар ч тохирох зүйл байдаггүй гэдэгт сэтгэл хангалуун байгааг мэдэрдэг. Энэ нь зөвлөн хивснээс ч илүү, сайхан үзэмжтэй хөшигнөөс ч илүү, ухаалгаар тохируулан зохицуулсан өнгөтэй зурагнаас ч илүү тэр л зүйл нь өрх гэрийг илүү сайхан хийгээд илүү үзэсгэлэнтэй сайхан болгодог.

Паулын дүрслэн үзүүлсэн “их зантай . . . бодлоггүй, биеэ тоодог” хэмээх харьцааны эсрэг залбирахаар өвдөг сөгдсөн тэр байдал ямар нэгэн онцгой зүйлийг хэлж байгаа юм.

Түүний дүрслэн үзүүлсэн “эцэг эхдээ захирагдахгүй, . . . үл хайрлагч” хэмээх бусад хүмүүсийн тэдгээр шинж чанаруудыг алга болгодог эцэг, эх мөн хүүхдүүд хамтдаа залбирахаар өвдөг сөгдөх тэрхүү дадалд нь ямар нэгэн онцгой зүйлүүдийг хэлж байгаа юм.

Бурханд хандан залбирах үед нэрийг нь дэмий дуудах мөн Бурханыг хайрлагчид байхаас илүү зугаа цэнгэлийг хайрлагч байхыг хойш тавьдаг тэр үйлдэлд нэг онцлог зүйл бий.

Ариун бус, талархалгүйг эрхэмлэдэг байдал нь Паулын тайлбарласнаар амьдрал, амар амгалан, мөн байгаа бүхний төлөө гэр бүлийн гишүүд хамтдаа Их Эзэнд талархах үед алга болдог. Мөн тэд нэг нэгнийхээ төлөө Их Эзэнд талархах үед, гэр бүлийн дотор шинээр талархал, шинээр хүндэтгэл, шинээр нэг нэгнээ хайрлах нь хөгжин нэмэгддэг билээ.

Судар “чи Их Эзэн Бурхандаа бүх зүйлүүдэд талархах ёстой” (С ба Г 59:7) хэмээн тунхагладаг билээ. Харин дахиад: “түүний гарыг хүлээн зөвшөөрдөггүй, . . . тэднээс бусад хүмүүн ямар ч зүйлээр Бурханд гэм нүглийг үйлддэггүй, эсвээс хэний ч эсрэг түүний уур хилэн дүрэлздэггүй” (С ба Г 59:21) юм.

Их Эзэний өмнө ядуу, гачигдаж мөн дарлуулж буй хүмүүсийг бүгдийг дурсах үед өөрөөсөө илүү бусдыг хайрлах, бусдыг хүндлэх, бусдын гачигдал, хэрэгцээний дагуу үйлчлэх нь өөрийн эрхгүй үнэн бодит болж хөгждөг билээ. Хэн ч ямар нэгэн зүйлийг хийж хөршдөө туслах өдөөлтгүйгээр гашуудан зовж буй тэрхүү хөршийнхөө төлөө Бурханаас туслаач хэмээн гуйж чадахгүй. Хэрэв дэлхийн хүүхдүүд аминч үзлээ хойш тавин бусдад үйлчлэх үйлчлэлд өөрсдийгөө мартаж л юм бол, тэднийг амьдралд хичнээн их гайхамшгууд тохиолдох байсан сан бол. Энэ сүүдэрлэдэг жимс өгөгч модны үр жимс нь, өдөр тутам гэр бүлээрээ залбирч тэжээл өгч боловсруулахад маш сайн суулгагдан ургадаг билээ.

Эцэг эхчүүд өөрсдийн амьдарч буй газар нутаг нь эрх чөлөө хийгээд амар амгаланд оршиж болохын төлөө Бүхнийг Чадагчийн адислалуудыг түүн дээр гуйн хүсч буйгаа хүүхдүүдийнхээ өмнө залбиран гуйж эх орондоо хайртай байхыг ятгах шиг үүнээс илүү сайн арга байхгүй гэдгийг би мэднэ. Гэр бүлийн өдөр тутмын залбиралуудад тус улсынхаа засаг захиргааны хүнд ачаануудыг үүрч буй удирдагчдыг дурсан санаж, эрх мэдлийг

илүү их хэмжээгээр хүндэтгэхийг хүүхдүүдийнхээ зүрх сэтгэлд хөгжүүлэн төлөвшүүлэх шиг илүү сайн арга байхгүй гэдгийг би мэднэ.

Би нэгэн зарлалын самбар дээр, “Залбиралтай байдаг үндэстэн нь амар амгаланд орших үндэстэн юм” хэмээн дурьдсан мэдэгдлийг харж байснаа санаж байна. Би өөрөө ч үүнд итгэдэг.

Их Эзэний адислалуудыг өрх гэртээ, мөн тэнд байгаа тэдгээр хүмүүст зориулан гуйхаар Их Эзэний өмнө сул дорой байдлаа хамтдаа илчилж, хамтдаа залбирч байх юм бол, башир арга барилд сарнисан гэр бүлүүдийг сүйрлээс татан гаргадаг нанманчлалын сүнсэнд нөлөөлж, дуулгавартай байдал руу хөтөлдөг эцэг эхийн хүндэтгэлийг авчирдаг, гэр бүлийн түгшүүртэй байдлыг алга болгоход маш их тус нэмэр болох илүү зүйл хаа ч байхгүй гэдгийг би мэднэ.

Нас бараад удсан нэгэн хүний хэлсэн мэдэгдэл сэтгэлд маань хоногшин үлдсэн юм. Жеймс Х.Мойле өрх гэрийнхээ гэр бүлийн залбирлын талаар ач хүүхдүүддээ бичсэн байдаг. Тэрээр хэлэхдээ: “Бид бурханлиг удирдамж, мөн зөвшөөрлийг гуйн хүсэхээр өвдөг сөгдөн залбирахаас өмнө нь орондоо ордоггүй байсан. Хамгийн сайн зохион байгууллалттай гэр бүлүүдэд ялгарах зүйл бий боловч тэднийг . . . залбирлын сүнсэтгээгээр . . . сарниулж болно. Үүний гол сэтгэл зүйн хандлага нь хүмүүний дунд илүү их зөв шударга амьдралыг нэмэгдүүлэхэд байдаг. Үүний гол чиг хандлага нь эв нэгдэл, хайр, өршөөл, үйлчлэлд байдаг.”

Айова дахь уй гашуу, гай зовлон тохиолдсон өдрүүдэд мөн Солт Лейк Хондий рүү цэргийн анги ирэх үеэр, манай хүмүүсийн гайхамшигтай сайн анд нөхөр болох Хурандаа Томас Л.Кейн, эхнэр хоёр хүүгийнхээ хамтаар 1872 онд баруун хэсэгт дахин ирж байсан билээ. Тэд Бригам Янгийн хамтаар Сэйнт Жорж руу аялах замдаа, Сүмийн гишүүдийн гэр оронд өдөр бүр хонохоор буудалладаг байсан байна. Хатагтай Кейн Филадельфид суугаа эцэгтээ олон захидлууд бичсэн байв. Эдгээрийн нэгэнд тэрээр бичихдээ:

“Энэхүү аяллын турш хоносон айл нэг бүрт, бид оройн хоол бүрийн дараа тэр даруй залбирдаг байсан бас өглөө ундны өмнө дахин залбирдаг байв. Хэнийг ч орхидоггүй байсан . . . өрх гэрийн тэргүүн эсвээс хүндэт зочин чангаар залбирч байхад . . . Мормончууд . . . нэгэн зэрэг өвдөг сөгддөг юм. Тэд Бурханы шинж чанаруудыг нэрлэхдээ маш бага цаг зарцуулдгаас бусдаар тэд өөрсдийн хэрэгцээг асуун гүйхдаа, мөн Түүний өгсөн зүйлд Түүнд талархахдаа өөр билээ. . . . Бурхан бидний танил болсон нэрс, цолуудыг мэддэг болохоор [тэд] үүнийг үл тооцдог бөгөөд

[тухайн хувь хүний нэрээр] адислалыг асуудаг, . . . би үүнийг хийж дасах үед, энэ нь надад таалагддаг байв” гэжээ.

Анхдагчдын маань өвөг дээдсийн хувьд ийнхүү ач холбогдолтой байсан энэхүү туршлагыг бид хүмүүний хувьд бүрэн дүүрэн хөгжүүлээсэй! Гэр бүлийн залбирал нь яг л Табернекл дотор хуралдаануудыг хуралддагийн адилаар илүү хүндэтгэл бишрэлийн нэгэн хэсэг нь байсан юм. Тэд өдөр тутмын залбиран гуйхаас ирдэг итгэлээр тэд шарилжийг түүж, хуурайшин хатсан хөрсийг услан цөлийг цэцэрлэгжүүлж, гэр бүлүүдээ хайраар удирдан нэг нэгэнтэйгээ амар амгаланд амьдарч, Бурханы үйлчлэлд өөрсдийгөө мартан нэрсээ мөнхжүүлсэн юм.

Гэр бүл нь нийгмийн үндсэн нэгж юм. Залбирдаг гэр бүл нь илүү сайн нийгмийн итгэл найдвар юм. “Олдож болох үед нь Их Эзэнийг хайгтун” (Исаиа 55:6).

Бид орон гэрээ илүү үзэмжтэй байлгаж чадах уу? Тийм ээ, жинхэнэ бодит гоо үзэсгэлэнгийн Эх Сурвалж болох гэр бүл хэмээн өөрсдийгөө нэрлэснээр үүнийг хийж чадна. Бид нийгмийг хүчирхэгжүүлж, амьдарч болохуйц илүү сайн газар болгож чадах уу? Тийм ээ, гэр бүлээрээ хамтдаа өвдөг сөгдөн залбирснаар дамжуулан гэр бүлийн

амьдралын ёс суртахууныг бэхжүүлж, Бүхнийг Чадагчид Түүний Хайрт Хүүгийн нэрээр залбиран гуйснаар хийж чадна.

Гэр бүлээрээ хүндэтгэн бишрэх энэхүү дадал, газар дэлхий даяар нэвтэрснээр биднийг хөнөөгч сүйрлээс нэг ч болтугай үр удмыг бүхэлд нь гаргаж авах болно. Энэ нь шударга, зарчимч байдал, харилцан хөгжиж буй хүндэтгэл хийгээд хүмүүсийн зүрх сэтгэл дэх талархлын сэтгэлийг сэргээх болно.

Их Эзэн тунхаглахдаа: “Гуй, тэгвэл та нарт өгнө. Хай, тэгвэл та нар олно. Тогш, тэгвэл та нарт нээгдэнэ” гэжээ (Матай 7:7).

Хэрэв та чин сэтгэлээсээ гэр бүлийн залбирлыг хийвэл, таныг шагналгүйгээр орхихгүй гэдэг гэрчлэлээ би хэлж байна. Өөрчлөлтүүд нь тодорхой илэрхий биш байж болох юм. Тэд хэтэрхий нарийн байж болзошгүй. Гэвч тэдгээр нь үнэн бодит байх болно, учир нь Бурханыг “Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог” юм (Еврей 11:6).

Бусдыг үүний дагуу үйлдэж байхыг урамшуулж мөн бид үүнийг хэрэгжүүлэхдээ дэлхийн хүмүүст үлгэр дууриал үзүүлж, үнэн итгэлтэй байх болтугай.

1991 оны Хоёрдугаар сараас, *Ensign*, хуудас 2–5.

## “ТЭР ЭЭЖ УЧРААС”

Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын  
Ахлагч Л.Том Перри

### Буянт Сайн Эцэг Эх

Мормоны Ном нь: “Би, Нифай, буянт сайн эцэг эхээс мэндэлсний учир, тиймийн тул миний бие өөрийн эцгийн бүхий л эрдэм мэдлэгт зарим талаар сургагдсан” (1 Нифай 1:1) хэмээх эдгээр үгсээр эхэлдэг билээ. Хэрэв Тэнгэрлэг Эцэгийн маань хүүхэд бүрийн хувийн тэмдэглэлийн дэвтрүүд нь—буянт эцэг эхтэй байж, тэднээр сургагдсан—гэсэн ижил хэллэгээр эхэлдэг байсан бол энэ дэлхий хичнээн өөр байх байсан бэ.

Бид Их Эзэний сайн мэдээ бүрэн байдлаар сэргээгдсэн тэр цаг хугацаа хийгээд түүхийн үнэхээр онцгой үед амьдарч байгаа билээ. Номлолын ажлын хүчин чадал чанар хийгээд тооны хувьд сайжирч, нэмэгдсэн юм; тиймд, сайн мэдээ нь илүү олон улс үндэстэнд мөн илүү олон хэл дээр, урьд өмнө байгаагүйгээр их олон хүмүүст заагдаж байна. Дэлхийн ихэнх хэсгүүдэд хэсэг болон гадасыг байгуулснаар шинийг бүтээгч оюун ухаан нь олон

дуулгавартай хүмүүсийг бошиглогчдийн удирдамж, заавруудад ойртуулан авчрач чадвартай харилцааны хэрэгслүүдийг хөгжүүлэхээр сүнслэгээр урамшуулагдсан юм. Сургаалын сайн мэдээ нь эдүгээ хүмүүний зүрх сэтгэлд мөнхөд орших амар амгалангийн итгэл найдварыг авчрахаар илүү хурдтайгаар түгээгдэж байна.

### Гэр Бүлийн Амьдрал Доройтож Байна

Сайн мэдээний агуу их захиас бичгүүдийн нэг нь гэр бүлийн нэгжийн мөнхийн мөн чанарын сургаал юм. Бид гэр бүлийн амьдралын үнэ цэнэ болон ач холбогдлыг дэлхийд тунхагладаг боловч, өнөөгийн дэлхий дээр байгаа их хэмжээний үймээн мөн бэрхшээл нь гэр бүлийн доройтлоос үүдэн гардгийг бид олж харсан юм. Гэр бүлийн хүрээнд хайртай эцэг эхийнх нь сургаал сургамж хүүхдүүдэд дутагдаж байна.

Хүүхдүүд эцэг эхчүүдийн хоорондоо харилцан ярилцаж, суралцан тоглож, мөн хамтран ажилладаг байсан гэр бүлийн амьдрал нь хурдан, тусдаа, шарах шүүгээнд болгосон оройн хоол болон үдшийг зурагтын өмнө өнгөрүүлдгээр солигдсон байна. 1991 онд Солт Лейк Хотод болсон цуг-



лаанд, Улс Орнуудын Үндэстний Нийгэмлэг нь гэр бүлийн нөлөө багасч буй явдал нь манай үндэстэний доройтол болохуйц тэр хэмжээнд хүрээд байгааг тэрхүү цугларалтандаа ярилцаж, онцлон тэмдэглэсэн билээ. Тэд гэр бүл бүрийн амжилтанд хүрэх боломжийг өсгөх таван үндсэн ойлголтыг тодорхойлсон юм.

Нэгдүгээрт, гэр бүлийн үйл ажиллагаануудаар дамжуулж гэр бүлийн харилцааг хүчирхэгжүүлэх; хоёрдугаарт, тохирсон дүрэм журам, итгэл горьдлогуудыг бий болгох; гуравдугаарт, өөрийгөө хүндэтгэх; дөрөвдүгээрт, биелүүлж болохуйц зорилгуудыг тогтоох; тавдугаарт, гэр бүлийн хүч болон хэрэгцээг мөчлөгтэйгөөр тооцоолон үнэлж байх.

Гэнэт энэ цаг хугацааны хамгийн эхнээс бошиглогчдын маань яаралтай хийгээд анхааруулж буй дуу хоолой онцгой хамааралтай болсон байна. Бидэнд зөвлөгөө, урам дэм өгснөөр бид гэр бүлүүдээ сонор сэрэмжтэй байлгаж, бусдад үнэний мэдлэгийг мөн гэр бүлийн нэгжийн ач холбогдлуудыг авчрахаар номлолынхоо оролдлогуудыг хурдасгах ёстой.

### Адам, Ева Хоёр Эцэг Эхийн Үүргүүдэд Суралцдаг

Хамгийн эхэнд Их Эзэний Адам Ева хоёрт өгсөн зааварт тэдний эцэг эх байхын үүрэг хариуцлагуудыг тодорхой болгосон байдаг. Тэдний үүрэг нь маш тодорхой байсан. Тэд Их Эзэнээс заавар хүлээн авсны дараа тэд Түүний зөвлөгөөг дагаж байгааг бид хардаг бөгөөд ийнхүү хэлсэн байдаг:

“Мөн тэр өдөр Адам Бурханыг магтан дуулж мөн дүүргэгдсэн байв, мөн дэлхийн бүх гэр бүлийн талаар бошиглож эхлэн хэлэв: Бурханы нэр адислагдаг, учир нь миний гэм буруугийн улмаас нүд минь нээгдсэн буюу, мөн энэ амьдралд баяр хөөртэй байх болно, мөн махан бодид бибээр Бурханыг дахин харах болно.

“Мөн түүний эхнэр Ева эдгээр бүх зүйлийг сонсоод мөн баяртай байж хэлэв: Хэрэв бидний зөрчил байгаагүй сэн бол бид хэзээ ч үр удамгүй байх байсан, мөн сайн ба мууг, мөн бидний гэтэлгэлийн баяр баясгаланг, мөн дуулгавартай бүгдэд Бурханы өгсөн мөнх амьдралыг бид хэзээ ч мэдэхгүй байх байсан.

“Мөн Адам, Ева хоёр Бурханы нэрийг магтан дуулав, мөн тэд бүх зүйлийг хөвгүүд мөн охиддоо мэдүүлэв” (Мосе 5:10–12).

### Хүүхдүүдийг Заан Сурга

Тийм ээ, эрт үеэс эцэг эхийн үр хүүхдэдээ заан сургах үүрэг хариуцлага нь Их Эзэний бидний анхны эцэг эхэд өгсөн заавруудын дотор байсан юм.

Сүм сэргээгдсэн энэ цаг үед хүлээн авсан илчлэлтэд эцэг эхчүүд дахин сануулахдаа хүүхдүүдэдээ заан сургах нь тэдний үүрэг даалгавар болохыг дурьджээ. Сургаал ба Гэрээний ерэн гуравдугаар хэсэгт, бид гэр бүлийн үүрэг хариуцлагтаа анхаарал тавихгүй байгаа зарим ах нарыг зэмлэсэн Их Эзэний зэмлэлийг олж болно. Судраас үзэхэд:

“Харин хүүхдүүдээ гэрэл ба үнэнд хүмүүжүүлэхийг би та нарт зарлигласан билээ.

“Чи зарлигуудын дагуу гэрэл ба үнэнийг хүүхдүүдэдээ заасангүй; мөн нөгөөх ёс бус нэгэн, чиний дээр хүчтэй хэвээр байна, мөн энэ нь чиний зовлон зүдгүүрийн шалтгаан болой.

“Эдүгээ би чамд зарлиг өгч байна—хэрэв чи чөлөөлөгдсөн байхыг хүсэх аваас, чи гэр орноо цэгцлэх ёстой, учир нь зөв бус олон зүйл гэр оронд чинь байна” (С ба Г 93:40, 42–43).

### Гэр Бүлийн Үдшийн Ач Тус

Олон жилийн өмнө Сүм бүх эцэг эхчүүдэд гэр бүлийн үдшийг зохион байгуулахыг сануулсан билээ. Өнөөдөр энэхүү сануулга нь Сүмийн гишүүдийн гэр оронд хэрэгжээд байна. Даваа гаргийн оройг гэр бүлүүд хамтдаа байх үдэш болгон төлөвлөсөн байдаг. Сүмийн үйл ажиллагаа эсвээс олон нийтийн айлчлах цагийг энэ үдэш төлөвлөдөг ёсгүй. Хэрэв бидний гэр бүлүүд энэ хандлагад итгэлтэй байх аваас агуу их адислалууд бидэнд амлагдсан билээ.

Ерөнхийлөгч Харолд Б.Ли нэгэн удаа бидэнд зөвлөхдөө:

“Одоо үүнийг санаандаа тогтоо; Елиагийн үүргийг бүрэн дүүрэн ойлгох тэр үед, эцгүүдийн зүрх хүүхдүүд рүү, хүүхдүүдийн зүрх эцгүүд рүү эргүүгдэнэ. Энэ нь зөвхөн хөшигний наад талыг төдийгүй цаад талд ч хамаатай юм. Хэрэв бид гэр бүлийн үдэш ба хариуцлагадаа хайхрамжгүй хандан, бидний хайхрамжгүйн улмаас хэн нэгнийг алдах юм бол тэнгэр ямар харагдах вэ? Бидний ураг төрлөөр дамжуулан Их Эзэний илгээсэн тэдгээр хүмүүсийг аварч болохын тулд бид чадах бүхнээ хийх хүртэл тэнгэр тэнгэр биш байх болно” хэмээжээ.

Тэгээд тэр үргэлжлүүлэн:

“Тиймээс хэрэв та нарт Елиагийн үнэн сүнс байгаа бол, та нарын эцэг эхийн зүрх сэтгэл яг одоо та нарын хүүхдүүд рүү эргүүлэгдэх бөгөөд энэ нь зөвхөн хөшигний цаад талд байгаа нэгэнд хамаатай гэж бодож болохгүй. Өөрсдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүүгээ эргүүлж, мөн хүүхдүүдээ заацаага; гэвч та үүнийг тэдний залууд сайтар сургах ёстой. Хэрэв та гэр бүлийн үдэшээ үл тоомсорловол, та Елиагийн эхний үүрэг болох удам судраа судлах ажилд хайхрамжгүй хандаж байгаа хэрэг юм” хэмээн хэлэв (*Relief Society Courses of Study, 1977–78 [1977], 2; налуу бичлэгийг нэмэв*).

Би үргэлж гэр бүлээ залуу, мөн хүүхдүүд маань гэртээ байсан тэрхүү аз жаргалтай мөчүүдийг дурсан санадаг юм. Би тэдгээр өдрийн талаар дурсан санахдаа тухайн цаг үед бид дахин амьдрах боломж байх юм бол, гэр бүл зохион байгуулах ба удирдлагадаа зарим нэг өөрчлөлт хийх байсан. Хэрэв манай гэр бүл дахин нялх хүүхэдтэй болох боломж олдвол би хоёр зүйлийг сайжруулах байсан.

Нэгдүгээрт гэр бүлийн зөвлөлд эхнэр нөхөр хоёр хоорондоо харилцах, суралцах төлөвлөх болон зохион байгуулах зэрэг эцэг эхийн үүргээ сайн гүйцэтгэхэд илүү цаг заваа зарцуулах байсан.

Хоёр дахь хүсэл маань хэрэв тэр цаг үе дахин олддог л юм бол би гэр бүлтэйгээ хамт их цаг зарцуулна. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл тогтмол утга учир бүхий гэр бүлийн үдшийг багтаана.

### Амжилтанд Хүрэхэд Залуусын Хувь Нэмэр

Гэр бүлийн үдшийг төлөвлөх ба бэлтгэх бүх ачааг зөвхөн эцэг эхчүүдэд үлдээх нь зохисгүй юм. Хамгийн амжилттай болж байсан нь миний үзэж байснаар гэр бүл дэх залуусыг идэвхтэй оролцуулах явдал юм.

Агуу туслагчид, багш болон санваартнууд, Бихайв охидууд, Май Мэйд ба Лаурелууд аа, би та нарыг өөрсдийнхөө гэр бүлийн үдшийг амжилттай болгоход гол хувь нэмрээ оруулаасай хэмээн хүсч байна. Олон гэр бүлд та нар гэр бүлийнхээ итгэл зүтгэл болж чадна. Энэ бүх зүйлийн дараа, та нар л үүнээс маш их туршлага хуримтлуулж чадна. Хэрэв амар амгалан, аюулгүй мөн боломж бүрдсэн дэлхийд амьдрахыг хүсэж байвал, гэр бүлдээ оруулах та бүхний хувь нэмэр сайн сайхан зүйлийг бий болгоход, тэр ч байтугай энэ дэлхийд ч хандиваа оруулж чадна.

Би Зул Сарын Баярын үеэр манай ач нар бидэнтэй хамт салхинд гарч байх үед тохиолдсон нэгэн жишээг санаж байна. Хамтдаа байж, аялах жинхэнэ боломжийг олох үүднээс бид фургон машиныг захиалсан юм. Тэр фургонд Өвөө, Эмээ, миний хүү болон түүний гурван том хүүхдүүд нь байлаа. Хүүгийн маань эхнэр гэр бүлийн бага насны хүүхдүүдтэйгээ гэртээ үлдсэн юм. Миний жолоодох ээлж болоход эхнэр маань хажууд сууж хаашаа явахыг удирдан хэлж өгч байлаа. Фургоны арын суудлаас том охин Аудрей аавтайгаа зөвлөлдөж байхыг би сонсов. Тэрээр “Аваа, бидний зорилгуудын маань нэг бол Мормоны Номыг энэ жил гэр бүлийн сургалтын цагаар уншиж дуусгах юм шүү дээ. Өнөөдөр энэ жилийн хамгийн сүүлчийн өдөр. Бид яагаад одоо дуусгаж болохгүй гэж тэгвэл бид цагтаа дуусна шүү дээ?” гэж хэлж билээ.

Хүүг гурван хүүхдүүдийнхээ хамтаар ээлжлэн Моронайгийн төгсгөлийн бүлгийг уншин, Мормоны номыг бүхэлд нь уншиж дуусгах зорилгоо биелүүлж байгааг сонсоход ямар гайхалтай байсан гээч. Эцэг эхийн аль нэг нь бус харин нэг залуу охин энэ саналыг гаргасан гэдгийг санацгаа.

### Залууст Хүргэх Уриалга

Та нар—хүн төрөлхтөний түүхийн онцгой цаг үед хадгалагдсан—сонгогдсон үр удам юм. Та нар байгаа гэр бүлдээ өсөж хөгжихөд асар их хувь нэмрийг оруулдаг билээ. Би та бүхнийг залуу хүний онцгой, урам зоригтой сүнстэйгээр урагш алхан гэр бүлдээ сайн мэдээг үнэхээр амьдруулаасай хэмээн уриалж байна. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн зөвлөгөөг санацгаа. Тэрээр хэлэхдээ:

“Би өөрийн хүүхдүүд, мөн Сион дахь бүх хүүхдүүдийг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан энэ хожмын өдөр сэргээгдсэн Сайн Мэдээний мэдлэгээс илүү үнэтэй зүйл энэ дэлхий дээр үгүй гэдгийг мэдээсэй гэж хүсэж байна. Энэ нь алдагдвал үүнийг орлуулах зүйл үгүй билээ. Есүс Христийн мэдлэгийн төгс байдалтай зүйрлэж чадах зүйл энэ дэлхийд үгүй болой. Тиймээс Сионы бүх эцэг эхчүүд хүүхдүүдээ анхаарал тавьж, тэдэнд Сайн Мэдээний зарчмуудыг заан тэднээр үүргийг нь биелүүлүүлэхийн тулд чадах чинээгээрээ хичээдэг—гэхдээ хүчээр бус, албадалгүй, харин хүүхдүүдийн зүрх сэтгэлийг сүнсний үнэн ба Сайн мэдээний хайраар аажмаар мэдрүүлэхийг оролдвол тэд өөрсдийн үүргийг зөвхөн эцэг эхийн шаардсанаар бус, харин өөрсдөө хүлээн зөвшөөрч хүссэн учраас гэдгийг мэдрүүлэх явдал

мөн” гэж хэлсэн байдаг (Brian H. Stuy–гийн, зохиол., *Collected Discourses Delivered by President Wilford Woodruff, His Two Counselors, the Twelve Apostles, and Others*, 5 боть. [1987–92], 5:436).

### Гэр Бүлийн Үдшийг Шинэчлэн Сэргээж Бай

Гэр бүлийн үдэш нь өрх толгойлсон ганц бие эцэг/эх буюу элэг бүтэн айл, эсвэл гэр бүлд цорын ганц гишүүн байгаагаас үл хамааран хүн бүгдэд зориулагдсан юм. Гэрийн багш нар аа, бид та нарыг сар бүр тогтмол айлчлан гэр бүлийн үдшийг шинэчлэн сэргээж зохион байгуулахыг зоригжуулж байгаасай гэж хүсч байна.

Бидний өнөөгийн Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон аз жаргалтай гэр бүлийг бүрэлдүүлэх хүчин зүйл болоод гэр бүлийн үдшийг зохион байгуулах шаардлагыг дахин сануулж байсан. Тэр хэлэхдээ:

“Гэр бүлийг бэхжүүлж хамгаалахаар зохиогдсон Сүмийн [гэр бүлийн] үдшийн хөтөлбөр нь гэр бүл дэх охид хөвгүүдийг долоо хоног болгоны нэг орой гэртээ хамтад нь цуглуулахаар эцэг эхэд өгөгдсөн онцгой адислал юм. Залбирал хэлж, сүмийн дуулал болон бусад дууг дуулж, судраас уншиж, гэр бүлийн тухай сэдвээр ярилцан, авьяасаа харуулж, сайн мэдээний зарчмуудыг заан, заримдаа тоглоом тоглож, гэрт хийсэн идээ ундаагаар дайлж болно” хэмээн хэлжээ (Conference Report–ийн, Philippine Islands Area Conference 1975 он, 10).

Та бүхнийг бошиглогчийн хэлсэн гэр бүлийн үдэш ямар байж болох талаарх санал дэвшүүлсэн бүхнийг тэмдэглэн авсан гэдэгт бид найдаж байна.

Тэгээд тэрээр үргэлжлүүлэн: “Эдүгээ долоо хоног бүр [гэр бүлийн] үдшийг хийдэг тэдгээрт Бурханы бошиглогчийн амласан адислалыг сонордуулья: ‘Хэрэв Гэгээнтнүүд энэ зөвлөгөөг сахивал, үр дүн нь агуу их адислал байх болно гэж амлаж байна. Гэр доторх хайр ба эцэг эхээ хүндлэх явдал нэмэгдэнэ. Израилын залуучуудын зүрх сэтгэлд итгэх итгэл нь өсөн нэмэгдэн хөгжих бөгөөд тэд нартай нүүр тулах хилэнцийн эсрэг тэмцэх хүч ба уруу таталтаас сэргийлэх хүч чадлыг олж чадна” хэмээн хэлжээ (Conference Report–ийн, Philippine Islands Area Conference 1975, 10; түүнчлэн *Improvement Era*, 1915 оны Зургадугаар сар, 734).

Бид хүн бүхнийг бидний бошиглогчийн зөвлөгөөг дагаасай хэмээн зоригжуулж байна. Сүмийн доторх бүх гэр бүлүүд, тогтмол гэр бүлийн үдшийг хийж буй явцаа дахин үнэлэн дүгнээсэй. Энэхүү хөтөлбөр нь таныг манай цаг үеийн хилэнцээс хамгаалах бамбай болох ба энэ цаг үед хувь хүмүүс болон олон нийтэд мөнхийн амьдралд үүрд орших элбэг дэлбэг баяр баясгаланг та нарт авчрах болно.

Бид гэр бүлийн гишүүдээрээ хамтдаа зөвшилцөн энэхүү нэн чухал хөтөлбөрийг шинэчлэн, хүчирхэгжүүлэхэд Бурхан биднийг адислах болтугай.

1994 оны Дөрөвдүгээр сарын Сүмийн ерөнхий чуулган дээр Ахлагч Перригийн хэлсэн үгнээс (Conference Report, 1994 оны Дөрөвдүгээр сар, 47–51; эсвэл *Ensign*, 1994 оны Тавдугаар сар, 36–38–г үз).



